


Е.И.Кычанов



**ГАЛДАН БОШГОТ
ХААНЫ ТУХАЙ
ХҮҮРНЭЛ**

Улаанбаатар хот

Галдан бошгот хааны тухай хүүрнэл

Зохиолч: Е.И.Кычанов

Орчуулсан: Х.Цэдэв

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Ховд хот байгуулагдсаны 240 жилийн ойд

Оросын эрдэмтэн, профессор Е.И.Кычановын зохиож 1980 онд Новосибирскийн “Наука” хэвлэлийн газарт хэвлүүлсэн энэхүү бүтээлийг орчуулж уншигч танаа толилуулах завшаан тохиосонд баяртай байна. Энэхүү номыг орчуулахад гүн туслалцаа үзүүлсэн, орчуулагч Д.Мөнх-Эрдэнэ, түүхийн зөвлөгч А.Баасанхүү, Д.Ширэндэв нар болон ивээн тэтгэж хэвлүүлсэн “Экимто” компанид халуун талархал хүргэж, юу санасан есөн хүсэл тань бүтэхийн ерөөл айлтгая. Энэхүү номын орчуулгын талаархи санал бодлоо МҮИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн албаны мэргэжилтэн, профессор Х. Цэдэвтг (navaanzoch@yandex.ru) гэсэн хаягаар ирүүлж, цаашдын уран бүтээлд минь үнэтэй санал, зөвлөлгөө ирүүлэхийг уншигч Танаас хүсье.

Оршил

Өршөөлгүй хувь тавиланг сөрж

Өрвөлзөж яваа биднийг өршөө!

Жанжа хутагт Ралбайдорж

Бидний олонх нь сургуульд байхаасаа л манай орны дорнод хил хязгаар дахь Зүүнгарын хаалга болох уулын гарцын талаар сонсож байсан билээ. Хятадын төв болон баруун районыг ЗСБНХУ-ын төмөр замын сүлжээтэй холбосон өргөн төмөр зам тавигдах учиртай байв. 1969 онд энэ нутгийн хил орчмоор маоист мөргөлдөөн гарсан нь харамсалтай. Зүүнгарын хаалганы цаана орших Зүүнгар улс нь 1884 онд байгуулагдсан хятадын Шинжаан /Шинэ хил, хязгаар/ мужийн хойд хэсэг бөгөөд тухайн үедээ халимагууд зарим хэсгийг нь бүрдүүлж байсан ойрадууд буюу зүүнгарчуудын биеэ даасан, хүчирхэг улс байсан гэдгийг тэр бүр хүн мэддэггүй. Энэ бол баян тансаг, сайхан орон байлаа. Ойрадын домогт яруу сайхан үзүүлснээр: “Ямар ч налуу, гүвээ дөрөлжгүй тавин оргилт Хангай сүндэрлэнэ. Ямар ч гарц, даваагүй Алтайн уулс ханарна. Далан цагаан цохио аниргүйхэн сүглийж, нэвтрэх аргагүй тавин хар бутан шугуй бараантана. Ой ширэнгэ нь нүд баясгана. Цаст тавин нурууд нь цайрч. Мөсөн хянга бүхий наян байц хадан оргилууд сүмбэрлэнэ. Яасан баяр хөөртэй, сайхан эх орон гээч! ... Арван мянган тунгалаг нуур нь хүрээ татан цайрч... зуун том гол нь мурилзан урсаж, хэдэн зуун мянган булаг нь нийлэн, бургилан, хөөсөрнө. Өнгө бүрийн цэцгүүд нь дэлгэрч найган, бүхий л өвчнийг анагаах рашаан булгууд нь жирэлзэн урсана. Найман янзын амттай ямар ерөөлтэй сайхан ус вэ.

...Талын агь хялгана нь нийлэн ургасан, өтгөн сайхан өвс ногоо нь өчүүхэн ч зааггүй. Аймшиггүй хүчит зэрлэг ан араатнууд нь хоол хайн хүрхэрэн, зүйл бүрийн жигүүртэн шувууд нь донгодсон, далан зүсмийн зээр гөрөөс нь ар араасаа хөврөн идээшлэнэ. Яасан баяр хөөртэй, сайхан эх орон гээч! Энэ тухай ийн өгүүлэх аж. Алтай, Хангайн хойд салбар уулсаар алаг, хар, хээр адуун сүрэг нь багширч..., найман ч удаа тоо алджээ. Цагаан Хангайн өмнөд салбар уулсаар улаан, шар тэмээд нь өсөн үржиж, говийг дүүргэн, ерэн есөн хар буурал халзан буурнуудын сүрэг галзуурсан арслан зааны сүрийг илтгэнэ. Атан тэмээд, ингэнүүд нь хэдэн зуун мянгаараа сүрэглэнэ. Гунжин тэмээд нь ялгарч, тавь жаран мянгаараа, ботго торомнууд нь хэдэн зуун мянгаараа зэрлэг сонгинотой газар идээшлэн, тарга тэвээрэг авна. Голын хөндий, хавцал, тал хээрийг дүүргэсэн улаан үхрийн тухайд яривал тэдний тоог таван ч удаа алджээ. Алтайн давааны гучин өндөрлөгийг эзэлсэн дун шиг цагаан хонин сүргийн тоог алдаад өчнөөн жил өнгөрчээ. Хичнээн олон мал вэ хэмээн хэлэх ч боломж алга! Хонь, адуу, үхэр, тэмээ гэсэн дөрвөн хошуу малын тухай ярихад л энэ!” [1].

XVIII зууны дундуур энэ орныг Цин улсын Хятад устгаж, хүн амын ихэнхийг нь хүйс тэмтэрчээ.

Явган Мэргэний тухай домог ойрадчуудын дунд тархсан байдаг. Домогт өгүүлснээр: “Нар, сарыг халхалсан нэгэн том шувуу Бээжинд бий болжээ. Энэ шувууг ойрадын Явган Мэргэнээс өөр хүн дийлэхгүй болохыг Манжийн хаан мэргэдээс сонсжээ. Ингээд Явган Мэргэнийг урьж

гэнэ. Тэрээр Бээжинд ирж долоо хоноод тэр шувууг устгаж гэнэ. Хятадууд ийм баатар эр биднийг ч захирч мэднэ хэмээн айж түүнийг хөнөөхөөр шийджээ. Явган Мэргэний хоолонд нь хор хийж түүнийг хөнөөжээ [2]. Цин улсын хятадтай хийсэн тулаанд ойрадын олон баатрууд амь эрсджээ. Тэдний мөхөл Явган Мэргэний тухай домогт тусгагдсан байна. Зүүн гарын улсыг үндэслэн байгуулагчдийн нэг Галдан Бошгот хааны тухай хүүрнэлээ эхлэе.

Нэгдүгээр бүлэг

Энэ навч цэцгийг хараач

Ээ мөн ч сайхан ургаж дээ

Эхээс мэндэлсэн хүүгийн атгаастай гар шиг

Энхэр хөөрхөн дэлбээ нь хуниастай мөрглөө

Эгц дээш тэнгэр өөд тэмүүлэх нь

Энэ ертөнц бүхлээрээ минийх гэх шиг

Овсей Дриз

Ойрад хөвгүүдийн нэгэн адил Галдан Бошгот хаан эсгий гэрт мэндлэх тэрхэн зуур Юм – Агас хатан халхавч хөшгөө татаж, дуу ч гарч чадахгүй болтлоо тамирдан, эсгий гудсан дээр эргэн хөрвөн төрөх мөчөө хүлээн хэвтэхэд, гэрийн гадна хурсан лам хуврагууд хөнгөрөх эхээс ад зэтгэрийг хөөн зайлуулах уншлага үйлдэнэ. Төрөх хүүхдийн эцэг Хун тайж гэрээс зайдуухан зогсоод ташуураа толгой дээгүүрээ эргүүлэн байж “Зайлцгаа!”, “Холдоцгоо!” хэмээн тэнхээ мэдэн хашгирах тэр л агшинд, ойрад түмний ирээдүйн дээд эзэн эр хүмүүн төрснийг зарлах адил, хөвүүн эхээс унамагцаа часхийн дуу хадаав. Гэрт үймэрсэн газар ээж болох эмгэд, эрчүүд ойрад заншлаар дөнгөж мэндэлсэн хөвүүний хүйг таслан угаалга үйлдээд, цагаан хурганы арьсанд өлгийдэв. Хөвүүний төрсөн өдрийн төөргөөр нэр хайрлах гэлэн уншлага уншин, аяга усан дээр сүү дусааж чимх арц цацаад Төвдийн ариун судраар адислан шившлэг үйлдээд аягатай ус руу хэдэнтээ үлээж тарнидаад зүүн гарынхаа ядам хурууг дүрж, хүүгийн амыг гурвантаа тойруулан домнов.

Аягандаа дахин ус нэмээд, хөвүүний нүүр толгойг угаав.

Хөвүүнд тэртээ холын цаст Төвд орны ариун хийдүүдийн томоохон нь болох Галдан хэмээх нэр хайрлаж, тарни бүхий ариун номын хуудас бүхий сахиус зүүж өгөв.

Галдан хэмээн нэрлэгдсэн бяцхан хөвүүн эхийн сүүгээ амтархан хөхөж, угаалгыг гурван өдөр ёслон тэмдэглэхэд, Баатар-хун тайжийн өргөөнд зочин гийчид багтаж ядан, арз хорз, айраг цагаа, идээ будаа цалгин бялхаж:

Хээрийн хулангийн сүү

Хэмжээ үгүй асгарч

Арз архи цалгиж

Ард олон жаргаж байв.

Бяцхан Галданг эрүүл чийрэг, дайчин эр болохыг билэгдэн давстай усаар гурвантаа угаажээ.

Баатар хун тайжийн зургаа дахь хөвүүн Галдан нь ууган ах Цэцэн, гурав дахь ах Баатар, тав дахь ах Сэнгэ нарынхаа адил нэр цууд гарсан билээ, Баатар-хун тайжийн есөн хатнаас арван хүү, хоёр охин төрсөн бололтой. Шинэ төрсөн Галдан хөвүүний эхийн удмыг хөөвөл Ижил хавийн халимагуудын хаан Аюухийн удам ажээ [1].

Халимаг болон ойрадын түүхч Гаван Шарав Бошготын угийн бичигт: “Онгоцын хөвүүн Абид-Бүлэн тайж, түүний хөвүүн Хар-хулын арван хөвүүний ууган нь Баатар хунтайж болой. Баатар хунтайж бас арван хөвүүнтэй байсны Сэнгэ, Бошгот хоёр л хаан ор суужээ. Сэнгийн хөвүүн Зоригт хунтайж, түүний хөвүүн Галдан-Цэрэнгээр Бошгот-хааны удам тасарчээ” [2] гэсэн байдаг.

Галдангийн намтар судлаач Японы эрдэмтэн Ханзда Акира түүнийг ямар ч маргаангүйгээр 1645 [3] онд төрсөн гэж үздэг ч, яг төрсөн сарыг нь тодорхой мэдэхгүйгээр оныг тогтооход бэрхшээл гараад байгаа юм. “Шунь-Чжийн хаанчлалын анхны жил нь” 1645 он гэж Ханзда Акира бас тодорхойлжээ. Гэтэл Хятадын лавлах бичгүүдэд 1644 он гэжээ. Хятадын тухайн үеийн бусад сурвалж бичгүүдэд, чухамдаа Галдан бошготийн Хятадтай дайтсан тухай баримт бичгийн түүвэрт мөн л 1644 он гэжээ.

Хятадууд 1679 он хүртэл Галдангийн талаар тодорхой мэдээлэлгүй ирснээ тэр жилийн 8-р сарын сүүлчээр /9-р сарын 2-ноос 10-р сарын 5 хүртэл/ Галдангийн элч Сайсанман гуч гаруй бараа бологчоо дагуулан Цин улсын нутагт орж ирэх үед орон нутгийн ихэс дээдэс ойрадуудаас нууцаар Галдангийн нас сүүдэр, зан авирыг лавлаад “Галдан 1644 онд төрсөн, нас сүүдэр 36-тай, архи дарс, эмс хүүхэнд шунан дурладаг, түрэмгий догшин авиртай” [4] гэдгийг тогтоожээ.

Галданг дөрвөн ой хүрмэгц нэгэн гэлэн билиг ерөөл айлдан, сэвлэгэнд нь гар хүрч, туг үс хайчлан эхэд нь өгөхөд ойрад заншлаар сахиусандаа хийгээд насан туршдаа зүүхээр авчээ. Галдан ухаалаг сэргэлэн зоримог, удам залгамжлах хүү болон өслөө. Энэ тухай ойрадууд : ”Зулай дээр нь Базардарь, магнай дээр нь Зонхов, нүүр дээр нь Махгал, хоолой дээр нь Хонсинбодьсадва, хоёр мөрөн дээр нь хорин нэгэн дарь эх тодорсон, барс арслангийн хүчтэй, гучин гурван луу, аугаа хүчирхэг хан гарьдийн чадалтай эр болон өслөө. Нялх багадаа зугаацан наадаж, өсөх тутам баатрын төрхийг олов. Зэгсээр нум, хялганаар сум хийгээд тэнгэрээр дүүлэх шаазгай хэрээ, газраар булгах хулгана, зурам харван өслөө” гэж ярьдаг байв.

Ийнхүү Баатар хунтайжийн хар, шар албат, санваартнууд Галдан хүүг хайрлан бахархаж өсгөв өө.

Хоёрдугаар бүлэг

Ур модон эхтэй

Ууль шувуун эцэгтэй

Ойрад ардын зүйр үг

Галдан Бошгот хаан /1644-1697/ тэнгэрийн охидоос удамтай, дайчин Цорос аймгийн хүн билээ. Эрт урьдын цагт ойрадын газар нутагт: “Хүний мөр гараагүй, үүлэнд умбасан өндөр сүрлэг хайрхан уулын оргилд шигүү бутаар эргэн тойрноо амжсан цэвэр тунгалаг устай нэгэн бяцхан нуур байжээ. Нэгэн цагт анчин залуу эр санамсаргүй уулын оройд гарчихаад, нуурын хөвөөгөөр бэдэрч явглаа цангинах инээд, цалгих усны чимээг сонсоод гайхшаа барав гэнэ. Тэгээд учрыг нь олох гээд шигүү бутан дундуур сэмхэн гэтсээр очтол нуурын усанд умбан шумбах тэнгэрийн охидыг харжээ. Тэд үүлэнд нэг халин умбаж, усанд нэг шумбан байв. Тэнгэрийн охид залуу эрийн тачаалыг хөдөлгөж, аль нэгий нь барьж эзэмдэх хүслийг шатааж гэнэ. Залуу эр буцаж хариад суран цалам авч ирээд нуурын эргийн бутанд нуугдан тэнгэрийн охидын нисэн ирэхийг хүлээжээ. Тун ч удалгүй нуурын мандлыг үүл бүрхэн тэнгэрийн охид бууж ирээд усандаа шумбан наадсаар, хар авалгүй эрэг рүү ойртон ирэх зуур залуу эр аяыг нь тааруулан нэг охиныг цаламдан авахад бусад нь дэрхийн нисэн үүлэнд умбан бараа тасарчээ. Барьсан охиноо өөртөө дасган, энхрийлэн янагласаар тэнгэрт нь суллан тавьжээ. Гэвч газрын хөвүүний хайр янаглал талаар өнгөрсөнгүй, тэнгэрийн охин бие шалтгаантай болоод, гутамшигт явдлаа нуух хэмээн, нуурын хөвөөнд эргэн ирж, нэгэн хөвүүн төрүүлээд, өлгийдэн модны мөчирт дүүжлэн орхихдоо балчир үрээ уйлбал сайхан жиргээгээрээ саатуул хэмээн Тангадууд ууль хэмээн нэрлэдэг бяцхан шар шувууг асрагчаар үлдээж өлсгөж цангаахгүй хэмээн бүдүүн модны ураар цорготой аяга хийгээд хөхний сүүгээрээ дүүргэн хөвгүүний аманд хөхүүлээд нисэн оджээ. Тэгээд ч цорбгор аяга хэмээх үгнээс цорос үүсчээ.

Тэр цагт энэ нутгийнханд ван, ноёд гэж байсангүй. Цагийн шаардлагаар ахлагчаа сонгох хэрэгцээ гарч чухам хэнийг ноён болгохоо шийдэж ядаад, холгүй суудаг нэгэн мэргэнд очиж учраа хэлэхэд уулын орой дээрх нуурын орчмоос ноён болох хүнээ олно гэж айлджээ. “Мэргэний зөвлөсний дагуу нуурын хөвөөнд очтол тэнгэрийн охины хөвгүүний уйлах, шувуухайн жиргээ сонсогдоод, өлгийтэй хөвгүүнийг олж аваад буцахад шувуухай нисэн оджээ. Нутгийн олон бяцхан хөвгүүнийг асран өсгөж, ноёнд өргөмжилсөн нь хожим Зүүн гарын үндэслэгч болжээ” [1] гэсэн домог дэлгэрчээ. Ийнхүү бяцхан шувуухайн нэрээр Өөлдүүд нэрлэгджээ, тэнгэрийн охины бүдүүн модны ураар хийсэн аяганы нэрээр Ойрадуудыг цорос хэмээн нэрлэж эхэлжээ. Тиймээс ч “ Ур модон эхтэй, ууль шувуун эцэгтэй, дээд тэнгэр язгуурт Хурмастын удам” хэмээн зүйр үг гарсан бололтой.

Эртний монголчуудын Хурмаст тэнгэр гэдэг ойлголт нь Ираны Ормуз шүтээнтэй холбоотой ажээ. Ой хөвчид амьдардаг эртний Ойрад-анчдын шүтээн нь мод байв. Үүнийг батласан ойрад, монгол домгууд олон бий. “Яагаад ч юм бэ Зүүн гарын болон дөрвөдийн ноёд өөрсдийгөө тэнгэрээс гаралтай хэмээдэг. Эрт цагт Амина, Дөмнө хэмээх бурхад амьдарч байжээ. Амина ес, Дөмнө дөрвөн хөвгүүнтэй байв. Эдний нэг анчин хөвгүүн нь мөчрөөс өлгөөд орхисон бяцхан хөвгүүнийг олоод модны шүүсээр угжсаар хүмүүн болгоод Цорос

хэмээн нэрийджээ, /Хөвгүүнийг өлгөсөн модны мөчир нь данхны цорго хэлбэртэй байжээ. / Олдсон хөвгүүнийг ууль шувуу, ур мод хоёроос төрсөн хэмээн үздэг. Энэ хөвүүн өсөөд эрийн цээнд хүрээд Амина, Дөмнө хоёрын үр хүүхдийг захиран тэдний удам нь Зүүн гарын болон Дөрвөдийн улсыг үүсгэжээ. Модны мөчрөөс олдсон хөвүүнийг тэнгэрээс гаралтай гээд тэнгэрийн зээ хэмээн нэрлэжээ” [2]. Үүний зэрэгцээгээр монголчууд чоно, марал хоёроос бас модноос үүсэлтэй гэх домгууд ч бий. “Монголчуудын эцэг модноос төрж, нохой хөвүүнийг нь өсгөжээ” [3] гэж ярьдаг. Чингис хаан ертөнцөд мэндлэхдээ модтой хүйн холбоотой байсан гэх хууч яриа ч бий. “Тэнгэрийн хөвүүн Чингис хаан газарт модны дүрээр мэндэлжээ. Аргал түүж явсан эмэгтэй хөвүүний уйлах чимээг сонсоод гэртээ аваачиж, хүмүүжүүлж өсгөжээ” [4].

Монголчууд одоогийн оршин суугаа газар нутагтаа Амар мөрний хавийн ой хөвчөөс нүүдэллэн ирж суурьшсан болохоор иймэрхүү буйд гайхах аргагүй юм. Баруун монголчууд буюу ойрадууд 12-13-р зууны үед бие даасан монгол хэлтэн ойн аймгууд байжээ. Эртний монгол домогт ойрадууд бүр элэнц хуланцын үед тусгаар байсан гэж баталдаг. Монгол түмний домгийн нэгэн цуут удам Дува-сохорыг үхсэний дараа дөрвөн хөвүүн нь авга ах Добу-мэргэнийг авгаа гэж үл ойшоон салан нүүцгээж, дөрвөдүүдийн удам болох дөрвөн аймгийг үүсгэжээ. Ойрадууд Енисей / Горлос / мөрний эхээр нутаглаж байв. “Ойрад аймгууд Найман голын эхээр суурьшин нутаглаж байлаа... Жижиг гол горхиуд эндээс эх аван Хэм хэмээх хүчирхэг мөрөнд цутган урсмой... Энэ аймгийн хан эртнээс нааш хүн олонтой, аж ахуйн өөр өөр хэлбэрийг эрхэлдэг, тус тусдаа онцлох нэртэй байв... Тэд эртний монгол аймгуудаас бага зэрэг ялгаатай монгол хэлээр ярилцдаг... Ойрадууд хэзээ ямагт хаан, удирдагчтай явж ирсэн. Хэдийгээр Чингис хааны үеэс эхлэн халх монголчуудтай тэмцэж ирсэн ч удалгүй эв эеэ ололцож, эрхшээлд нь оржээ” [5]. Ойрадууд, түүний толгойлогч Хутаг-бэх Монголын тал нутагт ноёрхлоо тогтоохыг санаархан Чингис хаантай тэмцэлдэж байхдаа эхлээд Жамух, дараа нь Найманы талд оржээ. Тэгээд удалгүй Жамухыг орхин ой хөвчдөө буцаж ирснийх нь хойно, Чингис монгол аймгуудыг үндсэнд нь нэгтгээд 1207 онд хүү Зүч нь ойн түмнийг эрхшээлдээ оруулахаар дайлаар мордоход Ойрадын Хутаг - бэх сайн дураараа Чингисийн захиргаанд нэгдэн “ ойн иргэдийг ивээгч” [6] алдрыг хүртэн үлджээ.

Юань улсыг мөхөлд хүргэж /1368 он/, Хятадаас Монголчуудыг хөөн зайлуулсны дараа хэсэг хугацаанд ойрадууд монголын засаг төрийн эрхийг булааж авчээ. Монголын тал нутагт монголчууд засаглалаа “ хоёр дахь удаагаа” алдсан энэ хүү гутамшгийг эхнэрээс болж амиа алдсан хааны домогтой холбож үздэг. “1394 оны нохой жил Элбэг хаан хаан ширээнд заларчээ. Нэгэн удаа ан хоморгонд явж байхдаа цасан дээр цусаа урсган алагдсан туулайг харчихаад: “Цастай жишим цагаан царайтай, цустай зүйрлэм улаан хацартай бүсгүй байдаг уу?” гэж асуухад ойрадын Хутхай Тафу хариуд нь : “Байлгүй яахав дээ“ гэжээ. –“Хаана, хэн гэдэг бүсгүй байна? Уулзаж учирч болох уу?” хэмээн хаан лавлахад “ Хэрвээ та үнэхээр үзье гэвэл өөрийн хүү Дүүрэн хунтайжийн эхнэр, чиний бэр Өлзийт гуайг хараарай“ хэмээжээ. Бэрийнхээ гоо үзэсгэлэнд биширсэн Элбэг хаан Ойрадын Хутхай – Тафуд хандан “ Үзээгүйг харуулж, холыг ойртуулж, хүслийг хангасан Тафу минь чи л тусалж үз! “ гээд явуулжээ. Тэрбээр Бэгз /Өлзийт – гуа/ хатантай уулзаад: -“Таны гоо үзэсгэлэнг хараад ирэхийг хаан надад даалгасан“ гэхэд, Бэгз хатан догшрон уурлаж: “Тэнгэр газрыг нийлүүлж болох уу, хаан эцэг бэрээ эхнэр болгож авч болох уу? Төрүүлсэн эцэг нь хар нохойд хувилсныг хүү нь үзэг“ – гэжээ. Бэрийнхээ хэлснийг хайхралгүй хаан эцэг нь төрсөн хүүгээ алаад, бэрээ эхнэр болгон

авчээ.

Үүний дараа Тафу Элбэг хаанаас алдар цол горилон уулзахаар очиход, хаан гэртээ байсангүйд хүлээж суухыг Бэгз хатан мэдээд элч явуулж, хүрээд ирэхийг гуйжээ. Тафу хатны өргөөнд яваад очиход Бэгз хатан дарс аягалан барихдаа: “Чи дорд намайг дээш өргөмжлөн, өчүүхэн биеийг аугаа ихэд хүргэж, Бэгзийг хатан – захирагч болголоо “ хэмээгээд хоёр тасагтай ширмэн дашмаг гарган нэгэнд нь ус, нөгөөд нь хатуу дарс уудлаад өөрөө уснаас нь, Тафуд дарснаас аягалсаар унагаав гэнэ. Согтож унасан Тафуг унтлагын өрөөнд хивс дэвсэн, дэр тавиад, хөшиг татан орон дээр хэвтүүлээд, хатан өөрөө үсээ сэгсийлгэн, нүүрээ шалба маажгаад хааны араас элч явуулжээ. Хааныг ирэхийн өмнө Тафу сэрээд зугатаж амжив. Гэвч мөрдөн мөшгөсөөр барилцаж авахдаа хаан чигчий хуруугаа таслуулжээ. Тафуг алаад суран бүсийг нь таслан хатандаа илгээхийг хаан Сөнөдийн Жамин Тайфуд зарлиг болгожээ. Бэгз хатан Тафугийн өөхийг хааны цустай хутгаж долоогоод: “Хүүгээ хороосон хааны цус, миний нөхрийн үхлийг ойртуулагч Тафугийн өөх хоёр нийлж надад бэлэг болсон нь эм хүний өшөө авсны тэмдэг болой! Одоо би үхэхэд гомдолгүй “ хэмээн хараажээ. Өөрийн хийсэн нүгэл хилэнц, Бэгз хатны үзэн ядахыг хаан мэдэвч, энэ талаар үг ч цухуйлгасангүй. Харин Тафугийн хөвүүд Батула - Чинсан, Үгүч - Хишигт хоёрт дөрвөн түмэн ойрадуудыг захирах эрх олготол, тэд 1399 оны могой жил буюу Элбэг хааны ширээнд суусны зургаа дахь жилд түүнийг алаад дөрвөн түмэн ойрадыг таслан авч салан нүүж, эвлэршгүй дайсан болон хувирчээ. Ийнхүү монголчууд төрийн эрхээ ойрадуудад алджээ” [7].

Юань улсын сүүлчийн эзэн Тогоон – Төмөрийн жич хүү, Чингисийн удам Элбэг хаанаас ойрадууд засгийн эрхийг булаан авахын өмнө бүр 1390 онд Лалын шашинтнууд тэднийг Калмаки /Халимаг/ гэдэг байжээ. Харин Оросын тооллын бичигт “Калмык” [8] гэдэг үг 16-р зууны үеэс л дайралдах болсон юм. Нэрт монгол судлаач В. Л. Котвич “Оросын болон гадаадын ном зохиолд баруун монголчуудыг гурван янзаар нэрлэж иржээ. Монголын сурвалж бичгүүдэд ойрад, эртний Оросын болон лал шашинтны сурвалж бичигт халимаг, Хятадад өөлд хэмээн нэрийджээ” [9] - гэжээ. Гэхдээ ойрад гэдгийн нарийн утга тодорхойгүй юм. XVII зууны үед Ижил мөрний хавиар нүүдэллэн очсон ойрадуудыг халимаг гэж бид нэрлэсэн бөгөөд 18-р зууны эхний хагаст энэ үг нь “гадны” гэсэн утгатай байсан бололтой. Халимагуудын дунд олон жил ажилласан Оросын дипломат, орчуулагч Василий Бакунин: “... хошууд болон зүүнгарчууд өөрсдийнхөө ижил торгуудыг халимаг гэдэггүй харин ойрад хэмээнэ. Харин Торгуудууд өөрсдийгөө болон хошууд зүүнгарчуудыг хэдийгээр халимаг хэмээн нэрийддэг боловч тэдний хэлэнд энэ үг байдаггүй бөгөөд үнэндээ Татарууд “бүдүүлгийн дээд бүдүүлэгчүүд” гэсэн утгатай татар үгээр эдгээр аймгуудыг нэрлэснийг оросууд зээлдсэн бололтой” [10] гэжээ. “Калмык” гэдэг нэр монгол хэлний “халих, асгарах” гэсэн үйл үгнээс үүсч “орон дэлхийгээр хальж, түгсэн” [11] хүмүүсийг нэрийджээ гэсэн өөр нэг таамаглал бий.

XIV зууны сүүлээр өрнөсөн дээрх үйл явдлаас үүдэн Баруун Монголын ойрад аймгууд, өөрсдийгөө халх монголчууд хэмээдэг зүүн монгол хэлтэн аймгуудын хооронд тэрсэлдэх үндсэн шалтгаан болжээ. 1425 онд их эзний суудалд Адай хаан заларсныхаа дараа урьдийн өш хонзонгоо санан бүх монголчуудыг нэгтгэн ойрадын эсрэг дайлаар морджээ. Монголын Шигшүдэй баатар, Ойрадын Гуйланчи баатар хоёр гардан тулалджээ. Шигшүдэй баатар эрдүү цавчигч /”Намайг цавчихад дуулга өмссөн, өмсөөгүй нь ялгаагүй”/, Гуйланчи баатар

мэргэн харваач /Намайг харвахад хуяг өмссөн өмсөөгүй нь ялгаагүй “/ байжээ. Тэгээд ч Шигшүдэй гурвантаа давхарласан хуяг, ойрадын баатар доторлосон дуулга өмсчээ. “Миний илдний хурцыг одоохон амсана” гэж хашгираад Шигшүдэй довтлон дайрч Гуйланчийн толгойг тас цавчив гэнэ. Ийнхүү монголчууд ойрадыг бут цохиод, тэдний хаан Тогооныг олзлон хоньчин болгожээ. Тэнгэрийн зарлигаар ялагдал хүлээв хэмээн хүлцэн эвлэрсэн Тогоон байн байн тэнгэрт залбиран мөргөхөд түүнийг өрөвдөөд монголчуудыг зүхэн муу ёрлож:

Ноход улин хуцаж

Морьд янцгаан хуйларч

Монголчууд уйлж хайлна –хэмээжээ.

Адай хаан дайснаа ялаад Тогооны эхийг эхнэрээ болгон авсны дараа хүүгээ суллан нутагт нь буцаая хэмээн гуйсаар зөвшөөрүүлж чаджээ. Тогоон нутагтаа очоод ойрадын дайчдыг дахин цуглуулж, монголчуудыг довтлон Адай хааныг алжээ. Тогоон 1418-1440, Эсэн 1440-1455 онуудад Халх монголчуудыг эсэргүүцэн тэмцэхдээ ихээхэн амжилт олжээ. Үүний дүнд “Монголын нэгдсэн төр ойрадын гарт орж “Эсэн хэсэг хугацаанд Монголыг өөрийн захиргаанд нэгтгэж чадлаа. Тэрбээр Гуйланчи баатрын толгой цавчсан илдийг Шигшүдэйгээс булаан аваад нэр цуутай арван монгол дайчдын хамтаар түүнийг цаазалжээ. Тэр цагт эрэгтэй хүнийг цаазлахдаа “Сээрийг нь шаагаад өг!”, эмсийг “Үсийг нь самнаад өг!” хэмээн тушаадаг байжээ.

Тогоон өөрийн бардам зангаас амиа алджээ. Тэрбээр Чингисийн цагаан өргөөн дэх бунханд нь мөргөхөөр очоод ”Хаан ширээг авлаа” гэж сагсууран чанга хашгираад эзний шарилыг цохижээ. Тэгээд гарахыг завдан эргэтэл ам хамраас нь цус садран асгарчээ. Тэрбээр мориндоо мордон дэлнээс нь зуурч “Юу гээч болов “ хэмээн үглэн явлаа. Гэтэл саадагны нүхээр нэвт харвасан бүргэдийн живэртэй сумыг даган цус олгойдсоор байлаа”. Ийнхүү Тогоон тайж 1440 онд Хятад руу дайлаар мордохын өмнө бусдын гарт /монгол юм уу, хятадын / амь үрэгджээ.

Эсэн хаан Манжуурт хуйхуучуудтай дайтсаар Хятадад халдан довтолжээ. Нэгэн аяны үеэр Эсэн хааны дотны хүмүүн Хятадын эзэн хааныг ойрадууд олзлон авлаа гэж зүүдэлснээ ярихад “Тиймээ, олзлогдоно” хэмээн тэрбээр хариу өчжээ. Тэгээд ч 1449 онд Эсэн хаан Мин улсын эзэн хаан Ин–Цзуныг олзлон авчээ. Хятадууд харийханд олзлогдсон тэнгэрийн хөвүүнээ үл таашаан өөр хүнээр хаан орыг залгамжлуулжээ.

Эсэний энэхүү ялалт Чингисийн сүүлчийн удам Дайду хааныг монголын төрийн эрхээс зайлуулж чадсанд оршино. Гэвч Эсэн тийм ч удаан хаанчилж чадсангүй. Үймээн самуун дэгдээсэн хамтран зүтгэгчиддээ бут цохигдон хээр талд явган оргон зугтаж яваад баригдан алуулжээ. Ийнхүү Нэгдсэн Монгол гүрэн дахиад үгүй болж, Монгол, Ойрадын эзэмшил Баруун, Зүүн монгол хэмээн олон жижиг, ван хануудын эзэмшилд хуваагдав. Юань улс унасан цагаас хойш Баруун Монголыг Цоросууд эзэгнэж байх үед л Цоросууд дээд тэнгэрийн гаралтай гэгдэх домог үүссэн байж болох талтай.

Дээрх үйл явдлуудаас хойш Монгол гүрэн дахин нэгдэж чадсангүй. Хүчирхэг хаант төртэй нэгдсэн улс байхыг мөрөөдсөн олон түмний хүсэл нь дундад зууны монголын аман зохиолын сонирхолтой, онцлог сэдэв болжээ. Эрт урьд цагт ганц сүүлтэй, мянган толгойтой, мянган сүүлтэй, ганц толгойтой хоёр могой байжээ. Ухаантай мянган толгой, унхиагүй мянган сүүл хоёрын аль нь хэрэгтэйг батлах хэмээн маргалджээ. Нэгэн удаа замаар довтолгон явсан ачаатай тэрэгний өмнүүр улаан зам дээр нөгөө могойнууд бяц даруулах аюулд учирмагц айж сандарсан олон толгой нь тал тал тийшээ зүтгэсээр няц дайруулжээ. Харин мянган сүүлтэй могой нь ганц толгойгоо даган замаас зайлж амь аврагджээ.

Ийнхүү: Хоёр нар мандвал

Ариун ус ширгэнэ

Хоёр хаан эзэгнэвэл

Ард олон үгүйрнэ. – гэдэг зүйр үг гарчээ.

Олон зуун жилийн турш монголын олон аймгууд хаан, жонон, ноёд, тайж, зайсан нарын хоорондын тоглоом болон түүхийн хүрдэнд нухлагдсан боловч Монгол түмэн сөнөсөнгүй. Галдан Зүүн гарын хаан болсон тэр үед энэхүү арцалдаан туйлдаа хүртэл даамжирч, түүний үр дагавар нь монголчууд болон ойрадуудад зовлон гачаал тээж иржээ.

Гуравдугаар бүлэг

Найр наадмын нар гийлээ.

“Сарны гэрэл “

Эсэн хааныг үхсэний хойно, XV зууны хоёрдугаар хагасаас XVII зууны эхэн үеийн Ойрадын талаар сурвалж бичигт тун ч бага тусгагджээ. Энэ үед Ойрадууд “Баруун зүгт Зайсан нуур, Хар-шаар хот, зүүнтээ Хангайн нурууны баруун бэл, өмнө зүгт Турфан, Бархөл, Хами хүртэлх их хязгаар нутагт нүүдэллэн” амьдарч байжээ. Харин ”хойт хязгаар нь Хар Эрчис, Горлос мөрний эхээр нүүдэллэдэг хасаг, киргис зэрэг бусад аймгуудын эзэмшлийн өмнөд талаар нутаглаж байлаа”. [1] Дорноос баруун зүгт хойдууд, торгууд, цорос, дөрвөд, хошуудын ойрад аймгууд дараа дараалан нүүж суурьшжээ [2]. 15-р зууны сүүлчээр ойрадууд монголчуудын захиргаанд нэгдэв. Монголын төр баригч “Мандухай цэцэн хатан урьдын өш хонзонг санан ойрадыг дайлаар мордохдоо сарлаг унасан явган цэргээрээ нүүр барин хойноос нь гурав хоногийн дараа морьт дайчдаа довтолгон...

Сайхан Мандухай хатан

Саадаг нумаа агсан

Салж бутарсан түмнээ нэгтгэн

Сайн Даяныг эзэнд өргөмжлөн ... аян дайнд морджээ

Мандухай хатан өөрийн хишигтнүүдийн нэг Алайдунгууг урьдчилан туршуулд илгээж, дөрвөн түмэн ойрадтай гэнэт тулан:

Бор чулуутад халдан довтолж

Үхэх сэхэхээ үзтэл тэмцэлдсээр

эд баялгийг олзлон бут цохижээ. Ийнхүү зургаан түмэн монгол ойрадыг эзлэн авчээ” [3].

Мандухай цэцэн хатны нөхөр Даян хааны захиргаанд орсон ойрадуудын зарим хэсэг нь түүний цэргийн бүрэлдэхүүнд багтан туслах хүчин болж, Баруун түмнийг дайлаар мордоход оролцов.

XVI зууны үед дорнод /зүүн/ монголчууд хэд хэдэн удаа ойрадуудыг амжилттай довтолж /1562-1574 он/ хэдэн жилийн дараа төр баригч Автай тэднийг бүрмөсөн бут ниргэж, өөрийн хүүгээ Ойрадын хаан ширээнд суулгажээ. Ойрадууд Турфан болон хөрш хасгуудад бас л цохигдсоор байв. Гэвч 1578 онд Байбагас-хаан тавин мянган хүнтэй цэргийнхээ хүчээр Эрчис мөрний Мааньт гаталганд Халх Монголын наян мянган цэргийн хүчийг бут цохижээ. Мөн XVI зууны сүүлээр ойрадууд Оросын цэрэгт цохигдсон хаан Хүчүлэгийн Халх монголчуудын үлдэгдэл хүчийг устгажээ.

Сибирь дэх тагаарын хаанчлал сүйрч, ойрадууд Ишим, Оми голын эхээр хойшлон нүүдэллэх боломжтой боллоо.

Энэ үеэс эхлэн Ойрадын Зүүн гарын хаант улс бэхжиж, шинэ нутаг дэвсгэр эзлэн, ойрадуудад тарж нутагшихын эхлэл тавигдсан нь ХҮI зууны сүүл, ХҮII зууны эхэн үеэр Дорнод /зүүн/ болон Төв Азид шинээр төр улсууд үүсэн гарч ирсэн “давалгаатай” давхацжээ. Олон зуун жил үргэлжилсэн энэхүү түүхэн үйл явцыг тоймлон үзвэл манай эриний II зуун хүртэл Хүннү гүрэн бүрэлдэн тогтож, МЭ-IV зуун гэхэд Сяньбийн төр улс байгуулагдан IV-VIII зууны Түрэг, бохай, солонгос, нанхиад, төвд, япон, уйгарын улс, IX зуунд Киргисийн, X зуунд Кидан Тангадын, XII зуунд Жужаны, XIII зуунд Монголын, XVI-XVII зуунд Манж чин, Ойрад, Хасаг, Анжааны төр улс байгуулагджээ.

1635 он бол Зүүн гарын хаант улс эмхлэгдэн тогтсон сүүлчийн жил юм. Энэ үе хүртэл хэдэн арван жилийн туршид хошуудын Байбагас, Гүүш хаан, цоросын Хар-хул /Галдангийн өвөг эцэг/, Баатар хун тайж /Галдангийн эцэг/ нарын хоорондын тэмцэл тасраагүй билээ. 1608-1609 онуудад Увс, Хөвсгөл нуурын хоорондох нутгийг эзэмшиж байсан Монголын хаант улсын төр баригч Алтан хааныхныг ойрадууд бут цохив.

XVII-зууны эхний 30-аад жилд дотоодын эмх замбараагүй сөргөлдөөн, ойрад аймгуудын нэгдмэл шахалт хавчилтын улмаас монголчууд баруун зүгт Ногайн тал дээр, зүүн зүгт Хөх нуурт нүүдэллэн тархжээ. Ойрад, дөрвөд, торгуудын хэсэг нь Хоо-өрлөг ноёныг дагалдан /1628-1630/ Ижил мөрний зүг нүүдэллэн очиж, ойрадын нэгэн аймаг байгуулсан нь хожмын Халимагийн удам угсаа болжээ. Анх нүүдэллэн хүрсэн ойрадууд Ижил хавийн орос тосгодын талаар: ”Мал сүрэг нь гахай зонхилон, газар шороогоор сууцаа босгодог, эмс хүүхнүүд нь шалбуур өмдгүй, худал хэлэхээсээ айж ичдэггүй, унаа хөсгөөр удаан явахдаа ядардаггүй хүмүүс энд амьдран суудаг ажээ. Цэнхэр нүдтэй учраас худал хэлэхээс ичдэггүй, тэргээр аялж явдагаас ядардаггүй бололтой гэж Хоо-өрлөг ноёны туршуулууд хаандаа мэдээлж байв” [4] хэмээсэн байдаг.

Хошуудууд Төр-Байх /Гүүш-хаан/-аар удирдуулан 1636-1638 онуудад Хөх нуурын хавиар нүүдэллэн очиж суурьшив. Зөвхөн Зүүн гар л цоросын мэдэлд хоцорчээ. “Манж Чин улс оршин тогтносон анхны жилүүдэд ойрад аймгууд цэцэглэн хөгжиж, хүн ам олшрон, хэсэг бусгаар тарж хуваагдаж эхлэв. Шар мөрний “тохойноос” баруун зүг рүү суурьшин малжиж байсан ойрадуудыг “Тао” буюу “Шар тохойн-харийнхан”, Хөх нуурийн орчмоор нутаглагчдыг “баруун нуурын хайжихууд”, Тэнгэр уулаар амьдрагсдыг Хойд ойрадууд хэмээжээ” [5].

Хэлань-шань уулсын араар нутагладаг Алшаагийн ойрадууд нь Ижил хавийн халимаг-ойрадуудаас салан тусгаарлагдсан бие даасан гурав дахь аймаг юм. Алшаагийн ойрадыг Гүүш-ханы ууган хүү Очирт-хан захирч байв. Ийнхүү Ижил орчмын ойрад-халимагийг тооцохгүйгээр ойрад аймгуудын үндсэн гурван бүлэг нь Байбагас-ханы захирсан хошуудууд, Хар-хулаар толгойлуулсан цоросуудтай тэмцэлдэж байжээ.

Энэ үед ойрадууд Төвдийн хэрэгт хөндлөнгөөс оролцох нь мэдэгдэхүйц нэмэгдэв. Тавдугаар Далай ламын толгойлсон шарын шашны бүлгийнхэн дотоодын хямралдааныг ойрадуудын дэмжлэгт горилон зохицуулахыг оролдов. Ийнхүү ойрадын цэргүүд Төвдөд цөмрөн оржээ. 1638 онд Гүүш хан мөргөл үйлдэхээр Төвдөд ирэв. Тавдугаар Далай-лам түүнийг Лхасын гол

сүм Будал ордонд будда бурханд мөргүүлж “Буддаг ивээгч итгэлт хан” хэргэм өргөмжилжээ. 1639-1640 онуудад Төвдөд цөмрөн орсон Гүүш хан 1642 онд Төвдийг захирах эрхийг Далай ламд ёслол төгөлдөр шилжүүлэв. 1660 онд Гүүш ханыг нас барсны дараа хөвүүд нь эзэмшил нутгаа хуваан Даян хаан Төвдийн төв хэсгийг, Даш-баатар Хөх нуурыг эзэгнэжээ.

XVIII зууны дунд үе гэхэд монгол хэлтэн аймгуудын дотроос Ойрадын Баатар хунтайж, Чингисийн тамгыг барьсан цахарын Лигдэн хаан хоёр товойж гарлаа. 1636 онд манж нар Лигдэн хааныг бут цохиж, Чингисийн тамгыг олзлон авчээ. 1640 онд Манжийн аюулыг сөрөн тэмцэхийн тулд Ойрад, Халх-монголын ноёдын нэгдсэн хуралдаан болж, Монгол Ойрадын хуулийг баталсан боловч Монгол хэлтнийг нэгтгэж чадсангүй.

Зүүн гарын хаан Баатар хун тайжийг Оросын Петр I-тэй зүйрлэдэг. Тэрбээр хот маягийн суурингууд байгуулж, гар урлал газар тариаланг хөгжүүлж эхэлжээ. Оросын элчин Федор Байков Ойрадын ийм нэгэн суурингийн талаар: “Бурхан өрсөн хоёр чулуун сүмд лам нар суух бөгөөд намхан шавар байшингууд, тарианы хагалсан талбай бүхий жижиг суурин”[6] хэмээн бичжээ. Энэ нь эргэн тойрондоо хагалсан газар үргэлжилсэн Буддын газар байв. Баатар хун тайж эдгээр суурингийн ойр хавиар урьдын адил нүүдэллэн амьдарч байлаа. Тэрбээр Оростой найрсаг харилцаагаа үргэлжлүүлэн 1652 онд хасагуудыг эрхшээлдээ оруулав.

XVII зууны эхний хагаст Зүүнгарын улсыг бэхжүүлэхэд соён гийгүүлэгч Зая бандида онцгой үүрэг гүйцэтгэв.

Ойрадууд бурханы шашныг чухам хэдийд авсан нь шинжлэх ухаанд тодорхойгүй. 16-р зууны үед Өмнөд монголын төр баригч Алтан хааны үед 2 дахь удаагаа монголчууд бурхан шашинд бүрэн оржээ.

1610 онд дэг жаяг баримтлан Сайн тэмнэ /Мэргэн Түмэн/ шарын шашинд орохыг Байбагас хаанд санал болгов. Ингээд Ойрадын бүх хаад нэг нэг хөвүүнээ гэлэн болгохоор санваар хүртээн Төвдөд явуулахаар тогтоход Байбагас хаан хошуудын ноён Байвханаас хөвүүнийг нь өргөж аваад тэдний хамт явуулсан нь ирээдүйн Ойрад түмний их соён гэгээрүүлэгч Зая бандида Намхайжамц байжээ. 17-р зууны дунд үеэс Ойрадууд шарын шашныг үнэнчээр сүслэн дээдэлдэг болоход “Бүхнийг энэрэгч Равжамба Зая “ онцгой үүрэг гүйцэтгэсэн билээ. Тухайн цаг үедээ гүнзгий боловсролтой, авьяаслаг энэ хүн Төвдөөс буцаж ирснийхээ хойно Яик, Эрчис гол, тал хээр, хөх нуур, Төвд гээд л газар сайгүй аялаж хүн зонтой уулзаж учирч явжээ. Тэрбээр Төвдийн ариун номлол сургаалаас олон тооны зохиол төрөлх хэлэндээ орчуулж жирийн түмэнд хүртээл болгохыг зорьжээ. Гэвч монголын хуучин утга зохиолын хэлийг ойрадууд тэр бүр ойлгоход бэрхшээлтэйг харгалзан 1648 онд “Тод бичиг” ийг зохиожээ.

Шинээр зохиосон цагаан толгойн монгол бичгээс ялгаатай тал нь үсэг бүр тодорхой тэмдгээр илэрхийлэгддэг тодорхой дүрст үсэг байлаа. Ийнхүү “Тод бичиг” ээ зохиож төвд хэлнээс ойрад аялгуунд 170 гаруй ном зохиол хөрвүүлжээ. Тэрбээр “Харын мөргөл” бөөгийн шашинтай шаргуу тэмцэн, шарын шашиныг идвэхийлэн дэлгэрүүлж байлаа [7].

Эрт цагт нэгэн ойрад бүрлээч болоход төрөл төрөгсөд нь талын будда шашинтны ёсоор шувуу араатанд идэш болгон хээр талд ил тавьжээ. Бүрлээчийн сүнс биеэ орхин доод тивд Эрлэг

хаанд очжээ. Цаашдын хувь заяагаа хэрхэхээ хүлээх зуураа нэгэн гайхалтай явдалтай учирчээ. Эрлэг хаан түүнийг хүлээлгэж хүлээлгэж уулзаад:

-Чи газартаа буцаж очоод энд сонсож дуулснаа хүмүүст хэлээрэй. Чи түүнийг зөвшөөрч ам өгвөл одоохон чамайг буцаана. Гэхдээ нэгэн удаа чам дээр гэлэн хүн очиж уулзтал хэнд ч, юу ч ярилгүй, хэлгүй царайлан яваарай гэжээ. Тэгээд цасан шуурга шамаргалсан нэгэн шөнө бүрлээч гэр орондоо буцаж ирэхэд төрөл садан нь сандран балмагджээ. Гэтэл яг л урьдын хэвээрээ ч, хэлгүй болчихсон байв гэнэ. Ийнхүү орон гэртээ буцаж ирснээс хойш яг дөч хоноход нэгэн шөнө нөгөө гэлэн гэнэт орж ирээд, аягалсан цайг уучихаад:

-Сонин хачин зүйл яриач гэжээ. Хэлгүй гэнэт дуу ороод хайлж эхэлсэн нь Жангарын туульс байжээ. Ойрадын аман зохиолын сувд эрдэнэ болсон энэ алдарт туульс ийнхүү зохиогдсон домогтой.

Дэлхийд гайхагдсан ойрадын алдарт Жангар XVII зууны үед зохиогдсон бололтой. Туулийн үйл явдал Зүүн гарын газар нутагт өрнөдөг юм. Зая бандида болон түүний хамтран зүтгэгчдийн бүтээлүүд Жангарын туульс зохиогдох эхлэлийг тавьжээ гэсэн таамаглал ч бий.

“Жангар бол хүн төрөлхтний түүхэнд гарсан уран зохиолын том бүтээл бөгөөд Зая бандидтай салшгүй холбоотой билээ. Түүний бүтээсэн утга зохиолын хэл, найруулга, соёл, уламжлалгүйгээр Жангарын туульс нь гайхамшигтай сайхан нарийн нягт бүтээл болж чадахгүй байсан юм”[8] гэж Н.Н.Поппе тэмдэглэсэн ажээ.

Зүүн гарын улсын төрийн тогтолцоо, ойрадын нийгмийн байгууллын талаар түүхэн баримт ховор учир тун бага судлагдсан юм. Ойрадуудын үндсэн баялаг нь мал юм. XVII зууны Европын нэг жуулчин: ”Тэд адуу, сарлаг, одос үхэр, хонь маллан ашиг шимийг хүртэхийн зэрэгцээгээр 8-10 мянган адуун сүрэг Хятадад гаргаж цалин цагаан мөнгө, эд агуурсаар сольж арилжина. Мөн л ийм тооны адуу тууж Тобольск, Томск хот орж, булигаар, зэс тогоо, гуулин аяга, төмөр, хамгийн үнэтэйд тооцогддог халиуны арьс зэрэг бараагаар арилжаа хийдэг”[9] хэмээн бичжээ. Ойрадууд гэр бүл, төрөл саднаараа хот айл болон нүүдэллэн амьдрах бөгөөд “ах” гэгдэх ахлагч толгойлно. Хэд хэдэн хот айл нийлж аймаг болно. Аймаг өөрийн нутаг билчээртэй, аймгууд нэгдэж улс болно. Улсыг тайж, хун тайж удирдаж, нэгдсэн улсыг хаан толгойлно. Улсын иргэд нь цэргийнхэн, жирийн харчуул, боол шивэгчидэд тус тус хуваагдна. Боол шивэгчид нь өөрийн угсаатны болон харийн хэмээн ялгагдана. Жирийн иргэд албан журмын алба гүйцэтгэнэ. Шарын шашны сүм хийдийн дэргэд шавь нар хэмээгдэх албат мал маллаж, хар бор ажлыг нь амжуулна.

Цэргүүд нь зохион байгуулагдсан 10000 хүнтэй, “сан” хэмээх хэсгүүдэд хуваагдаж, үндсэн зэвсэг нь нум сум, жад болой. Морьт цэргүүд дуулга малгай, хуяг өмсөнө. Г.В.Вернадскийн тооцсоноор ХҮИ зууны үед ойрадууд нийтдээ 100000-с доошгүй морьт цэрэгтэй [10] байжээ. Морьт дайчид цэргийн голлох цохих хүчин байсан бөгөөд ХҮИ зууны үед галт зэвсэг ялангуяа их буу хэрэглэж эхэлснээс түүний ач холбогдол буурчээ. Гэхдээ ХҮИ зууны дунд үе хүртэл Төв Азийн нүүдэлчин аймгууд их бууг хэрэглэдэггүй байлаа. Галданг ертөнцөд мэндэлсэн тухайн үед их бууг бараг мэддэггүй, хэрэглэж чаддаггүй байжээ. Галданг төрсөн жил Хятадад Бээжингийн дарангуйлал унаж, Манжийн хаанчлал эхэлсэн үе юм. Үүнээс 50-иад жилийн өмнө нум сум, хүйтэн зэвсгээр зэвсэглэсэн манжийн морьт цэргүүд, их буу бүхий хятадын

цэргийг довтолон Ляодун хотыг булаан авч Бээжин хавийн нутгийг цөлмөн, алслагдсан нутгийн гүний ард иргэдийг түйвээж байлаа.

Төв Азийн нутаг дэвсгэрийг эзэмших тухайн үеийн үйлдвэрлэх хүчний хөгжлийн хамгийн тохиромжтой хэлбэрийг нүүдэлчний соёл иргэншил бүтээсэн юм. Энэхүү соёл иргэншил нь цаг уурын хагуу ширүүн нөхцөл, гадны аюулыг уян хатан зохицуулах боломжтой, нарийн зохион байгуулагдсан, амьдрах чадвар бүхий байгуулалт байв.

Эсгий туургатны нүүдэл, малын хөлийн тоос, малчдын хүнд бэрх хөдөлмөр, дотоодын байнгын хямралдаан зэрэг нь хөрш зэргэлдээх суурьшмал аймгуудад аянгын ниргээн адил гай тарихаар байв.

Ийм цаг үед Галдан Бошгот хаан төржээ.

Дөрөвдүгээр бүлэг

Хүү минь хүү минь

Хүн болон дахин төрөөрэй

Ондоон газар очоод

Огт өөр хүн болоорой

Кукай

Алтай, Тэнгэр уул, Их говийн хооронд орших уудам нутагтай Зүүн гарын улсад Галдангийн бага нас өнгөрчээ. Айл бүр аль нэг хөвгүүнээ сүмд шавилан суулгадаг ойрад ёсоор Баатар-хунтайж зургаа дахь хөвүүн Галдангаа “Амилсан бурхан” буюу “бүрэлбай”[2] нэрээр лам болгон Түвдэд суралцуулахаар явуулжээ. Ойрадууд шарын шашны эх оронд хүрэхийн тулд Зүүн гарын улсаас гарч Нань-Шаны хойд салбар уулсыг даван Хөх нуурын зүгт дорнод тийш аялан тэндээсээ баруун өмнөд чигт Цайдамаар дамжин Нагчук хүрээд Цанглагийн давааг даван Лхас ордог замыг хэдэн сарын турш туулдаг байлаа.

...Ойрадчуудын ачаа хөсөг Зүүн гарын улсын хамгийн тохиромжтой цаг намар гараагаа эхэлжээ. Халуун ч биш, хүйтэн ч биш сэрүүвтэр, жихүүн салхи, шороон шуургагүй үе билээ.

Төвдийн ариун шүтээнд өргөх Зүүнгарын иргэдээс цуглуулсан эд баялаг, мөнгө ачсан хөсөг говийн чулуурхаг замаар аажуу тайван цувран өөртэй нь хамт шавилан суухаар яваа ойрад, киргиз хүүхдүүд дуугүй бодлогошрон явааг тэмээ унасан бяцхан Галдан ажигласаар эцгийн өргөө гэр, үдэж гаргасан эх, ах дүүсээ эргэн санаж уйтгарлана. Галдан эцэгтэйгээ уулзахаар өргөөнд нь ороход аугаа их багш Зая Бандида Намхайжанцан сууж байв.

-Богд лам минь, би зургаа дахь хүү Галдангаа ариун шашинд зүтгүүлэхээр шийдлээ, -хэмээн эцэг нь хэлжээ.

Зая Бандида хүүг ойртож суухыг хүсээд мөрөн дээр нь гараа тавиад намуухнаар: -Галдан чи гэлэн болохоор шийдэв үү?-гэхэд

- Үгүй, би адуучин, эсвэл цэрэг болмоор байна.

- Дуугаа тат! -хэмээн торгон олбогон дээр суугаа эцэг нь уурлан өндөсхийв.

- Бухимдаад яахав, хаан минь! Би ч багадаа банди болох дургүй явсан билээ. Тэр үедээ Байбагас-баатар, ойрадын бусад ноёд аль нэг хөвүүнээ банди болгодог байв. Байбагас-баатар өөрийн хөвүүнээ Төвд явуулахаас цааргалан намайг дуудаж “Миний хүүгийн оронд банди болоорой” хэмээн зарлиг буулгаж, би 17настайдаа [3] Манзушир-хутагтад шавь орж билээ. Гэтэл 6 ойндоо хүрч ядан яваа бяцхан хөвүүнийх зөв байлгүй яахав - хэмээжээ. Эцэг нь санаа зовон суухыг Галдан ажиглажээ. /Аугаа их багш бусдын шахалтаар лам болсноо ярьсанд Баатар-хунтайж итгэсэнгүй бололтой/.

- За, хөвүүн минь явж үз! Бурхан шашин, эх болсон зургаан зүйл хамаг амьтны тусын тулд ариун ном судлан орчуулж, Их багш шигээ хүн болоорой - гэв.

- Аугаа их сургаал үүрд мөнх дэлгэртүгэй! - хэмээн Зая-Бандид айлдаад хөвүүний толгойг илээд гаргажээ.

Галдан эхийнхээ өргөө рүү гүйн ороход тулганд гал дүрэлзэн, чанасан мах, шинэхэн айргийн үнэр ханхийнэ. Эх нь нулимс дуслуулан байж, хүүгийнхээ алсын аяны бэлтгэлийг базааж эхлэв. Хөвүүнээ номтой гэлэн юм уу, хутагт болно хэмээн бодохоор баярламаар ч, аяны хүнд бэрх холын зам туулан олон жилээр уулзахгүйг бодохоор сэтгэл шимширнэ. Бяцхан Галдан сэтгэл зовоосон энэ явдлыг дорхноо мартчихаад үеийн хөвүүдтэй тоглож явахад, хөөрхий эх нь нүднээсээ бөмбөрөх бөөн бөөн нулимсаа хятад торгон алчуураар байн байн арчиж, хөвүүнийхээ асрагчид захиас хэлнэ. Өнөөдөр л уйлж авахгүй бол маргааш өглөө хаан-эцгийн нь дэргэд нулимс гаргаж болохгүй. Галдан хөвүүн тэмээнд мордсон хойноо л өргөө гэр, эхээ орхин явахаа ойлгов гэлтэй. Уйлж унжсан эхийг нь эмэгтэйчүүд гэрт нь хөтлөн оруулах үед хаан-эцэг нь их л сүртэй ширтэн зогссоныг харлаа. Эхийг өргөөнд нь оруулж, хаалганы модон хавтас хаагдсаны дараа эцэг нь “хөдлөөд” хэмээн хашгираад хөсөг аян замдаа хөдлөн бяцхан Галдан дуу тавин уйлжээ. Энэ бол 1650 оны намар билээ. Энэ хөсгөөр Зая Бандида бас Түвдэд буцжээ.

Зорьсон газраа ирснийхээ хойно бяцхан хөвүүн аажмаар орчин тойрондоо дасаж эхлэв. Өндөр хэрмээр хүрээлэгдсэн шавар байшингууд бүхий том хот хөвүүний гайхлыг төрүүлнэ.

-Эд нар яаж нүүдэг бол ? Ийм байшинг тэмээгээр ачиж болох уу? Эдэнд мал сүрэг байна уу?- хэмээн асрагчаасаа шалгаана.

Энэ газар байнга суурьшсан, нүүдэл хийдэггүй, малаа ч бас иймэрхүү шавар хашаанд маллаж, газар хагалж амьдардаг хүмүүс - гэж асрагч нь тайлбарлана.

-Үхэр, хонь, адуу, тэмээтэй хирнээ газар хагалаад юугаа хийнэ - хэмээн Галдан гайхдаг байлаа.

1651 оны зул сард аянчид Лхаст хүрэлцэн ирж, шохойдсон 3 том байшингууд, аварга том Жокан сүм, Марпори ууланд босгосон Далай ламын орд харшийг үзээд мэл гайхсан билээ. Харин Лхаст суурьшаад нутгийн хүмүүн болсныхоо хойно хотын ойролцоох Шол тосгоноор байнга очиж, хүний уран гараар бүтсэн тэнгэр баганадсан сүрлэг барилгыг бишрэн харж зогсохдоо, их ламтаны гайхамшигт орд харшийг хэрхэн яаж босгож дуусгахыг харж амжаагүйдээ Галдан харамсдаг байжээ.

Тэрбээр Лхаст зуун арван мянган лан мөнгө тэмээн жингээр тээж ирснээ мэдээд гайхаж билээ. Будал ордон сүм зөвхөн ойрад түмний хөрөнгөөр босчээ. Цовоо, сэргэлэн, авьяаслаг Галдан хөвүүн хурдан хугацаанд төвд хэл сурч, шашны ном үзэн эрдэм мэдлэгээ тэлжээ. Зүүн гар улсын хүчирхэг хааны хөвүүнд Далай лам биечлэн санаа тавьж байнга уулздаг байжээ.

-Чи одоо эрдмийн оройд дөхөж очжээ. Нутагтаа буцаж сургааль, шашдир хөрвүүлж, бүхнийг тэтгэгч Буддагийн шашныг дэлгэрүүл! Миний төлөөөөс монгол хэлтэнгүүдэд ариун ном

орчуулан дэлгэрүүлж, эх болсон зургаан зүйл, хамаг амьтны тусын тулд зүтгэ! – хэмээн сургамжилжээ.

1653 онд Лхаст суугаа Галдан түгшүүрт мэдээ авлаа. Зүүн гар улсын төр баригч эцэг Баатар хунтайж таалал төгсчээ. Зая бандид бүрлээчийн сүнсийг дуудах ёслол үйлдээд, цогцсыг нь авсанд хийлгээд шатаажээ. Хунтайжийн үр хүүхэд, төрөл садан нь дөчин есөн хоногийн турш элбэг дэлбэг буян өргөл үйлджээ. Ийнхүү ёс заншлын дагуу үйлдлийг бүрэн гүйцэтгэсний дараа тавь дахь хоног дээр хаан ширээний төлөө дээдсийн тэмцэл буцлав.

1662 оны намар аугаа их багш Зая бандид Лхас орох замдаа тэнгэрт хальсан гунигт мэдээ түглээ. Түүний цогцсыг мөн л чандарлан Лхаст авч ирэхэд Далай лам шарил дээр нь: -Галын дөл өөдөө! – хэмээн хэлснийг Галдан-бошгот насан туршдаа мартаагүй билээ.

Далай ламын зарлигаар Зая бандидын дүртэй бурхан бүтээж, чандрыг нь бэхтэй хольж Галдан болон ойрадын бусад лам нар ариун гэрээслэл бичээд бурханыхаа шүншигт хийж аравнайлжээ. Далай-лам хутагтын дурсгалд зориулан бичсэн шүлэгтээ: “Аугаа хүчирхэг шашныг алсын бүдүүлэг Монголд дэлгэрүүлэгч” хэмээн өргөмжилжээ. Тэгээд Зая бандидын дүртэй бурханыг Зүүн гарын улсад залжээ. Хүн бүр Галдан-бошготыг Зая бандидын хойчийг жинхэнэ залгамжлагч хэмээн биширч суулаа.

Тавдугаар бүлэг

Би явахыг хүснэ

Намайг явуулахыг ч хүснэ

Ляйош Мадьяри

Баатар хунтайжийн дараа хэнийг хаан ширээнд залах талаар маргаан дэгдэж, ууган хүү Цэцэн биш, харин Галдангийн зулай даран төрсөн ах Сэнгэ нь угсаа залгамжлах болов. Ер нь Галдангийн эхэн үеийн амьдрал, үйл явдал өдий хүртэл судлагдаагүй юм. Шашин номлогч Жербильон төрийн эрхэнд Сэнгийн гарсан шалтгааныг тодорхойлох оролдлого хийжээ. Баатар хунтайж нас барсны дараа ууган хүү Өнчинд төрийн ширээ шилжжээ. Гэтэл Баатар хунтайжид ийм нэртэй хөвүүн байсан нь тэмдэглэгдсэнгүй. Ер нь тэрбээр хэдэн хүүтэй байсан нь тодорхойгүй /арав юмуу арван хоёр/. Өнчин хаан ширээг эзлээд дараахан нь киргисийг дайлаар мордох замдаа цагаан бурхан тусч, хүндээр өвчлөн дайчдаасаа хоцорчээ. Амьдралд юу эс тохиолддог ч, энэ баримт бодитой биш бололтой. Киргисүүд ойрадын орхин одсон булшин дээрээс Өнчинг олзолж аваад Ойрадын хаан хэмээн танилгүй ердийн нэгэн ноён гэж боджээ. Гэвч Өнчин үхсэнгүй, эмчлүүлэн эдгэрээд гурван жил болохдоо Ойрадын хаан гэдгээ хэлсэнгүй. Өнчингийн сураг чимээ тасарснаас дүү Сэнгэ нь түүнийг амь үрэгдсэнд тооцоод эхнэрийг нь хатан болгон аваад Ойрадын хаан болон суужээ. Энэ тухай сонссон Өнчин өөрийгөө ойрадын хаан гэдгээ киргисүүдэд ойлгуулжээ. Киргисүүд түүнээс дахин хэзээ ч өөдөөс нь довтлохгүй гэсэн ам тангараг аваад зуун цэргээр хамгаалуулан нутагт нь буцаажээ. Ийнхүү буцаж ирж байгаа тухайгаа Өнчин элч илгээн дүү Сэнгэд мэдэгджээ. Сэнгэ яах ч учраа олж ядан хатантайгаа зөвлөхөд авааль нөхөр минь буцаж ирвэл чамаас сална гэж хариулжээ. Сэнгэ нэгэнт шийдэж, Өнчинг хүндэтгэн угтах нэрээр өөрийн итгэлт хүмүүсээ өмнөөс нь илгээж, алах зарлиг буулгасныг ёсоор гүйцэтгэжээ.

Ойрад-Халимагийн түүх судлаач Ю.Лыткиний үзсэнээр Баатар хунтайж “улс гүрнээ хоёр хэсэг хувааж, Юм-Агас хатнаас төрсөн өөрийн хайртай хөвүүн Сэнгэдээ нэг хэсгийг, нөгөөг нь найман хөвүүндээ өгчээ”[1].

Баатар хунтайжийн нас барсан оны талаар ч маргаан бий. Зая бандидын намтар “Сарны гэрэл”-д Баатар хунтайжийг 1653 онд [2] нас барсан гэжээ. Үүнийг оросын эрдэмтэн И.Я.Златкин [3], Л.И.Думан [4] зэрэг хүмүүс зөвшөөрч байхад, харин Галдангийн намтар судлаач, Японы эрдэмтэн Ханада Акира түүнийг 1665 онд [5] нас барсан гэж үзжээ. Гэхдээ энэ таамаглалаа батлах оролдого хийсэнгүй. Ер нь Галдангийн намтраас үзэхэд Баатар хунтайж 1653 онд биш, арай хожуу нас нөгцсөн байж болох талтай. 1664 онд Томск хотод ирсэн ойрадын элч төлөөлөгчид Сэнгийн нэрийн өмнөөс хэлэлцээр хийсэн болохоор Ханада Акирагийн тооцсон он бодит байдалтай зөрж байгаа юм. Хэлэлцээрт Сэнгийн авга ах Цөхур-уваш, нэр нь тодорхойгүй хутагт зэрэг хүмүүс оролцжээ. Зарим судлаачид /И.Я.Златкин ч бас/ 1664 онд Галдан Түвдээс хэдийнээ буцаад ирчихсэн байсан учир хэлэлцээрт оролцсон хутагтыг гэж таамаглаж байна. Үүнээс үзэхэд Баатар хунтайж 1662 оны орчим нас нөхцөж, Лхаст энэ гунигт мэдээ түгсэн байж болох юм. Гэхдээ хэзээ нэгэн цагт он нь тодорхой батлагдах биз.

Залуу Галдан сэтгэл зүрхэндээ цэрэг эрийн замыг дээдлэн шүтэвч хутагт болох ирээдүйтэйгээ эвлэрч явлаа. Галдан өөрийнхөө эгчийн хөвүүн, нагац ах Галдамааг хүндэтгэн биширдэг байв. Галданг долоон настай байхад арван долоотой нагац ах Галдамаа нь Тэнгэр уулын киргисүүдтэй хийсэн тулаанд шалгарч нэр цууд гарчээ. Тэрбээр халз тулаанд киргисийн баатар Янгих хааныг буулган авч, аян дайнд ялах эхлэлийг тавьжээ. Залуу баатар эрийн тухай олон дуу зохиогдсоны дотроос Зүүн гарын улсын баруун хязгаарыг хамгаалагч Галдамаа ноёныг магтсан нэгэн дууг Галдан бахархан дуулдаг байв.

Хуяг дуулга өмссөн Галдамаа

Хааны ордны үүдэнд зогсном

Ханхалзуур хээр морь нь эмээлтэйгээ

Хавцал хөндийд сойлттой байнам.

Саадаг сум нь нуруунд бэлхэн

Сайн нөхөд нь амь нэгдэн

Дөрвөн настай халиунаа

Чөдөр уяанд дасгав.

Дөчин шилдэг баатраа

Дайн тулаанд бэлтгэв

Хагсааж сойсон халиунаа

Чөдөр уяанд дасгав

Харцага шонхор шувууг

Хун барихад сургав.

Галдан дуугаа сүм хийдээс холдож, хөдөө хээр гарч дуулдаг байжээ.

Галдан нутаг орноосоо түгшүүрт мэдээ авсаар байлаа. Хаан ширээ залгамжилсан ах Сэнгэ нь төрсөн ах Цэцэн тайж, Зодов баатар хоёртой эвлэршгүй муудалцжээ. Галдамаагийн эцэг хошуудын Цэцэн-хан Сэнгийг, түүний ах Авлай тайж бусдыг нь дэмжлээ. Сэнгэ хунтайж, Цэцэн хан хоёр нийлэн Авлай тайж болон түүний санаа нэгтнүүдийг бут цохисон мэдээг 1661 оны өвөл Галдан авлаа. Хорин зургаан настай байсан Галдамаа өөрийн эцэг, Сэнгэ хоёрыг ятгасаар Авлай тайж, түүний холбоотнуудаас булаан авсан газар нутаг, эд баялгийг нь буцаан өгч эвлэрүүлжээ. “Цэцэн хан, Галдамаа хоёрын шийдвэрийг бүрэн зөвшөөрч, хэрвээ авснаа буцааж өгөхөөр ам гарсан бол амласнаа нарийн чанд биелүүлэх хэрэгтэй” гэж Сэнгэ мэдэгдэв. Ийнхүү ойрадууд энх тунх амьдралд түр ч атугай шилжив.

Лхас хотноо Далай ламтай өргөөнд нь Галдан хутагт уулзжээ. Эрдэмтэн, яруу найрагч, их улс төрч, тав дугаар Далай лам шар өнгийн олбогон дээр завилан Галданг өмнөө суулгаад, хонины чанасан мах, замбаа, аагтай хятад цайгаар дайлав.

- Их багштан, та надад үнэний замыг зааж, монгол хэлээр ярьдаг ард олныг энэ замаар дагуулахыг даалгасан билээ. Би таны зарлигийг биелүүлэхээ андгайлъя. Зүүн гар улсын дээдэс, ах дүүс хоорондоо тэмцэлдэн самуун дэгдээж байгаа тухай мэдээг та сонссон биз. Таны дэргэд ч, өөрийн ах Сэнгэ хунтайжийн дэргэд ч би хутагтаараа байх болно. Би цэргийн хүн биш, гэлэн учраас ойрадын нэгэн дуугаар ая баръя гээд:

Хар морь минь явдалдаа сульдаагүй

Хатуу жад минь тулаанд мохоогүй

Хаан эцэг минь намайг явуулаач!

Бор морь минь явдалдаа сульдаагүй

Буудах сум минь тулаанд дуусаагүй

Буурал эцэг минь намайг явуулаач! - хэмээн дуулав.

Далай лам сонсож сууснаа:

- Сайхан дуу юм. Гэхдээ нас чинь бага, цус чинь шингэн, яс чинь хөнгөн ч чамайг явуулъя. Сэнгэ хунтайжийн дэргэд хутагтаар очоод, монголын хээр талд энхийг сахиулж, эрдэм ухааныхаа алдар хүндийг улам өргөж яваарай! – хэмээн ерөөв.

Цайлж дуусах үед Далай лам үүдэнд зогсож байсан ламд дохиход ойрадын хутагтад зориулсан Ванчин ламын хамраас гоожсон цусаар зурсан чойжингоор тарнидсан увидаст эмийн гавлын яс авчирч барилаа.

- Сургаал номоо дэлгэрүүлэн, сэтгэл санаагаа зориулсан түмний төөргийг харж яв! – хэмээгээд Далай лам Галданд бэлгээ барихад тэрбээр их л хүндэтгэлтэйгээр үнэт шүтээнийг гардан аваад:

- Би үүнийг Зүүн гар улсын хамгийн том хийдэд залж, алт мөнгөөр бүрье!-гэв.

Тавдугаар Далай лам Зүүн гар улсад төлөөний хүнээ суулгах хэрэгтэй байснаас, өөрт нь хязгааргүй үнэнч, сэргэлэн залуу хутагт тун таалагджээ.

Галдан Төвдөөс орон гэртээ буцаж ирэхэд ах Сэнгэ нь баярлан золгож: “Миний энхрий дүү минь, чи бидний баяр бахдал, хурдан бүргэд билээ! Чи хадат уулсын оройгоор архиран тэнэх хар эрээн барс, ард олны зүрх сэтгэл билээ! Чи цэнхэр уулсын оргилоор шунгах хүрэн элээ, ард олны зүрх сэтгэл билээ! Галдан минь, чи ингээд хүрээд ирлээ дээ!” – хэмээн уулга алджээ.

Оросын сурвалж бичгүүдэд 1664 онд Галдан Сэнгийн дэргэд ирсэн хэмээжээ. Ламын шашны дэг жаягаар Галдан улс төрийн амьдралд идэвхийлэн оролцов. 1668 он 4-р сарын 6-нд Галдан Оросын элч В.Былиныг хүлээн авч уулзаад, өөрийн үүргээ тодорхой тайлбарлаж: - Би хаан биш, цэргийн хүн ч биш, хутагт бөгөөд миний хир хэмжээнд хөрш орны элчинд мэдэгдэхэд одоо бид Орос улстай эв найртай, нөхөрсөг харилцаатай учраас урьд нь бидний харъяанд байгаад Орос нутагт зугадан нүүсэн тэлэнгэдүүдийг буцааж өг хэмээн шаардахгүй, хил хязгаарын амгаланг сахин хамгаална” [6] хэмээжээ. Сэнгийг нас нөгцөхөөс өмнө Галдан Төвдөөс эргэж ирсэн [7] гэсэн Ц.Ж.Жамсрановын нийтээр зөвшөөрсөн саналыг хүлээн авахаас аргагүй юм.

Галдан Төвдөөс буцаж ирснээс хойш хэдэн жилийн турш шашны идэвхтэй зүтгэлтэн хэмээн тодорчээ. “Миний шашин хойт зүгт түгэн дэлгэрнэ” хэмээн аврагч Будда бурханы урьдчилан айлдсанаар Зүүн гарын улсад шарын шашин хурдан тархжээ. Галдан бошгот Бодисадва бурханы замыг засаж, тантрийн гурван сүмийг босгож, мөргөл үйлдэн, тахил өргөжээ” [8]. Оросын сурвалж бичгүүдэд ”Гэгээн хутагт” хэмээгдсэн Галдан бошготын санаа тавьснаар Зүүн гарын улсад Шавдан Разан, Ламрин Разан, Тарни Разан [9] хэмээх шашны гурван сургууль байгуулжээ. Ийнхүү Галдан Зая бандидын гэрээслэлийг биелүүлж эхлэв. Төвдийн буддын шашны ёсоор ариун үйлсэд /Төвдөд ламын шашин төрийн хэрэгт оролцохыг хуулиар баталгаажуулсан байдаг/ оролцсон нь багаасаа цэрэг дайчин болохыг хүсэн мөрөөддөг байсан Галданг улс төрийн зүтгэлтэн болох замд хөтөлжээ. Гэвч хувь тавилан өөрөөр эргэж, Галдан хүсэн мөрөөдсөн цэргийнхээ хүн болжээ.

1671онд Красноярск хотын Оросын дээдэс Кузнецк хошууны оршин суугчдаас. “Сэнгэ тайж өнгөрсөн 1678 /1679 / онд алагдав. Түүнийг гэрт нь төрсөн дүү Матари тайж шөнөөр орж нойрсож байхад нь алжээ. Төрсөн дүү Гэгээн хутагт цэрэг дайчдаа аван ахаа алсан Матари тайжийг хороогоод мөн Цэцэн тайж. Цөхур тайжийн хөвгүүдийг бүгдийг нь устгажээ” [10] хэмээсэн мэдээлэл авсан байлаа.

1669 оны хавар эрт Очирт ханы захирсан Алшаагийн ойрадуудын нутгийг зорин Галдан бошгот хөдлөв. Тэрээр нэр цуут Лувсан гэгээнээс ариун сургаалын мэдлэгээ арвижуулж. далимд нь Очирт хантай уулзаж ажил хэрэг ярихаар зорьжээ. Баруун талдаа Ямаат хэмээх хад асгатай уулс сүндэрлэсэн алаг цоог хулс шаргалтсан Хар-ус нуурыг хөвөөлөн явахад, хүрэвтэр шороон хужир мараатай хөрс манаран, зарим хэсэгтээ мөс цайвартах нуурын бараантан хөхрөх

мандал, сүрлэг уулс хурц наранд униартана. Нялх ногоо цухуйж газар дэлхий ногоон хүрмээ арай нөмрөөгүй байхад, нуурын хөвөөний гүехэн намаг шалбаагт нугас галуу, хун сүрэг сүргээрээ ганганан гунганан шумбаж, үүрээ засахаар эсвэл бүр хол алслан нисэхээр бэлдэж буй бололтой. Энэ бүхнийг сонирхон явсан Галдан Төвдөд байхдаа сурсан нэгэн дууг саналаа.

Үүлэн тэртээ галуу дуугарна

Үзэгдэж нүдэнд харагдах нь үгүй л

Хангинах дуу нь чихэнд хадна

Хаа нисэх нь мэдэгдэх үгүй л

Эрэг гангын цаана наана

Эгч минь надаас тусгаар хол л

Сайхан дуу нь сонсогдохоос бус

Саруул царай нь үзэгдэх биш л

Асга хадны цаана наана

Ах минь надаас тусгаар хол л

Аргил дуу нь сонсдохоос бус

Ахуй дүр нь үзэгдэх биш л

Өндөр их саад босго

Өмнүүр минь хөндөлсөөр байна л

Уд бургасны өтгөн шугуй

Урдуур минь хөндөлсөөд байна

. Ах минь та хүрээд ирсийм

Асга хадыг даваад ирсийм

Эгч минь та хүрээд ирсийм

Энгэрийн шугуйг тойроод ирсийм

Цэцгийн дэлбээ шиг үүлэн дундаа

Цэн хун шувууд ниснэ л

Эгч минь та цэцэг билээ л

Энэ бие минь таных билээ л

Үнэр ялдам цэцгийн дэлбээнд

Эрвээхэй юунд суунам

Үнэн сэтгэлт ах минь

Уулаар даваад ирнэм

Цэцгийн дэлбээ шиг үүлэн дээр

Цугаар сууж амаръя

Дахиад хэзээч салахгүй

Дандаа ийгээд амьдаръя

Хосоор, дураараа цэнгэх энэ хун шувуу шиг аз завшаан Галданд оногдсонгүй. Тэрбээр Алашаад очоод Лувсан-гэгээнээс сургаал номын нууцыг тайлах увидасыг эзэмших, Зүүн гарын улсын талаарх Очирт ханы бодлого, дахиад дүрэлзэж мэдэх саяхан намжсан ах, дүүс хоорондын маргаан зөрөлдөөний талаар бодож явахад, Очирт ханы охин ингэн нүдэт, сарны гэрэл шиг цагаан царайт бүсгүй түүний сэтгэлд эргэлдсээр байв. Тэрбээр Төвдөөс нутаг буцах замдаа Алашаад түр саатахдаа түүнтэй учиржээ.

Сар шиг сайхан бүсгүйн

Суудал байдал намбалаг

Үзэсгэлэнт түүний царайг

Үгээр зүйрлэх хэцүү

Зүүн тийш харвал

Зүүн хацар нь туяарч

Зүүн энгэрийн модыг

Зүүдрэлгүй тоолж чаднам!

Баруун тийш харвал

Баруун хацар нь туяарч

Баруун энгэрийн модыг

Баараггүй тоолж чаднам!

Тэнгисийн ус руу харвал

Тэрээний ёроолын загас

Түрсээ шахахыг ч үзнэм

Төчнөөн байгааг нь ч мэднэм!

“Ум ма ни бад ми хум!”. Лхасын мөнгөөр тоногдсон хазаарынхаа жолоог султган морио давираад элсэрхэг замаар тоос манарган, тэмээн хөсгийнхөө өмнө гарлаа. Ах дүүсийн хоорондох урхаг дайсагналын аюулыг мартан, охиныг санасан уйтгараа тайлахыг санаархан салхи исгэрүүлэн давхисан нь энэ болой.

* * *

Хааны саруул өргөөнд харанхуй татаж, зөвхөн тулганд гал дүрэлзэн гэрийн дотор халуу дүүгнэ. Гэрийн хойморт залсан гуулин бурханы дүрс харанхуйгаас учиртайяа ширтэнэ. Сэнгэ зүүн хоймортоо цагаан эсгий ширдэг дээр сууж, алтаар эмжсэн аягаа арзаар дүүргээд баруун гарын ядам хуруугаа дүрэн галдаа сэржим өргөөд балгаж эхлэхэд хагуу архи дотор бүлээцүүлж, толгой манаруулна. Гэрийн гадна харуул манааны цэргүүд зэвсгээ хангинуулан холхиж, голын эргийн нугад морьд тургих нь холоос содохон. Олон жилийн турш ойрадын хүчирхэг том улсын эзэн сууж, хунтайжид өргөмжилсөн түүнийг төрсөн ах нар нь үл ойшоон, ноёд, албатуудын дунд хагарал гаргасныг буруушаан зүхэж суулаа. Цэцэн – тайж, Зодов-Баатар хоёр л ойрадын нэр хүндтэй ноёдыг талдаа оруулахыг байнга оролдож, Сэнгээс зэвсгийн хүчээр төрийн эрхийг булаахыг санаархсаар иржээ. Тэгээд ч 1657 оны гал тахиа жил улс гүрнээ хоёр хэсэгт хувааж чаджээ. Баруун - гарын улс хэмээх өмнөд нутаг Сэнгэд хоцорч, Зүүн гарын улс хэмээх хойт нутгийн эзэд нь тэд болжээ. Галдан зуучилсны ачаар цус асгаруулах тулаан болсонгүй. Сэнгэ улсын дээд эзэн хэвээр үлдэхэд Галдан-хутагт үг, үйл хэргээрээ тусалжээ.

Сэнгэ архиа ууж дуусаад, хатаасан өрөм заглав. Галдан нас залуу, ухаалаг, зальтай, хан суухаас ч буцахгүй, нэр төрд дуртай, тэгээд ч Очирт ханы охин Ануд сэтгэлээ өгөөд Алашаад жил гаруй сууж байгаа билээ.

Ер нь хэнд итгэхээ Сэнгэ шийдэж ядан суутал харуулынх нь ахлагч орж ирээд ээлж солигдсоныг айлтгав. Архинд согтсон Сэнгэ гараараа дохиод, торгон дэрээ дэрлэн нэхий дээлээр хучин унтахаар хажуулав. Харуулын цэргүүдийн нэг нь голын эрэгт сэжигтэй морьтонгууд ирэхийг үзсэн тухай ахлагчид айлдах гэж завдсанаа болиод гэрээс гарав. “Өөрсдөө учрыг нь олъё. Харуулын ээлжийн ахлагчид сануулья” гэж бодоод гартал үүдэн дээр нь ханы ах Зодов - Баатартай халз тулчихав.

- Хаан гэртээ байна уу ?

- Унтаж байна.

- Яаралтай хэрэг гараад Цэцэн тайж бид хоёр уулзахаар ирлээ

- Би хаанд сонордуулья

- Хэрэггүй ээ, бид өөрсдөө уулзана.

- Хаан унтаж байна шүү

- Зайл, эндээс!

Харуулын ахлагч гэрийн хаалгыг сөхөн орох тэрхэн хоромд харанхуйд нэг хүн толгойд нь цохиж унагав. Гэрийн гадна үймэлдэн бужигнаж, Цогт - тайж, Зодов-Баатарын талынхан харуулын цэргүүдийн зэвсгийг булаан алж хядаад, ухаан алдсан ахлагчийг чирч зайлуулаад Зодов Баатар гэрт орохдоо, айж балмагдан алж хядалцхад бэлэн зогсож байгаа гэж бодсон дүү нь тайван нойрсож хэвглээ. Зодов Баатар мэгдэн сандарч өөрийн эрхгүй илдээ алдах агшинд махлаг хөгшин Цэцэн- тайж орж ирээд:

- Юундаа зогсоод байна? Одоохон гүйцэтгэ! Харуулынхан бүгд баригдаж, алагдаагүй бол одоохон түгшүүр зарлаж таарна гэв.

- Унтаж байна шүү?

- Цаг алдалгүй дуусга!

Зодов – баатар илдээ сугалан нэхий дээлээ нөмрөн амгалан унтах дүүгээ хамаг хүчээрээ цавчлаа. Хааны бие татвасхийн, Цэцэн – хунтайж нэхий дээлийг нь авч чулуудав. Аймшиг хурсан нүдээрээ ах нараа хараад үг хэлэхийг хүчлэн завдах зуур улайрсан Зодов – Баатар дүүгийнхээ толгойг тайвнаар цавчив.

* * *

Галдан Очирт ханыд зочлуулан арз ууж, шүүс, халуун хоол зооглож суув. Ах нар нь самуун дэгдээвэл Сэнгэ, Галдан хоёрт туслахаа Очирт хан амлажээ. Галдан унтах гэртээ орохыг завдан гарах зуур хааны өргөөнд буухиа элч ороод ирлээ. Элч морио усан хулгана болтол шавдуулжээ. Сэнгэ хааны харуулын шархадсан ахлагч арайхийн өөрийн хүмүүстээ хүрээд болсон явдлыг дуулгахад тэд нар Галдан – хутагт Очирт- хан хоёрт аймшигт мэдээг хүргүүлэхээр элч илгээсэн нь энэ болой. Элч Галданг үзээд хоолой нь чичрэн:

- Сэнгэ хааныг Цэцэн тайж, Зодов баатар хоёр ах нь алчихлаа! гэв.

Элчид айраг аягалж өгөөд, Очирт хан өөрийн хүмүүстээ элчийг харж хандахыг даалгав. Уй гашуудаа багтарсан Галдангийн царай барсхийн:

- Өөдгүй нохдыг өөрын гараар ална. Хаан минь надад дайчдаа өг! Би маргааш мордоно! - гэхэд Очирт хан:

- Яаж болох билээ, чи цэргийн хүн биш! Гэгээн хутагт өөрийн дайсны өөдөөс өш хонзонгоор илд барин дайтах нь ёс бус уу! гэв.

- Өшөө авахын тулд би цэрэг болно!

- Их үйл хэргээсээ ламтан та татгалзаж байна уу?

- Ухаантай хүмүүнд их бага үйл хэрэгт ялгаа байдаггүй юм.

Очирт хан гайхаж эргэлзсэнээ нуухыг оролдон зогсоход хутагт түүний охин Ануг ширтэн шимтэнэ. Дэг жаягаа зөрчин лам хуврагууд эмсийг таалдагийн ижил Галдан ч буцахаас

өнгөрчээ. Энэ залуу хутагт өшөөгөө аван, төрийн эрхийн төлөө тэмцэхээр бусдын гараар гүйцэтгэж болох зүйлийг өөрийн гараар хийхээр зориг шулуудан, хутагт хэргэмээ золиослоход бэлэн болжээ.

Маргааш өдөр нь ямааны боодогны амтат мах зооглон, халуун шөл очиж суухдаа Галдан: Очирт ханаас цэргийн тусламж авахаар дахин ам алдуулж, дайтах төлөвлөгөөгөө танилцуулж амжлаа. Тэр өдрөө Лхаст суугаа Далай ламд элч төлөөлөгч илгээн шашны хэргэмээсээ татгалзаж, төрийн хар хүн болох зөвшөөрөл гуйлаа. Тэр хооронд өөртөө үнэнч Зүүн гар улсын ноёдыг урин ирүүлж, дүүгээ алсан ах нарынхаа эсрэг дайтахаар ярилцаж тохиров. Амь насаа алдахгүй бол Зүүн гарын хаан сууж хэнд ч энэ суудлаа өгөхгүй хэмээн тангараглажээ.

Алашаагаас Төвд хүртэл хол хэдий ч

Хүлэг сайн морь нь

Өдөрчийн газарт урд хөлөө тавьж

Хоногийн газарт хойд хөлөө тавьж

Хурдлан хурдлан давхих нь

Өвс ногоон дундаас бултах туулай шиг

Талын ногоо улаан тоосонд дарагдан

Хамрынх нь уур өвс ногоог цоонох шиг явсаар хэдэн сарын дараа Галдан шар нөмрөгөө тайлж, шашны хэргэмээ орхин, төрийн хар хүн болох зөвшөөрлөө тавдугаар Далай-лам, Ванчин-лам хоёроос авчээ.

Галдан ийнхүү Сэнгэ болон өөрт нь үнэнч дайчид, Очирт ханы цэргүүдийг нэгтгэж авлаа. Гэхдээ 1672 онд хийсэн түүний аян дайны талаарх мэдээ хадгалагдаж үлдсэнгүй. Сэнгэ алагдаж Цэцэн /зарим сурвалж бичигт Цэцэн хаан хэмээдэг/ хан ор суусан бололтой. Галдангийн талд Алдар-тайж, Дайчин- Омбо зэрэг ноёд оржээ. Галдангийн цэрэг хар Эрчис мөрний хавьд хуарагнаж, Цэцэн ханы өргөө Эмиль голын хөвөөнд байлаа. Цэцэн хан хэдийгээр нас дээр гарсан ч /түүнийг моринд мордуулж эмээлтэй нь бэхлэн уядаг байжээ/ эхний тулаанд ялалт байгуулжээ. Өрөнгө-булаг хэмээх гол дээр Цэцэн ханы талынхан Цөхур-Уваш /Галдан болон Цэцэний авга ах/, Алдар-Хошууч нар Галдангийн талын Алдар тайж, Дайчин-Омбо нарын цэргийг бут цохижээ. Эмиль голоосоо нүүж Ил голын хөндийг өгсөн даваад Хар нуурыг барааджээ. Галдангийн цэргүүд Хар нуурын орчим Цэцэнийг гүйцэн очоод бут цохиж цэргийн зарим нь олзлогдон, зарим нь тал тал тийшээ зулбан нуугджээ. Цэцэн хааныг дэмжиж байсан Зүүн гарын улсын том лам нар энэхүү ялалтын дараа Галдангийн талд орцгоосон нь нийгэм улс төрийн амьдралд маш чухал алхам боллоо. Сурвалж бичгээс үзэхэд лам нар: “Дөрвөн ойрадын лам нар бид хэний дэргэд ч байсан өглөг буянаа түгээхэд ялгаа гарахгүй” [11] хэмээдэг ажээ.

Цэцэн хан тулалдааны талбарт олзлогдоод алагджээ. Зүүн гарын лам хуврагуудтай

Галдангийн тогтоосон хувийн харилцаа нь ялалт байгуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн нь гарцаагүй. Галдан лам нарт тэднээс дайжсан хамжлагууд, шавь нар мал сүргийг нь эргүүлж өгчээ. Зүүн гар улсын шашны том төв сүм хүрээ дахин Эмиль голын хөвөөнд нүүн очиж суурьшив. Зодов-Баатар цөөн хүмүүс дагуулан Зүүн гарын улсаас зулбан Хөх нуурын зүг зугтжээ. Галдан йинхүү Зүүнгар улсын эзэн-хунтайж болов. Гэвч амгалан тайван амьдрал удаан үргэлжилсэнгүй. Амь үрэгдсэн Сэнгийн хүүхдүүд, Галдангийн мах цусны тасархай ач нар нь хааны ор залгамжлахыг өрсөлдөн түүний эсрэг тэмцэн босов. Сэнгийн нэг хөвүүн Соном-Равдан хорлогдож, хоёр дахь хөвүүн Цэвээн-Равдан гэр бүл, өөрийн хүмүүсээ дагуулан Турфан руу зулбан гарснаар авга ах, ач нарын хоорондын тэмцэл төгслөө. \Зарим баримт бичигт нагац талын торгуудын хаан Аюуш руу зугтсан хэмээн бичжээ.\. Зарим мэдээгээр Галдан бошгот Цэвээн-Равданг алахаар заналхийлж байсныг мэдсэн учир Цэвээн-Равдан Турфан руу зугтаж гараад, түүний хамгийн заналт өстөний нэг болжээ.

Зүүн гарын улсын хааны ор суусан Галдангийн амжилтын үндэс нь “тэрбээр хасгийн засаг ноёдын хүчинд тулгуурласан” [12], мөн “Дайтаж байлдах авьяастайн зэрэгцээ гаднаас Далай- лам дэмжиж, дотроос эцгийн нь хуучин албатууд, ах нар нь тусалсанд”[13] оршино.

* * *

Галдан төрийн хар хүн, Зүүн гар улсын хаан болсныхоо дараа Очирт ханд элч илгээж, охин Анугаа эхнэр болгохыг хүсчээ. Очирт ханаас анхны зөвшөөрсөн хариу авч, бэр буулгах тохиромжит хугацаа, боломжийг зурхайчаас асуугаад, ойрад заншлаар дахиад гурвантаа бэлэг хадагтай элчийг Алашаад илгээжээ. Дөрөв дэх удаагаа бэлэг болох хивс, торго, хувцас, зэвсэг, хятад ваар сав, сибирийн булганы арьс, дашмаганд дүүргэсэн нэрмэл архи ачсан ачаа хөсөг, шүүсэнд хэрэглэх малыг туун хүргүүлэв. Бэлэг хадгийн хамт ёс төрийг баримтлан ирээдүйн өрх гэрийн баян тансагийг билэгдэж, шахмал цай, залуу хосын салж хагацашгүйн тэмдэг – цавуу, бөх батын билэгдэл - сур зэргийг ч явууллаа. Тун ч удалгүй Алашаагаас удаан хүлээлгэсэн бэрийг нь залж ирлээ.

Галдан хааны өргөө нь хэмжээгээрээ ч, чимэглэлээрээ ч хосгүй байлаа. Гэрийн дотор цавагийг алтлаг ургамлын дүрст хээ угалз шагласан цэнхэр торгоор хийжээ. Алтан шар өнгөөр ямарваа сорилтыг давах чадвартай хааны хязгааргүй хайр сэтгэлийг билэгджээ. Гэрийн тооноос/ дээврээс/ цацаг унжлага унжуулж, хананы наагуур цацагтай торгон хөшиг татжээ. Намхан хөлтэй орыг зөөлөн эсгий, торгон бүтээлэг, дэрээр гоёжээ. Хөнжлийн захаар аз жаргалын билэгдэл өлзий утас хатгажээ.

Охиноо алсын замд хаан эцэг, хатан эх нь үдэхдээ алтлаг хоргой утастай хадаг барьж:- Хүслээрээ жаргаж, сэтгэл санаагаар уужуу амгалан яваарай,- хэмээн ерөөгөөд хоёр хацрыг нь үнсэн үнэрлэж, илэн энхрийлжээ.

Шарга зүсмийн моринд мөнгөн тоногтой эмээл тохож, хээрийн салхинд хялганы толгой халиурах адил хийсэг хэмээн ганзаганаас нь молцог цацаг зүүжээ. Гоёж гангалсан үйлчлэгчид Ануг моринд нь мордуулаад алсын замд найман сайхан аягач бүсгүй дагалдан гарахдаа хоорондоо гангар гунгар ярилцаж, үе үе мэгшин мэгшин уйлахад Ану ч нулимс дуслуулан байж :

- Богино жолоотой бүсгүй хүний хувь заяа яасан хэцүү билээ. Эцэг эхээ орхин холын хүний нутгийг юунд зорино вэ? - хэмээн дуу алдана.

Очирт хан Галданд: - Охиныг минь муу үгээр харааж, мод саваагаар цохиузай - хэмээн дамжуулахыг захив.

Зуны дунд сарын шинийн дөрвөнд хуримаа хийхээр товложээ.

Ану охиныг улаан шарыг тунаруулсан залуу хутагт-лам биш, баатар дайчин үзэсгэлэнт сайхан залуу хаан угтан тосоход бүсгүй Галданг гөлрөн ширтэхэд өмнө нь огт өөр Галдан зогсч байлаа.

Хар үс нь тунаран намирсан

Хатан баатар эрийн хүзүү нь

Хараа үл хүрэх уулан дээрхи

Хааны цайз шиг бат бөх

Хүчирхэг эрүү, баатарлаг чих

Хүйтэн нүднийх нь харц аймаар

Хацар нь бухын цус шиг улайж

Хөлдсөн мөс шиг нүүр нь цайрна

Шанааны нь хооронд бүргэдийнх шиг

Шил шиг цул хамартай

Хорин алдын өргөнтэй

Хосгүй сайхан гуятай

Нарийн сайхан бэлхүүстэй

Хүзүү, толгой үснээс нь

Хүжийн үнэр ханхийнэ

Магнай дээрээ Майдарын дүртэй

Зонховын гэгээ дөл шиг цацарна

Юутай ч зүйрлэшгүй тэргүүнээс нь

Очирваанийн туяа гийнэ

Торгон хөшиг татсан булган гэртээ Ануг Галдан өөрөө хөтлөн оруулав. Зүүн гар улсын дээд санваартнууд бүгд л хуримын ёслолд ирцгээжээ.

Өдрийн сайныг өнжин хүлээж, сарын сайныг саатан хүлээсэн азтай өдөр, цагтаа залуус хос мөнхийн улаан наранд мөргөн, амьдралаа холбосны бэлэг тэмдэг болгон шагай чөмөг авцгаав. Галдангийн оронд өргөмжлөгдсөн шинэ хутагт чанга дуугаар: ”Аугаа их Чингис-хаан болон бусад хүчирхэг эзэн дээдэс минь яг л одоогийнх шиг баяр цэнгэлт хурим найр хийж байлаа. Эртний өвөг дээдсийн гэрээсийг санан авир сайтай энэ бүсгүйг ёсыг даган гүн хүндэтгэлтэй оруулж иржээ. Бэр хүү хоёр амьдралаа мөнх холбосны ерөөл айлтгая”-гэв. Дараа нь галын бурханаа тахиж мах, өөх, тос, сүү өргөв. “Хүчирхэг эзэн гал минь өргөлийг болгооно уу! Ханилсан хосод эд баялаг, амар мэнд, гэрэл гэгээ, амгалан тайван амьдрал хайрлаач. Хүсэл мөрөөдөл, буян хишиг биелэгдэх болтугай! Бүхнээс төгс будда минь! Сайн үйлс, ариун сургаалыг дэлгэрүүлэхийн тулд ханилсан хоёрт нэг санаа, эрүүл энх, эе эв, үр хүүхэд хайрла. Газар эх, тэнгэр эцэгтээ хүргэх ач тус нь сар шиг эрхэм ариун болтугай! - “хэмээн лам мөргөл үйлдэв.

Бөөгийн болон бурханы шашны зан үйл холилдсон энэ ёсоор Галдан Ану хоёрыг ураг холбуулж, Анугийн олон салаалж сүлжсэн сэвгэр үсийг эхнэр үс болгон хоёр салаалж сүлжээд тохигонд хийв. Бүсгүйн зүүсэн ганц ээмгийг аваад /баруун чихэндээ ганцыг зүүдэг байжээ/ есөн ширхэг эрдэнийн чулуу шигтгэсэн, гурвалжин хэлбэртэй алтан унжлагатай дугуй алтан ялтаст сийхийг хоёр чихэнд нь зүүж өглөө. Нөхөртэй эмэгтэйчүүд л хоёр чихэндээ ээмэг зүүдэг байв.

Дун үлээн зар түгээж, зочдоо хуримын найранд урив. Тогооч, зоог бэлтгэгчдэд зарлиг буулган :”Зуун зуун газар зуух бэлтгэж, хөгжөөн цэнгээнт найрынханд зориулж мах чанацгаа! Айраг, архи далай болтол бэлтгэ! Үр жимс овоо болтол түү!” хэмээжээ. Тайж, ноёд, ихэс дээдэс зоригт баатрууд, буурал өвгөд, идэр эрс, улаан хацартай эхнэр, охид, нас буянтай эмгэд, эелдэг даруу эмс хүүхнүүд хааны гэрт тойрон суугаад идээ зоог хүртэцгээнэ. Айраг архи бялхан, тос даасан аагтай цай домбоноос аягална. Царанд хонины ууц, унаганы гуя чанаж тавиад том модон тэвшинд хонь, үхрийн мах жижиглэн овоолжээ. Адуу, тэмээ, үхэр, хонины махнаас зочид тааллаараа зооглон, гоёж гангалсан зарц бүсгүйчүүл, алтан мөнгөн аяганд архи айраг бялхуулан сөгнөж, уртын дууг уянгалуулан шуранхайлна.

Одот тэнгэрийн доор

Олон баатрууд найрлана

Шүүдрийн чийгэнд жиндээхгүй

Сүрхий халуунд цоноохгүй гэж

Хүчит тэдний дээр

Хөх тэнгэр асарлана

Арз шимж, бугын мах зооглож

Ард олноороо цэнгэн жаргана

Галдан хаан хайр сэтгэлээрээ гэрлэв үү, эсвэл Алашагийн ойрадууд Очирт хантай ойртох төрийн бодлого баримтлав уу гэдэг нь тодорхой бус./Ануг Очиртын охин[14], ач охин[15], дүү бүсгүй гэх зэргээр судлаачид маргадаг юм/. Галдан Анугийн зэрэгцээгээр нас нөхцсөн ах Сэнгийн эхнэрийг хатан болгоод, төрийн эрхийг авах тодорхой зорилготой байсанд хааны ор суух хүү Цэвээн-Равдан дургүйцэж, тэмцэлдэж эхэлжээ. Түүгээр ч барахгүй Ану хатан Сэнгийн бэлэвсэн гэргий бөгөөд Галдангийн бэргэн гэж М.Куран [16] санал дэвшүүлжээ. Ер нь Ану нэрийн дор наад зах нь хоёр хатан яригдаад байх бололтой. Тэдний нэг нь Цэвээн-Равданд эцсээ хүртэл үнэнчээр зүтгэж яваад Цин улстай хийсэн тулаанд амь эрсджээ.

Тархай бутархай, нэг хааны хатуу захиргаа тогтож чадаагүй улсыг Галдан нэгтгэх зорилго тавьсан бололтой. Тэрбээр хаан суумагцаа л монголын хэрэг явдалд шууд татагджээ. Үүнийг Сэнгэ ахаасаа ч өвлөсөн байж болох юм. Галдангийн дараагийн үйлдлүүдийг ойлгоход түүнийг засгийн эрхэнд гарах үед Монгол орны байдлын талаар товч боловч өгүүлэх нь зүй.

* * *

Даян-цэцэн хаан /1470-1543/ нас барсны дараа том хөвүүд нь одоогийн Өвөр монголд нүүдэллэн очиж, монголын эртний заншлаар отгон хөвүүн Гэрсэнз эцгийн гал голомтыг сахин Хангайн уулсын орчим хойт нутагт хоцорч халхын ноёдыг нэгтгэж чаджээ. Тэрбээр нутаг орноо хөвүүддээ өгч анх удаа Халхыг /одоогийн Монгол улсын/ зүүн /дорнод/, баруун/ өрнөд/ хэсэгт хуваагаад долоон хөвүүнийхээ гуравт нь /Ашихай, Оноху, Аминдурал нарт / захируулсан нь хожмын Халхын хаадын гурван үеийн эхлэлийг тавьжээ. Ашихайн удам халхын баруун /өмнөд/ хэсэгт суурьшин засагт ханыхан гэгджээ. Баруун, зүүн халх Туул голоор зааглагдаж байв. Зүүн /дорно/ зүгт нүүдэллэж очсон Оноху ба Аминдуралын удмынхан зүүн Халхыг эзэгнэж, Аминдуралын хөвүүд Хэрлэн мөрний сав газраар нутаглаж Цэцэн ханы удмыг үүсгэж, Онохын удмынхан Орхоны эх, Туулын дунд, адгаар суурьшин Түшээт-ханых гэгдэх болов. XVI зууны хоёрдугаар хагаст Засагт ханыхан ойрадуудыг өөртөө нэгтгэв. Гэтэл Засагт хан Автайг нас нөхцсөний дараахан ойрадууд босож, Автайн хан ор суусан хүүг алжээ. 1587 онд Халхчууд ойрад руу довтолсон боловч бут цохигджээ.

Түшээт ханыхан анх удаа Халхад шарын шашныг дэлгэрүүлж эхлэв. Оноху хөвүүн Түмэнхэнийг Далай-лам Халхын цуут эзэн хэмээн зарлаж, Сайн-ноён хан хэргэмээр шагнажээ. 1585-1586 онуудад Автай хан Эрдэнэ зуугийн хийдийг босгов. Залуу халх хөвүүдийг бичиг ном, буддагийн сургаалд суралцуулахаар цахар /газарт/ нутагт явуулж, ариун ном судар цээжилсэн монголчуудад үхэр, адуугаар шан харамж өргөдөг байлаа.

Халх монголчууд Манж улсын хэрэгт эртнээс хутгалдаж, дэвшил хөгжлийн эхэн үед амирлангуй, ивээнгүй хандаж байжээ. Нурхачын үед монголчуудын соёлын хөгжлөөс тэд хүртэн, монгол бичиг, хэлийг бичиг хөтлөхдөө ашиглаж, монгол бичгээр суурилан манж бичиг зохиожээ. Монголчууд болон манж нар Хятадын Мин улсын талаар адил бодлого баримтлан “Мин улс нь бидний дайсан” [17] хэмээн зүүн Монголчууд бичиж байлаа. Манжтай хөрш зэргэлдээ оршдог монгол аймгууд Нурхачид хаан хэргэм олгохыг амлаж

байсан тухай баримт сэлт бий. Баарин, Хорчин, Түмэн, Найман зэрэг монголын вант улсууд манж нарт идэвхтэй тусладаг байжээ. 1634 онд Манжтай хил залгадаг Үзэмчин, Сөнөд, Авага аймгууд найрамдлын гэрээ байгуулахыг манжийн Авахай хаанд мэдэгджээ. Цэцэн хааны дараа Түшээт хан Гомбо, Засагт хан Сувд нар манжтай харилцаа тогтоов.

Яг энэ үеэр манж-монголын харилцаанд чухал өөрчлөлт гарав. Монгол аймгуудын ганцаар ноёрхохыг санаархаж байсан цахарын хүчирхэг хаан Лигдэнг 1634 онд манжууд хиар цохив. Манж нарт байсан мэдээгээр Чингис –хааны тамгыг Лигдэн хаан хадгалж байжээ. Чингисийн тамгыг гартаа оруулж авснаар Хятад монгол аймгуудыг ноёрхон захирах онцгой эрхийг эдэлж, ялангуяа Хятадыг харьяалалдаа оруулж авахыг манж нар санаархажээ. Чингис-хааны үүсгэсэн Юань гүрний түүхийн хураангуй хувилбарыг 1640 онд монгол хэлээр орчуулж дуусгав. Тухайн үед манж хэлээр яг үүнтэй ижил хувилбар орчуулагдсан байлаа. XIII-XIV зууны үед Хятадыг монголчууд хаанчилж байсан түүхийг бичсэн манж –монголын энэхүү хураангуй хувилбарт Юань болон Цин улсын залгамж холбоог тодорхой тусгасан байлаа. Лигдэн хааныг бут цохигдсоны дараа /өмнөд / Монголын 46 вант улс Авахай ханд “бүх монголын эзэн” хэргэм өргөмжлөхийг хүсчээ. Энэхүү хэргэмийг өмнөхөн нь Лигдэн эзэмшиж байгаад Чингисийн тамгаа ч, амь насаа ч алдсан юм.

1640 онд Түшээт ханы зургаан настай хөвүүн Лувсан-дамба-жалцан Халхын буддын шашинтны тэргүүнээр өргөмжлөв. 1649 онд тэрбээр Жавзан-дамба хутагт хэргэм хүртжээ.

1638 оноос халхчууд жил бүр “есөн цагаан” хэмээх /нэг цагаан тэмээ, найман цагаан морь/ өглөгийн манж нарт өгч байлаа. XVII зууны 50-иад оны үед Халхын хаад ноёд манж нарт хараат болжээ. Энэхүү хараат байдлаа бататган: “найрамдлаа бататгахыг хүсэж тангараг өргөхдөө ...та нар жил бүр тодорхой хэмжээний алба гувчуур төлж, арилжаа худалдаа хийнэ. Бидний зүгээс та бүгдийг бэлгээр шагнан, энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш манай нутагт оргодол хулгай нарыг буцааж хүргүүлэх болно. Хэрэв найрамдал байгуулан, холбоо тогтоохгүйд хүрвэл та нараас алба гувчуур авахгүй, манайд зулбан ирсэн оргодол хулгай нарыг чинь гар сунган хүлээж авна.” Сайтар бодоорой“ [19] хэмээн тулган шаарджээ.

1656 онд Түшээт хан, Цэцэн хан хоёр манж нартай тангарагийн гэрээ байгуулсан боловч Засагт хаан татгалзжээ. Энэ баримт бичиг тун ч их уршиг тарьсан билээ. 1656 онд манжийн эзэн хаан дур мэдэн Түшээт хан, Цэцэн хан, Засагт хан, Лувсан тайж /Алтан хан /, Данжин лам, Мэргэн ноён, Цэцэн ноён, Хөндлөн тойн нарын Халхын найман том ноёдыг “засаг “хэргэмээр өргөмжилжээ. Тэр үеэс эхлэн зөвхөн “засаг “ хэргэмтнүүд л “есөн цагаан” бэлэг заавал барих боллоо. “Есөн цагаан”-ны хариуд тэд мөнгөн данх, таваг, 30 толгой хоргой, 70 толгой цэнхэр даавуу авч, цайллаганд ордог байжээ. Засаг хэргэмийг өв залгамжилдаггүй, жил тутам Манж эзэн шинээр зарлиг гаргадаг байв [20].

Ийнхүү 1656-1691 оны хооронд “нэр төдий харьяалагдаж“ байсан нь Цин улс Халхад жинхэнэ ноёрхлоо тогтоох эхний алхам байв. Монголчууд манжийн / эзэнт улстай /эрхтэн дархтантай тун амархан холбоо тогтоосон нь Цин улсын цэргийн хүч, Лигдэн хааны эмгэнэлт хувь тавилангаас шалтгаалсангүй. Харин Цин улсын төрийн эрхийг манж хаад барьж байсныг мэдэв ч, манж хаад хятадын эзэн хаан болж, уршиг тарихыг тооцсонгүйд оршино.

Халхын эзэмшил нутгийг хувааж эхэлсэн, зарим ноёд халхыг нэгтгэхийн төлөө тэмцсэн /

түшээт хан/ энэ ээдрээтэй XVI-XVII зуун бол монгол хэлтэн аймгуудын түүхэнд үндэсний соёлын хөгжил дэвшлийн үе байлаа. XVI-XVII зууны монгол оронд үндэсний соёлоо сэргээн мандуулах хөдөлгөөн өрнөж байлаа. XVI-XVII зуун нь монголын сэргэн мандалтын үе гэж тооцогдох бөгөөд 18-р зууны манж гүрний талхидалд байхдаа ч тэмцлээ зогсоогоогүй нь үүний шууд /үргэлжлэл нь/ юм “ [21] гэж Жамсраны Цэвээн /Жамсранов/ тэмдэглэжээ

17-р зууны 60 - д оны эхэн үеэс ойрадууд халхын хэрэгт татагдан оржээ. 1661 онд засагт хан Норов нөхцөж, эрх мэдлийн төлөөх хоорондын тэмцэлд ууган хөвүүн Цуу мэргэн хан ширээгээ дүү Ванчигт алджээ. Засагт хан аймгийн хямралд хотгойдын захирагч Лувсан тайж оролцож, 1662 онд Ванчигийг алж, Цуу мэргэнийг хаан ор суулгав. Амь үрэгдсэн Ванчигийн талынхан Түшээт хан Чахундоржоос тусламж гуйхад, Сайн ноён, Данжин лам нартай хамтран цэргээ илгээж, Лувсан тайж бут цохигдон ойрадуудын зүг зугтав. Гэвч тэрбээр ойрадуудтай удаан эвтэй байж чадаагүй. Сэнгэ, Лувсан тайж 2 Горлос мөрний хавийн киргис албатуудаас болж маргалдан дайн дэгдэж 1666-1667 онуудад ойрадууд Алтан ханы улсыг устгаж нутаг дэвсгэрийг нь өөрийн цэргээрээ харгалзуулан үлдээв. Лувсан тайж олзлогдсон байхыг оросын элчин /элч/ Павел Кульвинский харжээ. Тэрбээр энэ тухай “Сэнгэ тайж / мугал/ Моголын хаан Лоджаныг /Лувсан/ 3 хөвүүн охин дүүгийн хамт олзлон охин дүүгий нь эхнэрээ болгон аваад Лувсангийн баруун гарыг тас цавчин нохойд хаяж өгчээ” [22] хэмээн бичжээ.

Лувсан тайж ойрадуудад бут цохигдсон нь Засагт хан Цуу мэргэний хувьд үхлийн аюул байлаа. Цин улсын зүгээс Засагт ханы хэрэгт шууд оролцож эхэлсэн яг тэр үед ойрадуудын дотор үймээн дэгдэж Галдан төрийн эрхэнд гарсан билээ. Их эзэн хаан Кан-си 1670 онд Цуу мэргэний засаг хэргэмийг буулган Цэнгүүнд засаг хэргэм өргөмжилсөн нь цаад утгаараа засагт хан хэмээн зөвшөөрсөн нь байв. Энэ нь самуун дахин дэгдэх түлхэц болов. Урьд нь Түшээт хан болон Халхын бусад аймагт зугтаж очиж манжид дагаар орсон иргэд хэрүүлийн эхийг тавьжээ. Түшээт хан Чахундорж энэ иргэдийг Засагт ханд өгөхөөс татгалзсан нь шууд дайсагналцахын шалтаг болно. Цин улсын гар хөл болсон Засагт хан Цэнгүүн Түшээт хан Чахундоржийн талаар Цин улсын эзэн хаан, 5-р Далай лам 2-т гомдол мэдүүлжээ. 5-р Далай лам халхын нөлөө бүхий 2 ханыг эвлэрүүлэхээр өөрийн төлөөний хүн Жарбууныг явуулсан боловч Түшээт хан Засагт хантай уулзахаас татгалзжээ. Ер нь Засагт хан Түшээт хан 2-ын хооронд тэмцэл Халхад болсон сүүлийн 15-н жилийн хэрэг явдлыг тодорхойлж байгаа юм. Энэ 2-ын тэмцэл нь Халхын дотоод хэрэгт Цин улсын дээдэс, Галдан хаан ноёнттой зүүн гарын ойрадууд оролцох боломжийг нээжээ.

* * *

Красноярск мужийн захирагч Хрущевийн саруулхан өргөө тун ч бөгчим байв. 2 долоо хоногийн нар хайр найргүй шарж, ойд гарсан түймрийн хиншүү үнэртэнэ. Бяцхан цонхоо битүүлэн тагласнаас байшингийхаа хаалгыг нээжээ. Архи дарс халуун ногоо ургамал хольсон зууш дэлгэсэн ширээний хажуугийн вандан сандалд Хрущев мөстэй квас /эсгэс/ хааяа нэг балган ойрадын элч Мышийг хүлээж байлаа. Ойрадын элч төлөөлөгчид 3-н хоногийн өмнө ирсэн боловч захирагч анх удаагаа уулзах гэж байгаа нь энэ болой. Киргис, Тува, качинц, аринц, кем, камасин зэрэг бусад гаднын бага ястануудаас оросууд алба гувчуур татахаа зогсоохыг ойрадууд шаардахаар барахгүй, хэрвээ татгалзвал Москвад хүсэлт тавина гэдгийг

захирагч сайтар мэдэж байв. Хрущев тавьсан шаардлагаас нь татгалзаад зогсохгүй давхар татвар авахыг санаархаж байв. Элч төлөөлөгчид Москвад очвол очиг, хаан Алексей Михайлович ашиг хонжоогоо алдахгүйг бодох нь лавтай, тэгээд ч дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу гэдэг үг бий дээ хэмээн бодож суув. Хрущевтэй хамт бичээч орчуулагч 2 хүлээж байв.

Хаалганы гадаах шат чахруулан зарлага орж ирээд: - Халимагийн төлөөлөгчид ирлээ - хэмээн мэдэгдэв. - Оруулчих гээд халууцаж цухалдсан Хрущев ёслолын хувцсаа товчлов.

Элч 2 бараа бологчоо дагуулсаар орж ирээд хүндэтгэлтэй мэндлэхэд Хрущев суухыг урилаа. Албан яриа эхлэхийн өмнө тэд бие лагшин, аян замын, цаг агаарын тухай асуулцан суух зуураа Хрущев ойрадын элчийг сайтар ажиглав. Торгон цамцан дээр савхин цамц өмсөөд, гадуур нь нөмрөг углаж, өргөн суран бүс татсан, хялар нүдтэй, бяр тэнхээтэй сайхан залуу эр, хүрэн өнгийн гутал жийжээ. Элчин тааваараа ихэмсэг царайлан сууна. Тэрбээр архи балган, мах, зооглон загаснаас зөвхөн амтлан талх, өргөст хэмх байцаанд гарч хүрсэнгүй.

Танайхан архи юугаар нэрдэг вэ? -хэмээн Хрущев асуув.

- Исгэсэн сүүгээр нэрнэ. Гэхдээ архаданд /хөхүүр/ сүүгээ хийж хэд хонуулаад айргаа исгэхээр тасралтгүй бүлж эхэлнэ. Дараа нь том тогоо /хайсан/-д хийж, бүрхээр тавина. Бүрхээрийн баруун зүүн 2 талд нь гаргасан нүхнийхээ 1-ийг шавраар бөглөж, нөгөөд нь модон цорго суулгана. Бүрхээрийн дээд аманд жалавч тавьж усаар дүүргээд, жалавчныхаа доор бүрхээр дотор өлгөсөн цорго бүхий жижиг саваар архи дүүрч, гадагш цоргоор гарна.Зуухандаа гал маш ихээр түлнэ. Гарсан архийг дахин нэрвэл чанга арз, арзаа нэрээд бүр хатуу хорз гарна. Орос архи амтлаг, чанга, хурдан согтоодог ч хоноод л гарчихна. Манай ойрадын арз, хорзыг уугаад согтвол 2-3 хоногтоо л согтуу явна. Ноён захирагч таньд маргааш илгээе,та амсаж үзээрэй.

- Танд гялайлаа. Харин би танд 1 торх орос архи бэлэглэе. Эрхэмсэг зочид, та идэж ууцгаа. Хэлэлцэхээс өмнө хооллодог халимгийн ёсыг бид мэднэ. Хэрвээ элчин эхэлж уруул тосдох гэж байгаа бол үгээ хэлсэн нь дээр.

Ойрадын элч хэлэлцээ эхлэх цаг болсоныг ойлгож:

- Хааныхаа өмнөөс элчин нь ярьдаг.

Хрущев хүнд, бэрх сунжирсан яриа болохыг ойлгов.

- Зүүн гарын хаан Галдан Оросын хаанд морь, бүс хатан хаанд үнэт ээмэг бэлэглэн хүргүүллээ. Морь нь ч аргагүй сайхан хүлэг.

Эрмэг дайчин жижигхэн толгойтой

Өрөм шиг хос хөөрхөн нүдтэй

Хайч шиг хос чихтэй

Туулай шиг зөөлөн зоотой

Тал шиг өргөн цээжтэй

Давхиж явах нь жигүүртэй юм шиг

Даамай сайхан хүлэг морь

Анд сургасан шонхор шиг

Арвалзан шунгах хүлэг морь.

Соёолон насны 70-н морины үнэтэй чулуугаар чимэглэж, алт мөнгөөр тоноглогдсон бүс, 1000-н гэрийн үнэтэй хосгүй чамин гоё ээмэг гэж элч хэлэв.

- Эзэн хаан ч хариу бэлгэнд гар татахгүй - хэмээн Хрущев хариулав.

- Би Галдан хааны элч Бадма Мыш өөрийн биеээр Москва орж, эзэн хаанд бэлгээ гардуулна. Хрущев гайхсан царай гаргаж:

- Бадма гэдэг ямар утгатай үг вэ?

- Бадам-лянхуа хэмээх хамгийн ариун цэцгийн нэр.

- Танай эзэн хаан манай эзэн хаанаас юу хүсэж байна?

- Захирагч та мэднэ. Манай хаан одоо хэдэн түмэн цэрэгтэйгээ Красноярскаас 10-н өдөрчийн газар байгаа. Урьд бидэнд алба төлдөг байсан иргэд танайд алба төлөөд байгаа талаар Сэнгэ хаан оросын захирагчдад анхааруулж хэлжээ. Иймд одоо Галдан хаанд урьдын адил алба төлөхийг шаардсан. Хэрэв үүнийг үл зөвшөөрвөл Галдан хаан Красноярск руу довтлоно гэв.

Халимагийн цэргүүд одоогоор Оросын нутагт биш Алтан ханы нутагт ирснийг Хрущев мэдэж байв. Захирагч энэхүү сүрдүүлгээс айгаагүй ч юмыг яаж мэдэх вэ хэмээн болгоомжлон:

- Красноярскт хуарагнасан галт зэвсэг их буутай, орос цэргийн эсрэг дайтах хүч танайд буй эсэхийг Галдан хаан тооцсон болов уу? Эрт үеэс манай их эзэнд /татвар/ төлдөг харь үндэстнүүд урьдын адил л байх болно! - гэж Хрущев хариулав

Бадмагийн царай барсхийн биеэ барьж:

- Москва орж, танай их эзэн хаанд биеэр бараалхах миний хүсэлтийг захирагч та айлтгаж өгнө үү?

- Айлтгаж өгье. Элч та холын замд алжааж ядрах биз.

- Би хааны зарилгийг дагана.

Баатар эр хэрвээ цусаа урсгах аваас

Балгахан ч гэсэн түүгээр газар минь төлжиг

Алсын хязгаарт яс минь цайх аваас

Атгахан ч гэсэн түүгээр газар минь баяжиг!

- Та зоригтой, дайчин эр юм -гээд Хрущев хундага өргөн:

- Таны энх тунх, аз хийморийн төлөө үүнийг ууцгаая. “Эр хүний үхэл ээрэм талд” гэж танайхан ярьдаг. Амар ч байгаад биш, ажлаа хийж яваад гэсэн л үг юмаа даа. Би таны тухай илтгэж Москва оруулж өгье - гэв.

Ийнхүү 1673 оны 10 сард Галдангийн элч төлөөлөгчид Москвад очжээ. Галдан “өөрөө их хааны албат” учраас харь иргэдээс “алба татах эрхгүй, тэгээд ч их хааны хилэнг асаах ашиггүй” [23] гэдгийг элч төлөөлөгчдөд оросууд ойлгуулжээ. Галдан хаан Красноярск, Томск, Кузнецк мужуудад заналхийж байхын оронд оросуудтай эе эвтэй суувал дээр гэдгийг ч Их хаан сануулжээ. Тэгээд ч Галданд бичиг, бэлэгтэй элч томилон явуулах, ойрадын элч төлөөлөгчдийг шууд Москвад ирүүлж байхыг сибирийн захирагчдад зарлиг буулгажээ.

Галдан зөрүүдэлж зүтгэсэнгүй. Ямар ч гэсэн шалтгаан нөхцлийг бодолцон Оросын хааны саналыг зөвшөөрч эе эвийг сахижээ. “Галдан хаан Төв Азийн өргөн уудам нутагт амьдардаг монголчуудыг нэгтгэн захирч Цин улсын аюул заналаас хамгаалах зорилго агуулж, оросуудтай найрсаг эвтэй байхыг эрмэлзсэн” [24] гэдэг санал ч байдаг. Ер нь XVII зууны 70-аад оны үед Галданд үйл ажиллагааны тодорхой төлөвлөгөө байгаагүй бололтой. Харин алба гувчуурт булганы арьс авдаг ч бай, асар их хохирол амсах дайн өдөөх нь уршигтай гэдгийг ойлгож байжээ.

Зургадугаар бүлэг

Түүнтэй учрах цаг боллоо

Түүнтэй үзэлцэх мөч ирлээ

“Жангар”

“Ойрадын Галдан бошгот хааны түүх” хэмээх монголын он дарааллын бичигт” Очирт хан монгол чуулганы дээд тэргүүн байх үед л тэрбээр /Галдан/ дөрвөн ойрад, өөлдийг нэгтгэсэн богд эзэн болохыг санаархаж байсан”[1] хэмээн бичжээ. Түүхийн бусад тулгуур бичигт /нэн ялангуяа Хятадын/ Галданг нэр төрт дуртай, эрх мэдлийн төлөө үхэн хатан тэмцдэг хүн хэмээжээ. Дээрх “Ойрадын Галдан бошгот хааны түүх” номыг бичихэд Хятадуудын урт гар ч оролцсон байж болох талтай. Хятадууд өшгнөө яаж ч муу хэлэхээс буцдаггүй, бичиг ном ашиглахдаа дадсан хүмүүс билээ. Энэхүү номоос л бусад баримт сэлт тарсан бололтой. Манж улсын эзэн хаан Кан-си /Энх-Амгалан хаан/ өөрийн заналт дайсан Галданг “Ойрад” овгийн Галдан төрөлхийн хэрцгий, зальхай, эхлээд ах дүүсийнхээ толгойг хяргаж, дараа нь бүх ойрадууд, Халхын зарим хэсгийг базаж авчээ” [2] хэмээн тодорхойлжээ.

Галдан төр улсын хэрэгт идэвхийлэн оролцож эхэлсэн анхны жилүүдийнх нь талаар мэдээ баримт ховор, хийсэн тайлбарууд нь бодитой биш учир дээрх тодорхойлтод итгэхэд бэрх юм.

Зүүн гар улсын хаан ширээний төлөө Галдан хутагт өөрөө улайран тэмцэв үү, эсвэл хаан хүүгийн хувьд хувь заяаны эрхээр оролцов уу гэдгийг ялгахгүйгээр эрх мэдэлд дуртай, хар санаатай, зальхай хэмээн тодорхойлох нь зүйд нийцэмгүй. Харин хааны ор суухын тулд шашин хэргэмээс татгалзсан нь үнэн санваартан хүн нинжин сэтгэлийн үүднээс хамаг амьтны тусын тулд бие сэтгэлээ зориулах ёстой байтал алаан хядаан эрхэмлэсэн нь гайхмаар. Гэхдээ шарын шашны дээд тэргүүн 5-р Далай лам хутагтын хэргэмийг нь буулгасан билээ. Ах Сэнгийг алсан төрсөн ахаасаа амь насаар нь өшөөгөө авсан Галдангийн явдал тухайн үед гайхмаар зүйл биш байв. Галдан ач дүүгээ хаан ор суухыг ч ач дүү нь Галданг хаан ор суухыг ч хэсэг хугацаанд тэвчсэн байж болох талтай. Гэвч нэг морины жолоог хоёр хүн зэрэг татаж болдоггүйн адил тэд бие биедээ жөтөөрхөн Галдан ялж Цэвээнравдан Турфан руу зугтжээ.

Ийнхүү Галдан Зүүн гар улсын бүрэн мэдэлт хаан болоход Манжийн хаан Канси дургүйцсэнгүй. Галдан зөвхөн оросуудыг л айлгаж байв. 1672 онд Галдан Бээжин хот руу захидал бичиж элчин төлөөлөгчийг хүлээн авч, Хятад, Зүүн гар улсын харилцааг урьдын адил хэвийн үргэлжлүүлэхийг хүсчээ. 1673 оны 2-р сарын 4-нд Галдангийн элч нь Бээжинд хүрэлцэн очиж, уламжлалт “өргөл” билэг өргөж хариу ч авчээ. Энэ бүхэн зохих журмын дагуу болж өнгөрчээ.

1673 онд Галдан авга ах Цөхүр-Увашийг дайлаар мордов. Галдангийн эцэг баатар хун тайжийн төрсөн ах Хар хулын хоёр дахь хөвүүн Цөхүр-Уваш хааны ширээнд санаархан ач дүүдээ нүүр өгөлгүй хусагдсан хутагт хэмээн хочлон ойшоогоогүй юм. Цөхүр-Увашийг төвд рүү явсных нь хойгуур Галдан хутагт орныг нь эзлэн авчээ. “Дөрвөн Ойрадын чуулган”-ны тэргүүн хэмээн өөрийгөө үздэг Алашагийн Очирт цэцэн хан /Галдангийн хадам аав/

хүргэнээ Дөрвөн Ойрадын хаан болохоос сэрэмжлэн Цөхүр-Увашийг ивээлдээ авчээ. Ийнхүү хадам эцэг, хүргэн хоёр эрх мэдлийн төлөө зэвсэг хангинуулж эхлэв.

1677 оны хавар Очирт хааны цэргүүд Алашагийн уулсын баруун хойт хэсэгт “нумлан” хуарагнажээ. Энэ нь дайснаа бүслэн цохихын тэмдэг ажээ. Жаргах нарны туяа уулсын оройг гийгүүлж, битүү шугуй, бут, цайвар өнгийн үхэр чулууд өнгө хоршин алаглана. Иймээс ч эрт үеэс энэ уулыг “Эрээн уул” хэмээн нэрийджээ. Холын аянд ядарсан Галдангийн цэргүүд их тулааны өмнө амсхийн:

Асар майхнаа татаж

Аагтай цайгаа чанаж

Зүдэрч цуцсан цэргүүд

Зүлэг ногоон дээр хэвтэнэ

Хаан эрээн торгон бүрээстэй гэртээ унтаж амарна.

Үүр цайж,нар өндөрт хөөрөхийн өмнө Галдан цэргийн жанжингуудтайгаа зөвлөлдөөд:

- Ой ширэнгийн дайчин, говь цөлийн арслан, цэрэг эрсийн сүлд, ариун шүтээний бамбай болсон нөхөд минь, Очирт ханы цэргүүдийн байрлалын эсрэг хэрхэн яаж тулалдах вэ? – хэмээхэд,нэгэн ноён босож зогсоод :- Их эзэн минь, Та намайг хооллож, хувцаслаж өдий зэрэгт хүргэснийг чинь санаж танд үнэнчээр зүтгэе. Энэ байршлыг “Нуман түлхүүр” гэх бөгөөд “Бухын эвэр” хэмээх байрлалаар эсрэг тулалдах ёстой – хэмээв.

Ноёны саналыг нэгэн дуугаар зөвшөөрч, Галдангийн тушаалаар цэргүүд “бухын эвэр” байрлалаар яаран жагсав. Мөргөж байгаа бух ойр ойрхон, хүчтэй олон мөргөдгийн адил нум хэлбэртэй дайрах дайсныг огцом, гэнэт хэсэглэн довтлох арга байлаа. Галдан дайчиддаа хандаж:

- Ойн хөвчийн намуун шуугиан, харз усны мөнхийн хоржигноон, хүлэг морьдын төвөргөөн, нутаг газрын анир, миний хурц илд, бөх жад, хатаас сайтай сум болсон дайчид минь! Миний хадам эцэг Очирт цэцэн хан намайг хаан ширээнээс зайлуулахыг санаархан, авга ах Цөхур – Увашийг ивээлдээ авчээ. Тэгээд ч хэл амаараа нэр төрийг минь гутааж, өөрийгөө ойрад түмний эзэн хаан хэмээн тунхаглажээ. Доромжлолыг би үл тэвчин, хариугаа авахаар одоо ирлээ. Түшиг тулгуур болсон дайчид минь тулалдаанд урагшаа! - хэмээн уухайлав.

Алашагийн уулсын оройд наран мандахын өмнө Галдангийн цэргүүд дайсныхаа хүчтэй цохилтоос өрсөн Очирт ханы цэргийн байрлалыг зүүн, баруун талаас нь довтлон дайрав. Агаарт сум исгэрэнэ.

Довтолгоонд орсон морьдын төвөргөөн хөрст дэлхийг бөмбөрдөн, тэнгэр газар нийлсэн шороон үүлс татуулна. Галдангийн дайчид уухай хашгирсаар Очирт цэцэн ханы цэргийн байрлалыг дайрав. Усархаг бороо асгарч, жад илд хавиралдана. Нар өндөрт хөөрсөн хойно

Галдангийн дайчид Очирт цэцэн ханы цэргийн “нуман түлхүүр” байрлалыг хэсэглэн таслахад дайснууд тэвдэн, зулбаж эхлэв. Үхсэн, олзлогдсон цэргүүдийн илд бамбайг нь хуулан, зэр зэвсгийг нь хураав.

Очирт цэцэн ханыхан гэр бүлээрээ олзлогдов. Олзлогдсон хаан Галдантай улаан нүүрээрээ учирахыг хүссэн ч тэрбээр зөвшөөрсөнгүй “Ядарсан цагт хулгана ч ноён болдог” хэмээн Очиртын хэлүүлсэн үгэнд Галдангийн уур дүрсхийн: - Сээрийг нь шаагаад өг! - хэмээн зарлиг буулгав.

Эртний монголчууд толгойг нь авахыг ингэж нэрлэдэг байжээ.

Очирт цэцэн ханы бэлбэсэн эхнэр Ижил хавийн халимаг Аюки хааны охин дүү /зарим мэдээнд охин/ Дорж равданг албатынх нь хамт нутагт нь буцаагаад,

хэдэн мянган төвд монгол гэр бүлийг олзлон Зүүн гарын улсад аваачив [3]. Олзлогдсон язгууртнууд, хуяг дуулга, нум сум, зэр зэвсгийг 1677 онд Бээжинд аваачиж Кан-си хаанд бэлэглэхэд тэрбээр шударга биш явдал хэмээн татгалзсан боловч Галдантай харилцаагаа муутгахгүйн үүднээс болж өнгөрсөн үйл явдлын талаар үг цухуйлгасангүй.

Очирт цэцэн ханы харъяат хэсэг ойрадууд Хөх нуурын зүгт зугтаж манжид дагаар оров. Очиртын хань хамсаатан Лувсан-гомбо-равдан, Баатар-жонон нар ордосын Хаташан сүмийн орчимд очжээ.

Очирт цэцэн ханы цэргийг бут цохин түүний ивээлд багтсан авга Цөхүр-убашыг олзлон тэдний талынхныг цаазалснаар хаан ширээнд суух Галдангийн зам шулууджээ. 1677 онд Галдан хаан хэргэм хүртэж Зүүн гар улсын бүх Ойрадыг нэгтгэн захирагч болжээ. 1677 оны сүүлчээр Хятадад очиж байсан Халх-монголчууд “Галдан бол ойрадуудын хүчирхэг эзэн юм. Түүнд шороон түмэн морьт дайчид бий. Хэрэв дайлаар мордвол дотор газар /Хятад/ аргагүйн эрхээр хамгаалалтаа хүчтэй болгоно” [4] гэж үнэлж байв.

Галдангаас гадна хоёр хүчирхэг ойрадын аймаг байлаа. Оростой дотно Ижил хавийн ойрадуудаас Галдан жийрхсэнгүй. 1678 онд Галдангийн элч төлөөлөгчид “хил залгаа хөрш улсууд хил хязгаартаа эв сахих” [5]-ыг хүссэн хаанынхаа илгээлтийг Оросын хаанд барьжээ. Галдан баруун ба хойт хил хязгаараа тайван байлгаж, Хөх нуурын ойрадуудыг дайтан өөртөө нэгтгэхийг санаархжээ. Хөх нуурын ойрадууд түүний мах цусны тасархай төдийгүй, дээд үе болох Догшин ноён Гүүш хаантай хамсан Хөх нуурыг булаан эзэгнэж байжээ. Иймээс ч Галдан тэр нутагт хорхойсжээ. Гүүш хааны хөвүүдийн нэгнийх нь охин Галдангийн хатан байсан бөгөөд, нэг ач хүүд нь Галдан охиноо өгчээ.

Ийнхүү Хөх нуурын ойрадуудын нутгийн хэсгийг эзэмших эрхтэй хэмээн Цин улсын хязгаарын нэг ноён Чжан Юнд мэдэгджээ. Цин улсын засаг захиргаа Хөх нуур дахь хошууд аймгийн захирагч Далай баатар хунтайжид хил хязгаараа бэхжүүлэх, нутаг дэвсгэрээ хамгаалахыг даалгаад, гадна өнгөндөө Галдангийн Хөх нуурт санаархаж буйд саад хийхгүй гэмгүй царайлж, Алашагийн үйл явдлыг дахин гаргуулахгүй гэж бүхий л талаар сэрэмжилжээ. /”Цин улсын хил хязгаарт халдахгүй аваас Хөх нуурын ойрадуудыг Галданд өгөөш болгон хаяхад бэлэн байжээ.” [6]/ гэсэн нь Цин улсын далд санаанд Хоёр дахь Алаша

байхгүй гэдгийг сануулж байв.

Галдан аян дайнд бэлтгэсээр байв. Цин улсын засаг захиргааны мэдээлснээр 1678 оны арав, арван нэгдүгээр сард зугтан очсон Очирт цэцэн ханы дагаар орсон ойрадууд “Галдан хаан чинээлэг баячуудаас 10 морь, 3 тэмээ, 10 хонь, ядуусаас 5 морь, 1 тэмээ, 5 хонь албадан гаргуулж, цэрэг дайчдаа аван үл мэдэгдэх зүг рүү хөдөлсөн” [7] хэмээн мэдүүлснийг тэмдэглэсэн байна.

Энэ бүгдээс үзвэл Галдан Хөх нуурын зүг үнэхээр хөдөлсөн боловч арван нэгэн хоногийн дараа замын хагасаас буцжээ [8]. Ойрадуудыг нэгтгэх гэсэн зорилтын анхны алдаа энд гарчээ. Галдан айж хулчийсан бололтой. Ер нь өнгөлзлөг юугаар төгсөж байсныг тааварлахад хэцүү. Харин ойрадууд Галданг хаан ор суусанд таашаахгүй явснаа ойлгуулсан бололтой. Цин улсын сурвалж бичгүүдээс үзэхэд ар талдаа бослого самуун гарахаас болгоомжлон Галдан аянаа үргэлжлүүлэлгүй буцсан ажээ. Бүр эрт Сэнгийн үед татвар өгдөг байсан Ганьсу хавийн төвдүүд Хятадын ноёдод: “Галдан Хөх нуурт халдан довглохыг санаархаж байсан ч дээдсийн хүрээлэнд санал зөрөлдсөнөөс шалтгаалж, алс холын осолтой аянд мордноо ар талд хэрэг төвөг гарах вий хэмээн сэрэмжилж, зориглоогүй юм” [9] гэж мэдээлжээ. Галдангийн гол өрсөлдөгч, боломжтой үеийг хүлээж суусан Цэвээн-равдан ар талд үлдсэн байжээ. Хөх нуурын Ойрад ноёдууд ч Галдантай нийлэхийг хүсээгүй нь дараа дараагийн үйл явдлаар батлагдсан юм. Нэрт монгол судлаач В.Л.Котвич Монголын түүхийн лекцэндээ Галдангийн хаан суусан үеэс эхлэн “Ойрад аймгуудын холбоо улам бүр суларсаар байсныг” [10] зүй ёсоор тэмдэглэсэн байна. Ер нь манжийн аюулын эсрэг ойрад болон монголчууд нэгдэж тэмцэхэд бэлэн байжээ гэж дүгнэхэд бодит байдалтай хэзээ ч нийцэхгүй юм.

Тухайн үедээ Очирт ханыг бут цохисныг далимдуулан Халхын Түшээт хан Чахундорж ойрадын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцсон нь Галдангийн амьдралд хамгийн уршиг тарьжээ. Аюух ханы охин /охин дүү/ гэгдэх Очирт ханы хатан нь Чахундоржийн эмэг эхийн төрсөн эгч бөгөөд Чахундоржийн охин нь Очирт цэцэн ханы ач хүү Лувсан-Гомбо-Равдангийн эхнэр байжээ. Тэгээд ч Очирт хан Галдангийн эсрэг тэмцэхээр Түшээт ханаас туламж эрсэн боловч Чахундорж цэргээ илгээж, тулалдаанд оруулсангүй. 1678 онд зөвхөн эмэг эхийнхээ эгчийг /Очирт ханы хатан/ хамгаалахаар 300 орчим дайчдыг явуулжээ. Очирт ханы бэлбэсэн хатан Зүүн гарын нутгаар саадгүй нэвтэрч Ижил мөрний хавьд эсэн мэнд нүүж очжээ. Түшээт ханы Цэрэндашийн хэсэг цэргүүд Хятад руу явсан Галдангийн хөсгийг дээрэмдсэн нь Галдан, Түшээт хан хоёрын хооронд хагарал гарах шалтаг болж, эцэстээ Монголын түүхэнд уршиг тарьсан билээ.

Долоодугаар бүлэг

Туркменд дайлаар орж

Тал нутгийг нь эзлэе

“Сарны гэрэл”

Аппак / Афак/-хожа 1679 оны хавар Алтайд байсан Галдангийн өргөөнд хүрэлцэн иржээ. Хожда Исмаилын буруу номтон хар уулынхан мусалман шашинд үнэнч цагаан уулынхныг хөөн зайлуулсан Кашгирын гунигт хэрэгт явдал хэдийнээ өнгөрч, Хожа Аппак баруун Төвдийн чулуурхаг цөл, уул голыг гатлан хүнд бэрх замыг туулан Лхаст хүрэлцэн очжээ. Тэгээд Лхасаас дахин хөдөлж дорнод Төвдээр дамжин Хөх нуур ороод, одоохондоо буруу номтны эзэмшилд байгаа алдар цуут, хүчирхэг Кашгарын хойно орших Алтайд ирэх урт замыг туулах хүч хайрласан төгс хүчит Аллахын чадалд бишрэн явлаа.

Галдан хаан Хятад, Маргеланы үнэтэй торгоогоор засаж чимсэн нүүдэлчний цагаан эсгий өргөөндөө Аппакийг хүлээн авлаа. Хаан торгоор өнгөлсөн өдөн суудалтай, найман хөлтэй намхан суудалдаа заларчээ. Толгойгоо цагаан алчуураар ороосон, торгон хар хувцастай Аппак-хожа буруу номтон халимагуудын хаанд бөхөлзөн мэндлэхэд хоёр бараа бологч нь дуурайн тонголзов. Тос шаргалтсан сүүтэй цай, айргаар дайлав. Аппак том вааран хулаар / кэс/ хүйтэн айраг шимэн суухдаа ирсэн хэрэг зоригоос өмнө, сүүтэй цайнаас халгаж суув. Тэрбээр онгод тахигч Түвд орноор хөндлөн гулд хэсэхдээ бишгүй л амсаж явсан цай хэмээх энэхүү сүүтэй цутанг балгана гэхээс бөөлжис нь цутгана. Галдан хаан хэн яах гэж ирснийг сайтар мэдэж байвч хэлмэрчээр дамжуулан:

- Хүндэт зочин та хаанаас ирэв? - гэв.

- Эх нутаг минь Кашгар – гээд дахин бөхөлзөв.

- Нэр алдар хэн билээ?

- Аппак –Хожа.

- Хэнд зорьж юуг хүсэж явнам бэ?

- Их хаан таныг зорьж ирлээ. Таныг, танай иргэдийг Аллах бурхан өршөөг! Агуу их Далай ламын танд илгээсэн захидалд хэрэг зоригийг минь илэрхийлсэн – гээд Аппак хожда өврөө уудлан торгон илгэн хүүдийнээс төвдийн дөрвөлжин үсгээр хятад муутуу цаасан дээр хар бэхээр хаягласан захидал гаргаж өглөө. Хаан захидлыг аваад духандаа хүргэн адислаад уншиж эхлэв. Далай лам Аппакийн хүссэн бүхнийг бичив үү, аль эсвэл гай зовлон нүүрлэх зүйл бичив үү хэмээн тэрбээр сэтгэл түгшин суув.

Галдан амар амгаланг асуусан захидлын эхийг нүд гүйлгэн уншсанаа, зогсосхийн: “Кашгараас Исмаил хөөн зайлуулсан их хүн Аппакт төрөө төвхнүүлэхэд нь тусалж цэрэг дайчдаа илгээвэл зохино”[1] гэснийг хараад баярлав. Энэ захидал итгэлийг хадгалагч догшин

бодисадва бурхадаас буяныг зөгнөн илгээсэн бичиг ажээ. Хөх нуурын аянаас буцаж ирснээсээ хойш аян дайны шалтаг сүвэгчлэн ядсан түүний хувьд энэ ходжагийн нүүр барин Далай ламын бичсэн захидлаар далимдуулан Кашгар руу мордох боломж олдсонд Галдан баярлана. Өмнө алдсанаа залруулахад өвөг дээдсийн шалгарсан арга дутуугаа бусдаас гүйцээх учрыг Галдан сайтар мэднэ. “Цустай болгоныг хядаж, цулбууртай бүхнийг хөтлөн өсчээ. Эр болгоныг алж, эм бүхнийг хулгайлж хүслээ хангаж явжээ “хэмээн авга ахаасаа багадаа сонссоноо санав. Хаан баярлаж хөөрснөө нууж, аян дайнд бэлэн гэдгээ цухуйлгалгүй:

- Бодьё - гэв.

Аппак хожагийн эргэлзсэн царайг ажаад захидлын агуулгыг бүрэн гүйцэд мэдээгүй гэдгийг нь Галдан таамаглаж:

- Таны алс холын бодлыг гүйцэлдүүлэхэд яаж туслахаа бодьё - гэв.

Тэгээд айраг, архи сөгнөж найрлаж эхлэв. Хаан далай ламын бие лагшинг асуугаад түүнийг Лхаст хэрхэн яаж хүлээн авсан, Далай ламын орд барьж дууссан эсэхийг сонирхов. Аппак ч ажил хэрэг ярьсангүй, Аллахдаа залбиран суулаа.

Хэд хоносны дараа Галдан дахиад л Аппакийг урьж, бөх барилдахыг сонирхуулав. Талбайн голд хоёр бөх гарч ирээд нэг нэгнээсээ: - Яаж барилдах вэ? Илд зэвсгээр үзэлцэх үү, эр бяраар барилдах уу? - хэмээн асуугаад: - Илд зэвсгээр үзэлцсэнээс, эр чадлаараа барилдацгаая! – гэв.

Хоёр бөх бух юмуу, бугын ширээр оёсон зузаан хүрэн арьсан шалбуур багтааж ядан өмсөөд, олон өнгийн торгон даавуугаар томсон бүсээ мөнгөн горхинд нь оруулж чанга татан бүслэв. Бөхчүүд ээмгээ авч, үсээ гээг болгон ороогоод, харцага адил дэвэн, тогоруу адил дэвхцэн, бохисхийн шаваад, мөргөлдөх гэж буй шиг тулан зогсцгоов. Тэгээд нэг нэгнийхээ гараас барин тавин зууралдаж, барилцаж аваад ар нуруугааар нь шороодуулхаар ноцолдож эхлэв.

Архинд халамцсан Галдан бөхчүүдийг нүд салгалгүй ширтэнэ. Ноцолдож ноцолдож нэг нь нөгөөгөө нуруугаар нь унагаж, дал нь шороодмогц, хаясан бөх унасан бөхийнхээ цээжинд өвдгөөрөө тулаад босон харайв. Галдан гэнэт Аппак ходжа руу эргэж хараад согтуу нүдээр цоортол ширтэн: - Исмаил хожатай ингэж л үзнэ дээ! – гэв.

Ийнхүү хаврын адаг сарын сүүлчээр /6 рсарын 7!/ ойрадын цэргүүд Кашгар, Яркенд / Самарканд/ рүү дайлаар мордов.

Аппак хожа хааны бараа бологч ноёдын хамт тулааны эхлэлийг ажиглаж зогсов. Хааны хамгийн дотно өвгөн ноён арслантай цагаан авдар онгойлгож, цайвар хөхөвтөр мөнгөн дуулга гаргаж ирэв. Дуулганы хажуу талаар одод, саравчинд нь нар, сарыг цохиж товойлгожээ. Хаан гээгээ хумхин дуулгаа хөмсөг хүртлээ дарж өмсөв. Өвгөн дахиад хоёр хүрлэн бурхан гаргаж харуулав. Бурханы энгэрт ноцолдож буй арслан, заан, гэдсэнд нь шүтээн шувуу гарьд, цээжинд нь Хонжин бодисадва бурхан, мөрөнд нь Дарь эхийг тус тус товойлгон сийлбэрлэж, аюумшигт хар мангасыг толгойгоор нь газар савахаар мөрөвчилжээ. Нэгэн зарц бурханыг өргөж, хааны өмнө очиход, өвгөн ноён хаанд сум өгөв.

- Багц гучин цагаан сумны дунд хамгийн хөнгөн, хурц, тасын живэртэй алтарсан оньтой, ган үзүүртэй, хөнгөн модоор хийсэн сум нэг л байдаг, – хэмээн хэлмэрч Аппакт тайлбарлав.

Өвгөн ноён дахиад хаанд мөргөлдөж буй хонь ямааны сийлбэр бүхий нум өгөв. Бугын эврээр доторлож, хурдан хүлгийн шөрмөсөөр ороосон чанга нум, - гэж хэлмэрч тайлбарлав.

Хаан нумаа саадганд нь хийхэд өвгөн ноён олны нүдэн дээр илд өргөн харуулав. Олон дархчуул давгаж хийсэн илд. Дөрвөд дархан давгаж, хятад дархан хээлж, орос дархан хатыг нь тохируулж, балба дархан чимэглэж, халх дархан цоолборлосон, ган иртэй, хас чулуун бариултай, хаж мөнгөн сийлбэртэй илд байна, - гэж хэлмэрч тайлбарлав.

Алтан бүрээстэй хуйнд илдийг гялсхийн хуйлаад, өвгөн ноён хүндэтгэлтэйгээр гардуулахад хаан аваад зүүв.

Эцэст нь булганы арьсан бариултай, хурц үзүүртэй хүрэн жад барив. Тэгээд морь хөтлөн ирэхэд хаан нэг гараараа цулбуураа авч, нөгөө гараараа хондлойг нь илж :

- Аюумшигт дайсанд аянга, алд биенд минь түшиг, алс нутагт унаа, аавын хүүд нөхөр байтугай! - хэмээн ерөөв.

Галдан эмээл дээрээ сэвхийн мордоод, дохио өгөхөд дайчид замд гарав. Тэмээнд чирсэн хэд хэдэн их буу, зэвсэгт дайчдыг Аппак ходжа онцлон сонирхох авай.

Ойрадууд эрт үеэс Моголын гүрэн Дорнод Туркестантай харилцаа холбоотой байснаар барахгүй хэсэг ойрадууд исламын шашинд орж Моголын хааны албат явжээ [2]. Яркенд / Самаркандын/ хаадын дэргэд моголын засаг захиргааны өндөр албанд ойрадууд ажиллаж байв. ХҮП зууны дунд биеэр ойрад моголын харилцаа гэнэт өөрчлөгдөв. 1660 онд ойрадын эсрэг довтолсон Абдалла хан бут цохигдож, 1665 онд ойрадууд Керш, Чальш, Аска, Кашгарыг эзлэн, 1668 онд Абдалла-хан аргагүйн эрхэнд Яркендыг орхин Энэтхэг рүү зугтав. Ойрадын захирагч Сэнгэ, Элдэн тайж нар төлөөний хүнээ Яркендэд суулгажээ. Сэнгийн төлөөний хүн нь Иолбарс хан, Элдэн тайжынх Исмаил хожа байв. Эцэст нь Иолбарс хаан Кашгарын захирагч болоход, Элдэн-тайж Ислам хожа-г Аска /муж/-ын эзэн суулгаж, тэдний хооронд дайн дэгдэв. Иолбарс ханы харьяат ойрадууд бослого гаргаж, 1670 онд Исмаилыг Яркендын захирагч болгожээ. Аппак хожа ийнхүү Исмаилтай зөрчилдөн, аргагүйн эрхээр Төвд рүү зугтан гарчээ. Нилээд сүүлд ойрадууд Исмаилыг төрийн эрхээс зайлуулсан юм.

Энэхүү боломжтой нөхцлийг ашиглаад Галдан Дорнод Туркменыг бүрэн эзэгнэхийг санаархав. Ойрадууд Дорнод Туркменд дайтсан түүх тун бага судлагдсан юм. Хятадын эх сурвалжаас үзэхэд Галдан найм, есдүгээр сард Турфанд довтолж, 1679 оны зун хоёр ч удаа лалыхныг дайлаар морджээ. 1679-1685оны хооронд моголын эсрэг Галдан наад зах нь 4-н удаа довтолжээ [3] гэж энэ түүхийг судалсан О.Ф.Акимушкин баталж байна. Түүхийн сурвалж бичгүүдээс үзэхэд Галдан 1679 - 1680 онуудад Кашгар, Яркенд, 1681 оны сүүлчээр Турфан, Хамийг эзлэж, 1680-1688 онуудад казахуудтай дайтаж, 1686 онд тэдний эсрэг дахин довтолжээ. В.Л.Котвич энэ үйл явдлыг хөндөн: “Энэ үед Дорнод Туркменд шашны хоёр бүлэг сөргөлдөж, эхлээд нэг нь Галдангаас тусламж эржээ. Галдан ихэд баярлан, туслах нэрээр 1680 онд Дорнод Туркменийг эзлэн авчээ. Чингис хааны гэрээсийг даган тэнд өмнөх зохион

байгуулалт, дэг журмыг эргүүлэн тогтоож, цэрэг дайчид бүхий төлөөний хүнээ суулгаж, киргисүүдийг давхар харьяалуулжээ”[4] - хэмээн тэмдэглэжээ.

Ойрадууд дорнод Туркменыг эзлэн аваад орон нутгийн ходжа нарт тулгуурлан хяналтаа тогтоохдоо засаг захиргааны хуучин бүтцийг эвдсэнгүй. ”Ойрад болон хотан /бухарчууд/-ын хооронд гарсан ямарваа маргааныг нарийвчлан хянах ёстой. Бид тэдэнд төрөл саднаа хэмээн хандана. Бухарчууд өөрсдөө хууль, шүүхтэй байх бөгөөд чухал хэргийг нь бид шийдвэрлэнэ [5] –хэмээн ойрадууд дорнод Туркмены иргэдийг /юуны өмнө дээдэс / холбоотон, төрөл садан гэж үзээд далдуур сэрэмжлэхээ мартсангүй. Дорнод Туркмены хүн бүр сард нэг танга / мөнгөн тэмдэгт/ татварт өгдөг байв.

Дорнод Туркменыг эзлэн авсан зорилго, үр дагаврын талаар эрдэмтэд өдий хүртэл санал зөрөөтэй байна. Ойрадын гадаад бодлогоос үүдэн гарсан Дорнод Туркмен, ойрадын хоорондын сөргөлдөөн нь халх ойрадын харилцааг 2-р зэрэгт тавьсан юм [6] гэж И.Я.Златкин үзэж байхад Цин улсыг эсэргүүцсэн Галдангийн бодлого нь дорно зүгт чиглэн, дорнод Туркменыг эзлэн авснаар ар талаа бэхжүүлэх зорилготой байсан [7] гэж Ш.Чимиддоржиев үзжээ. Нэг талыг хэт барьсан дээрх дүгнэлтүүд нь Галдангийн бодлогыг зөв тодорхойлж чадахгүй юм. Өвөг дээдсийн гэрээслэлийг хэрэгжүүлэхийн үүднээс Галдан дорнод Туркменыг эзлэсэн гэж батлах ноттой баримт байхгүй. Галдан дорнод Туркменыг эзэмшилдээ оруулсан нь өөрийн гэх тодорхой зорилго агуулж байжээ.

Галдангийн энэ ялалт нь дорно зүгт санаа зовохгүй /өөртөө дайсагнагч ач Цэвээн-равданг байсаар байхад / өрнө дорнодод адилхан хандах боломжийг нээж өгсөн байж болох талтай. Дорнод-Туркменд санаархаж, нөлөөгөө дэлгэрүүлэхийг хүсэж байсан Цэвээн-равдантай муудалцсан Галдан Дорнод Туркменыг эзлэхдээ ямар зорилго агуулсан нь тодорхой биш билээ. Ямар ч гэлээ Цэвээн-равдан Галданг хүчтэй болоход дургүйцэж, Цин улстай холбоо тогтоож, “алахыг санаархсан” [8] нь тодорхой. Гэхдээ Цин гүрний дээдэс Галданг заналт дайснаа гэж санаагүй байв. Учир нь тухайн үед Галдан, манжийн хаант улстай дайтах бэлтгэл, алсын бодлогогүй байсан бололтой.

Гэхдээ дорнод Туркменыг эзэмшилдээ авсан нь Хятадын Цин гүрэнтэй тэмцэлдэхэд Галданд гол тулгуур болсноор барахгүй, Цэвээн-равданд эзлэгдсэний дараа Зүүн гарыг эзэгнэх түшиц газар болжээ.

* * *

Галдан аян дайнаас ялалт дагуулан буцаж ирэхэд, түргэн урсгалт голын өргөн хөндийд хааны хүрээ төвхнөсөн байв. Хааны авч яваад ирсэн ариун судар Гаанжуур, Даанжуурыг гавшгай шавь нар тэр дор нь тэмээнээс буулгаж байранд нь залав. Ноёдууд үй олон харьяат албат нараа дөрвөн хошуу малын хамтаар тараан байрлуулав. Хааны ордон-өргөө нь наян уньтай гэр байлаа. Гэрүүдийг тойруулан сийлбэр бүхий хайс хатгажээ. Хайсны цаана зарц нарын сууц болон цахарууд байрлана. Хүрээний өмнө хэсэгт хурал хурах газар, бурхны шүтээнүүд буй.

Хаан зузаан эсгий дээр хэвтэж, хааны шадар Шар-бодон баатар зайдхан суужээ. Хоол унд, архи дарс уугаад хоёул “улаан зээрд” болжээ. Шар-бодон Галданд өргөмжилсөн шинэ хэргэм,

саяхны ялалтын талаар дахин дахин сануулж:

- Хаан та дайснаа дарж, дархан цолоо оллоо. Алалдах дайсангүй, аз жаргалтай, өвөлгүй зунтай, үхэлгүй мөнхөд, хаваргүй намартай, хамаг даяар цэнгэлтэй, санаа сэтгэл түвшин, сав суулга бялхаж, түмнээрээ төгөлдөр, ардаараа амгалан явах болтугай! Хаан та шинэ хэргэмээ хүлээн авах хэрэгтэй,- гэв.

-Ямар хэргэм билээ? Хэргэм хайрла гэж хэнд хандах болж байна? Хятадаас гуйх хэрэг үү? Богд хаан ван цолоор шагнадаг ч, хаанаас дээгүүр хэргэм гэж үү? Би түүнээс хэргэм горилохгүй.

- Шарын шашны ариун хэргэм хүртэх ёстой!

- Далай ламаас гуйх уу?

- Яалаа гэж дээ. Төвдөөс хэргэм хайрласныг батласан бичиг ирнэ. Ийм хэргэм цолгүйгээр их хэргийг хөтлөн явуулах боломжгүй шүү, хаан минь!

Галдан Шар-бодонг ширтэн ажиглана. Хэтэрхий залирхаг, ухаалаг туслагч нь түүний санаа - бодлыг уншсан адил мэдэж байв.

- Шар-бодон чамд энэ хэргийг даалгая.

- Тааллаараа болтугай!

Үүнээс 2 сарын дараа Далай ламаас хэргэмд өргөмжилсөн жуух хүргэх элч Төвдөөс ирж яваа мэдээг их хаан Галданд сонордуулахаар цагаан тоос татуулан морьт элч давхин ирэв. Элчийг хөл болон, найр хийн хүлээж авлаа. Үнэт цаасан дээр төвдөөр бичсэн Далай ламын жуухыг цоохор торгоор ороожээ. Жуух бичигт: Галданд “бүрэн эрхэт” [9] Бошгот хаан хэргэм шагнасныг уламжилжээ. Монгол уламжлалаар залуу чийрэг дайчид хааныг цагаан эсгий дээр суулган өргөж хүндэтгээд арз, хорз бялхсан том найр хийв. Орчлон ертөнцийн хувь заяа шалтгаалах бүрэн эрхийг Далай ламаас авснаар ариун үнэний сургаалд үнэнчээр зүтгэх цаг ирлээ. Галдан бошгот хаан хэргэм хүртсэн нь түүнд сайн сайхныг авч ирсэнгүй.

Галдан энэхүү хэргэмийг хэдийд авсан талаар эрдэмтдийн санал зөрөөтэй байна. Бүр эртТөвдөд шавилан суухдаа авсан, хойно нь 1671 онд ах нараа ялаад хаан ор суух үедээ авсан, 1678 онд Очирт ханыг бут цохиж бүх ойрадууд зөвхөн түүний зарлигийг даган сахих болсон үед авсан [10], Дорнод Туркменд ялалт байгуулаад авсан гэж янз бүрээр үздэг ажээ. 1679 оны 9-р сард Хами, Туркменыг эрхшээлдээ оруулсаны дараа энэ хэргэмд өргөмжлөгдсөн [11] хэмээн Ханада Акира үзжээ. Ш. Чимиддоржиев дээрх саналыг зөвшөөрч “1679 онд Далай лам Галданд Бошгот хаан хэргэм хүртээж, бурхан тэнгэрийн бошгоор хаан болсон хэмээн зарлажээ” [12] гэж бичжээ. А.М. Позднеев Галдангийн бошгот хэргэмээр өргөмжлөгдсөнийг Дорнод Туркмены хэрэг явдалтай холбон: “Дорнод Туркменыг дайлаар мордон эзэлсний төлөө Далай-ламаас Бошгот хаан цол хүртжээ” [13] хэмээжээ. Харин Н.Я.Бичурин Очирт ханыг болон Дорнод Туркменыг ялсны төлөө Галдан энэ хэргэмийг авсан гээд: “Галдан цэргийн гавьяа байгуулж Далай-ламаас Бошгот хаан цол хүртсэнийг элчин яамаар дамжуулан

хятадуудад мэдээлжээ” [14] хэмээн бичжээ. Галданд бошгот хаан хэргэм өргөмжилсөн мэдээг хятадууд 1679 оны 10-11 сард авсан бололтой. “Галдан-тайж Далай ламын ивээснээр Бошгот хаан болж бэлэг гардуулах элч төлөөлөгчдөө илгээжээ.” [15]. Хятадын Цин улсын гадаад харилцааны газрын илтгэлд Галдангийн элч төлөөлөгч мэдэгдэхдээ: “Далай лам Галдан тайжийг өргөмжлөн түүнд Бошгот хаан цол хүртээжээ” [16] хэмээсэн байна.

Ер нь Галдан чухам хэдийд Бошгот хаан хэргэм хүртсэн нь тодорхой бус юм. Дорнод Туркменыг ялсныхаа дараа 1679 оны / нэг, хоёр жилийн хойно ч/ зун авсан

байж болно. Гэхдээ ямар замаар авсан нь ч маргаантай юм. Зарим сурвалж бичигт Галдан өөрийгөө бошгот хэргэмд өргөмжилсөн гэж байхад, зарим нь Төвдийн тавдугаар Далай лам түүнд өгсөн гэж ч үздэг. Төвдийн сурвалж бичгүүд болон Далай ламын намтарт: “1678 оны 6 сарын 30 - нд Далай лам Галданд элч илгээн Бошгот хаан – “Галдан - эрдмийн тулгуур” цол хэргэм хүртээжээ” [17] гэсэн байдаг. Гэтэл Хятадын сурвалж бичигт Галдан шинэ цол хэргэмээр шагнагдсан тухай мэдээг Цин улсын дээдэс Төвдөөс биш хаанаас өөрөөс нь сонссон гэдэг. Харин М. Куран Төвдийн засаг баригч Санжжамц эртний нөхөрлөлөө санан Галданд Бошгот хаан цол хэргэм өргөмжилжээ гэсэн саналыг дэвшүүлжээ. [18]. Энэхүү санал зөрөлдөөнийг үл хэрэгсэн В.Л.Котвич: “Далай ламтай тогтоосон хувийн харилцаагаа ашиглан Галдан өөртөө Бошгот хаан цол хэргэм өргөмжилжээ” [19] гэж тэмдэглэсэн байна. Иймэрхүү санааг монголын түүхийн “Эрдэнийн эрхи” зохиолд “Өөлд гарлын Галдан багадаа шашны хэргэм хүртээд Далай ламын ивээлд суралцахаар оджээ. Тэгээд Зүүн гар улсаа буцаж ирэхдээ Далай лам түүнд Бошгот хаан цол хэргэм өргөмжилсөн хэмээн худал хэлж, хууран мэхэлжээ” [20] гэсэн байдаг.

Энэ цол хэргэмээр өргөмжлөгдсөн нь тодорхой зорилготой байсан нь мэдээж.

Тэрбээр эрх мэдэл, өндөр суудалд хүрэхдээ энэ цол хэргэмээ ашигласан юм. И. Я. Златкин: “Энэхүү цол хэргэм хүртсэн нь Далай ламын тойрон хүрээлэгчид, нэр нөлөө бүхий дээдсийн төлөөний хүн болсон Галдан, сүм хийдийн хоорондын онцгой харилцааны баталгаа болж өгсөн юм” [21] хэмээжээ. 1679 онд Галдан “Далай ламын ойр дотны, нэр нөлөө бүхий хүмүүсийн төлөөний хүн болжээ” гэсэнд итгэх аргагүй юм.

Галдан тухайн үедээ Алтан хан Лувсанг олзноос суллан тавьжээ. Алтан хан Оросын хязгаар нутагт очиж, Красноярскийн захирагчид “Киргисийн эсрэг дайтахыг” санал болгожээ. Хятадын сурвалж бичигт Галдан Алтан хааныг ойрадын олзонд 9 жил байлгаж, дараа нь Засагт ханд илгээжээ. 1680 оны 8, 9-р сард Галдан Цин улсын хаанд их бэлэг илгээжээ.

Кан-си 10-р сард /XI сарын 3-наас XII сарын 3/ Галданд яаралтай хэл хүргэж, Галдангийн өвөг аавын албат Цөхүр-увашийн Эрдэнэ хошууч тайжийг барьж өгөхөд туслахыг гуйжээ. Цөхүр-уваш бут цохигдон Эрдэнэ хошууч Зүүн гар улсаас ачаа дагуулан зугтах замдаа ядарч зүдэрч явахдаа Цин гүрний хамжлага урутуудыг дээрэмдэн тоножээ. Гэхдээ Галдан Эрдэнэ хошуучийг барихыг бодсонгүй. Үүнээс болж, Галдан, Цин гүрний дээдсийн хооронд удаан хугацаанд маргаан дэгдэж, албат биш гэдгээр шалтаглан Галдан Эрдэнэ хошуучийг баривчлахаас цааргалж байжээ [24].

Нэгдсэн хүчирхэг Зүүн гар улсыг байгуулахыг санаархсан Галдан Хятадын эзэнт гүрний

дуулгавартай гүйцэтгэгч байхаас татгалзан, төрөл нэгтнийхээ эсрэг Бээжингийн заавраар зэвсэг хангинуулахыг хүссэнгүй. Хөх нуурт дайлаар мордохоос татгалзаад 80-аад оны эхээр бүх ойрад аймгийг нэгтгэх боломжгүй гэдгийг Галдан ойлгон, Зүүн гарын улс ойрад аймгуудын дэмжлэггүйгээр бэрхшээлтэй болохыг ч мэджээ. Мах цусны болон төрлийн хэлхээ холбоотой Ижил хавийн ойрадуудын дээдсийн санал ойрад аймгуудын дотоодын маргаан сөргөлдөөнийг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой хэвээр байв. Урьд өмнө нь Хятад Төвдтэй нарийн холбоотой байсан төрөл нэгтнүүд байршил нутгийн хувьд Зүүнгар улс, Цин улсын болон Төвдийн хоорондын харилцаа ер нь монгол, ойрад аймгуудын холбоонд онцгой нөлөө үзүүлэх боломжтой байжээ. Богд хааны зарлигийг сохроор даган гүйцэтгэгч Зүүн гарын хаан Хөх нуурын ойрдуудын таашаал хүртээд зогссонгүй, Төвдийн тогтвортой байдлыг хангахад Лхасын зүгээс тусламж горьдох аргагүйд хүрчээ. Ер нь Цин улс, Хятадын далд санаа, бүрэн эрхт байдалд холбоотноо нэгтгээд ч нөлөөлж чадахгүйд хүрчээ. Иймээс ч Зүүн гарын оргодол тайж Эрдэнэ хошуучийг албат биш гэдгээр далимдуулан, урьдын дайснаа барихыг бодоогүй нь Галдангийн хувьд үндэслэлтэй байжээ.

Наймдугаар бүлэг

Салхи тогтож ертөнц шүүдэрт умбана

Саран нартай тэнгэрт шуурга намдана

Бид ч удахгүй хөрсөн доор нойрсоно

Биеэ биеэ зовоодог тэрслүү тэр хэн буй.

М.Цветаева

Бид одоо Галдан хааны нэрийг Азийн түүхэнд оруулсан тэр үйл явдлуудтай холбоотой амьдралынх нь шийдвэрлэх жилүүд, Халх дахь Галдангийн бодлого, Цин үеийн Хятадтай сөргөлдөх болсон хийгээд Халх Хятадад нэгдсэнээс болж мөхөлд хүрсэн тухай өгүүлье. Галдангийн үйл ажиллагааны энэ талаар бичсэн түүхчдийн үнэлэлт ч их зөрчилтэй. И. Я. Златкин түүнийг эцсийн эцэст биеэ даасан бодлого баримталж чадаагүй, Лхасын төлөөний хүн гэж үзсэн байдаг [1]. А.М Позднеев, Г.Е.Грумм - Гржимайло нар зохих шийтгэлээ хүртсэн түрэмгийлэгч [2], Ш.Нацагдорж, Д.Гонгор, Ш.Чимиддоржиев нар Монголын эрх чөлөө тусгаар тогтнолын төлөө тэмцэгч [3] гэж үзжээ.

Галдангийн хувьд Халхын хэрэгт оролцох болсон шалтгааныг санацгаая. Засагт ханы зарим хүмүүс эзэмшил нутагт нь хэрүүл тэмцэл гарснаас болж Түшээт хан руу зугадан нийлжээ. Үүнээс үүдэн Засагт хан Цэнгүн, Түшээт хан Чахундоржтой зарга заалхай хийж эхлэв. Гэлээ ч Чахундорж хүмүүсийг нь эс өгөв. Засагт хан Түшээт ханд гомдсоноо Манжийн эзэн хаанд илэрхийлж, Кан-сигийн бичсэнээр “Чахундорж манай албат, босуулуудыг булаан авч дарлаж байна” гэжээ. Алба гувчуур төлөгчдөөс үүссэн энэхүү зарга нь Засагт хан Түшээт хан хоёрыг дайсагналцахад хүргэжээ. Засагт ханы талд орох нь ашигтай хэмээн Галдан шийджээ. Түшээт ханы төрөл нь болж түүний дэмжлэгийг авдаг байсан Очирт цэцэн ханыг бут цохигдсоны дараа Галданд Түшээт ханыг үзэн ядах бодит үндэслэлүүд байсныг бид мэднэ. Эвгэй найрсаг хөрш Засагт ханыг хүчтэй болгох үүднээс Галдан Түшээт ханыг сулруулахыг хүссэн үү, эсвэл энэ нь анхнаасаа Цин үеийн Хятадад захирагдах заналхийлэл учрах гэж байсан Халхыг захирах алсын зорилготой байсан уу гэдэг асуултад хариулахад төвөгтэй юм. Халхын хэрэгт оролцох учир шалтгаан нь Галданг Цин үеийн Хятадтай сөргөлдүүлж, өөрийг нь мөхөлд, халх монголчуудыг ч гай зовлонд унагав. Ер нь монголчууды хувьд Манж, Хятадын талаас явуулж буй аюул заналыг Галдан хааны үйл ажиллагаанаас харж болох уу? Үүнд хариулахад хэцүү, хэдийгээр тийм санал зонхилж байгаа ч гэсэн гартаа барьсан баримтгүйгээр батлах гэдэг бүүр ч амаргүй. Ш.Чимиддоржиев бичихдээ: “Галдан бол гадаадын аюул заналын өмнө монголчуудыг нэгтгэх уриа дэвшүүлсэн, үүнд ч гол үүрэг гүйцэтгэсэн” [4] гэжээ. Х.Ховорс Өвөр-монголын ноёдод илгээсэн захидлынхаа нэгэнд Галдан бүх Монголыг нэгтгэх шаардлагын [5] талаар шууд бичсэн тухай мэдээллийг иш татсан байдаг. Нэгэн монгол гар бичмэлд зохиогчийг нь заалгүйгээр залуу Галдангийн: “Тэд Зүүн гарын улсад ч ирнэ. Кан-ситэй ч үзэлцэх болно” [6] гэсэн үгсийг оруулсан байдаг. Гэвч энэ нь хожим дураараа оруулсан үгс ч биш, дараа нь болсон үйл явдлын тайлбар ч биш гэсэн баталгаа биш.

Зөрчлийн эхлэлийг Цин улсын эрх баригчид халуун мөрөөр нь хэрхэн дүрсэлснийг үзье. “Эзэн хаан арван мянган улс гүрэн, эзэмшил нутгаа гайхалтай удирдаж, гадаад хил хязгаарын дотор аж төрж буй нийт ард түмний хувьд ч хаан нь болж байна. Түүний уран цэцэн үгс нь ухааруулах увьдистай, буянт хүч нь элбэг баян, цэргийн гавьяа нь аугаа их, бүхнээ илт, өөрөө ч хүнд хайр халамжтай, алагчлахыг мэдэхгүй шударга, хамгийн алс холын муж улсууд нь ч соёл иргэншлийн зүг нэгэнт тэмүүлж, түүний сургаал нь ч хамгийн аглаг зах нутагт ч хүрчээ. Бүхий л ертөнц энх тунх, эв эетэй аж төрж... дотооддоо ч тэр, гадаадаа ч тэр, түүнд захирагдаагүй улс гүрэн, түүнд үйлчилдэггүй албатууд гэж ер үгүй. Зөвхөн өчүүхэн, зэвүүцэм, бүтэлгүй ойрадын Галдан л соёл иргэншлийн зүг өөрчлөлт хийхэд болон холбоо тогтооход ч эсэргүүцэл үзүүлсээр байна. Өөрийн алс зэлүүд, аюултай нутагтаа түшиглэн, тэрээр цэрэг дайнд суралцан, хорь гаруй жил хорон санаат дээрэм, тонуул үйлдсээр ирлээ. Тэрээр баруун зүгийн ойролцоох улс гүрэн рүү довтлохдоо хот цайзуудыг нь устгаж, бараг бүгдийг нь эзлэн авчээ. Түүний нутагт том том, ус ургамалгүй элсэн ба чулуурхаг цөлүүд бий. Тэрхүү уйтгарт цөл, улайдам элсэнд яаж ч хил хязгаар тогтоох аргагүй. Түүний хүмүүс нь зэрлэг, хэрцгий, эр зоригтой, шазруун, биеэ авч явах горим, шударга ёсыг мэдэхгүй, ажил албаны бүх горимыг уландаа гишгэчиж, ямарваа дэг журмыг ч зэвүүцнэ. Тэдний энэрлээр итгэл хүлээх боломжгүй. Тэд цаггалан байхдаа их зантай, яг л дарвуул шиг хийрхэнэ. Өлсөхөөрөө арга нь барагдан, бие биеэ хашгирч дуудан хэсэг бүлэг болж, нэг газраа тогтож суухгүй, ийш тийшээ нүүдэллэн, зэргэлдээх нутгаа дээрэмдэн, ханахыг үл мэднэ. Тэгээд ч тэд бидэнд захирагдсан халх аймгуудыг зовлонд унагав. Тэдэн рүү дайран, хүмүүсийг нь дээрэмдэн, мал сүргийг нь хөөн одно. Тэдний учруулсан хор уршгаар орох оронгүй, оочих аягагүй, заяа нь орхисон хүмүүс хил дээр бөөгнөрөхөд хүргэв. /Галдангийн.-Е.К/. Түүний санаа нь ихэмсэг, дээрэнгүй болохыг тооцон үзээд, хүнийг хайрлах сэтгэл нь тэнгэр газрын зүгээс тэднийг ивээдгийн адилаар манай эзэн хааны тэвчээр алдагдан их цэргээ аянд мордуулав” [7].

Энэ бол Хятад хувилбар.

Зарим судлаачид Галданг Монгол улсыг болон Хятадын эсрэг бүх монголчуудыг нэгтгэх чадвартай шинэ Чингис хаан мэтээр үзэж байлаа. Өөрийн судалгаандаа “Манжийн эзэнт улс уу, эсвэл Халимагийн эзэнт улс уу?” гэсэн нэр өгсөн Францын түүхч Морис Куран Зүүн гарын улсыг Шарын эзэнт улс [8] хэмээжээ. Үнэхээр “Цин Ши Лу”-д Төвдийн төрийн эрх баригч Санжаажамц ойрадуудыг “шарын сургаалын” [9] гол хамгаалагчид хэмээн зарлажээ. Гэхдээ энэ бол Хятад мэдээлэл. Хэрвээ Төвдийн хувьд заналхийлсэн XVII зууны эцсийн тэр нөхцөл байдалд Санжаажамц тийн мэдэгдэл хийсэн бол бодит түүхэн асуудал хэзээ ч байсангүй. “Энэ өдрөөс /Дорнод Туркестан дахь ялалтаас –Е.К/ өөрийнхөө амьдралын эцсийг хүртэл тэрбээр яг л цэргийн жанжин, албан хэлэлцээр хийдэг дипломатч лугаа өрнүүн үйл ажиллагаа явуулж байсан гэж М.Куран зөв тэмдэглэжээ. Тэрбээр Монголд Түшээт ханы эсрэг зогсож, Засагт хан, Далай ламын эрхийг хамгаалж, хасгуудтай байлдаж, тэднийг захирч байв. Узбекүүдийн өмнө бол лалын шашныг нь талархан нахилзана. Иссък-Кулын Киргизүүдийн зүгээс бол тэрбээр талархал дэмжлэг хүлээнэ” [10].

“Халхыг захирах гэсэн Галдангийн эрмэлзлэл нь ойрадуудын хувьд улс төрийн шинэ бодлого биш. Энэ нь ойрадын феодал язгууртан ноёдын ивээл дор Юань улсыг мөхсөн үеэс явуулж ирсэн бүх Монголыг нэгтгэх бодлого байлаа” [11] - гэж Ж.Чимэддоржиев бичжээ. Халхад

өөрийн бодлогоо идэвхжүүлэх үед ч Галдан бүх ойрадуудыг нэгтгэж чадаагүй байв. /Ижил орчмын халимагууд, Хөх нуурын ойрадуудыг ч бид анхааралдаа оруулаагүй юм. Галдантай зэргэлдээх нутгийг эзэмшиж, цоросын омгийг захирагч, тэр омгийн төлөөлөгч ганц Цэвээн-равдан юу болох билээ/. Зөвхөн л Зүүн гарын улсад өөрийн эрхийг бэхжүүлэх батжуулах тухай л боддог байлаа. Дорнод хил хязгаараа тэлэх, түүний аюулгүй байдлыг бэхжүүлэхийн төлөө санаа тавьснаас болж, Халх хятадад захирагдаж магадгүй болсон нь түүний санааг зовоож, Халхын хэрэгт оролцох болжээ. Үйл явдлын өрнөлтийн шалтгаан нь түүнийг Цин үеийн хятадтай зөрчилдөхөд хүргэжээ. Зөрчил тэмцэл зайлшгүй болов. Бүүр ХҮП-р зууны 80-аад оны эхээр Галдан Халхын хэрэгт төдийлөн их ач холбогдол өгөхгүй байсан ба энэ үедээ Дорнод Туркестанд дайн явуулж байлаа. Галданг Цин улсын эрх баригчид Халхын хэрэгт чадварлагаар татан оруулжээ. Энэ бол үйл явдлын өөр өрнөл.

70-80-аад оны зааг дээр Галдан засаг захиргааны зарим өөрчлөлтүүд явуулсан нь илт байна. Тэрбээр Зүүн гарын хаант улсын цэрэг-захиргааны, үндсэндээ бол аравтын бүтцийг бэхжүүлэв. Захиргааны доод нэгж нь болох 10 гэр бүл бүрийг ахлагч толгойлно. Энэ аравтууд нь отогт, отгууд нь аймагт нэгдэнэ. Энэ бүх өөрчлөлтийн мөн чанар нь Зүүн гарын хүн амыг нийтэд нь боолчлоход оршиж байв. Энэ үеээс эхлэн ямарч хүнийг оршин суугаа газраа солихыг эрс хориглож, хаана ч харъяалалгүй “өөр хоорондоо хутгалдсан, бусдын хошуу нутгаар явдаг” хүмүүс байх ёсгүй байв. Тийм хүмүүсийг “цуглуулж отог, аймагт нь буцаах ёстой байв” [12]. Энэ өөрчлөлт нь юуны өмнө хүн амыг нилээд эрчимтэй дарлах гэсэн эрмэлзлэл байсныг батлан харуулж байна.

1680-1682 онд Халхын хэрэг дэх Галдангийн оролцоо нь цэвэр тохиолдлын шинж чанартай байв. Энэ үед Засагт хан Хотгойдын алтан хан Лувсантай муудалцсан үе байлаа. Засагт хан Шарын хүү Лувсанг дайрч, түүнийг баривчилжээ. Лувсан Галдан руу оргон ирж, тэрээр магад ч үгүй цэргийн хүчээр хүмүүс, эд хөрөнгийг нь булаан авахад тусалжээ. Ингэж Галдангийн хийсэн анхны алхамын нэг нь Засагт ханы төлөө бус, харин ч эсрэг явдал болов. Энэ жилүүдэд сайн ноён Жанчин-Эрдэнэ Галдангийн Халхад довтолсон тухайд “Энэ довтолгоонд Халхын ноёд хайхрамжгүй хандсан” [13] гэж Манжийн ордонд мэдээлсэн байна.

А.М.Позднеевын иш татсан Буриадын нэгэн цаг тооллын бичигт өгүүлснээр бол Галдангийн цэрэг Халхад довтолсон нь 1683-1684 оны үед болж, “Алтай Хангайн хооронд омгоороо аж төрж байсан Авшга тайж Галдангийн цэргийн хоёр бүлэглэл

рүү дайрч түүний нэг угсаат “Халхын тайжуудыг нийтийн дайсны эсрэг босгох гэсэн авч тэдний бүх оролдлого талаар болов. Өөрсдөө морьдоо цуцаан, эцэж ядарсан тэд нутаг руугаа буцахдаа хамаатан садангууд нь ямраар ч хамтран ажиллахгүй байгааг ойлгон, тэднээс тусгаарлахаар шийдэцгээв. 1684 оны хавар тэд өөрийн омгийн захирагчдаа цуглуулан Орост дагаар орохоор шийдэж, үүнийгээ тэр жилээ гүйцэлдүүлжээ.

“Эцэст нь Төвдийн “Хөх нуурын түүх” хэмээх он тооллын бичигт Галдан Цэцэн хан хоёрын арцалдааны тухай мэдээлсэн байдаг. Тэнд өгүүлснээр бол Цэцэн хан, Галдан хоёрын зөрчил нь “Хоёр улсын хил дээр орших Хурил бэлчээр гэдэг газар зуны цагт баяр хийдэг байжээ. Нэгэн удаагийн баярын дараа Халхын цэцэн хан яльгүй явдлаас Бошготын хүү Санжаалыг гэртээ буцах замд нь хөнөөжээ. Энэ үеэс ойрадууд, халхын хоорондох арцалдаан үүсчээ” [15]. Төвдийн он тооллын энэхүү мэдээлэлтэй Галдангийн Халхтай хийсэн дайны шалтгааны

тухай монголын домог ч холбоотой. “Өөлдийн хаант улсад /Зүүн гарын/ Галдан бошигт нэртэй нэгэн амьдран суудаг байв. Тэр хүн Төвд рүү явж бүх төрлийн ухаанд сурсан, цэцэн мэргэн байжээ. Гэртээ ч буцаж ирсэнгүй. Галдан төвдийн хийдэд даа лам болсон гэнэ. Түүнийг эзгүйд нь нэгэн байдсан гүү Халхын нутаг руу гүйж, Цээ вангийн хошуунд адуун сүрэгт нь нийлжээ. Дөрвөн жил өнгөрч гэнэ. Нэгэн удаа Галдан Бошготын хүү ажил алба хөөцөлдөн Цээ вангийн нутгаар явж байтал алга болсон гүүгээ андууралгүй таньжээ. Тэгээд гүүгээ буцааж авах гэтэл сүргийн эзэн нь татгалзсанаас үүдсэн маргаан зодооны үеэр Галдан Бошготын хүү алагдав гэнэ. Дагаж явсан өөлдүүд түүний цогцсыг аваад эхэд нь хүргэж өгчээ. Ээж нь болсон явдлын талаар эцэгт нь захиа бичиж, буцаж ирэхийг дуудсан авч эс ирэв. Т Тэгэхлээр нь эх нь талийгаач хүүгийнхээ толгойг тасдаж аваад илгээмж маягаар нөхөртөө явуулжээ. Галдан Бошгот илгээмжийг хараад ихэд баярлан, найз нөхдөө дуудан бэлгийг задалж найрлахаар шийдэв. Илгээмжээс эхлээд хадаг, дараа нь эхнэрийнх нь захидал, эцэст нь хүүгийнх нь толгой гарч иржээ. Галдан Бошготын уур нь дүрсхийн шатаж, бүх Халхыг устгана гэж тангараглажээ” [16].

Иймэрхүү байдлаар 80-аад оны эхэнд Галдан Халхын захирагчдаас хэнд нь ч хүндэтгэл үл үзүүлэн, наад зах нь тэдний гурав нь болох Алтан ханаас болж Засагт хантай, Очирт цэцэн ханаас болж Түшээт хантай, цуу чимээ нь дээр өгүүлсэн домогт хадгалагдаж үлдсэн ямар нэгэн мөргөлдөөнөөс /хэрвээ энэ мэдээлэл үнэн ба “Хөх нуурын түүх” -ийг зохиогч андуураагүй болж Түшээт ханаас болж Цэцэн хантай/ хэрүүл маргаантай байлаа. 1680-1682 онуудад Халхад болсон үйл явдал нь ойрадуудын ямар нэгэн өнгөлзлөг довтолгооноор бус, Халхын гол хоёр /3-аас/ нь болох Засагт хан, Түшээт хан хоёрын зөрчилдөөнөөр тодорхойлогдож байна.

Хятадын өмнөд хэсэгт Сань–Гу–гийн зүгээс гарсан Манжийн булаан эзлэгчдийг зохион байгуулалттай эсэргүүцэлтэйгээр дөнгөж 1681 онд дарсан Цин улсын эзэн хаан Кан-си Хятадын нутаг дээр манжийн эрх мэдлийг тогтоов. 1682 он гэхэд л тэрвээр монголчуудын хэрэгт анхааралтай хандах боломжтой болж, Цин улсын ордныхон монголын хаадыг нэгтгэх оролдлого хийх, эсвэл ядаж халхын хаадыг өөрийнхөө ивээл дор нэгтгэх, Оросын нөлөөнд ч, Галдангийн ойрадуудын нөлөөнд ч огт ороогүй хаадын хүчийг бодолцон эвлэрүүлэхээр шийджээ. Эдгээр үйл явдлыг авч үзье.

Элчинд зориулсан тансаг хүлээн авалт, таван өдрийн найрын дараа Галдан Цин улсын элчин Китатыг ганцаараа хүлээн авчээ. Арз уусны дараа хааны толгой өвдсөн учир өглөөнөөс авахуулаад эсгэлэн сүү уужээ. Хаан ширээний нь арын хөшигний ард тарагтай том шаазан аяга байна. Орох хаалганы эсрэг талд баян чинээлгийн бэлэгдэл болсон цэнхэр өнгө бүхий гэрийн хойморт Богд хаанаас хүртсэн бэлэг сэлт, булган эмжээртэй нөмрөг, эрдэнийн чулуу, шүрэн чимэгтэй бүс, үнэтэй сав суулга, барын арьс сэлт харагдана. Торгон бүтээлгээр бүрсэн олбог дээр хаан, элчин хоёр сууж байв. Согтсоноос болж Китат илт зүдэрч байв. Үүнээс гадна түүнийг бүүр хоёрдох өдрөө идсэн тослог шөл, таван өдөр идсэн тарган мах ихэд сурьдуулжээ. Яая гэхэв. Монголд болсон Зүүн гарын улсад нутгийн заншлыг нь дагахыг Богд хаан элчин сайдад тушаасан байв.

Илэн далангүй ярих цаг нэгэнт болсныг Галдан ч, Китат ч сайтар ойлгов. Тэд гэртээ дөрвүүл, хаан, түүний лам, элчин, орчуулагч байв. Китат монголоор үл ярина.

- Олон зууны туршид Хятадын элчин бидэн дээр ирж байсангүй. Ямар ажил таныг манай нутаг руу ирэхэд хүргэв, Китат?

- Богд хаан, аугаа их эзэн хаан Бошигт хаанд мэнд хүргэж, таны болоод гэр бүлийнхний чинь эрүүл мэндийг мэдэж, мал сүрэг чинь бүрэн үү гэж асуулаа.

Галдан ламын зүг хараад хариулсан нь:

- Талархаж байна. Бүгд энх тунх. Мал бүрэн. Богд хааны эрүүл мэндийг асууж болохсон болов уу?

- Тэнгэрийн хүү хэмжээгүй сайн хаанчилж байнаа!

- Би сонссон юм. Хятадад бослого гарсан гэв үү?

- Дотоод дахь бүх дайснаа бүрмөсөн дарснаа Богд хаан мэдэгдэж байна.

Ард түмэн аз жаргалтай, амар тайван байна. Одоо тэрээр өөрийн элчин нараа ойрадуудад, халхууд руу илгээж, харамж шан, хишиг буянаа үлэмж нэмэхээр шийдээд байна!

- Үүнийг сонсоход баяртай байна. Элчин нар хэн рүү явсан бэ?

- Түшээт хан, Засагт хан, Жавзандамба, Эрдэнэ-дайчин ноён, Мэргэн ноён, Халхын элчин нар нэгэн дугаар “Сүмбэр уул шигээ суурьтай, эрдэнэт бие минь 4 далай дунд бий. Өчүүхэн бид бодохдоо амар тайван байдлыг үлгэр жишээчээр тодорхой хангаж чадна” хэмээн давтан өгүүлцгээж байна.

- Халхууд юундаа тэгтлээ хоорондоо мэтгэлцэнэ? Халхаас болж нохос яснаас болдог шиг арсалдаж байна!

-Үгүй дээ. Таны довтолгоон л Халхыг түгшээсэн хэрэг. Богд хаан надад болон Фянгу-д захихдаа одооноос манж монголыг энэ тэр хэмээн хуваах хэрэггүй гэж сануулаад, тэд нэгдмэл санаатай байж, хамтын ажиллагаа, энх тунх амьдрахын төлөө эрмэлзвээс зохилтойг шаардсан юм.

- Богд хаан Халхыг хамгаалж байна гэнээ. Хэнээс тэр вэ?

Китат дуугарсангүй. Орчуулагч үг бүрийг нарийн хөрвүүлээд зогссонгүй, бас дэвтэртээ бичиж авч байв.

- Энэ хүн яах гэж бичээд байгаа юм бэ? -гэж Галдан асуув.

- Орчуулга нь алдаагүй, миний бүх үг, таны хариулт цөмийг нь бичиж ирэхийг Богд хаан тушаасан юм. Дараа нь өөрт нь илтгэх учиртай.

- Сайн байна.

- Ойрадууд, халхууд олон жилийн туршид хүндэтгэлтэйгээр захирагдаж алба гувчуураа бүрэн дүүрэн, шударгаар төлсөөр ирснийг санаж байгаагаа Богд хаан хэлэхийг тушаасан юм. Богд хаанд хишиг шангаа болон бэлэг сэлтээ улам нэмэгдүүлэхээс өөр зоррилго байхгүй. Манай гүрний хүч чадал тов тодорхой билээ. Түүнийг мэдэхгүй нэг ч гадаадын улс гүрэн тэнгэрийн дор үгүй гэнэм.

- Китат! Би чамайг ойлголоо!

- Богд хаан чамд зааж байна. Бошгот хаан Эрдэнэ хошуучийг барих ёстой. Тэрээр таны албат, манай Урудуудыг дээрэмдсэн юм.

- Эрдэнэ-хошууч гэмт хэрэгтэн хүн. Тэр одоо Хятадын хил рүү зугтсан. Би түүнийг барьж чадахгүй, хаа байгааг нь ч мэдэхгүй. Түүнийг Далай ламд захирагдсан гэх юм. Би түүнд бичнээ.

- Түүнийг Эзнээ голд байгаа гэж хүмүүс ярих юм.

- Хаа байгааг нь би мэдэхгүй.

- Богд хаан чамд тушаал хүргэж байна.

Китат шар торгонд хуйлаастай юмыг гаргаж ирвэл дотор нь цаасан дээр нааж манж, хятад, монголоор бичсэн зарлиг гарч ирэв. Галдан хагас суун зарлигийг хоёр гардан хүлээж авав. Тодорхой юмгүй нийтлэг үгс. Эрт үеэс Хятадын эзэн хаад энэ ертөнцийг гадаад, дотоод гэж алагчлалгүй захирсаар ирсэн/ Ишш чи, бүгд л таны албатууд!/ “Галдан Бошгот хаан, чиний эцэг өвгөд, ах нар тань бие биеэсээ Засгийн эрхийг өвлөн авч Хятадтай сайн харьцаатай байхыг дэмжин алба гувчуураа хүндэтгэлтэйгээр төлсөөр ирсэн билээ. Хойшид ч энэ хэвээр байх болно гэдэгт итгэж байна. Ялангуяа бүх улс орон амар тайван аж төрөхийн төлөө эрмэлзэх аваас бид ч хишиг буянаа нэмэхийг бодно “.

- Талархаж байна. Халхын бүх хаадад энэ зарлигийг хүргэсэн үү?

- Тиймээ.

- Би Богд хааны санааг ойлголоо. Халхууд бидний хөрш болохоор тэдний ажил төрөл намайг хөндөхгүй байж чадахгүй.

- Энэ бол хааны хариулт уу?

- Тийм ээ.

- Богд хаанд захидал өгөх үү?

- Үгүй.

- Бошгот хаан, хэрвээ ойрадын элчүүд ирэх аваас бид таных гэж хэрхэн мэдэх болж байна?

- Тамга зөвхөн надад байна. Хэрвээ тамгагүй бичигтэй бол минийх биш гэсэн үг. Богд хааны элч нарт нэг морь, 10 тэмээ өгье. Китат, чамд хувиасаа 5 морь өгье

- Талархаж байна.

Бараалхалт дуусч, Китатыг өөрт нь зориулж барьсан өргөө рүү явуулав. Хэрэв үйл явдал өөрт нь хортойгоор эргэвэл Галдан Халхын хэрэг явдалд оролцохоос татгалзахгүй нь тодорхой болов.

Дахин гэрээ хэлэлцээр гэж үнэндээ болсонгүй, Китат болон түүний бараа бологчдод цамын бүжиг үзүүлэв. Дараа өдөр нь тэд мөргөлд оролцож, судар ном уншихыг сонсоцгоов. Дараа нь дахиад л найрлацгаав. Эцэст нь алс холын зүдэргээт замдаа гарцгаав. Китатыг Эрх хишиг хаан болон Галдангийн бусад хүмүүс дагалдав. Тэд Кан-Си-д барих Галдангийн хариу бэлгийг авч явлаа. Манжууд Хятадын заншлаар яагаад ч юм бэ өглөг барьц гэж нэрлэдэг. Бэлэг нь ч гэж том бэлэг, 400 морь, 60 тэмээ, 300 булга, 500 үен, 100 үнэг гэхчлэн. Китатын ажиллагаа 1682 оны эцэс, 1683 оны эхэн үеийг хамарчээ.

Галдангийн буулт хийхгүй байдал, халхын хэрэгт оролцохгүй байх эв найрамдлын баталгаа өгөхөөс татгалзсан зэргийг Бээжинд тэр даруйд нь үнэлж, хариу арга хэмжээ авчээ. Үүнээс хойш Зүүн гарын улсаас Хятадын дотоод нутаг руу 200 хүнтэй элчин ирж болно, гэхдээ тэд цөм Галдангийн баримт бичигтэй байх ёстойг ч Галданд дуулгажээ. Энэ нь хүмүүс хил дээр хэдэн мянгаараа ирж, замдаа хил орчимийн монголчуудыг тонон, тариаланг сүйтгэн, нутгийн оршин суугчдыг гахай явган, нохой нүцгэн болгож байгаатай уялдсан юм. Бүх ойрдууд хил орчимийн Хаалган болон Хөх хотод наймаа хийж болох ажээ. Энэ нь онцгой хүндэтгэл үзүүлэх маягаар зарлигт өгүүлсэнчлэн: “Бид дөрвөн далайг (дэлхий ертөнц-Е.К) нэгэн гэр бүл мэт харж, гадаад дотоод гэж ялгалгүй, нэгэн бие мэт ойлгодгийг Галдан Бошгот хаан хараахан татгалзаагүй, хүндэтгэлтэйгээр өөрийгөө залж, байнга элчингээ илгээж тэдний толгойлогчоор дандаа л ухаантай, чадварлаг хүмүүсийг томилж, тэд нар нь өөрийн хүлээсэн үүргийг чандлан биелүүлж байна” [17] гэжээ. Ойрадын элчингийн гишүүдээс гэмт хэрэг үйлдвээс Хятадын хуулиар шүүх зарлиг гарчээ.

1683 оны 7-р сард (VIII-22 -IX-20) Галдан Кан-Си-д бичсэн захидалдаа “учир утгагүй үйлдлээр” [18] Цин улсын хилийн боомтыг дамжин өнгөрөх хүмүүсийн тоо хязгаарлагдмал байгааг дурьдаад ойрадуудтай хийж буй худалдааг өргөжүүлэх ажлыг буруушаажээ. 1684 оны 9 сард (X-9 -XI-6) Галдан хятад руу Гүрбалбайгаар толгойлуулсан 3000 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчидийг илгээжээ. Тэднээс зөвхөн 200-г нь Цин улс уруу оруулж бусдыг нь буцаав. 1667 оны зуны эхээр Галдан худалдааны хязгаарлалтын эсрэг давтан эсэргүүцэл илэрхийлэв [19]. Түүний эсэргүүцлийг эрс анхаарч үзэв. Төлөөлөгчдийн тоо хязгаарлагдмал байх нь Галдангийн буулт хийхгүй байдалд хариу арга хэмжээ биш гэсэн санал байдаг хэдий ч “Цин улстай найрсаг харцаатай ойрадуудын бүх овог аймгуудийн захирагчдад ч нэгэн адил хамаарч байв [20]. Иймээс энэ хязгаарлалт ямар ч атугай юуны өмнө Зүүн гарын улсын эсрэг чиглэжээ гэж үзвэл зохино. Хятад улс нүүдэлчидтэй хийдэг худалдаагаа улс төрийн зорилгоор тэр үед нүүдэлчин ард түмэнтэй элчин солилцдог нь гадаад худалдааны хэлбрийн нэгэн байв.

1683-1684 онд Галдан Андижан болон Хасагийн тал нутаг уруу амжилттай довтолгоон хийж,

ногачуудын эзэмшилд хүрэв. Хуучин хүсэл мөрөөдөл нь шинээр оргилон буцалж, Халхын хэрэгт тэрээр хараахан оролцдоггүй байсан үе. Засагт хан, Түшээт ханд гаргасан гомдлоо далай ламд өгч, хүмүүсийг эргүүлэн өгөхийг шаарджээ. Далай лам Монголын бодит улс төрийн засаглалыг мэддэггүй, нэр төртэй саваартан хүний байдлаар хүлээн авчээ. Тэрээр өөрийн төлөөний хүн Жарбунайг Халх руу илгээж, Халхын хоёр гол хаадыг эвлэрүүлэх даалгавар өгчээ. Гэлээ ч Түшээт хан Далай ламын нэр хүндийг эс тоон, тэр бүү хэл түүний төлөөний хүнтэй ч уулзсангүй.

Нилээд сонин нөхцөл байдал бүрдэв. Халхад Засагт хан, Түшээт хан хоёрын хооронд эртний босуул - урвагчдаас үүдсэн хэрүүл зарга үүсчээ. Энэ тухай эргэн тойронд цөм мэднэ. Аль аль тал нь цэргийн хүч хэрэглэсэнгүй. Гэвч Цин улсын ордон хаадыг “эвлэрүүлэх” гэж хичээвч энэ нь булингартай усанд загас барихын үлгэр шиг тэдний хооронд яс хаях хүслийг нь давын өмнө буцалгав. Кан-Си өөрийн элч Ачит гэлэнг Лхас уруу илгээж, хараахан ямар ч заналхийлэл болоогүй байгаа халхын хувь заяанд хуурамчаар санаа зовсон байдлаа илэрхийлжээ. Тэрээр Далай ламд бичсэн нь: “Ертөнц дээр амь зууж буй амьд амьтан бүхнийг удирдан залахын төлөө, өлсгөлөн сүйрлийг зайлуулж, бүх амьд амьтныг амар жимэр, чинээлэг байлгах хүсэлтэй байна. Ламтан та, аугаа их сайн үйлстнүүдийнхээ хүчээр өрөвч зөөлөн сэтгэлээр бүх амьд амьтанд нөлөөлж байдаг учраас, таны нэрийг алдаршуулж үйл ажлыг чинь хүндэтгэн бахархаж, таныг бахдан шагшихаас өөр хүмүүн гэж огт үгүй. Халхын хаад, бээсүүд цөмөөрөө ламтан таныг хүндлэн, таны шашныг сурталчлан, таны ёс, шүтлэгийг эрхэмлэн дээдэлж байна. Та чин үнэн санаа хүндэтгэлтэйгээр өргөл барихаар над руу ч гэсэн байн байн ирдэг билээ. Одоо энэ хорвоо дээр амьдарч буй бүхэн амгалан тайван байна. Зөвхөн Засагт хаанаар тусгаарлагдсан албатуудыг буцааж өгөөгүйгээс үүдэн би маш ихээр сэтгэл зовнин шаналж ... ямар хэлбрээр Засагт хан Түшээт хан хоёр хамтран аж төрж чадах бол? Тэд эхэндээ миний санаа зорилгыг тайван хүндэтгэлтэйгээр гүйцэлдүүлж, над дээр ирцгээдэг байлаа. Тэд бас эртнээс танд өргөл баригчид болсон билээ. Ямар маягаар бид үүнийг эцсийг хүртэл санаа амар харж суух билээ? Ламтан та нэгэн томоохон ламыг тийш нь илгээ... Харин би эндээс элч сонгон таны элчтэй уулзах товлосон газар руу илгээе... Хариуд нь Далай лам Кан-Си-д бичсэн нь : “Халхын өрнө дорнодод болж буй үйл явдлаас үүдэн, энэ ертөнцөд оршигч амьд бүхэнд нигүүлсэнгүй хандаж, би Ярбунайг явуулав. Баруун тал зөвшөөрсөнгүй, зүүн тал ч бас адилхан - нэгтгэх боломж алга. Тусгаарлаж салсныг нь нэгтгэн нийлүүлж, өндөр эзэн хаан минь, үй түмэн амьд амьтанд эцэг ёсны, өр зөөлөн сэтгэлээр хандаж буй нь нэн сайн. Одоо ч би Шамба-цэм хутагтыг явуулж өвлийн сүүл сар гэхэд Халхын улсууд руу хүрсэн байхыг даалгав [21].

Лхасын хутагт Халх хүрч чадалгүй Хөх хотод нас баржээ. Бээжингийн санаачилгаар боломжийн шилдэг арга хэрэглэж муудалцсан хоёр хааныг эвлэрүүлэх гэж чармайж эхлэв. Кан-Си хоёр элчийн уулзах газар, цагийг товлохыг Далай ламд санал болгов. Лхасаас Халх руу Галдан Ширээт лам, Далай ламын бие төлөөлөгчөөр явлаа. Халхын талаас ямар нэгэн илэрхий шалтгаангүй ч гэсэн Кан-Си Халхын хаадыг ойртуулах гэж хичээнгүйлэн хүсч байгаа нь тэднийг дайсагналцахад итгүүлж, улмаар тэднийг дайн дажинд түлхэж байгаа мэт санагдана. Тэгвэл энэ нь Халхын хэрэгт санаатайгаар оролцох шалтаг болж улмаар Төв Азийн стратегийн хувьд чухал энэхүү бүс нутгийг Өвөр монголчуудын араас Хятадын Цин улсын бүрэлдэхүүнд оруулах явдал байв. Кан-Си нэгэн зүйлийг тууштай давгаж байв. “Халхын хоёр жигүүрийг эвлэрүүлэхгүй юм бол энэ нь дайн дажны уршиг гарахад хүргэх вий

гэж эмээж байна” [22]. Гэхдээ сурвалж бичгүүдэд Кан-Си-гийн үйлдлийг авч үзэхэд Халхын хэрэгт Галдангийн оролцоо, Засагт хан, Түшээт ханы хоорондын дайны үйлдлийн талаар битүүлэг дохио ч алга байна.

Дайны эхийг 1686 онд болсон Монголын хаадын их хуралдаан дээр болсон мөргөлдөөн тавьсан юм. Энэ хуралдаанд анхаарлаа хандуулж, дээр өгүүлсэн зүйлийн дагуу Галдан энэ хуралдаан дээр нарийн өдөөн хатгалга явуулсан уу, тодруулваас, түүний дараачийн үйлдлүүд нь Бээжингийн нууц ажиллагаанд гаршсан хүмүүсийн сайтар боловсруулсан бодлогын үр дүн биш биз.

Ингэж Зүүн гарын улсын хаалганаас Их хянган хүртэл, Хэнтийн нуруунаас Гималай хүртэл, Лхасаас Бээжин хүртэлх удам нутагт Монголын хаадын их хурилдаанд бэлтгэх ажил өрнөж байлаа. Тавдугаар Далай ламын нэрийн өмнөөс Төвд /Тэрээр 1685 онд таалал төгссөн авч үүнийг нь Төвдийн засгийн газар 15 жилийн турш нуусан юм/ Далай ламын элч Галдан ширээтийг 4-р илүү сард /V-22-VI-20/ ирүүлж Мэргэн тайжийнд буулгана гэж мэдэгдэв. Кан-Си өөрийнхөө нэрийн өмнөөс Халх руу шаншу Арни /эзэн хааны нарийн бичгийн газрын тэргүүн/ болон түүнд туслалцуулахаар Баймашбилэг, Ачит Цорж лам хоёрыг илгээх шийд гаргажээ. Хаврын шороо тоос манарсан замаар Бээжингээс Хаалган, Хөх хот руу Халхын бүх хаад, жонон, ноёд руу элч довтолгон, эв түнжингүй суух аваас та нар сална, “дотоодын үймээн самуунаас болж алдана. Баруун жигүүрийн ахан дүүс болон бусад хүмүүс зүүн жигүүр рүү оргон, зүүн жигүүрийн ахан дүүс бусад хүмүүс нь баруун жигүүр рүү оргож буйг” [23] монголчуудад тайлбарласан Кан-Си-гийн тушаалыг хүргүүлж буй нь энэ ажээ. Монголын хаад, ер нь монголчууд, үүнийг Кан-Си-гүйгээр ойлгоно гэдэг нь л ойлгомжгүй зүйл. Манжийн эзэн хаантай холбоотой “есөн цагааны” хүндтэй бэлэг барьдаг хаан, жонон, эздүүдийг хэрүүл хэлцээнээ умартан эвлэрүүлэхийг их хуралдаан дээр уриалжээ. Энэ бол онцгой анхаарвал зохистой зүйл. 6-р сард /VII-20 -VIII-18/ Кан-Си Халхын шарын шашны тэргүүн өндөр гэгээн Жавзандамба хутагтад их хурилдаанд очихын нь өмнө онцлон зарлиг буулгажээ. “Ерөнхий шийдвэрийг боловсруулахын тулд их хурилдаанд хүрэлцэн ирэхийг Жавзандамба хутагт танаа би зарлиг буулгаж байна” [24]. Хутагт Кан-Си-д захидлаар хариу өгчээ. “Засагт хааны хөвгүүд, ач нарын хагас нь аажмаар буцацгаав”. Ингэхэд тийм хурц асуудал алга, харин “бусад нь Чахэд байгаа... Далай лам, мөн Галдан Ширээтийг өөрийн төлөөлөгчийн хувиар их хурилдаанд явуулав. Энэ хэргийг нийтийн хүчээр шийдвэрлэхийн тулд намайг ч гэсэн их хурилдаанд очихыг зарлиг болгосон. Би ч гэсэн зарлигийг дагаж бусдын хамт их хурилдаан болох газар руу явна” [25]. Үүнийг дахин анхааралтай уншиж үзье. Санваартны тэргүүн Жавзандамба хутагт, Кан-Си-гийн зарлигаар их хурилдаанд очихдоо Далай ламын төлөөлөгч /Төвдийн/ Галдан Ширээтийн эсрэг тал болох Манжийн талыг төлөөлнө. Дундыг баригчдын төлөөлөгч болох хоёр том лам их хурилдаанд иржээ. Ийм нөхцөлд бидний урьдчилан харснаар Бээжинд ч нарийн төлөвлөж чадаагүй юм шиг тийм учир шалтгаан ч бүрэлдэж болзошгүй байв.

Бас нэгэн нөхцөл байдал тодорхойгүй байна. Энэ нь тус их хурилдаанд Галдангийн ирсэн явдал байлаа. Түүнийг Кан-Си дуудаагүй. Галдан ч түүнд захирагдаагүй. Галданг их хурилдаанд Төвдийн ямар нэгэн захидлын мөрөөр ирсэн гэсэн баталгаа алга. Тэрээр өөрсдийн холбоотнуудынхаа ажил төрлийг сонирхдог хүний хувьд л /Цин үеийн Хятад, Төвд, Зүүн гарын улс / оролцсон байх хэмээн таамаглах л үлдэж байна.

Мэргэн тайжийн харьяат нутаг дахь Хулан билчэр гэгч газар, намхан нүцгэн уулсаар хүрээлэгдсэн өргөн талын дундуур урсах Заг голын хөвөөнд Монголын эзэд төлөөлөгчид болох хаад, жононгууд, ноёд, тайжууд их хурилдаандаа хуран цугларав. Хаан, жонон бүр төв дунд нь цагаан өргөө бариулжээ. Ирсэн төлөөлөгчид Арни болон түүний бараа бологсод, Галдан Ширээт, Ойрадын Галдан бошигт хаан нар тусгай өргөө бариулжээ. Дугуйлан барьсан өргөөнүүдийн зах нь гол руу хүрсэн агаад, хэлэлцээр хийхэд зориулж сайтар дагтаршуулсан газрыг сонгожээ. Өглөө, оройд нь өргөөнүүдийн орчмоор тарган махны үнэр ханхийж, зарц нар нь тэрэг түрэн эзнийхээ гэр лүү том том хөхүүртэй айраг зөөнө. Хаадын ширээнээ ховор ундаа болох хятад, орос архи, туркестаны дарс бүхий савууд үзэгдэнэ.

Эсгий, арьс дэвсэж бэлтгэсэн өндөрлөгүүд дээр эвлэрүүлэгсэд, эвлэрэгсдийг суух үед анхны садаа гарав. Далай ламын төлөөлөгч Галдан Ширээт, Манжийн Богд хааны төлөөлөгч Түшээт ханы ах Жавзандамба хутагтыг хаана суулгах вэ? Нэг талаас Далай ламын санваартны засаг шарын тэргүүн нь хамгийн өндөр хэргэмт, сүжигтнүүдийн хувьд маргаангүй хүн болох Галдан ширээт бүхнээс дээр залрах учиртай байв. Нөгөө талаас халхын шарын шашны тэргүүн Жавзандамба хутагт нь манжийн богд хааны сонирхолыг төлөөлж түүний зарлигаар ирсэн хэдий ч өөрийн санваартаныхаа хэргэм зэргээр Галдан Ширээтээс дутахааргүй хүн. Хамгийн гол нь тэрээр Галдан Ширээтээс доор суухыг хүссэнгүй ч адилхан өндөр гзар суухыг зөвшөөрчээ. Монголын хаад ч өөрсдийн санваартныхаа тэргүүний эсрэг санал эс гаргав. Арни бол ил далдаар Халхын хутагтыг дэмжиж Галдан бошигт хаан Галдан Ширээтийн талыг барьсан нь мэдээж цөөнх хэвээрээ үлдэв. Урьдчилсан хэлэлцээрийн дараа тэдний адил зиндааг бодолцоод нэгэн өндөрт суулгая хэмээн шийджээ. Энэ нь Далай ламын нэр төрд харшилж, тусгаар улсын хаан атлаа Жавзандамба хутагтыг өөрийн шашны тэргүүн ч гэж Богд хааны төлөөлөгч ч гэж үзээгүй нь Галданг доромжлогдсон болгож түүний уур унтуут нь хүргэжээ. Далай ламыг эрхэмлэн хүндэтгэгч сүсэгтэн хүний бодол санаа шууд доромжлол мэт болсноос хэрэг мандав Түшээт хаан болон түүний овгийнхны талаар Галданд байсан хуучин таагүй бодлыг нь тооцвол Бээжингийн цохилт гол зорилго байж, энх тайвны их хурилдаан нь дайн дажны их хурилдаан болох нь гарцаагүйг зоригтойгоор баталж болно.

Том лам нар голд нь ижил өндөрлөгт, Жавзандамба хутагтаас цааш Арни болон Түшээт хан, Галдан Ширээтийн талаас Галдан бошигт хаан, Засагт хан, бусад хаад, жононгууд, суудлаа эзэлсний дараа хурилдаанд гол үүрэг гүйцэтгэсэн Арни, Халхын засаг ноёдод хандсан Кан-Си-гийн зарлигыг уншиж сонсгов. “Та нар, хаад жононгууд, ноёд тайж нар бие бие рүүгээ дайрч, албат нараа дээрэмдэн, ахан дүүсээрээ эв нэгдэлгүй аж төрцгөөж байна. Та нар бол чухамдаа нэг л удмынхан. Хэрвээ та нар хагаралдан дайсагналцваас хэт нь үнсэн товрог болно. Бид энэ бүхнийг тэвчин харж сууж чадахгүй. Ийм учир та нарыг даруйхан эв нэгдэл, амар амгаланд хүрээсэй гэж энэхүү зарлигийг тусгайлан гаргав. Та нарын дотор амар жимэр байдал тогтвоос бидэнд ямар нэг ашиг гарахгүй нь та нарын хагаралдаан бидэнд ашиггүйтэй ав адилхан бүлгээ. Та бүхэн үеэс үе дамжин биднийг дагаж, бидэнд өглөг барьцаа бүрэн барьж ирснийг харгалзаад л бид санаа тавьж буй хэрэг. Хүмүүсийн төлөө шаналал дүүрэн бидний сэтгэл хүмүүсийг дотоодын, гадаадын гэж ялгаж үздэггүй билээ. Энэхүү үйлдлээрээ бид та нарын хувьд үнэний замыг нээж, энэхүү зарлигийг та нарт сонордуулан хүргэж, та нарыг хайр элбэрэл, амар амгалан байдалдаа эргэн орохыг бид тушааж байна [26].

Хурсан олноос эхлээд Сали Ахай тайж өвдөг дээрээ сөхрөн ийн мэдэгдэв: –Манай халхын 7

туг – энх тайван, эв түнжинг эрхэмлэдэг нэгэн овгийн удам билээ. Лувсангийн бодлогын үеэс эхлэн бие биеэсээ хүмүүсийг нь булаан эзлэх болсноос харилцан заналхийлэх явдал үүслээ. Биднийг эвлэрүүлж тайтгаруулах гэж Их эзэн хаан, Далай лам нар өөрсдийн өндөр хэргэмт түшмэл, лам нараа явуулжээ. Би өчүүхэн хүн. Энэхүү учир шалтгаанаас өөрийн баяр хөөрөө илэрхийлэхгүй байж чадашгүй. Гэхдээ мэргэн гэгээний зарлигийг бид хүндлэн дагаж эвлэрч, хэрүүл доруулаа зогсоох уу, үгүй юу гэдэг нь манай хоёр хаанаас л хамаарна. Тийм биз дээ?

Дараа нь Түшээт ханы отгон дүү Сэдшир Баатар тайж өвдөг дээрээ сөхрөн хэлсэн нь: - Зарлигт өгүүлсэн Мэргэн гэгээний сургааль нь үнэн шударга байна. Манай хаадын хоорондох хатгалдаан нь үл бүтэх хүмүүсийн гүтгэлгээс үүссэн. Одоо бид хоёр ханыг үнэн шударга үгэнд итгүүлж, худал хуурмаг үгсийг няцаахад нь өөрсдийн зүгээс хүчин чармайлт гаргавал тэднийг сэнхрүүлж, улмаар эвлэрэхийн төлөө өөрсдөө ч хүсэх болно.

Засагт хан, Түшээт хан хоёр дуугүй л байв. Тэгэж тэгэж энэхүү үргэлжилсэн дуугүй байдал сүрдүүлэг мэт болох үед Шар засагт хан суудлаасаа босолгүй хэлсэн нь:

- Богд хаан бидэнд амар тайван аж төрөхийг заалаа. Би түүнтэй сөргөлдөж зүрхлэхгүй байна.

Яг л цуурай давгах мэт Түшээт хан өгүүлсэн нь:

- Богд хаан бидэнд амар төвшин аж төрөхийг заалаа. Би түүнтэй сөргөлдөж зүрхлэхгүй байна.

Суугаа, зогсоо хүмүүсийн эгнээ дамжин урамтай шивнээ усны долгион мэт тархав. Арнигийн дохиогоор зүүн, баруун жигүүрийн зарим тайжууд хаалга руу очицгоов. Хоёр талаас тэднээр дэмжигдсэн, буруушаагдсан хүмүүс ч босоцгоож бие бие рүүгээ шийдмэг бус алхацгаав. Түшээт хан анхаарлаа өөр тийш хандуулан өгүүлсэн нь:

- Хааны бие амар амгалан уу ?

- Амгалан байна. Харин таны бие амар амгалан уу?

- Баярлалаа, амгалан байна.

Ойр дотныхныхоо түлхэлгээр хаадууд тэврэлдсэнээ түргэн эргэцгээж өөрсдийн суудал руу чиглэцгээв. Яг л тушаал биелүүлж байгаа мэтээр зүүн, баруун жигүүрийн тайжууд босч, бие биерүүгээ ойртон очоод амар мэндээ мэдэлцэн тэврэлдээд холдоцгоов.

11-р сарын 7-нд Галдан Ширээт, Жавзандамба хутагт нар бурхан сахиусаа зүүн мөргөл хийж, Засагт хан, Түшээт хан нараас амар амгалан байж бие биеээсээ булааж авсан хүмүүсээ эргүүлэн өгөх ам тангараг авчээ. Хаад зогсоогоороо тангараглаж, дараа нь бурхан Буддагийн өмнө өвдөг сөхрөн тангараглахад жононгууд, тайжууд:

- Одоо бид ашид мөнх амар жимэр, аж төрөхөө тангараглаж байна [27].

Тус их хурилдаан дээр Галдан Бошгот хаан хаана байж юу ярьсан, юу хийсэн бэ? Үүнийг бид мэдэхгүй. Далай ламын төлөөний хүн Галдан Ширээт юу ярьсан, юу хийсэн бэ? үүнийг бид

мэдэхгүй. Далай ламын төлөөний хүн Галдан ширээт юу ярьсан, хийснийг ч бид мэдэхгүй. Жавзандамба хутагт хэдийгээр доромжлогдсон ч төвдийн нөлөөтэй хишиг буянаа хайрлагсадыг алдах вий гэсэндээ Цин улсын төлөөлөгчийн өмнө дуугай байв уу, эсвэл үүгээр зөвхөн Галдан доромжлогдсон гэдэг нь зарчмын хувьд үнэмшил багатай, Галдан ширээт, Галдан бошгот хаан нарын дараачийн байдал нь зохицолдлоготой, байсан нь мэдээж. Халх дахь өөрсдийн үйл ажиллагаандаа Түшээт хан, түүний ах Өндөр гэгээн Жавзандамба хутагтад түшиглэж байсан нь Цин улсын эрх баригчид тэдний байдлыг урьдчилан мэдэж, өдөөн турхирсан гэдэг нь чухал. Өөрийн Засагт хаантай явуулсан зөрчилдөөндөө Түшээт хан нь Цин улсын Богд хааны дэмжлэгт найдаж байсан шиг Засагт хан хариуд нь Галдангаас тусламж эржээ. Төвдийн байр суурь их төвөгтэй байлаа. Тэрээр Халх, Зүүнгарын улсын адилхан заналхийлэлд байлаа. тавдугаар Далай лам таалал болсон нь нөхцөл байдлыг хурцатгаж, түр захирагч Санжаажамц, Далай ламын таалал төгссөнийг нууснаараа талийгаачийн нэр хүндийг тус орны сайн сайхны төлөө хадгалах гэсэн нэг л зорилготой байв.

Дайснуудаа ганц нэгээр нь цохих хэрэгтэйг Кан-Си мэдэж байлаа. Халхчуудыг эвлэрүүлэхдээ тэрбээр тэднийг өөр хооронд нь биш ч гэсэн Галдантай юм уу, Төвдтэй муудалцуулахыг хүсч байлаа. Жавзандамба хутагттай гаргасан мэх эндээс л гарсан. Энэ бол зохиогч миний санаа ч биш. Бараг 100 гаруй жилийн өмнө А.М. Позднеев; “Чуулган дээр ч гэсэн тийм явдал / Жавзандамба хутагтын байдлыг хэлж байна. –Е.К/ гаргасан нь эргэлзээгүй ба Хятадын Богд хааны өндөр зарлигт ч гэсэн өөрийн гэх үндэслэлтэй юм” [28] гэж бичжээ. Харамсалтай нь энэ өгөөшийг Галдан залгичихсанд л байгаа юм. Заналт дайснаа гэсгээн шийтгэхийн тулд ичээнээс нь хуурч гаргасан нь энэ. Магадгүй, Галдан ч энэхүү өдөөн хатгалгад хариу өгөхгүй байж чадсангүй. Галдангийн амьдрал үйл ажиллагааны талаархи бидний мэдээлэл зонхилон Хятад эх сурвалжаас гаралтай. Харин Монголын нилээд хожмын он тооллын бичгүүдэд үүнийг олон талаар давтаж байгаа хэдий ч бид нилээд удаан хугацааны туршид үнэнийг мэдэхгүй.

Түшээт хан болон түүний ах хутагт хоёр Бээжингээс чиглүүлсэн бодлогын хүрээнд үргэлжлэн ажилласаар байлаа. Шар Засагт хан тохиролцсоноо үл хэрэгсэн, хүмүүсийг эргүүлэн өгөөгүйгээрээ их хурилдаан дээр өргөсөн тангарагаасаа няцав. Энэ зорилгоор тэрээр Кан-Си - гэс “Хаад, захирагчдаас онцгойрон ялгарахын тулд ... алтан тамга” гуйсан чинь татгалзсан хариу авчээ. Кан-Си Бээжин рүү явуулсан захидалдаа Халхыг “Миний Халх улс” [29] нэрлэсэн аж. Кан-Си – д Түшээт хан Чахундоржийг Халхын бусад хаадуудын тэргүүн гэхээсээ Халх нь түүний Их эзэнт улсын умард зүг дэх тулгуур бэхлэлт байх нь л хэрэгтэй байв. Учир иймээс Бээжин аажмаар Халхыг болж гүйцсэн алим өөрөө хөлд нь унаад ирэхүйцээр бүхнийг чиглүүлжээ.

* * *

Галдан Бошгот хааны хүрээ нь алтайн уулсын зүүн хажуугаар тунгалаг ус нь мяралзсан, өвс ногоо халиурсан нутагт оршино. Хааны өргөө, хатдууд, зарц нарынх нь гэр, бурхадаа залдаг гэр, хийдүүд, шавь нарын гэрүүд, хааны хүрээний ядуусын тосгон. Ид хаврын цаг. Галдан халхаас аль эрт буцаж ирэн, алсын замын алжаалаа аль хэдийнээ тайлжээ. Баяр баярын дотроос хамгийн дээд нь болох Цагаан сар - хавар эхэлсний баяр ч хэдийнээ өнгөрчээ. Хүйтний улирал өнгөрч, хаврын урь орж байгаатай уялдуулан тэр өдрүүдэд хүмүүс бие

биетэйгээ золгоцгооно. Ёслолын мөргөл 8 хоног үргэлжлэн, лам нар эгэл хүмүүст бурхан Будда Шакьяамунигийн байгуулсан янз бүрийн гайхамшгийн талаар түүний хуурамч сургаалийг дийлсэн ялалтын тухай өгүүлцгээнэ. Цагаан сар – баяр хөөртэй, сайхан баяр!

Энэ үед 40 дөнгөж гарч буй Галдан зөөлөн улаан гутал жийж, хөнгөн шингэн алхлан, налуу хажуу даган гол руу бууж ирэв. Нар хурцаар гийнэ. Хааны дэргэдүүр адуун сүрэг уулнаас буун ус руу давхилдан орж ирэв.

Тоос татуулах шуурга адил

Тарган морьд алсад давхилдана

Талын салхинд атаархах шиг

Туурайн нүргээнээс үргэх шиг

Замд шидэгдэх чулуу шорооноос

Зайлж үргэн бусгах шиг

Хийсэн цацрах дэл сүүлнээс чинь

Хийлийн эгшиг цуурайтах шиг

Хөгжмийн ая ч жингэнэх шиг

Хаан зогсов. Сайн байна! Түүний мал сүрэг өвлийн хүйтнийг өнтэй давлаа. Цаашдын ажил үйлсийн минь гол найдвар, амин зуулга минь.

Дөнгөж саяхан Галдан Арни, Жавзандамба нарт захидал хэлж өгч бичүүлжээ. Зарим мөрүүд нь дахин дахин санаанд орж ирнэ. Арнид бичүүлсэн нь: “Халхын 7-тугийн хэрэг явдлаас Далай лам хэдийгээр Ярбунайг их хурилдаанд явуулсан ч гэсэн 7-н туг түүний үгэнд захирагдах чадваргүй байлаа. Халхыг амар жимэр, баяр хөөртэй байлгахын тулд ариун гэгээнтэн олон хүмүүсийг явуулахыг хүслээ. Далай ламд илч илгээв. 7-н тугийн их хуралд эзэн хааны элчтэй хамт оролцсон Ширээтийг далай лам явуулав. Ажил төрлийн байдал ийм байна. Гэхдээ Жавзандамба хутагт, Ширээт хоёрын нүүр тулан уулзах ёслол туйлаас боломжгүй байна” [30]. Тэрээр Халхын хутагтад, шуудхан ямарч ёжлолгүйгээр бүхнийг бичжээ. “Ширээттэй суудал хуваарилах үед, чи бүхий л ёс горимыг зөрчсөөн. Өөрөө ч туйлын зохисгүй аашилсан. Далай ламын сургааль бол арван оронд түгсэн билээ. Зонховын хаан ширээн дэх Ширээт лам бол асуудлыг шийдэхээр тусгайлан илгээгдсэн хүн. Түүнтэй та цаг үргэлжид л ав адилхан зиндааны үүднээс харьцах нь таарч байгаа юм гэж үү?[31]”. Энэ ах дүү хоёр бол эртнээс манжийн богд хаанд худалдагдсан хүмүүс. Тэдний хувьд энэ нь зүгээр өнгөрөхгүй гэдгийг мэдэцгээх болно.

Галдан хааныг өргөөнийх нь гадна хоёр элч хүлээж байв. Нар өндөрт хөөрч хүчтэй гэгч ээж байлаа. Хааны өргөөнөөс холгүй гал тогоонд ажилладаг бүсгүйчүүд яг л зун цаг шиг нимгэн хувцастай, бүсэлхийгээ хүртэл нүцгэн явцгаана. Элч нар аян дайнд явахын өмнөх шиг

хувцастай, нөмрөг хуяган дотуураа хөвөнтэй хантаазтай, хөө хуяг, дуулга өмсч, зүүн ташаандаа сэлэм зүүжээ.

Галдан цэргүүдийг гараараа дохин гэрт орохыг уриад өөрөө түрүүлэн тэд араас нь орцгоов. Гэрт хааны залуухан хатан байв. Хоёр цэрэг ч нэгэн зэрэг өвдөг сөхрөн уруу харав.

- Биднийг орхи, – гэж Галдан хэлэв.

Хааны залуу хатан хөнгөн шингэн алхан үүд рүү явахад анхилам үнэр ханхийж, зүүлт сэлт нь уянгатайяа жингэнэв. Залуу цэрэг хааны хатныг сэмхэн хараад, түүний гоо сайхныг дахин бишрэв:

Торгон дээлтэй тэр бүсгүй

Бадамлянхуа цэцгийн үнэртэй

Салаа гэзэг нь томоос том

Сугандаа хавчсан ч үл багтана.

Сувдарч асгараад илүү гарна.

Бие нь ч гэсэн уян налархай

Хааны эхнэрээс наран цацарна.

Харцнаас нь ч гэрэл туяарах нь

Хээ угалз шаглах мэт

Адууч эр дэргэд нь байх шиг

Адуун сүргээ харанхуйд манах мэт

Дөчин шүд нь сувд шиг гялалзана

Хуруунууд нь хангайн цаснаас ч цагаан

Хөмсөг нь хараацайн жигүүр шиг тахирлана.

Халуун цус дусах нь уу гэлтэй

Уруул нь улаанаас улаан

Ганган тогосын толгой л гэлтэй.

Харах зүйл алга болмогц ханы захирангуй дуу хадаж:

- Босцгоо! – гэв.

Хаан өөрөө элч бүрт захидал гардуулав.

- Та нар мэдэж байгаа биз дээ, Халхад болсон их хурилдаан дээр Жавзандамба хутагт Далай ламын элч Галдан ширээтийг доромжилсон билээ. Илдээ сугалмаар л болсон доо! Хараал идмэр! – гээд хаан зүхэн шагшрав.

- Та нар сайн унаатай биз?

- Тэнхээтэй ч морьд, сайн ч морьд, хаан минь, Алтайг ачсан ч даахаар чадалтай.

- Сайн байна. Морьдоо ээлжлэн өдөр шөнөгүй давхи гэж тушааж байна.Хариу үл хүлээ!

Тэгээд хаан улаан хайрцагнаас бурхан Буддагийн дүрс бүхий хоёр сахиусыг гарган авч элч бүрийн хүзүүнд зүүж өгөв.

- Аз жаргал ивээг! Цэрэг эрийн цээжин дэх бурхан Буддагийн дүр бүхий сахиус бол түүний хүч чадлынх нь эх үндэс мөн!

Хоёр элч зэрэг хаанд мэхэсхийгээд хариулсан нь:

- Бурхан Будда бол гэрч, бид үнэнч цэргүүд!

- Тэгвэл замдаа гар, эр хүний бие амьд л бол сайн, эмээл хазаар хоёр бөх л бол сайн!

Галдан бошгот хаан Жавзандамба хутагтад зэмлэсэн захидал илгээж, Далай ламын элч Галдан ширээтийг өөртэйгээ нэг зиндаанд тавихыг зүрхэлсэндээ хариуцлага хүлээхийг түүнээс шаарджээ. Түшээт ханаас ирүүлсэн мэдээгээр Галдан цэцэн Увашийг Халхын баруун захирагчдын тусгай их хурилдаан хийлгэхээр тушаал өгч явуулжээ. Энэ их хурилдаан дээр баруун халхын ноёд, тайжуудын тангаргийг уншин сонсгожээ. Тэнд: “Бид баруун жигүүрийн хүмүүс, Засагт хааны тушаалыг зөрчихийг эс зүрхэлнэм. Хэрэв бид үүнийг зөрчих аваас, энэ нь шашинд урван тэрсэлсэн хэрэг болно!” [32] гэжээ.

Ийнхүү Халх хоёр жигүүр болон салав. Халхын дорнодод Цэцэн хан нас барж, түүний хүү Илдэн Равдан нь залгаж авав. Түшээт хан, Жавзандамба хутагт нар шинэ цэцэн ханыг энэ хэргэм дээр тохоон томилов.

Зун нь Галдан өөрийн хүмүүсийн хэсгийг Ховд голын зүүн тал уруу нүүлгэж, атар газар хагалж, тариа тарихыг зарлиг буулгав.

Зун болсны баяр-Шинийн сар, Хонины сар, хонь сар-Бурхан Будда Шакъямуний төрсөн өдрийн баяр болов. Ойрадын тал нутаг, уулсын хөндийгөөр хөл хөдөлгөөн, хөгжөөн баясал дүүрэн. Хаа сайгүй л хүмүүс гэрээ өвс ногоогоор чимэглэсэн том том толгоор гэрээ бүрцгээнэ. Баярын өмнөхөн айл өрх бүр сул бөгс хэмээх ургамлын үндэс бүхий хожуулаас хэрчиж авчран, хожуулын хэсгийг гэрийн хүндтэй суудал болох хонин суудлын өмнө тавина. Хөх ягаан цэцэг бүхий сул бөгс хэмээх ургамлын багцыг хонь суудал дээр зална. Нар дөнгөж

мандмагц гэр бүрт өрхийн тэргүүн нь хонин суудлын өмнө өвдөг сөхрөн сууж, уншлага мөргөл үйлдэнэ. Дараа нь аягатай айраг барьж, дээрээс нь арз нэмж дүүргээд хониноос /суудал/ сул бөгсийн багцыг авч, аяганд дүрээд айраг архины хольцыг тал бүхэн рүү цацна. Ингэсний дараа гэр бүлээрээ гадагш гарцгаана. Өрхийн тэргүүн ургаж буй наран тийш харж, мөргөл уншлага үйлдээд архи айрагны хольцыг дөрвөн зүг рүү өргөнө. Хүүхдийнхээ толгойг ч цавдана. Тэгээд мал сүрэг рүүгээ очиж, “Ум ма ни бад ми хум” гэж байнга давтсаар бүх төл малаа цавдана. Дахин тэнгэр, нар, сар, гэгээн уул Сүүмэр, Далай лам, Чингис хаанд хандан уншлага мөргөл үйлдэнэ.

Мөргөл цацлагаа дуусгаад бүгдээрээ идэж уун, морь уралдуулж, бөх барилдуулан дуулж бүжиглэн хөгжилдэнэ. Залуус нь барилдаж, давсан нь унасныгаа дал нуруугаар нь газарт наалдуулан дарахын тулд цээжин дээр нь өвдөглөнө. Ахмадууд нь хагас тойрог үүсгэн сууж айраг ууцгаана. Тэгснээ гэнэт хэн нэгэн өөрийн хар сахлаа илэн, далных нь хооронд хар гэзгээ тавих нь ч бий. Тэгээд л дуулцгааж гарна. Хэрвээ нэрд гарсан Жангарч - Жангар баатар, түүний Ойрадуудын тухай баатарлаг туульсыг хайлагч гарч ирвээс түүнийг тойрон бөөн бөөн сонсогчид цугларна.

Морины уралдаан үзэгчид унаж яваа хүмүүсийг нь хөгжөөн хашгиралдана. Морь унаж яваа хүн бүр гарахынхаа өмнө мориндоо ийн шивнэнэ: “Усны тунгалгийг уу, өвсний шимтэйг ид, хурдан таргалж тэвээр гэж чамд хэлсэн шүү!”. Хоцрогсод морио зэмлэн “Аа, чиний чихийг тасдаж, ясыг нь хамхалмаар хар новш!”

Түшээт ханы Хятад руу мэдээлснээр бол Галдан удалгүй өөрийн хүрээг Алтайн өмнөд бэлээс Саньхэйкэр рүү шилжүүлэн нүүлгэж, Засагт хан ч бас хүрээгээ нүүлгэн, Галдантай уулзжээ. Баруун жигүүрийн бүх ноёд, тайж нарт Засагт ханы хүрээг тойрон байрлацгааж, түүний аюулгүй байдлыг хангахыг зарлиг болгожээ. Халхын зүүн жигүүрт нэгдэхийг хүсч, тийшээ нүүх бодолтой байсан Дэгдэх мэргэн тайж, Ахай тайж нарын нүүхийг нь хоригложээ. Болсон явдлын талаар Манжийн Богд хаанд Түшээт хан илтгээд цэргийн тусламжаа нэмэгдүүлэхийг түүнээс гуйжээ. Кан-Си-д бол Халхад цэрэг дайны бэлтгэл бус, дайн самуун л хэрэгтэй байлаа. Иймд тэрээр Түшээт ханаас авсан мэдээлэл, хий цуурхлыг зарлан, Түшээт ханыг энх тайван аж төрөх тангаргаа дагахыг санал болгов. Халхын зарим тайж нар Галдан умард, өмнө чиглэлд довтолсон мэтээр мэдээлжээ. Харин баруун жигүүрийн халхчууд Засагт хан, Дэгдэх тайжаас бусад нь өөрсдийн цэргээ бэлэн байдалд оруулж, хил хамгаалалтаа чангатгав [33].

Дайн хараахан эхлээгүй байв. Кан-Си Галдан болон Түшээт хан Чахундоржид дайн самуунаа зогсоохыг шаардсан захидал илгээх гэж яарч байв. Тэрхүү нөхцөл байдалд үнэндээ бас бие биедээ үл итгэгч дайсагнагч талуудын хооронд, хараахан дайтаагүй талуудын хооронд тайван байдал тогтоох гэсэн нь бодит эрмэлзэл бус, юуны өмнө дайнд түлхсэн явдал байлаа. Энэ үеийн Хятадын бүх баримт бичгүүдэд Халхын баруун, зүүн талуудын хоорондын шийдэгдээгүй асуудлуудаас үүдсэн зөрчлийн голыг Түшээт хан, Галдан бошгот хаан хоёрын зөрчилд хамааруулсан байдаг ч гэсэн нэг ч захидалд /хэрвээ тийм захидлууд байсан юм бол тэдгээр нь Хятадын он тооллын бичгийн хуудсанд шууд орсон биз/ Галдан, Түшээт ханыг болон түүний ах хутагтыг Далай ламын элчийг доромжилсон гэж дайнаар огтхон ч сүрдүүлээгүй байна. Сөргөлдөн маргагч талуудыг эвлэрүүлэхэд дуйлдуйдагдсан хэмжээгүй их эрмэлзэл тэднийг бүрмөсөн муудалцуулж, Халхыг дайн самуунд эргэлтгүй түлхээр

Эхлээд л Түшээт хан Чахундорж уураа барьж чадсангүй. Шар Засагт хан, Дэгдэх мэргэн, Ахай Дармабага, Зодов ноён нар Галдантай нэгдэхээр гарсан мэтээр шалтаглан Түшээт хан тэднийг гэндүүлэн дайрчээ [35]. Түшээт хан Засагт ханыг дайрсан явдлыг өрсөн цохилт гэж зарим эх сурвалжид тайлбарласан байдаг. “Ойрадын Галдан бошгот хааны түүх” гэдэг он тооллын бичигт өгүүлснээр бол Галдан Түшээт ханд бичсэн нэгэн захидалдаа түүний ах Хутагт Далай ламын элчийг хүндэтгэсэн, Чахундорж тухайн үедээ Очирт цэцэн ханд тусласан, Хятад руу явуулсан Галдангийн элчийг дайрч Очирт цэцэн ханы ач охин - Лувсангомбыг эхнэрээ болгож авсны төлөө Түшээт хантай тооцоо бодохоо амлажээ. “Өшөө авах болсон үндэслэл бий” гэж Галданг бичсэн мэтээр өгүүлээд тэр ч бүү хэл “Чиний овог, аймгийг булаан эзлэхээр би дайлаар мордоно” [36] гэсэн үгс ч байна. Бусад эх сурвалжид энэ захидлын талаар дурьдагдсангүй.

Галдан Халхын хил руу ойртсон тухай Засагт хан болон баруун Халхын хэд хэдэн ноёд Галдантай нийлэх хүсэлтэй бодит болон хуурамч цуу яриаг ашиглан дайнд бүрэн бэлэн байгаа Түшээт хан Засагт хан руу дайран довтолсон нь ”Эдгээр...хүмүүсийг буцаах” [37] гэсэн мэтээр хагас жилийн дараагаар Бээжинд илтгэх зорилготой байлаа. Энэ дайралт нь Засагт хан, Дэгдэх мэргэний хувьд ч амь настай нь ч холбоотой байв. Түшээт хан амжилтаа бататган Засагт ханд туслахаар ирсэн Галдангийн бага дүү Доржжавын удирдсан ойрадын 300 хүнтэй жижиг бүлэгтэй тулгарчээ. Түшээт хан бүлгийг бут цохиж, Доржжавыг хөнөөжээ” [38]. Галдангийн дүүгийн толгойг жадны үзүүрт өлгөн нийтэд харуулан тавьсан аж. Энэ явдлын талаар Ш. Чимэддоржиевийн дүгнэлттэй бүрнээ санал нийлж болно. “Түшээт хан Чахундоржийн үйлдэл нь монголчуудын тусгаар тогтнол, эрх чөлөөгөө хамгаалах сонирхолтой нийцсэнгүй” [39]. Цин улсын тал ч гэсэн энэ үед дайныг Түшээт хан эхэлснийг хэзээ ч няцаагаагүй юм. 1689 оны эхээр Далай ламд бичсэн захидалдаа: ”Түшээт хан Жавзандамба хутагт нар тангаргийн гэрээг зөрчиж Засагт хан, Дэгдэх мэргэн болон Ахайг...алж, ойрадуудыг цэргээ хөдөлгөхөд нь Галдангийн отгон дүү Доржжавыг алжээ [40] гэж мэдэгдэв.

Ойрадуудын хилийн ойролцоо Засагт ханыг, тэр тусмаа Галдангийн төрлийг бут цохиж /Засагт ханы эгч нь Цэвээн-Равдантай гэрлэсэн болохоор Галдан бол талийгаач Засагт хан Шарын хүр дүү болно/ Галданг тууштай үйл ажиллагаанд бэлэн байхыг нэгэнт шаардав. Энэ нь манжийн чиг шугамыг тодорхой барьдаг, саяхан манжийн ятгалгаар оросын эзэмшил рүү /Селенгинск/ дайрч тэнд томоохон түшиц газартай болсон нь Зүүн гарын улсад ч гэсэн аюултай гэдгийг Галдан тодорхой ойлгосон үе ч байж болзошгүй.

1688 оны эхний хагасын цэргийн үйл ажиллагааг Түшээт хан Бээжинд явуулсан илтгэлээс мэдэж болно. Түүний үзсэнээр бол Галдан 30 гаруй мянган хүнтэй армийг үрэлдүүлж, 3 чиглэлээр Халх руу хөдөлжээ. Галдангийн өөдөөс /Түшээт ханы баталснаар/ тэрээр Сухай Лувсангомбын хамт хөдлөхөөс өөр аргагүйд хүрчээ. Дайсагнагч талууд бие биетэйгээ хар Эрчис, Цагаан Эрчис гэдэг газар ойрхон таарчээ. Энд тэднийг талийгаач Далай ламын нэрээр ажиллаж байсан Лхасын элч угтаж, тэдэнд эвлэрэхийг санал болгов. Түшээт ханы мэдэгдсэнээр тэр ”сөргөлдөхийг эс зүрхлэн“ цэргээ дагуулан Чогдос нуурын зүг хэлэлцээ

хийхийг хүлээхээр явсан ажээ. Галдан халхын баруун жигүүрийн хэд хэдэн тайжийг дээрэмдэн хангайн уулсаас зүүн жигүүр рүү орж, Тамир орчмын /Орхон голын цутгалан Тамирын гол/ нутагт хүрчээ. Энд ойрадууд Түшээт ханы хүүгийн бүлэглэлийг ут цохив. Ойрадуудын түрүүчийн бүлэглэлүүд халхын нэрд гарсан хийд Жавзан дамба хутагтын шилтгээн болох Эрдэнэ зууд дөхөж ирэв. Эндээс Түшээт ханы хүрээ хүртэл хоёрхон өдрийн газар үлдэв. Галдан ялалт байгуулсаар л байв. Зая Бандидын намтар бичээчийн үгээр бол "Бошгот хаан ...үймээн дэгдээн булаагдсан олзыг эзэмшиж, олзлогдогсодыг олзолж, зугтагсадыг зугтаалгав."

Эрдэнэ зуугийн орчимд Галдан дахин цэргүүдээ хуваав. Үүнээс өмнө Хангайн нурууг давахдаа өөрт нь дайсагнасан байр суурь бүхий Хотгойдын Алтан ханы эсрэг умарт зүгт хаалт хийхээс аргагүй болсон юм. Одоо Галдан Жавзандамба хутагтын хүрээ Эрдэнэ зуу хийд руу нэг бүлгийг явуулж, өөрөө цэцэн ханы үхлийн тухай болон түүний овог аймгийн захирагчийг солих тухайд бүх Халхад хяналт тавихын тулд Хэрлэнгийн зүг хөдлөх шийдвэр гаргав. Гэхдээ Галдан хаана ч, хэзээ ч, Халхтай байлдаж байна гэж яриагүй. Харин энэ бол Галдангийн Түшээт хантай хийж буй дайн гэж тэмдэглэсэн байдаг. Энэ ч бодит байдалд илүү нийцтэй юм. Учир нь Галдан, Засагт хантай ч Цэцэн хантай ч байлдаагүй юм.

Ингэж Халхад сунжруу дайн самуун болсоор байлаа. Тэрээр Орхоны хөндийд орших Монголын эртний, хамгийн том хийд болох Эрдэнэ зуу руу ойртсоор л. Энэ хийдэд сууж байсан Жавзандамба айдаст автаж, олон тооны лам хувраг нь мөн адил балмагдав. Хийд тэр аяараа л сэтгэл зүрхээ алдаж, нүүрээ буруулсан гэгч шиг л болов. Ямар нэгэн бололцоогүй юм л болчихлоо, үзэгдээгүй юм л үзэгдчихлээ гэж лам нар өгүүлнэ. Бидэн руу аюул занал нүүрлэж, цагаан арслангийн хараал бидэн дээр л буулаа. Энэ Бошгот хаан урьд нь эрхи эргүүлж байсан хүн, одоо илд эргүүлж байх юм". Хутагтын зарлигаар хаврын баярыг ч хойшлуулжээ. "Бидний өмнө өстөн дайсан ирчихээд байхад, биднийг аюул заналхийлж байхад цэнгэн жаргах цээртэй. Энэ сайхан эзэмшил нутаг дайсагнасан хааны гарын бээлий болж, ганзаганых нь тээш болох цаг ирлээ". Дээд ламтан нарын хурал дээр Жавзандамба хутагт, бүх хүмүүсийг хийдээ орхин Цин улсын хил руу яаралтай хүрэхийг зөвлөв. Дайсан даан ч олон:

Тал нутаг уудам ч гэлээ

Тийм их цэргийг даана гэж үү

Ус ихтэй мөрөн байлаа ч

Унд цайнд нь хүрнэ гэж үү

Уулгалах дайснууд шуурга шиг өнгөрөв

Хүмүүс хоосорсныхоо дараа:

Нуугдаж л болбол нүх ч хамаагүй!

Хоргодож болбол бут ч хамаагүй!

Ингээд зайлж одохоор нийтээр зөвшилцөв.

Хутагт өглөө эрт босч, хийдээ тойрлоо. Түүний өөдөөс гүнзгий утга илэрхийлсэн алт, торго, эрдэнэсийн чулуугаар чимэглэгдсэн цутгамал шүтээн болсон бурхад ширтэнэ. Бүхнийг авч явахын аргагүй. Зуугийн гол бурхан Очирваань энэ байна. Хийдийн архивын баримтаас үзэхэд хутагт энэ бурхан хэзээ, хэрхэн бүтсэнийг сайтар мэдэж байсан ч түүний тухай ардын домгийг өөрийн эрхгүй санав. Далай лам монголын хаанд барьж байгаа сүмд нь зориулж бурхан сонгон авахыг санал болгожээ. Ингээд л сонгох болж дээ. Эхний бурхан руу сэлэмнийхээ үзүүрийг чиглүүлвээс бурхан хойшоо ухарч гэнэ. Бусад бурхад ч бас тэгэж гэнэ. Зарим нь эмээснээ болж нүдээ ч аньж байж. Зөвхөн Очирваань огт ухарсангүй, хүйтэн мэсийн өмнө ер хөдөлсөнгүй гэнэ. Монголын хаан энэ л бурханыг сонгож, алс Төвдөөс Эрдэнэ зууд авчирчээ. Үүнийг яах ч үгүй. Ойрадууд үүнийг хөдөлгөхгүй, бурхад өөрсдийгөө хамгаална. Аваад явчихаар үнэтэй зүйлүүд ч бас бий. Хутагт сүмээс гарч хашаа руу оров.

Анир гүмд эргэн тойрон бурхад

Ариун шавь нар нь ч цөмөөрөө

Ав адилхан хувцастайгаа

Амдан гарч дунгаа үлээнэ

Өөрийн хүсэл зоригийг гүйцэтгэгчдэд хутагт ийн зарлиг болгов: - Та бүгдээрээ л миний хүмүүс, жижиг бурхад, үнэт ариун ном судар, ариун эд хогшил бүгдийг цуглуул, бүгдийг нь цуглуул, бүх малыг цуглуул, өнчин хүүг ч бүү орхи, бүгдийг авчир, өнчин ишгийг ч бүү орхи, өнчин унагыг ч бүү орхи. Ачлагын морьд тэмээгээ сайн гарга. Өдөр шөнөгүй явцгаах болно. Бид аврагдах ёстой.

Тэрээр хар бүрээгээ үлээлгэн түмэн тамыг цуглуулах, шар бүрээгээ үлээлгэн бүх санваартныг цуглуулахыг тушаав. Шавь нар нь болон бусад хүмүүс жороо морьдод бурхдаа ачив. Тогтсон ёсоор бурхан бүрийг өөр өөр зүстэй моринд ачив. Бурхад ачиж буй эмээл нь алтан бүүрэгтэй, суудал нь улаан цэмбэ юм уу, торгоор бүрсэн байна. Эмээлийн суудал дээрээс дотор нь бурхдыг хийсэн намхан жижиг хайрцгуудыг ачна. Хамгийн жижиг бурхад, ном судрыг цэнхэр улаан эдээр ороож хайрцаглажээ. Хүмүүс тун шалмаг ажиллацгаав. Янз бүрийн ном ачсан тэмээн жин, мал сүрэг цөм бөөгнөрөв.

Жингийн цуваа замд хөдөлмөгц хутагт мөргөлийн дугануудынхаа дөрвөлжин цагаан хана, далан хальс модоор хийсэн дээвэр, түүний үндсээр хийсэн дээврийн хөвөө, тэрхүү хар хөвөөн дээр суулгасан наранд гялалзагч шар зэсэн цагиргууд руу харав.

Хийдээс холгүй хутагтын эцэг эх нь ирэх үед түүний мөргөл үйлдэхэд нь тусгайлан барьсан жижиг дугана ганцаардангуй харагдана. Хутагтын элэг нь эмтрэх шиг болов. Тэрээр наашаа эргэж ирэх болов уу? Хэрвээ ирвэл хэн болж ирэх вэ?

Эзэнтний мэлмийнээс гэнэтхэн

Эрдэнийн хоёр дусал унав.

Торгон ханцуй аажим хөдөлж

Баруунаас зүүн, зүүнээс баруун тийш

Гунигийн нулимсаа арчих авай.

Ойрадын бүлэглэл Эрдэнэ зууг эзлэн авахад, хийдэд хуруу дарам тооны өндөр настай лам нар л үлдсэн байв. Монголчуудын ижил сүсэгтнүүд, хардамтгай буддистууд дугануудад гар хүрсэнгүй. Галдан өөрөө Эрдэнэ зуу оролгүй, гол хүчтэйгээ Цэцэн ханы эзэмшил нутаг Хэрлэнг зорив. Гэвч олон түмний цуу яриагаар хийд хэвээрээ үлдсэнийг буддист-ойрадуудын зан төрхөөс болоогүй, харин Эрдэнэ зуугийн бурхадын хүчин чадлаас болсон гэнэ. ”Өөлдийн цэргийн толгойлогч Бошгот Халхын нутаг руу довтлов. Сүмд сууж байсан учир түүнийг Бошгот Галдан гэж дуудна. Тэрээр Орхон хүрч, Эрдэнэ-зуу руу оров. Дугана руу ороод тэрээр бурханы духан дахь бадмаараг эрдэнийг сэлмээрээ ухаж /Зонхов бурханы духан дахь үү нь бадмаараг эрдэнэ байв/ гэнэ. Зуугийн хажуугаар байрлах хоёр Гомбогүр бурхад илд барин өөдөөс нь ухасхийхэд тэрээр дуганаас зугтан гарчээ. Энэ үед Аватай өөрийн халхчуудад хэлсэн нь: Галдангийн гарт орохгүйн тулд Орхондоо живж үхсэн минь дээр” гэжээ. Ингээд бүх халхчууд Орхон руу гүйлджээ. Гэтэл Орхон тэднийг мөс шиг хатуу гадаргуу дээрээ өргөн гаргажээ. Тэдний араас өөлдүүд очвол ус тэднийг тэтгэсэнгүй, бүх өөлдүүд живжээ” [41].

Галдангийн бүлэглэлүүдийг Халхын дорнод муж руу явж байх үед Жавзан дамба хутагт Түшээт хан нар өөрсдийн хүмүүсээ аваад Цин улсын хил рүү зугтсан ажээ. Тэд мянган цутгалан, үй олон салаа бүхий гол мэт зам даган урагшилна. Жингийн цуваа аяны шувууд ирэх шиг шуугилдан буцах шувууд шиг шаагилдан ачаатай тэмээ уянгалан буйлж, албатууд чанга чанга хашгиралдан, ахмадууд, цэргүүдийн дуу хадан, ертөнцийг хүн малын тоос манан адил бүрхэж байлаа.

Ойрадууд хийдийн ойр орчныг болон дараа нь Түшээт ханы хүрээг дээрэмдэв. Түшээт ханы эзэмшил нутгийн хүмүүс нь өмнө зүг рүү зугтацгаав.

Бүрэлдсэн нөхцөл байдлаас Кан-Си нэгэн дүгнэлт хийв. /Хэдийгээр улсын эрх баригчид Галданг ойрадуудынхаа хамт Халхад байгаа эсэх талаар бодитой мэдээлэлгүй байлаа/. “Халхчууд ойрадууд бие биетэйгээ байлдаж, манай хил хязгаарыг ч хамгаалах хэрэгтэй болж байна” [42]. Үүнийг Цин улсын бүрэлдэхүүнд орсон монголчууд л хийх ёстой байлаа. Түшээт хан болон түүний ах хутагтын босуулуудыг Цин улсын харуулууд хил рүүгээ нэвтрүүлсэнгүй. Тэднийг олигтойхон шиг айлгаж өөртөө итгэх итгэлийг нь алдагдуулан улмаар өөрсдөө Цин улсад дагаар оруулахыг гуйхад хүргэжээ.

1678 оны 7-р сард /VIII-8 – IX-6/ Галдан Кан-Си-д захидал илгээж, “Жавзан дамба хутагт, Түшээт хан хоёр Далай ламын сургаалын эсрэг бослоо. Тэд ёс заншлаа умартан Ширээтгэй хүндэтгэлгүй харьцсан. Би тэдэнд хандаж тэднийг ёс заншилдаа эргэн орж, улмаар тэдний хооронд сайн харилцаа тогтоохыг уриалсан авч, тэд миний саналыг няцааж, шударга бус хандлаа. Эцсийн эцэст цэргээ хөдөлгөж аян дайнд мордоход хүргэв. Ингэж зэвсэг барьснаараа би Далай ламын сургаалыг хамгаалж байна. Тэдний хүрээг бут цохилоо. Эдгээр

хүмүүс цэрэг албаттай байх учиргүй билээ. Эцэж ядарсан, хоргодох байргүй тэдгээр хүмүүсийг хэрэв та нар дээр очвол бүү хүлээж аваарай” [43]. Цин улсын орон нутгийн эрх баригчдад Галдан Түшээт хан, Хутагт хоёрыг хүлээж авалгүйгээр баривчилваас өөрт нь өгөхийг сануулжээ.

Түшээт хан, түүний ахын хувь заяаны боломжийн талаарх асуултанд Кан-Си хариулсангүй. Талуудыг эвлэрэхийг санал болгоод, үүндээ Далай ламыг туслалцахыг уриалжээ. Цин улсын эрх баригчид өөрсдийн хил хязгаараа хамгаалах арга хэмжээг нэгэн зэрэг авчээ. Цин улсын тагнуулын мэдээгээр Галдангийн бүлэглэлүүд Цин улсын хилээс дөнгөж 7-8 - хан өдрийн замд байгаа ажээ. Жавзандамба хутагтыг хамгаалуулхаар 200 хүнтэй тусгай бүлгийг илгээжээ. Тэдний цөөнийг гайхах хэрэггүй бизээ. Энэ бол Цин улсын цэргүүд, тэдэнтэй мөргөлдөх нь Галдангийн хувьд өөрөө хүсээ ч үгүй байсан Цин улстай дайтах явдал байлаа. Тэрээр хариуд нь мэдэгдсэн нь ”Мэргэн гэгээн эзэн хаан надад туслахаар ирлээ... Би өөрийнхөө тоос хөдөлгөж явааг хөхүүлэхийн тулд зөвхөн Тэнгэрийн гүрэнд л найдаж байна” [44].

Галдангийн бүлэглэлүүд Хэрлэнгийн бэлчирт хүрэв. Цин улсын хил рүү зугтсан Цэцэн ханы хүмүүсийн мэдээлснээр Галдан хэсэг цэргийнхээ хамт Хэрлэнг гатлан уруудахдаа өөрийн элч нарыг Цэцэн тайж болон ноёд руу илгээж түүний дайсан бол Жавзан дамба хутагт, Түшээт хан хоёр мөн, бусад халхуудтай байлдахгүй амар тайван аж төрж нутагтаа тайван байхыг мэдэгдсэн байна. Харбинаас Цин улсын нийслэлд ирсэн мэдээгээр Хэрлэнд Галдан руу Далай ламын элч иржээ. Түүний асуултанд Галдан хариулсан нь: “Хэрвээ би Түшээт хантай эвлэрвээс миний дүү Доржжавын амийг хэн төлж өгөх вэ? Би 5-6 жил бүх хүч чадлаараа байлдан халхыг устгаж Жавзан дамбыг заавал барьж авна!” [45]. Энэ бол чухал, учиртай үгс. Төвд улс өөрсдийнхөө гол хишиг буян хайрлагчидтай дайтахыг хүссэнгүй, шашны төв болсон төвдөд санхүүгийн өргөл барьц өгдөг улсууд нь туйлын чухал байлаа. Хятадын Цин улсын эсрэг тэмцэлдээ тулгуур болох хүчийг задраахыг Төвд хүссэнгүй. Гэлээ ч Галдан Төвдийн саналыг дагасангүй, улмаар дүүгийнхээ Цусан өшөөг авахаар мөргөлдөөнд нэгэнт орж Жавзандамба хутагт гэж дахин хэзээ ч бий болохооргүйгээр, өстөн дайснуудаа бүрмөсөн устгаж, улмаар тэднийг Богд хааны хамсаатан хэмээн түлхэх байлаа.

7 сарын эцэс 8 сарын эхээр /8 сарын эцэс, 9 сарын эх/ Түшээт ханы эсрэг эцсийн арга хэмжээ авахаар бүлэглэлүүдээ Хэрлэнгээс Туул голын зүг эргүүлэв. 1687 оны 10-р сарын 8-нд Түшээт хан Цин улсын эрхтнүүдээс Галдангийн эсрэг хүйс тэмтэрсэн дайн явуулахаар цэрэг гуйжээ. “Эрт цагаас би ариун сэтгэлээр Богд хаанд өргөл барьцаа харамгүй барьж, хэрвээ намайг туйлын хүнд байдалд оруулсан догшин дайсантай тулгарахад би Богд хааны аврал тусламжинд үргэлж найдаж байсан. Галдан цэргээ хөдөлгөж над руу довголлоо. Байдал хүндэрлээ. Хэдийгээр би цөөн цэрэгтэй ч гэсэн Галдантай байлдсаар, ялагдал хүлээсээр байна. Гэхдээ одоогоор би хамгаалах чадваргүй боллоо гэхээс эмээж байна. Тэнгэрийн их гүрэн цэргээ илгээж туслана гэж өчүүхэн би гуйж байна!” [46].

Шийдвэрлэх цаг болов. Хятадын Цин улсын төрийн зөвлөлийн хуралдаан дээр: “Ойрадууд ч, халхчууд ч, бусад нь ч гэсэн адилхан бидэнд хүндэтгэлтэй захирагдан, жил бүр өглөг барьцаа өгч ирлээ. Халхчууд буруу зам дээр гарсныг ойрадууд нотолж, халхчууд ч гэсэн ойрадуудыг буруу хэрэг үйлдсэн гэж ярилцаж байна. Хэдийгээр Түшээт хаан Ойрадуудаас болж, толгой

нь эргэсэн ч манай улсаас тусламж гуйж байгаа нь одоохондоо түүнд цэрэг явуулж туслуулах болоогүй гэлтэй. Юуны өмнө Түшээт ханыг 49 туг шиг байр сууриа эзэлтэл, өөрөөр хэлбэл, манай улсад захирагдахыг тулгавал зохилтой” [47]. Йинхүү үнэн санаа нь илэрхийц үгс нэгэнт хэлэгджээ. Хэрэв Халхын гол хан Түшээт хан Хятадын Цин улсад захирагдвал, өөрийнхөө хүмүүс, газар нутгийн хамт Хятад улсын бүрэлдэхүүнд орвол хүссэн авралаа авч болно. Тэгэхдээ Кан Си-гийн саналаар бол, “хан хэргэмийг нь хадгалж болох боломжтой” [48].

Түшээт ханы гуйлт нь Галданг Хэрлэнгээс буцахад хүргэлээ. 1687 оны 10-р сарын 9-10 нд Галдан хааны цэрэг, Түшээт хан Чахундоржийн цэргийн хоорондох тулалдаан Улаан нуурын дэргэд болов.

Галдан бараа бологчдоо дагуулан дайсны болон өөрийн байрлалыг харах, шийдвэрлэх тулааны төлөвлөгөөг тунгаахаар 2 бээр орчим /14км орчим/ давхив. Далай лам тухайн үедээ Галданд дорно зүг рүү хийх аян дайндаа амжилт олно гэж урьдаас хэлсэн, гэвч амжилт хүссэнээр ирэхгүй л байв гэсэн цуу яриа түгсээр. Бараа бологсод нь ч гэсэн өлсч ядран, морьд нь ч цуцав. Зөвхөн Галдангийн алтан шарга л урьдын адил омголон хэвээр, хаан ч нэг их ядарсан юмгүй байв.

Галдангийн зүүн талаас хааны зүүн дөрөөг өөрийнхтэйгээ харшуулан нум шиг

биеэ цэргийн албаны элдэв гачаалд дасгасан залуу зайсан, цэргийн жанжин давхин ирэв.

- Хаан, буцацгаая. Маргааш өглөө дайсныг баруун талаас нь дайрч, зүүн талаас нь тогтоон барьж нуур руу шахая гэсэн саналыг зоригтой хэлмээр байна.

Галдан хариулсангүй. Гэвч 200-300 алхам хир давхиснаа сая л мориныхоо жолоог татан эргүүлэв. Хүрээнд иртэл түүнд Түшээт ханы тагнуулыг баривчилсан тухай илтгэв. Галдан амсхийгээд, аяга хүйтэн айраг залгилаад тушаасан нь;

- Зөвлөлийг хуралдуулья!

Хааны хүрээлэлийнхэн тойрог гарган сууцгааж, түүний төрөл, хөгшин залуу цэргийн жанжнууд, Хэрлэнгээс Ногайн тал хүртэл хал үзэж, хашир суусан хүмүүс сууцгаана. Чанга бус тайван яриа өрнөв. Хааны баруун талд ойрхон суусан хүмүүс эхний асуултуудыг тавив. Тагнуулын ажлын үр дүнг асууцгааж, тулалдааны төлөвлөгөөний талаар өөр хоорондоо тааварлан ярьцгааж байв. Эцэст нь нэгэн ахмад жанжин хоосон яриаг үл тэвчин, дэмий ярианд цаг үрэх хэрэг цэргүүдэд байна уу хэмээсэн янзтай Галдангаас ширүүхэн асуув;

- Тэгэхээр, Хаан та, биднийг Түшээт ханыг бут цохихыг тушааж байна уу? Галдан инээмсэглэхэд;

Шүд нь бүхний өмнө яралзаж

Зүрх хэлбэрт уруул нь

Тасам болон тэлэгдэв.

- Түшээт ханыг яаж цохих вэ? “Газрыг нь эзэгнэж, хан төрийг нь хоосруулж, цэргийг нь бут цохиж, хүн олныг боолчилъё” гэдэг биз дээ. Олзны хүнийг оруул.

Олзлогдсон халх залууг оруулж ирэв. Тэрээр толгой нүцгэн, үс нь сэгсийсэн, баруун шанаандаа хөх няц болсон, шингэн нарийн сахалд нь цус хатсан, гарыг нь ард нь нарийн сураар хүлсэн байв.

- Яах гэж ирсэн вэ?

- Хаан таныг олон цэрэгтэй юм уу гэдгийг мэдэх гэж ирсэн!

- Тэгээд олон байна уу?

- Олон байна, хаан. Бид тэсэхгүй байх.

- Тэгвэл бидний талд зүтгэх үү?

- Үгүй ээ, хаантан. Харийн хааныд аргал түүдэг боол болохгүй.

- Чамайг цаазална.

- Энэ бол таны хүсэл зориг.

- Түшээт ханы цэргийн талаар түүнээс асуусан уу?

Олзлогдсон залууг авчрагсадын нэг нь:

- Асуусаан, хэлэхгүй байна. Магадгүй, ташуур л хэлүүлэх байх.

Галдан дуугүй болж, бодлогширов.

- Одоохондоо хэрэггүй. Миний шар цоохор тугийг авчир!

Галдан бошгот хааны тугийг нь авчрав.

Хэрэв Богдын туганд бүрээс нөмөргөвөл

Харанхуй нөмөрнө, нэг л нарыг

Хэрэв тугийг хийсгэж, мандуулбал

Харанхуй нөмөрнө, долоон нарыг ч

Ийм л туг байлаа даа.

Галдан нэг ноёныг дуудан ирүүлж, түүнд ямар нэг юм шивнэв. Тэгээд туг руугаа заан, хоёр

залуу цэргийн барьж байсан олзны монголыг хүчээр өвдөг сөхрүүлээд:

- Чи миний цэргийг харсаан. Миний тугийг, миний алдар сууг ч харж байна. Би амийг чинь өршөөе. Явж Түшээт хандаа дамжуул; “Хаан чи, өөрийн ахын хамт Далай ламын элчийг ч, намайг ч доромжилсон билээ. Чи миний дүүг алсан, би чамаас өшөөгөө авна”.

Өмсгөлөөр нь харвал ойрад цэргийн жанжин болох хүн гарч ирээд суув. Дуулгаан хэлтгий тавьсан нь баатар эрийн эр зоригийнх нь шинж гэлтэй.

- Данжила, - гэж Галдан түүнд хандаад,

- Өглөө нар мандсанаас хойхно цэргээ Түшээт ханы буудал руу дагуулаад яв. Битгий унтчихаарай!

Данжила гомдолтой гэгч шуухитнан уур нь дүрсхийв. Түүний хуурмаг зан гаргаж байгааг харахад андашгүй.

- Тийм үгээр яана! Хаантан, та намайг мэднэ шүү дээ. Би бол ясны цэрэг, надтай маргалдвал хадны ангалд л ялзарна, би бол цуснаасаа өдөөгч хүн, надтай шөргөөлдвөл голын урсгалд улайрах болно. Маргааш нар мандмагц дайръя!

Данжила хултай айргийг авч, баригдсан Халх руу ууртай гэгч хараад, гэв гэнэтхэн мөрөвчөө алгадан, шулмас лугаа зэвүүтэй хөхрөв.

Халх эрийг газарт дарж буй цэргүүдэд Галдан тушаасан нь:

- Үүнийг манай харуулуудаас өнгөрүүлж, эсэн мэнд буцаа!

Халх эрийг аваад явмагц, Галдан сууж буй хүмүүст хандан зөөлөн дуугаар хэлсэн нь:

-Шөнө дайръя! Одоо унтацгаая,- гээд зөвлөлийг тараав.

Галдангийн шилмэл цэргүүд Жамба Эрх дайчны удирдсан Түшээт ханы цэргийн хүрээг шөнө дөлөөр дайрав. Гэндүүлэн дайрагдсан халхууд бараг л толгой дараалан цавчуулав. Өглөө болоход Түшээт ханы тайжийн цэргийн хэсэг нь ойрадын цохилтын амтыг хараахан амсаагүй, зарим нь бүүр эзнээ орхин хятадын зүг, ер нь харагдсан зүг рүүгээ зугатацгаав. Түшээт хан өөрийн цэргийнхээ хагасыг тогтоон барьж, эгнээгээ бүрдүүлж амжив. Галдан цэргүүдийнхээ өмнө өөрийн биеэр гарч ирэв.

Хүчирхэг духных нь судас гүрэлзэж

Хэмжээгээрээ ташуур шиг болов

Зүрх нь цээжин дотроо дэлдэж

Зориг нь ёстой л буцалж байв

Аль ч үед тасхийхэд бэлэн

Арван цагаан хуруу юугаан

Атгаж чангалсан нь аймшигтай

Хуруу бүр нь арслангийн хумс шиг

Хүчит тэр хүнд хүрэхэд ч аймшигтай

Хүйтэн нүднийх нь хүүхэн хараа

Арван хоёр дахин эргэлдэв.

Олз хөөхдөө л шонхор шувуу

Осолгүй яг л ингэж хардаг!

Ингээд бараг 3 өдөр үргэлжлэсэн тулаан эхлэв.

Ой мод ч ганхаж, улайд автах мэт

Орчлон дэлхий харанхуйд умбав.

Унаатай, явган цөм холилдож

“Урай”-н дуу төмрийн харшилдаантай холилдож

Унаа морьдын цус хүнийхтэй холилдож

Унаатай хүмүүсийн өвдгөөр татав!

Ийнхүү хүчтэй цохилт үзүүлж, ...

Далан товч нь догшин хуягнаасаа

Тас үсрэхүйд, шар илд

Мөрнөөс доогуур биенд нь зоогдов.

Мэсийн хурцыг зүрх нь мэдрэв.

Нурууны нь үенүүд татганан мурилзав.

Дайсны хавирганууд үйрэмдэг болов.

Далдуур санаа нь ч нэгэнт дуусав.

Тас харанхуй нүдийг нь бүрхэв!.

Дөрөв дэх өдөр нь Түшээт ханы цэргүүд сандарч мэгдэн зугтаж эхлэв. Нуурын усыг энэ өдрүүдэд асгарсан цусны өнгөөр сүлсээр наран жаргав. Нуга хүүрээр дүүрч, цусанд будагдсан ногоон дээгүүр ойрадын цэргүүд явж, алагдсан дайсныхаа хуягийг авах аж. Маргааш нь Түшээт хан цэргийнхээ үлдсэн хэсэгтэй цуг Ханхай өнгөрч, Жавзандамба хутагтын нүүдэлтэй нийлэн гэрийн зүг, Кан- Си-гийн их бууны энэрэлд багтахаар хөдлөв. Засагт хан алагдаж, Цэцэн хан таалал төгссөн учир Халхын хувь заяаг Түшээт хан Чахундорж л шийдэх цаг болов.

1688 оны өвөл гэхэд Халх нь Монголын болоод Ойрадын газар нутаг дахь улс төрийн ба хувийн олон үзэл, сонирхол нийлсэн төв болов. Жавзандамба хутагттай зөрчилдсөнийхөө дараа Галдан Халхын дайнд татагдан орсон юм. Халхын хэрэгт түүний оролцох болсон нь зөвхөн дүүгийнхээ төлөө цусан өшөө авахад чиглэгдсэн үйл явдал биш байлаа. Галдан Халхад Түшээт ханы засаглал хүчтэй болж буйн эсрэг, Халхын нэгдлийн эсрэг байсан төдийгүй, Хятадад талтай хаадын засаглалд орох бүүр ч дургүй байлаа.

Хэдийгээр Халхыг Цин улсад захируулахыг хүсдэггүй царай гаргавч, Хутагт ахтай Түшээт хан Халхад өөрийн гэр бүлийн, шашины манлайлалдаа болон Цин улсын ордтой холбоотойдоо дулдуйдан, улс төрийн бодлогодоо Халхын бусад хаадыг давамгайлж байлаа. Шийдвэрлэх үе ирэхэд ганцаар тэсэхгүйгээ ухааран, ойрадуудаас айхдаа /Галдан Түшээт хан болон Жавзандамба хутагтын амь насанд нь заналхийлсэн юм./ тэрээр Орост, эсвэл Хятадад захирагдах уу хэмээн эргэлзэхдээ Хятадыг сонгосныг бид цаашдаа харах болно.

Засагт хан Шарыг Түшээт хан хорложээ. Засагт ханыхан Түшээт ханыхан болон ойрадуудаас эмээдэг байсан учир нь ойрадуудтай хамтран ажилладагт байв.

Цэцэн хан таалал болов. Манжийн хөрш Цэцэн ханд тэдэнтэй эртнээс холбоотой байсан ба Түшээт ханыхныг хүчтэй болохыг хүссэнгүй. Оросын эсрэг байр суурьтай, Хятадын Цин улсад дагаар орох хандлагатай байлаа. Галдангийн цэрэг Хэрлэнд орж ирэхэд Цэцэн ханы тайжуудын нэг хэсэг нь Цин улс руу тэмүүлж, Түшээт ханаас бүр өмнө Богд хаанд дагаар оржээ.

Төвдийн Засгийн газар нь дээр дурьдсанчлан Тавдугаар Далай ламын таалал төгссөнийг нууцлан түүний олон улсын болоод хувийн их нэр хүндийг ашиглаж байлаа. Төвдөд Гүүш хааны ойрадуудыг батлан оруулснаас болж, улсын дотооддоо ярвигтай болсон Төвдийн засгийн газар, гаднаас Цин улсын заналхийллээс эмээж байлаа. Тэрээр Халхыг Цин улсад захируулахыг хүсэхгүй байсан нь мэдээж. Харин Ойрад - Халхын зөрчилдөөнд аль нэг талыг нь илт дэмжихийг ч хүссэнгүй. Үүнийг Галдан сөргөлдөгч талуудыг эвлэрүүлэхэд уриалсан Төвдийн элчтэй уулзах үедээ Галдан ойлгосон нь тодорхой.

Цин улсын засгийн газар /тэргүүн нь болох Богд хаан манжийн хаан байхаа больж, эзэнт улсын их гүрний сонирхлыг төлөөлсөн Хятадын эзэн хаан бол /1688 онд Тайваны арлыг өөртөө захируулснаар дотоодын газар нутгаа нэгтгэх явдал нь дуусч, хойд зүгт ажил явдлаа цэгцлэхэд шулуун болов. Юуны өмнө энэ нь Орос улс байв. Энэ тухай товч дурдъя.

1682 онд оросууд Амар мөрний эхэнд Албазиний шивээт хотыг үндэслэн босгожээ. Оросын газар нээгчид дорно зүг рүү эрчимтэй хөдөлж, Амар мөрний хавиар хэнд ч үл хамаарагдах газрыг эзэмших болов. Энэ газар нутаг ямар ч улсад харъяалагдаагүйг Цин улсын эзэд сайн мэддэг байв. Тэд нэг бус удаа Амар мөрний зүг аянд мордож, нутгийн олныг дээрэмдэж, ялангуяа нанайчуудын өвөг олон мянган олзлогдогсдыг хөөж туун боол болгох юмуу, эсвэл 8 тугт цэрэгтээ оруулдаг байв. Амар мөрний орчмыг нутгийн оросууд хоосруулсангүй, харин эзэмшиж, тариалан эрхлэх болсон нь Цин улсын эздэд энэ баялаг нутгаас тэднийг шахах хүслийг нь төрүүлжээ. 1652 онд манжууд Сунгарын адаг дахь хасаг Хабаровын бүлэг рүү довтлон, тэднийг энэ нутгийг орхихоос аргагүйд хүргэв. 1658 онд тэд Сунгар болон Хүрх голын завсраар Степановын бүлгийг дайрчээ.

1675-1678 онуудад Кан-Си Оросын элчин Николай Спафарыг /Минеску/ хүлээн авчээ. Өмнөх Оросын элч нар Федор Байков, Иван Перфильев нарын адилаар өвдөг сөхрөн, эзэн хаанд 3 мөргөхөөс /ингэж татгалзсан Байков, Перфильев нарыг Кан-Си хүлээж аваагүй юм/ татгалзан, бэлгийг нь босоогоор хүлээн авчээ. Цин улсын эрхтнүүд оросуудыг Амар орчмын нутгийг эзэмшихээ зогсоох, оросын элчингүүдийг хүлээн авалтын ёсыг дагаж байхыг шаарджээ. Албазины шивээлсэн хотыг барьсан явдал Цин улсын засгийн газрыг ихэд шаналгажээ. Кан-Си өөрөө Мүгдэн орж Албазины орчим руу түшмэл Лантаныг бугын авд, үнэндээ бол цэргийн тагнуулаар явуулжээ. Албазин дахь оросуудын хамгаалалтын цэрэг олон биш, хотыг хүчээр авч болно хэмээн Лантан Кан-Сид мэдээлжээ. 1683 онд Албазиныг дайрах зорилгоор Цин улсын эзэд Амар мөрний баруун эрэгт Сахалян уул /Айхун / цайзыг барьж, Мүгдэн рүү Хятадын гүнээс цэрэг явуулж байлаа. 1683 онд Айхуны ойролцоо манжууд Григорий Меньшиковын 67 хүнтэй бүлгийг дайрч бут цохив. Жилийн дараа 1684 оны 7 сард тэд анх Албазин руу дайрчээ. Тэд хөлөг онгоцоор дөхөж очоод, довтлох үед хэрмийн цаана

байсан олон арван оршин суугчдыг булаан авчээ.

1685 оны хавар Пэн Чуны удирдсан Цин улсын бүлэглэлүүд бүрэлдүүндээ 10 мянган цэрэг, 150 хээрийн ба 50 бүслэлтийн буутайгаар 450 хүн, дөрөвхөн сумтай 3 их буу бүхий хамгаалалтын цэрэгтэй Албазиныг дайрчээ. Цин улсын цэрэг шууд дайралтаар эзэлж чадалгүй улмаар бүсэлжээ. Эмэгтэйчүүд, хүүхдүүдийг аврахын тулд мужийн цэргийн ноён Толбузин Шэн Чуньтай хэлэлцээр хийв. Гэр бүл, зэвсэгтэйгээ цайзыг орхин явах боломжийг бүслэгдэгсэд олгохоор талууд тохиролцжээ. 1685 оны 5 сард Кан-Си Оросын хаан Алексей Михайлович-д захидал илгээж, Оросуудыг Амар мөрнөөс зайлахыг шаарджээ. Гэтэл албазинчуудыг Нерчинск хүртэл, тэндхийн цэргийн ноён Власов тэднийг буцааж явуулжээ. Албазинчуудыг буцаад ирэхэд цайзыг үнсэн товрог болтол шатаасан учир шороон далантай шинэ цайз барьж эхлэв.

1686 оны 6 сарын 6-нд Цин улсын цэргүүд Албазин руу ахин довтлов. Энэ удаа Оросын 9 их бууны эсрэг нөгөө талд нь 400 их буу байв. Гэлээ ч гэсэн бүслэлтийн 5 сард үр дүн гарсангүй. Тулалдаанд 2500 хүнээ алдсан Цин улсын цэргийн жанжнууд хэрмийн бүслэлтийг зогсоож, бүх замыг нь хаажээ. 1687 оны 5 сар гэхэд дайн тулаан болон чийг бамын өвчнөөс болж, Албазинд дөнгөж 70 хүн үлджээ.

1686 оны 1-р сард Оросын элчин Ф.А.Головин Хятадыг зорив. Түүний элч Оросын элчин ирж явааг мэдэгдээд Цин улсын цэрэг Албазиний районд оросын нутаг дэвсгэр рүү дайрсаныг эсэргүүцсэн захидлыг хүргэжээ. Цин улсын цэрэг бүслэлтээ орхисон ч урьдынх шигээ хуучнаараа Албазинаас тавхан мод газрын зайд буудаллажээ. Цин улсын шууд өдөөн турхиснаар 1688 оны 1-р сард Түшээт хааны бүлэглэлүүд Байгалын чанад дахь оросын хотууд, Селенгинск, Удинск руу довтолсон хэдий ч цохигдсон байна. Түшээт хан Галдан нарын дайн, ойрадууд Түшээт хааныг бут цохисон явдал байдлыг нилээд өөрчлөв. Оростой явуулсан хэргээ дуусгаагүй байсан Кан-си,Халхын хэрэг явдалд цэргийн шууд оролцоо хэрэглэхээс түдгэлзэв. Тэгээд ч энэ үед Түшээт ханыг хамгаалж, түүнийг Цин улсад дагаар оруулах шаардлагатай байв. Цин улсад Халх дагаар орвол Оросын хаантай хэлэлцээр хийхэд Кан-си – гийн байр суурийг бэхжүүлэх байв. Кан-си Халхыг Хятадын бүрэлдхүүнд тууштай оруулж чаджээ.

Энэ үед Орос улс Турктэй зөрчилтэй байсан учраас Амар хүртэл төвөөс хэт хол учраас Цин улстай харилцаагаа зохицуулахаас төвөгшөөж байлаа. Халх-Ойрадын үйл явдал Оросын улс төрийн бодлогод ямар нэгэн онцгой байдлаар туссангүй.

Эцэст нь Галдангийн ач Цэвээн–Равдан гэгч өөрийн авга ахыг үзэн ядаж, Зүүн гарын улсыг Галдангийн эсрэг босгосон бас нэгэн хүчин буй болжээ. Галдангийн эсрэг бодлого нь Цэвээн–Равдан болон түүний холбоотнуудыг Цин улстай холбоо тогтооход аяндаа түлхэв. Цэвээн –Равдангийн зорилго бол Галданг устгаж, өөрөө Зүүн гарын улсын хаан ширээнд залрах явдал байлаа.

1688 оны 9 сард /IX-24-нөөс X сарын 23/ үлдсэн цэрэг хүмүүстэйгээ Цин улсын хил дээр очсон Түшээт хан, Жавзандамба хутагт нар хэрхэх эсэхээ тааварлаж ядан байв. Галданд захирагдана гэдэг бол үхэлтэй ижил. Орост дагаар орох санал ч гарч байлаа. Энэ оны нэгдүгээр сард Оросын Байгалийн чанад дахь Оросын хотууд руу бүтэлгүй дайралт хийсэн

Түшээт хан Орост дагаар орохыг өөрийн хувьд аюултай гэж үзжээ. Ингэж л Цин улсад захирагдах шийдвэр гарчээ. Түшээт хан, түүний ах хоёр Цин улсад ямар ч эргэлцээгүйгээр дагаар орсныг тэмдэглэх нь чухал. Нөхцөл байдал ч тэднийг тийм алхам хийхийг шаарджээ.

1688 оны 10 сарын 1-нд Түшээт хан, Хутагт хоёр Цин улсын эрхтнүүдэд өөрсдийгөө бүх хүмүүс, эд хөрөнгийн хамт дагаар оруулахыг хичээнгүйлэн гуйжээ. Халхын монголчуудаас тийм алхам хийсэн хүмүүсийн анхных нь биш гэдгийг хэлэх зүйтэй. Цэцэн хан Намжил тайж болон бусад хүмүүс өмнө нь Цин улсад дагаар орсон байв. Цин улсын эрхтнүүдэд Түшээт хан, Жавзандамба хутагт хоёр захидал бичжээ: ”Бид хоёр бол үл бүтэх хүмүүс, бидэнд илгээсэн зарлигийн утга санаатай гүн танилцаад, бид баярлан гялайснаа нуухгүй байж чадахгүй нь. Эрт цагаас биднийг удирдан залж ирсэн Зүүн жигүүрийн халхчууд олон жилийн туршид бидний хамтаар агуу их эзэн хааны ордонд захирагдах бололцоо олгож өгөхийг биднээс хүссээр ирсэн гэдгийг хүндэтгэлтэйгээр мэдэгдэж байна. Бидэнд өгөөмөр хишгээ хайрлаж, биднийг аль болох хурдан аврахыг хичээнгүйлэн гуйж байна”[50]. Энэхүү захидлыг явуулахын өмнө Жавзандамба хутагтын удирдлагаар Түшээт хан болон түүний ноёдын зөвлөлгөөн болжээ. А.М.Позднеев бичихдээ: “Энэхүү хурилдаан дээр Халхад өөрсдөө бие даан оршин тогтнох боломжгүй болсон тул дагаар орох арга хэмжээ авах шаардлагатайг мэдэгджээ. Тэр үед монголчуудад Шар хятад хэмээн нэрлэгдэж байсан Оросууд уу, эсвэл Хар хятад гэгдэх манжуудад уу гэдгийг л шийдэх үлджээ”[51]. “Хэнийг дагах сонголтын талаар гэгээн ламтан л мэдэг” гэж ноёд хариу мэдэгдэхэд хутагт Хятадыг сонгосон байна. М.Кураны саналаар бол хутагт зөвхөн шашны бодлогоосоо л болж Цин улсыг дагахыг эрхэмлэжээ [52]. Хятадад ирсэн хутагтын элчин түүний нэрийн өмнөөс ийнхүү мэдэгдэв: “Мэргэн гэгээн эзэн хаан минь ...надад ариун сургаалын агуулга, дэг жаягийн талаар санаа тавихыг заасан билээ...Гэнэт ойрадууд ирж, миний сүм хийдийн ариун номуудыг минь шатаалаа...Эртнээс надад тэнгэрийн эзэн хаанд нэгдэх бодол байсаан...Миний бодол бол тууштай гэж би хариулсаан.Хэрэв тэдэнд дагаар орох үнэнхүү хүсэл байваас өөрсдийн хүслээр болцгоог. Тэдний өмнөөс би илтгэх явдалгүй” [53]. Үнэхээр ч бүх Халхын өмнөөс ярих бодит үндэслэл хутагтад байгаагүй нь ойлгомжтой. Түүний үйл ажиллагаанд Далай лам Төвдийг захирдаг шиг бүх Халхыг захирах гэсэн эрмэлзлэл байсныг ажиглаж болно. Гэхдээ Хятадын харьяанд орохгүйгээр, өөрөө бие даан хийж чадахгүй байлаа.

Гэхдээ Халхын бүх тэргүүнүүд Түшээт хан, Жавзандамба хутагт хоёрыг шууд дагаагүйг тэмдэглэвэл зохино. Зарим нь бүүр 2-3 жилийн дараа Халхын сүйрлээс эмээхдээ л Цин улсад захирагдах болжээ. Халхчуудын Гүүш ханы удмынхны захирдаг ойрадууд руу, зарим нь орос руу оджээ. БНМАУ-ын архивын мэдээгээр Түшээт хан, хутагт хоёрын хамт Хятадад 35 мянгаад хүн захирагдах болжээ [54]. Тэдний олонх нь арга буюу ингэхэд хүрсэн хүмүүс, ноёд эзэлж байв. “Эрднийн эрхи”цаг тооллын бичигт Хутагт, Түшээт хан хоёр шуудхан л “Халхчуудыг араасаа дагуулан есөн цагаанаа авчран дагаар орохыг шаардав”[55].

Харь овгийнхонтой харилцах Хятадын албан захиргаа /лифаньюань/ “10 мянган улс гүрний эзэн хаан нэгэн бие мэт бүхэнд нийгүүлсэнгүй ханддаг” гэдгээс үүдэн Түшээт хан, хутагт хоёр “чин үнэнээсээ тэднийг дагаар оруулахыг гуйсныг” харгалзан үзээд “тэднийг хүлээн авч, тэдэнд хоол унд залгуулах, амар жимэр амь зуух нөхцлийг нь бүрдүүлэхийн” [56] төлөө байгаагаа мэдэгдэв. Хутагт, Түшээт хан хоёртой уулзахаар зөвлөгч Арни-г илгээжээ.

Нэгэн зэрэг Галдан руу Цин улсын нар Ачит, Бэйл нар ч очжээ. Галдан тэднийг хүндлэн хүлээн авч Цин улсын гаргасан хязгаарлалтууд нь түүний албатуудад ойлгогдохгүй байгаагаар шалтаглан хил худалдааны хэргийг хэлэлцэн шийдэх санал гаргав. Тэд бүхний буруутан нь Хятадын ордны тушаал биш, харин Галдангийн “ах дүү тайжуудтайгаа нөхөрсөг харьцаагүй байснаас болсон хэмээн тунгааав. Цин улсын элчин нарын хамт Галдангийн элчин Бээжин рүү хамт явлаа. Тэрээр Цин улсын эрх баригчдад Түшээт хаан, Жавзандамба хутагтын нэр дээр хуучин зэмлэлээ давтан, Түшээт хан эхлэн “Манай дөрвөн ойрад руу дайрч” дайны ажиллагаа эхэлснийг нотлов [57].

Галдангийн мэдэгдсэнээс хоёр чухал дүгнэлт гарч байна. 1-рт, түүний үйлдлүүд нь бүх ойрадын тайж нараас дэмжлэг хүлээгээгүй, 2-рт, Түшээт хантай явуулсан дайн нь Түшээт ханыг Цин улсад захирагдсаны дараа Цин улстай дайн болон хувираасай гэж огт хүсээгүй явдал юм. Цин улсын ордон Галдантай хоёр үндсэн шалтгаанаар хэлэлцээр явуулав. Юуны өмнө Цин улсын засгийн газар одоогоор Халхыг бүхэлд нь бус, зөвхөн Халхчуудын багаахан хэсгийн авсан болохоор Халх нь Галдангийн хяналтан доор байлаа. Тэнд түүнтэй сөргөлдөх хүч байсангүй. Тэр үеийн Цин улсын Хятад Оростой энхийн хэлэлцээр хараахан байгуулаагүй байсан нь манж нарыг Халхад үйл ажиллагаагаа идэвхжүүлэхэд саад болж байлаа.

1688 оны 11 сард /XI-23-наас XII-23/ Галдан Халхтай байлдаж байгаа бус, зөвхөн хоёр хүн, Түшээт хан, Жавзандамба хутагт нартай байлдаж байна гэдгээ Цин улсын эздэд дахин мэдэгдэв: “Халхын 7 туг миний дайсан болох учиргүй. Миний дайсан бол зөвхөн хоёрхон хүн: Зонховын итгэлийг алдагсад Түшээт хан, Жавзандамба хоёр юм”. Цааш нь Галдан Түшээт хан бол зөвхөн засагт ханы эзэмшлийг булаан авсан төдийгүй, Зүүн гарын хил орчим руу дайрсан гэдгийг баталжээ. Тэрээр манжийн эзэн хаанд Түшээт хан, хутагт хоёрыг Цин улсын хилийн дээсийг алхуулахгүй байхыг санал болгов [58].

Буй болсон байдлыг хэлэлцэсний дараа Цин улсын төрийн зөвлөл Түшээт хан “эхлэн ойрадууд руу довтолсон” [59] гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Энэхүү бүрэлдсэн нөхцөл байдлыг хэлэлцээд Цин улсын төрийн зөвлөл болон Кан-Си талууд эвлэрэхгүй гэдэгт итгэлтэй хэдий ч Галданд энхийн хэлэлцээрээ сэргээхийг санал болгож, хүлээнэх тактикийг сонгон, хугацаа сунжруулахыг эрмэлзэж байлаа. Тэгээд ч Галдангийн ач Цэвээн-Равдан, түүний эсрэг хүчин болохоо харуулсаар байсан үе билээ.

* * *

Галдан зээр авлаж байлаа. Үргээгчид сүргийг /хүйтрэхээр тэд 100-120 толгойгоор сүрэглэнэ/ тэгш газар руу хөөж, анчид түүн рүү ухасхийлдэн саадагнаасаа сумаа гарган, нумаа махийтал татацгаана. Зээрийн сүрэг анчид, үргээгчид цөм бачимдан шуугилдаж, цус болсон амьтад унана. Авлалт ид дундаа болж ирэхүйд Галдан зогсоох тушаал өглөө. Айснаасаа болж галзуурсан сүргийн үлдсэн хэсэг нь ойролцоох толгодын зүг цахилан одоцгоов.

Элс цас холилдон дагтаршсан тэгш газар тогооч нар хоолоо хийхээр цуглав. Тэдний нэг нь тулгын чулуу тавингаааа ийн тодоор өгүүлэв:

Энэ бол хаан чулуу, энэ бол хатан чулуу, энэ бол боол чулуу.

Тэгээд гишүү овоолж, ган хэтээр хурдан гэгч нь гал асаахад шинэхэн, дүүрэн махтай тогоон доор гал дүрэлзэв. Дэргэд нь өөр нэг тогооч галд чулуу улайтган, гурав дахь нь хурц хутгаар зээрийн хоолойг тас татав. Төдөлгүй л час улайдсан чулуугаар дүүрсэн арьсанд зээрийн мах багтчихав. Халуун чулуу нь махыг чанаж болгон гүзээ нь тослог өтгөн шөлөөр дүүрнэ.

Анчид амттай тарган махаа зооглож, ходоодоо бүлээцүүлэхээр суутал баруун зүг дэх алсын толгодын тэртээгээс хөлс цувсан морьтой элч давхин ирэв. Түүний малгай нь үнгэгдсэн, энгэр заам нь задгай, үсийг нь гадагш нь харуулж хийсэн оготор ширэн дээлтэй нэгэн байв. Тэрээр мориноосоо үсрэн буухад, ядарснаасаа болж хөл нь туйвж байв. Цулбуураа бариастай хэвээр, тойрон суугаа найрлагсдын дундаас хааныг олж хараад өвдөг сөхрөн өгүүлсэн нь:

- Их хаантан минь, битгий намайг цаазал, өршөөж хайрла. Урван тэрслэлт болоод байна.

- Галдангийн царай цонхийв. Нүдэнд нь аянгын гялбаа улсхийж, гар нь сэлэм рүүгээ ухасхийв.

- Хаантан минь, муу юм дуулгалаа гэж бүү цаазал. Хэрэв намайг албал аягахан цус л асгарна, миний яс л хэмхэрнэ. Өршөөвөл би тандаа дахин зүтгэх болно!

- Яриач дээ !

- Чиний ач Цэвээн-Равдан Бор талын хөндийгөөс гарч Цагаан овоонд ирж, таны харъяат албатууд, таны хүмүүсийн хаан гэж өөрийгөө өргөмжлөв. Танд үнэнч нэгэн гэргий чинь ийн дамжууллаа:

Надад дассан хээрийн аялгуу !

Үзэсгэлэн төгс омогт бүргэд !

Дайсанд нөөсөн миний сум !

Үүрээ хошуундаа тээгч шонхор !

Эр нөхөр минь, наддаа түргэн туслаач !

- Ээ, новш! Би чамайг өөрийн гараар тарчилгаж, духан дээр чинь шагай эргүүлж, хонины тойгыг толгойруу чинь чихье ээ!

- Хаан минь, Цэвээн-Равдан Турфаныг эзэлж, Хами-г сүйтгэн, хангайн даваануудыг хаалаа.

Захыг нь зөөлөн арьсаар эмжсэн цав цагаан дөрвөн талт олбогноосоо Галдан ухасхийн босвол Эрхэндээс ирсэн усан үзмийн үнэт дарс аяганаасаа асгарч олбогны цагаан захаар улаан толбо гулсав.

- Би төрөлхийн хаан, өөрийн улс орноо ч, газар нутгаа ч, усаа ч алдаагүй. Би өөрийнхөө дайснуудын өвдгийг чичрүүлэхийн төлөө төрсөөн. Миний ташуурыг хар, голыг нь гунан бухын арьсаар, хүрээг нь дөнөн бухын арьсаар бүрж, могойн шүлсэнд чанасан билээ.

Тоногийг нь хараач, ган товруунуудтай, үзүүртээ ган цохиуртай. Цохиход яг л галаар төөнөх шиг болно. Энэ ташуураараа би тэрслүү муу урвагчийг зад ороолгоно. Түүний бүх найз нөхдийг нь цаазлана. Би явахдаа захирагч миний үгийг эс дуулах аваас хэлийг нь тасдаж, чихийг нь огтолно гэж хэлсэн. Одоо ам гарсанаа гүйцэлдүүлэх цаг нэгэнт боллоо.

- Хаан минь, таны ач Цэвээн-Равдан хотгойдыг эзэгнэлээ.

Галдангийн цээжнээ оволзох уур хилэн намдав. Хөдлөх л хэрэгтэй. Энэ бол цагаан яс, түүний ноёдууд бол өв залгасан язгууртнууд, зайсангууд нь өөрийнх нь болон Далай ламын соёрхолт язгууртнууд. Тэднээс хэн нь түрүүлж өөрийг нь орхин Цэвээн-Равдан руу, Зүүн гар руу явах болж байна? Аймшигт алжаал хааныг эзэмдэв.

- Үүнийг миний нүднээс холдуул гэж хаан хэлэв.

Элчийг аваад явав. Авлалт дуусч гэрийн зүг буцах цаг боллоо. Галдангийнцээжинд хорсол занал дахин дүрэлзэв. Тэрээр босож эсгийн дээр тавьсан хоолон дээгүүр алхан модон тэвштэй махан дээр гишгэн, айрагтай хулыг өшиглөн, уурандаа хөхүүрийг дэвслэн, хараахан баригдаагүй байгаа ачийгаа харааж зүхсээр аяны өргөөнөөс гарлаа.

Үүнээс хойш Галдангийн хүрээ нь Засагт ханы нутаг, Ховд голын болон Сэлэнгийн эхийг хамрагч голуудын хөндий л болжээ. Хятадуудын олж авч, Төвд рүү мэдээлснээр бол “Галдан Цэвээн-Равданд бут цохигдов. Түүний бараг бүх албатууд нь зугтан сарнив. Тэрээр ихээхэн гачаалд нэрвэгдэж, хүний мах идэхэд ч хүрчээ” [60].

Талийгаач Засагт ханы хүү Галдангаас зугтан эхлээд өмнөд Алтай, дараа нь 1690 оны зун Хятад хүрч, тэндээ захирагдан, эцгийнхээ цол хэргэмийг өвлөх зөвшөөрөл гуйжээ.

Иймэрхүү өөрчлөлтүүд гарав. Амаргүй цаг үе ирлээ. Анчин өөрөө хоморгонд орсон гөрөөс адил болов. Галдан өөрийн гэх эх оронгүй болов. Ойрадын эв нэгдэл гэж байгаагүйд бид итгэх бололцоотой. Тэр нь ямар ч боломжгүй байсан ба монголын (халхын) нэгдэл ч гэж алга байлаа. Тэр үед түүнийг хүлээхийн ч аргагүй байв. Манжууд Галданг Халхтай дайнд турхирч, Түшээт хантай тэмцэлдсээр байгаад, Түшээт ханыг албатуудтай нь Цин улсад “сайн дураараа” захирагдах хүртэл тэрхүү дайны эсрэг идэвхтэй арга хэмжээ авсангүй. Шилдэг хүчээ хоосорсон Халх руу дагуулан явж байхдаа л тэрээр өөрөө болон түүний улс төрийн бодлогыг ойрадуудын олонх нь дэмжихгүй байгааг гэнэтхэн олж харав. Ойрадууд хууль ёсны хаанаараа Цэвээн-Равданг түүний оронд хялбархаан гэгч сольж орхив. Энэ үед Цин улстай хийх худалдаанд найдах явдал багагүй үүрэгтэй байв. Цөхур-Увашийн хүү Өнчин тайж 500 ноёдынхоо хамт Цин улсад захирагдав. Галдан Халхыг эзэгнэж байсан ч халхчуудын олонхи нь өөрийг нь болон ойрадын засаглалыг огтхон ч хүсэхгүй байлаа.

Галдангийн ойрын жилүүдийн төлөв, Халх дахь үйл явдлын явцыг тодорхойлогч үйл явцын тоонд Хятад, Оросын Нерчинскийн гэрээ байгуулсан явдал байлаа. 1689 оны 6 сарын 16-нд Цин улсын төлөөлөгчид 8 мянган хүнтэй цэрэг, 76 байлдааны хөлөг онгоц дагуулан, хамгаалалт нь 600-хан хүнтэй Нерчинскийн районд хүрэлцэн иржээ. Хотоос хагас мод газрын зайд асар босгож, Цин улсын дипломат албаныхан, Оросын мужийн цэргийн захирагч Головин нар хэлэлцээр хийжээ. Оросууд олон жил Амар мөрний зүүн эргийг эзэмшиж

байсан учир Амар мөрөн мэдээжийн хоёр улсын хил байх учиртай гэсэн саналыг Головин тавьсаар байв. Цин улсын тал болохоор хилийг Нерчинскээр зааглах саналтай байлаа. Головин өөрийнхөөрөө хичнээн зүтгэвч, Хятадууд шууд л цэрэг дайны шахалт үзүүлэв. Тэд өөрсдийн давуу хүчиндээ дулдуйдан Нерчинскийг бүслэн хаав. Бэлчээрээс таслагдсан учир Нерчинскт мал үхэж эхлэв. Халдварт өвчин гарахаас эмээн байдал хүнд болсныг харгалзан үзээд Оросын тал 8-р сарын 23-нд Албазинаас татгалзахаар шийдэв.

Нерчинскийн хэлэлцээрээр Орос улс Цин улстай хилээ тогтоов. “Амар мөрны эх хавиар гэхдээ... ихээхэн бүдэг. Үд голоос урагшаах газар нутаг зааглагдалгүй үлджээ” [61]. Албазиныг устгажээ. Цин улсын талаас ”шивээлсэн хот байсан газар болон зэргэлдээх нутаг хэзээ ч тосгон байх учиргүй” гэсэн тангаргийн баталгаа гаргажээ. Гэлээ ч гэсэн Хятад Орост цэргийн хүчээр тулгасан Нерчинскийн хэлэлцээрийн үр дүнд оросын хасгууд болон шилжин ирэгсдийн бараг хагас зуун жил эзэмшсэн нилээд нутаг дэвсгэрээ Орос улс алджээ. Түшээт ханы Цин улсад дагаар орох шийдийг ашиглан Цин улсын эрхтнүүд хэлэлцээр дээр Байгалийн чанад дахь нутагт ч санаархаж байв. Гэлээ ч энэхүү чармайлт нь талаар болов. Оросын тал Цин улсын эрх баригчдад энэхүү зааг тогтоох асуудлыг оросууд тусгаар тогтносон Монголын хаадуудтай шийдсэн гэдгийг Цин улсын төлөөлөгчдөд сануулсан юм.

Эдгээр үйл явдал хараахан шийдэгдээгүй, Цин улсын эрхтэн дархтнууд Цэвээн равдангийн үйл ажиллагааны талаар тодорхой мэдээлэлгүй байсан үе рүү эргэж орёе. Кан-Си цаг хугацааг сунжруулснаар Төвдийг дундыг баримталсан гэж үзээд, дахиад л ”энх тайвныхаа” төлөө улиглаж гарав. 1689 оны хаврын эцсээр Галданд тэрээр захидал бичиж, түүндээ Түшээт ханы үйлдлийг Галдангийн довтолгооны хариу мэтээр төсөөлөн: ” ... Түшээт ханы мэдээлснээр Ойрадууд хоёр замаар давшилтаа хийж байгаа учраас дайсныг угтахын тулд цэргээ Түшээт хан хөдөлгөв” гэжээ. Кан -Си Галданд Түшээт ханаас өрслөө гэж мэдэгдээд:

”Хэрвээ Ойрадууд хөдлөхгүй бол чи энэ хэргийг эхэлнэ, тэгвэл чи энэ самууныг өдөөгч болно” хэмээв. Гэвч Түшээт хан үгнээс зөрж, Засагт ханыг алсан байна”. Тэр нэгэнт хэрэг явдлыг эхэлсэн болохоор чи цэргээ дайнд хөдөлгөж, халхыг бут цохисон болохоор чиний буруу биш, халхчуудынх. Чи буддагийн сургаалыг бишрэгч хүн, хэдийгээр халхын нутаг дэвсгэр дээрх сүм, хийдийг шатаан, Будда-гийн дүрт бурханыг сүйтгэсэн ч гэлээ, чамайг би нэг их зэмлэхгүй. Халхыг чи дээрэмдсэн. Түүний ноёд, хаад, жонон, тайж нар өөрсдийн хүмүүсээ дагуулан ирж, миний захиргаанд орлоо. “Гачигдал зовлонг амсаж буй ямарч улс надруу ирж, захиргаанд минь ордог, би үүнийг нэгэн биеийн минь хэсэг хэмээн үзэж, тэдний хоол хүнс, амар тайван байдлийн талаар санаа тавьдаг” [62]. Энэ бол Галданг дагаар оруулах гэсэн дохио байв. Тэгээд ч худалдаагаа эхлэхийг санал болгов. 1689 оны 9 сарын 19-нд Галдан руу Цин улсын элчин Арни хүрэлцэн ирэв. Түүний албан тайланг авч үзье. 8-р сарын 7/ 9-19 / -нд би Ойрадын Галдангийн нутагт очлоо. Захидал бичиг, бэлэг хадаг дамжуулсны дараа би Галдантай хамт уулзалтын үеийн бүхий л ёс жаягийг гүйцэтгээд биднийг суухад Галдан надаас асуув: “Төрийн нарийн бичгийн түшмэл та, Халхын 7 туг болон бидний хооронд тангаргийн гэрээ байгуулахаар хүрэлцэн ирэв үү?”. “Тиймээ” гэж би хариулав. Галдан ахин асуусан нь: “Чи өнгөрсөн жил Сэлэнгэ рүү явсан гэсэн. Ямар хэргээр? Цэрэгтэй юу, эсвэл цэрэггүй юу?”. Би хариулав: ”Дорнод хилийн ажил төрлийн талаар Оросын цагаан хаан илтгэл явуулсан юм. Хаана хэлэлцээр явуулахыг тогтох ёстой болов. Мэргэн гэгээн эзэн хаан намайг Сэлэнгэд гэрээ хийх газрыг сонгуулах тушаалтайгаар илээсэн юм. Надтай дөнгөж

2000 цэрэг л явсан. Замдаа би чиний ойрадууд Халхтай эмх замбараагүй явдал үүсгэсэнтэй тааралдсан. Мэргэн гэгээн эзэн хаан ч энэ талаар мэдсэн. Би ойрадууд, халхчууд хоорондоо байлдаж байна гэж бодоод аянаа үргэлжлүүлэв. Чи ч юм уу, хэн ч бай, намайг хэн нэгэнд нь туслахаар цэрэг авч явж байна гэж эргэлзсэн байх. Ийм учраас цэргүүдээ хилээр буудаллах тушаал өгөв. Энэ жил энэ хэргээр хэлэлцээр байгуулахаар дахин элч илгээв”. Ингээд бидний яриа дуусав. Надад болон бусад хүмүүст зориулсан найр хийв. Мөн сарын 18/9-30/-нд Галдан намайг болон бараа бологсдыг өөрийнхөө өргөөнд орохыг уриад, хөндлөнгийн хүмүүсийг гаргаад хэлсэн нь: ”Мэргэн гэгээн эзэн хааны хүнийг хайрлах нь хязгааргүй. Тэрээр бүх амьд амьтны төлөө санаа тавьж, тэднийг амартөвшин, аз жаргалтай, тэгш эрхтэй амьдрахыг хүсдэг. Би энх тайвны бодлогын төлөө байна. Үүнээс илүү юм юу байх билээ. Би мэргэн гэгээн эзэн хаанаас заавар зөвлөлгөө гүнээс хүсч, түүнийг чадах ядахаараа дагах бодолтой байна. Харин Жавзандамба хутагт, Түшээт хан хоёр ямарч шалтгаан заалгүйгээр эмх замбараагүй байдлыг эхлэн гаргаж, Засагт хан, Дэгдэх мэргэн ахайг алсан билээ. Ингэснээрээ тэд мэргэн гэгээн эзэн хааны тушаал эрмэлзлэлийн эсрэг боссон юм! Үүнээс өмнө би 2–3 ч удаа тэдний талаар танд мэдээлээгүй гэж үү? Би ийн хариу өгөв: ”Жавзандамба, Түшээт хан хоёрын амь нас нь хутганы ирэн дээр байсан үедээ ирж бидэнд захирагдах болсон юм. Мэргэн гэгээн эзэн хаан – Хятадын тэргүүн тэнгэрийн доорхи нутгийг захирдаг билээ. Энэ нэг хоёр хүний амь насны төлөө санаа зовох нь бүх амьд амьтны төлөө санаа тавьсан хэрэг биш үү? Чи нэг бус удаа илтгэл явуулж, мэргэн гэгээн түүнийг чинь судалсан. Чиний үйл ажилгааны талаар эртнээс сайтар мэдэх болсон тул чиний үнэнхүү санааны талаар гадарлаж байна. Анхнаасаа л би чамд захидал илгээж, дайнаа зогсоож, урьдын адил амар тайван замдаа орохыг зааж байсан. Энэ талаар чамд хичнээн удаа ярих ёстой байсан юм бэ? 22 /X-4/-нд Галдан, Данжила, Гэлэнгээ хоёрыг илгээж, тэд дахин надад Галдангийн илгээлтийг гардуулсан. ”Далай лам хүн явуулсан ба Ялгуусан хутагт чмөн энэ хэрэг дээр завгүй байна!” гэж мэдэгдээд, би тэднийг зэмлэсэн билээ. Ингэж хариулаад ”Үүнээс дээгүүр та нар өөр юу хэлэх гэж байна?” гэж би асуув. Данжила өөрийн хааны өмнөөс хариулав: ”Далай ламын гаргасан тайлбар нь Мэргэн гэгээн эзэн хаан бидэнд заасантай ав адилхан. Би өөр юм хэлж чадахгүй”. 24 /X-6/-нд Галдан баруун тийш нүүж, би буудалласан газар руугаа буцаж, маргааш нь буцах замдаа гарлаа” [63].

Төвдөөс Бээжинд ирсэн Далай ламын элч Жамблан хамба, Галданд Түшээт хан, Жавзандамба хоёрыг өгөхийг Кан- Си-д санал болгожээ. Кан-Си татгалзсан төдийгүй, ”тэднийг хамгаалах ёстой” гэж заан, хэдийгээр ”би тэднийг хүлээн авч, тэжээж чадахгүй ч”, ”би тэднийг барьж, дайснуудад нь өгөх хэрэг үү?”[64] гээд төвдчүүдэд Галданг “ирж, надад дагаар орох”-оор болтол нь нөлөөлөл үзүүлэхийг санал болгов.

1690 оны эхээр Халхад Баньд түшмэл Галдангийн байдлыг нууцаар тагнах зорилготойгоор иржээ. Цин улсын эрхтэн дархтнуудын мэдээлснээр 1690 оны 1-2 сард Галдан өөрөө болон түүний нэгэн бүлэглэл Дорно зүгрүү, Хэрлэн, Улз голын орчим руу аянд хөдөлж, Цэцэн ханы албатуудыг дээрэмджээ. Төвдийн элч Далай-хамба Цзяюйгуангийн боомт дээр асуугдахдаа 12 сарын 3-нд /1690-I-12/ Ялгуусан хутагт, Шинан Дорж, Далай ламын элч Жирун хутагт нар Галдантай уулзсан, одоо бол /1690 оны хавар/ Галдан Ховдод Халх руу аян дайнд мордохоор цэрэг цуглуулж байгаа. Цэвээн-Равдан болон түүний талд орсон Галдангийн хуучин эхнэр Ану хатан нар аажмаар Галдангийн хуучин нутаг “Төрсөн хонхор” руугаа шилжиж байлаа. Галдангийн олон албатууд зугтаж Цэвээн-Равданг бараадав. Галдангийн цэрэг хэдхэн мянга

ч, унаа морьд цөөн ажээ. Төвдийн элчийн мэдээлснийг нотлон Галдангийн хоёр хүнд нэг морь оногдож, тэр ч бүү хэл зэр зэвсэг хүрэлцээгүй тул бороохой шийдэмдээ ч хүрснийг туршуулууд баталж байна.

Галдангийн байдал илт хүндрэв. Цин улсын эрх баригчид хилээ бэхжүүлж, юуны өмнө тэдэнд дагаар орсон монголчуудын төлөө хийж буй царай гаргавч, цаанаа Халх руу аян дайн хийхээр зэхэж байлаа. Хутагтуудтай уулзах үед Галданг Халхын зүүн өмнөд муж руу дайн хийхээр шийдсэнийг Хятадууд ойлгожээ. Одоо бол тэр хүмүүсээ тогтоон барихын тулд халхчуудыг дээрэмдэхийг зөвшөөрөхөөс өөр аргагүй болов.

Кан-Си энэ үед энх тайван байдал гэж улиглахаа нэгэнт больжээ. Тэрээр одоо дайсагнагч талуудыг эвлэрүүлэх шаардлагагүй хэмээн мэдэгдэж байлаа. Энэ талаар санаа тавих түүний бодол нь ч тов тодорхой болов [65]. Үнэн хэрэгтээ бол Кан-Си Галдантай хийх дайнд хэдийнээс бэлтгэсээр байв. 1690 онд буюу 5-р сард өвөр монголчууд болох цахарууд манлайд нь, араас нь их буу бүхий 8 тугт цэрэг дайран довтлох нь шийдэгдэж.. тэгэхдээ ердийнхтэй харьцуулахад бүлэглэлүүд дэх их бууны тоог нэмэгдүүлэх тушаал өгсөн байв. Өөрийнх нь талд байлдах халхчуудад Хятадад зэвсэг захиалахыг ч Кан-Си зөвшөөрчээ.

Цин улсын эрх баригчид Цэвээн-Равдангийн бодит үнэн байдлыг мэдэх, Галданг засгийн эрхээс нь салгасан төрийн эргэлтийн үнэн шалтгааныг олох, Цэвээн-Равдан болон Ану-д барих шан, хишгээ нэмэх амлалтандаа яаралтай хүрэхийг завдаж байв. Баруун зүг дэх Цин улсын эзэмшлийн хамгийн захын нэг нь болох Цзяюйнуанаас Зүүн гар руу Цэвээн-Равданд захидал хүргэхээр яаралтай элч довтолгов. Тухайлбал: Кан–Си Цэвээн-Равданд: “Одоогоор чи Галдантай тайван бус харьцаатай байгааг мэдлээ. Хэрүүл маргаанд хүргэсэн шалтгааны талаар ч мэдээлэл ирж байна. Чиний ойрадууд өргөл барьцаа бүрэн төлж, үгийг минь онц хүндлэн дагадаг билээ. Та нар өөрсдөө, өөр хоорондоо дайсагналцсан нь ямар учиртай юм бэ? Бид үүнд их санаа зовж байна. Алсаас ирж буй мэдээнд үнэн худлыг ялгахад хэцүү байна. Ийм учраас би тусгайлан Цэвээн-Равдан, Ану хоёрт эзэн хаадын хэрэглэдэг 20 толгой торго хүргүүлэхээр Даху-г явууллаа. Та нар түүнд юунаас болж муудалцсан шалтгаанаа юуг ч нуулгүй тайлбарлаваас зохистой” [66].

Хариуг нь Хятадын тал Төвдийг зорьж явсан Цэвээн–Равдангийн элч нараас авчээ. Цэвээн-Равдан Галданг “гэмт хэрэгт” буруутгаж, үүнийх нь төлөө Галданг хүйс тэмтрэхээр цэргээ босгосноо Далай ламд уламжилжээ [67]. 1961 оны 2-р сард /II-28-III-30/ Улаан Буданд Галдангийн ялагдсан тухай мэдсэн Цэвээн–Равдан, Ану нар Кан-Си-д бичсэн нь : “Бид Галдантай дайсагналцсаар байна“. “Миний улсад самуунтай байна. Түүний шалтгаан нь Начин Омбо засгийн эрхийг зүй бусаар булааж, миний отгон дүүг /Соном–Равдан/ хордуулав. Тэрээр надтай бас таарамжгүй болсон. Миний улсын хүмүүс бие биетэйгээ дайсагналдан бутарцгааж байгаа нь зөвхөн энэ шалтгаанаас л үүдэж байна” гэжээ. Ингээд эргэлт болсноос жилийн дараа гэхэд Цэвээн-Равдан Зүүнгарыг “өөрийн улс” хэмээн тооцох болжээ.

Бусад эх бичгүүдэд дүүг нь хордуулж алсан Начин Омбо нь Галдангийн даалгавраар ажиллаж байсан гэж Цэвээн-Равдан санадаг байв. Галдангийн хатан Ану нь зарим мэдээгээр бол хэзээ нэгтээ Цэвээн-Равдантай сүй тавьсан ба одоо бол түүний талыг идэвхитэй дэмжиж байгаа аж. /Түүнийг Галданд бүр мөсөн өгсөн Очирт ханы охинтой андуурч болохгүй./ Кан-Си тусгай захидалдаа: “Бид Далай ламаас салан тусгаарлах тушаал авлаа. Бошгот хаан Далай

ламын сургаалийн эсрэг босч, олон тооны шударга бус үйлдэл хийж, Соном-Равданг алсан байна. Түүнээс гадна Цэвээн-Равдангаас болон надаас ч хөндийрлөө. Ингээд тус тусдаа амиа бодож довоо шарлуулан, өөрөө ч тэр, тусдаа нүүдэллэж явна” [68].

Засгийн эрхийн төлөө тэмцэл нэг эцэгтэй, эх тусгаар ах дүүсийн хоорондох цусан өшөө, Галдангийн бодлогыг үл зөвшөөрөгч ойрадын олонхи тайжуудын амиа золиослосон бодлого нь Галданг хаан ширээнээс нь унагаад зогссонгүй, улмаар эх оронгүй болгож, Кан-Си-гийн гарт оруулж өгөхөд хүргэсэн нь төрийн эргэлтийн үндсэн шалтгаан болов.

* * *

Цин улсын тагнуулын мэдээгээр Галдан 1690 оны зун гэхэд ойрадууд болон түүнд захирагдсан халхчуудаас бүрдсэн 30-аад мянган цэрэг бүхий хүчтэй армитай байв. Цин улсын эрх баригчид Галданг Халхад явуулж буй дайндаа Оросыг холбоотноор оруулах бодолтойг ч мэдэж байсан аж. Тобольск-т ойрадын элчин Эрх Дархан очиж Галдангийн цэрэг халхыг эзэлж, Оросын хилийн ойролцоо байгааг оросуудад мэдэгджээ. Сүүлийн жилүүдэд Нерчинск-т болсон үйл явдлуудаас ургуулан Оростой холбоо тогтоох боломжийг ч Элчин тайлбарлах учиртай байжээ. Эрхүү рүү мужийн цэргийн захирагч Кислянский болон оросын элчин Головин нарт бичсэн захдилдаа Галдан Хэрлэн гол руу оросын цэргийг явуулж, өөртэйгээ нэгдэхийг шууд гуйсан байна. Галдан руу хасаг Кибиревийг явуулсан нь Цин улсын цэрэг хүрээг нь дайрахын өмнөхөн Галдангийн хүрээнд Төвдийн элчтэй нэгэн зэрэг хүрчээ. Галдан Кибиревээс 20 мянган хүн тусламжаар явуулахыг гуйжээ. Кибирев тодорхой хариу өгсөнгүй, өгөх ч боломжгүй байв. Бээжинд байсан Оросын төлөөлөгч Лошаниновт хэрэв Орос улс Галданд тусламж үзүүлвэл үүнийг 1689 оны энхийн гэрээг зөрчсөн хэмээн үзнэ гэж мэдэгдсэн аж. Үүнийг мөн энэ зорилгоор явсан Цин улсын илч Сонготу Нерчинск-т мэдэгдсэн байна. Ийм учраас орон нутгийн мужийн цэргийн захирагч Скрипицынд Галдангийн захидлыг хүргүүлэхээр Аюух Дархан Хашигийг ирүүлжээ. Тэрээр цэргийнхнийг Галдангийн ойрадуудад туслуулах эрх байхгүй гэж хариу өгчээ.

Энэ үед оросын тусламжид илт найдсан нь Галдан Хэрлэнг уруудан явж байлаа. Тэд хүнс хоол муутай учир, ойрадууд морьдоо ч алж идэхэд ч хүрч байгааг Цин улсын эрх баригчдад айлтгасан байна. Тэрчлэн Галдан 10 мянга гаруйхан цэрэгтэйг ч дурьджээ. Бусад мэдээлэлээр бол Галдангийн арми бүрэлдхүүндээ 40 мянган хүнтэй, Улз голын зүг явж байна гэжээ. Галданг манж руу довтлохыг эмээн Цин улсын эрх баригчид баруун хилээ хамгаалалтад бэлтгэхийн зэрэгцээ Галданд сөрөг цохилт үзүүлэхээр нэгэнт шийдсэн байв.

1690 оны зун гэхэд л Галдангийн Түшээт хантай хийсэн дайн нь Цин улстай явуулж буй дайн болсныг арай ядан ойлгов. Энэ үед анх удаа түүний хүмүүсээс нийт монголын нэгдлийн тухай гэсэн үзэл санааны талаар мэдэгдэл гаргах болов. 7-р сарын 19-нд Ойрадын тэргүүн үзэмчний монгол Мэргэнтэй тааралджээ. Тэрээр түүний тайж Баранчун Ноха ойрадын бүлэглэл ойртож байгааг мэдээд зэвсэглэсэн 100 гаруй хүнтэй угтжээ. Ойрадууд тэдэнтэй байлдсангүй, харин ийн мэдэгдэв:

- Эхлээд чи халх хүн байсан, одоо чи Хятадын эзэн хааны цэрэг. Бид нэгэн омгийнх. Чи яах гэж зэр зэвсэг агсан биднийг хүлээж байв? Бидний дайснууд зөвхөн халхчууд. Тэд хаа байгааг бидэнд заагаад орхи.

Баранчун Ноха хариулсан нь:

- Бүх халхчууд өмнө зүг зугтсан. Тэдний хаана байгааг би мэдэхгүй.

- Бид чамтай найз нөхөд, чамд хор хүргэхгүй, - гэж ойрадууд хэлэв.

- Илд жадаа авцгаа, тангаргийн гэрээ байгуулах өдрийг товлохыг хүсч байна. Итгэхгүй бол бидэнтэй хамт явж болно.

Баранчун Ноха-г дагуулан тэд явцгаав. Дараа өдөр нь ойрадууд Баранчун- Ноха-гийн эхнэр, хүүг нь болон түүний 60 хүнийг авчээ. Тэдний дунд хээр тал руу зугтаж яваад Цин улсын туршуулуудтай тааралдсан нэгэн ч байв [69].

Ийм байдлаар Галдангийн хүмүүс манжтай эртний холбоотой үзэмчний монголчуудыг бид нар бол нэгэн омгийн хүмүүс, бид зөвхөн халхчуудтай дайтаж байна гэж ятгахыг оролджээ. Энд зөвхөн Түшээт ханы халхчуудын талаар яригдсан нь илэрхий. Монголын түүхч Д. Гонгорын авсан мэдээгээр Галдан энэ үед өөрийн элчин нараа өмнөд Монголчууд руу илгээжээ. Тэрээр тэдэнд бичсэн нь: “Манай эртний өвөг дээдсийн нэрийг бузарлагч мөнхийн боолчлолтой бүү эвлэр, нэгдсэн хүчээр эх орноо хамгаалахын төлөө миний цэргийг угтан босоцгоо. Бидний монголчууд эрт цагаас хүчирхэг, чадалтай ард түмэн байсныг та бүгд мэднэ” [70]. Энэхүү захидлыг авч явсан Галдангийн элч нар Цин улсын эрхтнүүдийн гарт оржээ. Хятадын он тооллын бичигт энэ баримт тэмдэглэгдсэнгүй.

Хятадын Цин улсын хувьд Халхын төлөө, Галдантай хийх дайн нь шийдэгдсэн хэрэг байв. Төрийн зөвлөл нь аян дайны эхлэх өдрийг 8-р сарын 8 гэж тогтоожээ. Цэргийг Кан-Си өөрөө биечлэн толгойлох аж. Энэ бүхэн өөрийн дүү Хан-Ду тайжаар дамжуулан Цин улсын эрхтнүүдийн анхааралд хүрсэн “Би зөвхөн өөрийн дайсан халхчууд руу л дайрсан, би Хятадын хил хязгаарыг зөрчихийг зүрхлэхгүй байна”. Шаншу Арни цэрэг дагуулан хойд зүг хөдөлж байна. Ямар үндэслэлтэй юм бэ? Жавзандамба хутагт, Түшээт хан, Цэцэн хан хаана байна?” [71] гэсэн илт өдөөн хатгасан бус мэдэгдлийн нөхцөл дээр ... явагдаж байлаа. Хариуд нь тэр Кан-Си-гээс захидал хүлээн авчээ. Одоо үзэмчнүүд чам руу хүмүүсээ явуулсаан. Чи тэдэнд хэлсэн: “Би Хятадтай ганцхан замаар л явна. Дотор газрын хилийг зөрчихийг би эс зүрхэлнэ”. Гэлээ ч дахин хил зөрчиж, үзэмчнүүдийг тонон дээрэмдсэн. Энэ чинь урьд хэлснээсээ ухарч, найрамдалт харьцаагаазөрчсөн хэрэг биш үү? Урьд нь миний чам руу илгээсэн Ялгуусан хутагт одоо болтол буцаж ирсэнгүй. Чиний үнэнхүү санаа чинь ямар байна? Одоо чамд ба энэ захидлыг Аривдах Далайгаар явууллаа. Чамд өөрийн бодлоо өөрчлөх боломж одоохондоо байна. Хэрэв чи хил хязгаарыг зөрчвөөс, би өөрийн биеэр бүх ван, бэйл, тайж нартайгаа дайлаар мордож, чамайг буг ниргэх болно. Учир иймээс би чамайг өрөвдсөндөө, чамайг зогсоохын тулд элчингээ явууллаа. Дээрэмдсэн юмаа даруйхан эргүүлэн өгч, надад захирагд!” [72].

Галдангийн хувьд Кан-Си-гийн баримталж байгаа байр сууринаас үзвэл Ойрадын хааны байдал мухардмал болжээ. Түүнийг хил зөрчсөн тохиолдолд устгана гэж сануулав. Галдан үүнийг зөрчихгүй байж эс чадав. Яагаад гэвэл Түшээт хан, Жавзандамба хутагт нарын Цин улсын бүрэлдэхүүнд орох тухай хүсэлтийг авсан үеэс Цин улсын эрхтнүүд Халхыг өөрийн нутгаа гэж үзсэн учир Галдангийн тэнд байгаа нь ч Цин улсын хил хязгаарыг зөрчсөн хэрэг

байлаа. Энэ үед Галдан хаашаа ч явах аргагүйтэж, өөрийн “төрсөн хонхор” ч үгүй болов. Дээрэм хийхээс татгалзах аргагүй болов, яагаад гэвэл цэргүүдийнх нь амин зуулгын нь эх үүсвэр тэр л байлаа. Халхын хаад Хятадын Цин улсад захирагдаж, Хятад, Оростой энхийн хэлэлцээр байгуулсан болохоор Кан-Си Галданг устгахаар хатуу шийджээ. Энэ нь Галдан руу явахаасаа өмнө Аривдах Далайн авсан зааварчлагаас бүр ч тодорхой байна.

Арни, Аривдах Далай хоёр Арни-гийн хээрийн лагериас холгүй зугаалж явна. Хаа нэгтээ ойролцоо хүмүүс бужигналдан, морьд янцгаалдан, хааш нь ч юм бэ зэс их буунуудыг чирэх ажээ. Энд, талын жижиг нуурын дэргэдэх хотгорт нам гүм. Арни аажмаар хөлөө зөөн газарт мөрөө тод гаргахдаа алхаандаа тааруулан бусдын чихнээс холхон намуун дуугаар, тодорхой заавар өгч байлаа.

- Өмнө нь чи өглөг барьцаа өгдөг, ёс жаягаа дагадаг байсан бол одоо хил хязгаарыг зөрчиж, бидэнд харьяалагддаг улсыг дээрэмдэж, тонолоо гэж чи хэл.

Аривдах Далай Халх тийм амархан Хятадынх болчихлоо гэдгийг ташаа сонсов бололтой, Арни руу харав. “Үүний төлөө байлдах хэрэгтэй” гэсэн санаа хаа нэгтээ төрөх шиг болоход ийн асуув:

- Ноён, төрийн нарийн бичгийн дарга, та давтан хэлнэ үү?

Арни урьдахаасаа бүр ч тайвнаар хэлсэн нь:

- Бидэнд харьяалагддаг улс орныг дээрэмдлээ, санаж байна уу?

Цаашдынх нь зорилго ямар байгааг асуугаарай. Богд хаан өөрийн элчин Аривдахыг түүнд няцаалт өгөхөөр явуулж байгаа юм шүү дээ. Хэрвээ урьд нь их дуулгавартай байсаан, тэр хэвээрээ үлдэж чадна гэвэл чамайг бут ниргэхээр явах гэж байгаа цэргээ ч явуулахгүй ээ. Тэрээр одоохондоо өөрийн төлөвлөгөөгөө өөрчилж чадна, “одоохон чадна” гэдгийг л онцлохыг хичээгээрэй.

- Хэрэв хаан уурлавал яах вэ?

- Чи л битгий уурла, бие барь, гэхдээ хааныг сэтгэлийн хөдлөлд нь бариад бай.

- Манай цэргийг дайлаар мордоход бэлэн гэж Галдан мэдэж магадгүй шүү.

- Хятадын цэрэг яагаад дайлаар мордох гэж буйг чамаас хэрэв асуувал чи түүнд энэ тухай сонссон гэж хариул: Өөрөө л үүнд буруутай гэдгийг түүнд учирла. Өөрөө ямар ч шалтгаангүйгээр хил хязгаарыг зөрчсөн, харин манай цэрэг бол хилийн хамгаалалтад л гарч байгаа юм гэж хэл.

- Богдхаан юм уу, эсвэл том түшмэлүүдээс хэн нэг нь ц эрэгтэй гарах уу гэж асуув ал?

- Энэ талаар хэн ч мэдэх ёсгүй гэж хариул. Түүнийг элчин явуулахад л хүргэ. Хэрвээ түүнийг элчин илгээж чадахгүй гэвэл чи өөрөө Богд хаанд түүний талаар яаралтай илтгэл өгөх гэж байгаа гэж хэл.

- Гүйцэтгэе ээ.

- Одоо гол юмаа сонс. Арни зогсож, Аривдах Далай руу хараад ширүүхэн дуугаар хэлсэн нь: - Богд хааны нууц тушаал, чиний зорилго бол Галданг саатуулах, эсвэл түүнд эхлэн дайрах боломж өгүүлэхгүй байх явдал. Манай их арми болгоомжлолыг дээд зэргээр сахин, зөвхөн шөнөөр л хөдөлж байна. Иймээс хэрэв Галдан цэргээ авч зүг буруулах аваас чиний зорилго бол түүнийг саатуулж, түүнд цохилтоос зайлах боломж олгохгүй байхад л оршино![73].

Уншигч та бидний ойлгож байгаагаар Аривдах Далайн Галдантай хийх ямарч хэлэлцээр нь Галдангийн армийг бут ниргэх, түүнийг бие бялдрынх нь хувьд устгах гэсэн үндсэн зорилгоо амжилттай хэрэгжүүлэхэд нь өнгөлөн далдлалт төдий л үүрэгтэй байв. Аривдах Галданг олсонгүй. Хээр талаар тэнэж тэнэж хүнс хоолоо бараад гар хоосон буцаж ирэв.

1690 оны 6-р сард Цин улсын 2 арми /1 нь Манжуураас Хэрлэн голын зүг Арни-гийн удирдлага дор/, нөгөө нь Хаалган, Хөх хотын чиглэлээс Туул голын зүг/ Галдан руу аян дайнд хөдлөв. Энэ дайнд Манж - Хятадын цэргүүд, тэрчлэн өмнөд Монголчуудын болон Халх Монголчуудын бүлэглэлүүд оролцов.

Энэ үеэр Галдан Халхын зүүн хойд нутаг Улз гол дээр байрлаж байв. Арни-гийн цэрэг 1690 оны VII-26-д түүний хүрээг дайрчээ. Ойрадууд галт зэвсэг хэрэглэн Цин улсын цэргийн дайралтыг няцааж, улмаар тал талаас нь цохиж Арни ялагдал хүлээв. Арни ухарч, Галдан өмнө зүг Шар мөрний хавь, Цин улсын зүг хөдлөв. Тэрээр энд үзэмчингүүдийн /БНХАУ, өвөр монголын өөртөө засах орны зүүн хойд муж/ нутгийг дээрэмдэв.

Галдангийн өөдөөс Кан-Си 2 арми илгээв. Зүүн жигүүр Чубэйкоугоос, баруун жигүүр Сифынкоугоос гарав. Зүүн жигүүрийг чин ван Фу Цюань удирдаж, орлогч нь Кан-Си-гийн том хүү Юнь Ти байв. Цэргүүд ч “Ойрадуудыг устгаж, тэндээс нутаг дэвсгэрийг чөлөөлөх” [74] маш тодорхой зорилготой байв. Түүнээс гадна “Галданг баривчлах буюу алах чадвартай болон эсвэл түүнийг буулгаж авсан хүнд” өндөр шан өгнө гэж амлажээ. Цин улсын тагнуулын мэдээгээр тэр үед Галдан үзэмчний нутаг Чирбулагт байрлаж байв.

Галдан өөрт нь тулгарсан аюулыг ойлгож, Цин улсын цэргийн гол хүчтэй шууд сөргөлдөхийг хүссэнгүй. Түүний элч Дархан Галдан дараахь мэдэгдэлтэй иржээ. “Миний дайснууд бол халхчууд. Тэднийг мөрдөн мөшгөсөөр яваад би хил нэвтэрлээ. Хятадын эзэн хааны зан заншил, хууль ёсыг баримтлан утга учиргүй үйлдэл хийж эс зүрхэлнэ”. Хариу захидалдаа Кан-Си Галданд түүний бүх нүглийг тоочоод, түүний арми нь Галданг шийтгэхийн тулд биш “зөвхөн ажил төрлөө түүнтэй хэлэлцэх хүсэлтэйгээр аянд морджээ” [75].

8-р сарын 18-д тагнуулд гарсан цахарууд ойрадуудыг Чжах-эрхун голын эхэнд буюу Цзиэрх голын дэргэд буудалласан Цин улсын цэргээс 2-хон өдрийн замд байгааг илтгэв. Цин улсын цэргийн нэгэн захирагчид Галдан дараахь мэдэгдэл бүхий элчийг ирүүлжээ: “Би өөрийн биеэр хил дээр байгаа боловч, түүнийг намрын цагаар зөрчих бодол огтхон ч алга ... Бүх замын цэрэг, хуримтлагдсан болохыг би сая мэдлээ. Зуун мянган хүнтэй арми ирсэн ч бид юунаас нь айх билээ?”.

Энэхүү илгээлт нь шийдвэрлэх тулалдааны өмнөх хэлэлцээрийн бас нэгэн шатны эхлэл

болов. Галдан мөргөлдөөнийг сунжруулах үүднээс мэдэгдсэн нь: “Өмнөдийн эзэнтэн – мэргэн гэгээн эзэн хаан, би бол хойд зүгийн эзэн билээ. Хятадтай би ганцхан замаар нэгэн чиглэлээр л явж байна. Хэдийгээр би хил рүү дөхөж ирсэн ч, зөвхөн өөрийн дайснуудийг л хайж байгаа ч, хил хязгаарыг чинь өчүүхэн төдий ч зөрчих бодолгүй. Одоо бол энх тайвныг сэргээж, түүнд үнэнч байх тухай ярих цаг мөн” [76].

Энэ үеэр Цин улсын армиуд хойд зүг улам бүр урагшилсаар. Кан–Си-д “Цэргүүд дайсантай улам бүр ойртсоор байгаа” мэдээлэл ирсээр. Галдан дахин Цин улсын бүлэглэлүүдийн нэг рүү өөрийн төлөөлөгчөө илгээж, шууд мөргөлдөөнөөс зайлсхийхэд найдсаар л байв. Галдангийн цэрэгтэй хамт байсан Төвдийн төлөөлөгч Жирун хутагтын элч Гэлэг, Галдангийн бие төлөөлөгч Хатан хошууч нар мэдэгдсэн нь: “Өнөөг хүртэл манай нутагт цэргийн жанжин Амидийн армид элчээ илгээж, түүнд Галданд Далай ламын өгсөн зааврыг мэдэгдсэн билээ: “Чи Хятадын эзэн хаантай энх тайвныг тогтоо!”. Чи одоо Түшээт хаан, Жавзандамба нарыг мөрдөн хайж явна. Хэрэв энэхүү шалтгаанаар дажин үүсвэл, энэ нь бүх амьд амьтанд хор хүргэх уршигтай. Тэдэнд амар тайван газар олдохгүй. Энэхүү зааврыг Галдан онц хүндлэн хүлээж авав. Ийм учраас тэрээр биднийг Хятадын цэргийн жанжнууд руу очиж, энэ тухай мэдэгдэхийг тушаав” [77].

Цин улсын цэргийн захирагч Галдангийн элч нар ирсэн тухай Кан-Си-д илтгээд: “Баруун тийшээ явчихаж мэднэ гэж эмээж байна” хэмээн эмзэглэж байгаагаа илэрхийлэв. Иймээс Фу Цюань Галданд яаралтай 100 эр хонь, 20 үхэр илгээж, ийн бичжээ: “Эзэн хаан биднийг урт хугацааны бат бэх эв найрамдал тогтоох ...хэргийг хэлэлцэн шийдвэрлүүлэхээр тусгайлан илгээлээ. Бид хаана уулзаж, хэлэлцээр хийх вэ? Газраа товлож их үйлсийг шийдэцгээе!” [78]. Урт хугацааны бат бэх найрамдал тогтоох эрмэлзлэлдээ Галданг итгүүлэн Фу Цюань, Кан-Си –гийн том хүү хоёр нэгэн зэрэг цэргүүддээ Галдантай хийх тулалдааны жагсаалд жигдрэхийг тушаав.

Энэ үед /8-р сарын 31/ Кан–Си өвдсөн учир Бээжин рүү буцахаас аргагүй болов. Кан-Си-г Бээжин рүү явж байхад, түүний явуулсан Аривгах Далай Галданг олж, Мэргэн гэгээн эзэн хаан зөвхөн энх тайвныг хүсч байна гэдгийг батлан илэрхийлэв. Түүний хариуд нь Галдан бахь байдгаараа “Түшээт хан, Жавзандамба хутагт хоёрыг надад даруйхан өгөх үү?” хэмээн давгжээ.

Энэ хооронд Цин улсын цэрэг Галдангийн армитай Улаан Буданд тулгарчээ. Тэд энд анхны жинхэнэ “хэлэлцээрээ” эхэлж талууд их буу, галт зэвсэг нүргэлүүлэн, протокол нь ойрад, халх-монгол, цахар, манж, хятад цэргүүдийн цусаар бичигдэв.

1690 оны 9 сарын 3-ны өглөө Галдангийн зохион байгуулсан цэргийн зөвлөл хуралдаанаа өндөрлөв. Түүн дээр дайсныг эхэлж өөрсдөө довлохгүй, харин ”тэмээн цайз” барьж, дайсны дайралтыг хүлээх шийдвэр гаргав. Галдан босч, цэргийн жанжнуудаа гарахад нь ийн өгүүлэв.

- Анд явж байгаа хүнд “олз” гэдэгсэн билээ. Дайнд явж байгаа хүнд амжилт гэдэг билээ. Хувь тавилангаас хаашаа ч зайлахгүй. Цэргээ сайн бэлтгэцгээ, үзэлцэх л болно доо.

Цэргүүд өргөнөөрөө алга дарам хирийн төмөр ялтаснууд хадсан хөвөнтэй хүрэм-хуяг өмсч, зарим чинээлэг нэг нь ойрадын болон олзны хуяг өмсч, толгойндоо төмөр дуулга өмсөцгөөв.

Сэлэм жадаа хурцалж, тахир нумаа шалгацгаана. Яшил модон хатуу нумаар хүрз хэлбэрийн хошуутай сумаар харвацгаана. Ийм сумаар дайсныг толгойгүй ч болгож болох ажээ.

Галдан лагерь дундуур холхин цөөхөн буу зэвсэгтэй, бараг их буу байхгүйдээ харамсан бодлогоширно. Тэгээд уул руу гарч байрлалыг ажив. Уулын хажуу туждаа ой модтой, мод нь голынхоо эрэг рүү түрж ургасан, зарим газраараа эрэг нь эгц өндөр. Шаварлаг эрэг бүхий гүехэн нарийн гол баруун талаас Галдангийн цэргийг Цин улсын цэргээс тусгаарлаж байлаа. Цэргүүд тэмээний хойд урд хөлийг таваглан уяж хэвтүүлээд, нуруун дээр нь нойтон эсгийгээр бүрсэн хаалтуудыг тавьж байв. Хаалтуудын завсраар буудах нүхнүүд гаргав. Хаалтууд нь нумны сумнаас сайн хамгаалах авч, их бууныхаас эс чадна. Эндээс довтлон ирэх дайсны дайралтыг няцаан, буудахад тохиромжтой. Морин цэрэг нь уулын ард нуувчинд төвлөрчээ. Түүдэг гал энд тэндгүй улалзаж, тогоо буцлан, цэргүүд борц чанаж, /намар цаг байсан ч шинэ мах бүгдэд эс хүрэлцэв/, хатсан бяслаг идэцгээнэ.

Галдан Хятадын цэргийн асар том лагерийг сайтар ажив. Зэс их буунууд наранд гялалзах нь сүрдмээр. Жигүүрүүдэд монголын, манжийн морьт цэргүүд төвлөрч байв. Тэд бол цохилтын гол хүч. Зүгээр л хүлээж бай, аюумшигт тулаан нэгэнт эхлэхэд олон зүйлийг тооцон үзээгүй таны хувьд үхлийн дайн болох болно.

Галдан уулнаас уруудан буув. Нэгэн түүдгийн дэргэд буурал толгойтой өвгөн цэрэг хүрээлэн буй цэргүүдэд эртний дууллаас цэргийн тангаргийн дууг нь дуулж байв.

Хүйтэн жадны үзүүрт алтан амиа өгцгөө

Хүсэл бодол бүхнээ эх орондоо өргөцгөө

Хорсол атаа, хоосон магтаалаас салцгаая

Хуурамч зан, урван тэрслэхээс ангижирцгаая

Баатар эр, дайсан хичнээн олон ч

Барааг нь хараад эргэж зугтахгүй!

Хүчит төмөр цайтлаа улайдсан ч

Хэнийг хэзээ ч айлгаж чадахгүй!

Бид үнэнч цэрэг хэвээрээ үлдэцгээнэ!

Бид дандаа шударга хэвээрээ үлдэцгээнэ!

Жангар хаан болон түүний баатруудын тухай туулийг сонсох дуртай байсан Галдан түүнийг “Жангар” гэдгийг төвөггүй мэдэв. Тэгээд дайчин эр рүү хараад: “Танихгүй л юм байна, мэдээж сайн жангарч шиг байна, хөөрхий, амиа алдах л байх” хэмээн бодлоо. Галданг цэргүүдийнх нь дайчин зориг баярлуулав. Хамгаалалтын араас цэргүүд нь голын нөгөө талд даналзаж байгаа цэргүүдийн

зүг хашгирцгаасан нь:

- Хэрвээ чамайг олзолж авдаггүй юм бол Богдын уур хилэнд алтан амиараа өртөө!

- Бид нар та нартай эцсээ хүртэл эрэгчин эмэгчнээ үзэлцэнэ. Ялагдахаас илүү нүгэл гэж байхгүй. Эрлэгийн хааны талд орвол ч орог, бид зовлон зүдүүрээс шантрахгүй. Та нар эндээс амьд гарахгүй!

Тэмээн хэрэм рүү яарч явсан нэгэн цэрэг эрийг Галдан зогсоон асуусан нь :

- Дайнд амиа алдах байх гэж айж байна уу?

Дайчин эр хааны мэлмий рүү хараад тайвнаар хариулсан нь :

- Хаан минь, таны дайчдын хувь тавилан тийм л байгаа бус уу? Шархдаж цусаа урсгасан ч эх газар минь нэг ч болов балга цусаар төлжинө. Алсын энэ хязгаарт үхвээс яс минь цайж, атга боловч чандраар газар шороо минь төлжиг!

Цэрэг эр заншлын дагуу ийн хариулав. Амиа алдахад бэлхэн байна гэдэг бол ялхад бэлэн байна гэсэн үг биш ээ. Энэ их буунууд байхгүй бол ч!

Цин улсын их буунууд хүлээх завдал өгсөнгүй. Үдийн хирд их бууны нүргээн газар тэнгэрийг донсолгов. Галдангийн хоёр их буу Цин улсын цэргийн байрлал руу хариу гал нээсэн авч удалгүй л таг чиг болов. Их бугаар үдэш болтол буудав. Галдан гол хүчээ уулын ард, модон дотор оруулаагүй бол тулалдаанд орох хүнгүй хоцрох байв. Тэмээн цайз сүйрэв. Айж балмагдсан тэмээд тушаа даруулгаа таслан, зарим нь холдож амжив. Ихэнх нь үрэгджээ. Нар шингэхүйд монгол манжийн морин цэргүүд дайралтанд орж, тэдний араас Хятадын явган цэрэг хөдлөв. Галдан өөрийн хүмүүсээ нуувчнаас гаргаж, голын цавчим эргийн зүг очихыг тушаав. "Ум ма ни бад ми хум" хэмээн залбираад түүний шар арслангууд дайсны өөдөөс ухасхийлдэв. Шар илдний ган үзүүр гялалзан, сэлэм жадны даялаан хурын дараах үерийн ус шиг хөвөрч, унасан нь өндийж, дахин унасаар, хар цус гол шиг үерлэв. Цин улсын цэрэг Галдангийн зүүн жигүүрийг ховх цохиж, тэдний тойрох арга нь ашигтай болж, сэмхэн голыг гатлан уулыг тойрч, араас нь цохилт өглөө. Зэс хошуутай, бөхөнгийн эвэртэй хорон санаатай шулмас нисээд ирэх шиг л болов. Ойрадууд дайсныг хожим мэдэв. Зүүн жигүүр хумигдан бут цохигдлоо.

Хамгийн алдартай дайчин баатарууд ч

Хатуужилтай нь ч гэсэн үймрэн зугтав

Хатан зоригтой нь ч харалгүй зугтав.

Уулан дээрээс байлдааныг ажиглаж байсан Галдан цэргүүд нь бүгдээрээ тулааны талбарыг орхин санд мэнд зугтаагүйг ч харлаа. Зарим нь ухарч, эгнээгээ алдалгүй, дайсныг цохиж, дайсны морьдыг эмээлийг нь гэдсэнд нь чиргүүлэн авч одов. "Армиа л хадгалах! Энэ л миний аврал!" хэмээх бодол Галдангийн толгойд буув. Төв хэсэг нь хэвээрээ тэссээр, галын

шугамнаас голын намгархаг намхан эргээр хамгаалагдсан баруун жигүүр ч тэссээр л байлаа. ”Армиа л хадгалах!” гэсэн бодолтойгоор Галдан тулааны төв цэг рүү чиглэв.

Шөнө дөл болоход тулалдаан зогсов. Амжилтаа үргэлжлүүлэн бататгах боломжгүй болсон Фу Цюань цэргээ лагерь руугаа буцах тушаал буулгав.

Галдан ч тэр даруйд цэрэгтээ ухрах тушаал өгөв. Шөнийн дотор Ойрадууд хол явж чадсангүй. Яарч сандран бололцооныхоо хирээр шинэ байрлал эзэлцгээв. “Армиа л аврах!” гэсэн бодол Галдангийн толгойг улайдсан шөвгөөр өрөмдөх шиг болов. “Хэрвээ би цэрэггүй хоцорвоос хэн нэгэн Халхын тайжийн идэш болно”. Өглөө болоход Галданд гарах зам олсон мэт санагдав. Тэрээр харуулаа дуудан:

- Гэгээнтэн Ялгуусан хутагтыг яаралтай урьж ирүүл!

Мөчийн дараа нойрмог, айж балмагдсан хутагт Галдангийн өргөөнд орж ирэв.

- Хутагт минь, Төвдөд болон Далай ламд миний эртний хайр энэрлийг өвөрлөн, ноён цэргийн захирагч-жонон руу явж ийн дамжуул: “Би сэлмээ хуйнд нь хийж, эвлэрч байна! Өшөө хонзонг эрэхгүй ээ би! Бидний хооронд энх тайван, энх тайван, энх тайван л байг!” Надад зөвхөн Түшээт хан, Жавзандамба хутагт хоёрыг л өгчих.

Хутагт Галдангийн цонхигор царай руу түгшүүртэй гэгч хараад түүний хэлсэн будлиухан үгсийг сонсч байлаа. Ялагдал хараахан болоогүй байхад юун энх тайван байх билээ? Ухарсан ч гэсэн ялагдахгүй гэж үү?

- Хутагт минь, түргэн яв, чамайг хэлэлцээр хийж байхад чинь, би армиа аварна.

Хутагт ойлгов бололтой.

- Би хааны зааврыг гүйцэтгэе!

Хутагтыг үүд рүү алхаж байхад нь Галдан:.

- Чиний араас Жирун хутагтыг шавь нартай нь явуулна гэдгийг дамжуулаарай!

Ялгуусан хутагт чимээгүйхэн гарч, гэрийн дэргэд бараа бологсод лам нартаа хэрхэн тушаал өгч байгаа нь Галданд сонсдов.

Фу Цюань шөнөөр Бээжин рүү элч илгээж, байгуулсан ялалтынхаа талаар мэдээлж, тулалдаанд Галдан үхсэн эсэхийг тааварлаж ядан байв. Өглөө нь Фу Цюань шинэ давшилтын тушаал өгөх гэж байтал Галданг шинэ байрлал руу ухарсныг нэгэнт мэдэв. Ялгуусан хутагт хэлэлцээр хийхээр ирсэн байв. Ингээд Фу Цюань хэлэлцээрийг эхлэв. Энэ нь түүний алдаа байсан юм. Ялгуусан хутагт энхийг сахихыг хүсч, Түшээт ханыг ахтай нь хамт эргүүлж өгөхийг хүсч байх зуур Галдан хүмүүсээ зохион байгуулалттайгаар холдохоор яаралтай зэхэж байв. 9-р сарын 5- ны орой тэрээр Жирун хутагтыг урив.

- Хутагт минь, надад тусал. Гэрээ хийхээр явж, цаг сунгах хэрэгтэй байна. Чамайг явуулна

гэж би амласан юм. Түшээт ханыг өг гэж би дахин шаардахгүй, Жавзандамба хутагтыг Төвд рүү явуулбал явуул гэж хэл.

- Намайг шавь нартай минь явуулж болгооно уу, хаан минь.

- Тэг, тэг, гэхдээ бүгдийг нь бус, надад цэрэг үлдээгээрэй. Сайн яваарай.

Галдан хутагт руу очиж, түүнийг тэврэн хацрыг нь үнсэв. Надад чамд бэлэглэх юм алга. Энэ ууттай эзгийг ав. Чамайг үүнд дуртайг чинь би мэднэ.

- Баярлалаа, хаан.

9-р сарын 6 – нд Фу Цюанийн цэргийн хүрээнд Жирун хутагт 70 шавьтайгаа хүрч ирэв. Фу цюань тэднийг лагерь руу оруулсангүй, зайдуухан гэрүүд барьж өгөв.

Хэлэлцээр Фу Цюанийн асарт болов. Хутагт Фу Цюаньд хадаг барьсны дараа ийн мэдэгдэв:

- Бошгот хаан Ялгуусан хутагт, Шанин Дорж нарын хатгалганд итгэж, хил зөрчсөн байна. Тонуул дээрэм хийсэн нь туйлын харамсалтай.

- Ялгуусан хутагт түүнийг сургадаг болоо юу? - Фу Цюань чихэндээ ч итгэсэнгүй. Үнэндээ Галдан Ялгуусан хутагтыг өөрт нь өгсөн хэрэг байв.

- Ертөнцийг захирагч, мэргэн гэгээн эзэн хаан минь, Бошгот хаан бол бяцхан омгийн ахлагч хүн байж хичнээн үл бүтэх хэрэг тарихыг зүрхлэв гэж Жирун хутагт үргэлжлүүлэв. Фу Цюань дахин гайхав. Элчин нь өөрийг нь илгээсэн хаанаа муулж байлаа. Өөрийн дайснууд болох Түшээт хан, Жавзандамба хоёрыг барих гэдэг бол Бошигт хааны зүгээс том алдаа боллоо, – гээд Хутагт доош харав.

Хутагт хүлээсэн байртай харав. Фу Цюань ч дуугарсангүй, хүлээсээр л.

- Одоо бол, - гээд Хутагт яриагаа түр зогсоон: -Одоо Бошгот хаан Түшээт ханыг барих хүслээ орхисон. Жавзан дамбыг өөрийнхөө багш Далай ламд өгөхийг мэргэн гэгээн эзэн хаанаас гуйж байна.

- Би энэ талаар эзэн хаанд айлтгая.

Хутагт аягатай, амтлаг хятад цай оочоод:

- Би аль эртнээс Галданг амар жимэр байхыг ятгасан юм. Ийм хурцадмал байдалд хүргэх хэрэггүй байлаа. Холдож нүүгээд хүлээзнэ, устай, өвстэй нутаг руугаа буц, хүлээж бай гэж түүнд их ярьсан юм даа.

-Түшээт хан Жавзандамба нар үнэндээ хэрэг тарих нь тарьсан улс. Гэвч манай эзэн хаан онцгойлон шалгарагсдыг хөхүүлэн шагнаж, гэмтэнгүүдийг шийтгэдэг. Жавзандамба хутагтыг Далай лам руу явуул гэж Галдан хаан яаж гуйж чадаж байна?

- Би буцаж очоод Жавзандамбыг нэхэж шалалгүй Цин улсын хязгаарыг орхин явахыг Галданд итгүүлэхийн тулд бүх хүч чадлаа дайчилъя.

- Хутагт минь, чи Галданг биднээс зугтаалгалгүй, тогтоон барьж байхад тусалж чадах уу?

Хутагтын бие хүйт оргих шиг болов.

- Яалаа гэж дээ, Галдан намайг заавал хүлээх болно, тэр хол явахгүй ээ. Хэрэв манай арми ойрадуудтай тулгарваас тэднийг даруйхан бут ниргэнэ. Гэвч би таны хүсэлтийг хүндэтгэж байна. Хутагтын санаа нь уужрав. Хэлэлцээр явагдсаар, цаг хугацаа ч урссаар л байв. ФуЦюань Хутагтад нөмрөг, алт бэлэглэв. Дотны хоёр шавиа Галданд хэлэлцээрийн явцын талаар мэдэгдэхээр илгээв. Кан–Си рүү ч мөн тийм даалгавартай элчүүд давхив.

Энэ хооронд Галдан үүрэглэж суусангүй. Түүний санасан төлөвлөгөө нь бүтсэн учир цэрэг, хүмүүс, малаа цуглуулан Шар мөрнийг гатлан Дацзишань Алиний уулсыг давж, түргэвчилсэн явдлаар баруун зүг хөдлөв. Бүх найдвар нь хүлэг морьд байлаа:

Хайрт амраг энхрий чамаас минь ч илүү

Хөнжлөө хуваадаг эхнэр чамаас минь ч илүү

Ариухан дэлт хүлэг чамаараа би бахархдаг

Эр цэргийн зориг зүрхнээс минь ч илүү

Эрх танхил ганц хүүгээс минь ч илүү

Эрдэнийн сүүлт хүлэг чамаараа би бахархдаг

Хурц мэлмийт хурдан хүлэг минь нис!

Халуун хүйтэн, өлсөх цангахыг тэвч!

Энэ үед Цин улсын төрийн зөвлөл Галданг зайлан явсныг ойлгов. Зөвлөлийн шийдвэрт өгүүлсэн нь: “Жирун хутагттай хэлэлцээр хийсэн нь алдаа мөн гэдэг нь илт мэдээж. Миний арми түүний үгэнд орсноор боломжийг алдсан гэдэгт буруугүй гэж үү? Галданг яаралтай мөрдөн хөөж чадвал түүнийг устгах тушаалыг эзэн хаантнаас гуйя”[79]. Фу Цюань болон өөрийн хүүгийнхээ үйлдлийг буруутай гэдгийг Кан-Си хүлээн зөвшөөрөв. ”Давшилтыг эхэлж, устгах” тушаал илэрхий хожимдлоо. Кан-Си хүүгээ дуудуулан баригдсан бүх ойрадуудыг цаазлах тушаал буулгав.

Галдан мөрдөн мөшгөлтөөс болгоомжлохдоо хэрвээ ”эзэн хаан, энх тайван байхыг зөвшөөрвөл, энэ цаг мөчөөс эхлэн Халх руу довтолж эс зүрхэлнэ” [80] гэсэн ам өчиг бүхий тангарагийн захидал ахин илгээв. Цин улсын эрх баригчид Жирун хутагтаар дамжуулан Галдантай хэлэлцээр хийх төлөвлөгөө боловсруулан, ингэснээрээ түүнийг цэргийнхээ байрлал руу аль болох ойртуулахыг эрмэлзэж байв. Гэвч энэ нь сайхан мөрөөдөл л байв. Галдан яаралтай Ховдыг зорив. Үүний үр дүн нь: Галдан холдон зайлж, армия хадгалж

үлдсэн, Халхын нэгхэн хэсэг түүний гарт хоцорсон ч, нөгөөх нь түүний байнгын заналхийлтэнд өртөж, Цин улс Халхыг өөртөө хадгалахын тулд Галдангийн армийг устгах, өөрийг нь ч гэсэн цааш харуулах явдал байв.

Цин улсын засгийн газар Галдантай явуулсан цэргийн мөргөлдөөнөө эцэст нь хүргэж, түүнийг устгахыг эрмэлзэж байхдаа Кан-Си дахин хуурах мэхээ хийлээ. Тэрээр ойрадын хаанд бичсэн захидалдаа Цин улсын Засгийн газрын байлдах бодлогыг үгүйсгэв. Тэгээд ч тэрээр цэрэг хөдөлгөсөн явдал бол чамайг шийтгэх тушаалтай, ”чамтай хамтарсан хэлэлцээр хийх зорилготой. Чиний цэргүүд эхэлж хөдөлсөн болохоор бид цэргээ хөдөлгөсөн юм. Энэхүү тулалдааны дараа ноёд түшмэлүүд дахин тулалдахыг надаас гуйсан авч, би хориглосон юм./Уншигч та өөрийн хүч, үнэнд ямар их итгэлтэй байгааг нь харж байна. Галданг барьж устгах бүх талын арга хэмжээний тухай тушаал, Галданд бичсэн бидний ишилсэн захидал Кан-Си-г амьд байх үед нэгэн номонд бараг зэргэлдээ нийтлэгджээ!...Чи одоо тангаргийн итгэмжлэх илгээж, үйлдсэн гэмт хэргээ наманчлахыг гуйж, энх тайвныг хүсчээ... Чиний цэргүүд миний нутгаас гарч, нутгийн гадна амьдрах ёстой, надад харъяалагддаг халх аймгуудаас чи нэг ч хүнийг булааж, нэг ч малыг авч болохгүй”[81]. Тэр үед цэргүүдээ байлдааны бэлэн байдалд байлгаж, Галдангийн тангарагт итгэхгүй байхыг урьдчилан сануулсан байлаа.

1690-1691 оны 12-1-р сард Галдан Ононд байрлаж байв. Түүнийг тайвшруулах гэж 1691 оны 1-р сард Кан-Си түүнд 1000 лан алт бэлэглэх тушаал өгчээ. 2-р сард Галдан одоогийн Улаанбаатараас холгүй орших Хан ууланд өвөлжив. Хятадуудын хэлсэнээр бол энэ үед Халхад дээрэмдэх юм юу ч байсангүй. Галданд Кан-Си-гээс элч ирэв. Кан-Си бичсэн нь: ”Чиний ойрадууд малаа дуусч идэх юмгүй болсон гэж дууллаа. Та туйлын хүнд байдалд орж, хүмүүс чинь байнга өвчнөөр үхсээр байна. Хэрвээ Галдан ямар ч арга хэмжээ авах тэнхэлгүй болж, над руу ирж захирагдах юм бол би дуртайяа хүлээн авч, амь зуулгаар хангах болно гэж үүнээс өмнө би Далай ламд бичсэн юм. Чи үнэхээр ядарч хоол хүнсгүй болсон бол хуучин газар нутаг руугаа хүрч эс чадна. Цин улсын хил рүү ойртож нүүдэллэ! Би танд маш өндөр шан хайрлана. Хэрвээ Цин улсад дагаар орохыг хүсвээс хүнс хоолоор элбэг дэлбэг хангаж, чамайг огтхон ч буруушаахгүй, урьд нь Халхчууд руу дайрахгүй гэж бас тангараглаж байсан. Гэхдээ манай арми байлдааны бэлэн байдалд байна ... Энэ үеэс эхлэн цаашдаа чиний хүмүүст дээрэмдэх юу ч үгүй болж, хуучин нутгаа ч бараадаж чадахгүй, хүмүүс чинь их үхэж үрэгдэж байна. Хэдийгээр чи гэмээ мэдэж байгаа ч нэгэнт оройтжээ. Чи үүнийг сайтар мэдвэл зохино”[82].

Кан-Си-гийн мэдээлэл үнэний хувьтай. Тэрбээр Галдангийн байдлыг зөв зураглан, хэт нь түүнийг юу хүлээж байгааг өгүүлжээ.

Улаан-баатарын хавиас Галдан аажмаар баруун тийш нүүж 1691 оны зун Хамбад хүрч ирэв. Энэ үед Кан-Си Халхыг Цин улсын бүрэлдэхүүнд орсныг хуульчлан батлахаар Халхын хаад хэргэмтний их хурилдааныг Долнуурт хийлгэхээр зэхэж байлаа.

Хурилдаан 1691 оны 5 сард болов. Нуурын эрэгт хашаан дотор 4-н эгнээгээр эзэн хааны өргөөг зэргэлдээ хоёр эгнээгээр хурилдаан хийх том том гэрүүд барьжээ. Гэрт том цагаан эсгий, вьетнам чийрс дэвсэж, ханыг нь туг, хиур, луу хээтэй шар торгоор бүржээ. Эргэн тойронд нь ихэвчлэн Манжчуудаас бүрдэх Кан-Си-гийн бие хамгаалах цэрэг байрлах аж.

Кан-Си өөрөө Монголын хаад тайжуудын өмнө хуяг дуулгаа өмсөн гарч ирэв. Тэрээр өөрийн биеэр Цин улсын цэргүүдэд үзлэг явуулав: Халхчуудад Манж, Хятадын цэргийн дүрмыг тайлбарлан таниулав. Кан-Си Халхын 35 захирагчийг тус тусад нь хүлээн авч, тэднийг Жавзандамба хутагт эзэн хаанд төлөөлж байв.

Их хурилдаан дээр Кан-Си-гийн өмнө Халхын хаад, тайжууд 7 эгнээ болон сууцгаахад, эхэнд нь Түшээт хан Чахундорж байлаа. Хурилдааны үндсэн үр дүн нь 45 жилийн өмнө Абахайд захирагдсан Өмнөд монголын 49 тугийн тэрхүү нөхцлөөр Хятадын бүрэлдэхүүнд Халхыг засаг захиргааны хувьд багтаах явдал байлаа. Түшээт хан, Жавзандамба хутагт, талийгаач Засагт ханы бага насны хүү Цэвээнжав нарт чин ван хэргэм хүртээв. Түшээт хан мэдэгдсэн нь:

- Үхэл мөхлийн ирмэг дээр байсан бидний боолуудын мэргэн гэгээн эзэн хаан хэмжээлшгүй их хишиг буянаараа тэтгэж, бид дахин хүчин чадлыг оллоо. Үүнээс хойш бид энх тайван, эв нэгдэлтэй, баяр хөөртэй аж төрөх болцгооно. Өөрийн нийт ард олонтойгоо мэргэн гэгээн эзэн хаанд эртнээс захирагдаагүйдээ харамсаж байна!

Жавзандамба хутагт Их ламын хэргэм хүртэж, Монголын буддистүүдийн тэргүүн болов.

Кан-Си Далай ламд бичсэн захидалдаа /Төвдийн засгийн газар / Долоннуурын их хурилдааны дүнгийн талаар мэдээлээд өнгөрсөн дайны үеэр төвд рүү зугтаж орсон монголчуудыг хуучин нутагт нь буцаахыг хүсчээ. Галдангийн тухай Кан –Си бичсэн нь: “Галдан туйлын хүнд байдалд байгаа нь тодорхой, хоол хүнс ч үгүй, өлсөж цангаж байгаа. Галдан тэнгэрийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн нь эндээс харагдаж байна. Тэрээр ирж лам танд ч захирагдаж болохгүй гэх газаргүй. Хэрэв үнэхээр ирж захирагдвас би түүнийг яаж байрлуулах вэ? Зөвхөн ламтан та л үүнийг шийдэж чадна. Галдан явахдаа ам өчгөө өгсөн. Хэрвээ тэр энэхүү тангаргаа зөрчиж, хаа нэгтээ надад захирагдсан халхчууд руу дайрч довтолбол би цэргээ хэд хэдэн чиглэлээр яаралтай хөдөлгөж, түүнийг заавал устгана”[83]. Энэхүү захидлыг Төвдийн засгийн газраас Галданг армитай нь урьж ирүүл гэсэн дохио гэж ойлгож болох юм. Энэ нь ухаалаг явдал болох байв. Хэрэв Галдан Халхыг чөлөөлөн Төвд рүү нэвтэрч чадвас түүнийг замд нь Цин улсын хил рүү ойртуулж ирүүлэх гэж байнга эрмэлзсээр байлаа. 1691-оны 7-р сард тэрээр түүнийг уриалан дуудаж: ”Хил орчмын цайзуудад ойр суурьшихыг“ хүсээд “Чамайг тэнд амь зууж чадахуйц шанг би чамд нэмж өгнө. Хэрвээ чи надад дагаар орвоос би чамайг хишиг буянаараа хангалуун байлгах болно“. Галданд 500 лан алт илгээжээ. Тэрээр хариуд нь: “Урьд нь би ихээхэн бэрхшээлтэй тулгарч байсан, одоо бол ажил төрөл овоо сайржич л байна”[84]. Цин улсын хил рүү явж болохгүй гэдгийг Галдан ойлгож байлаа. Тэрээр Баруун Монголд суурьшин, Халхыг багтай эзэгнэхэд юмуу /аль эсвэл хагасыг нь/ эсвэл Зүүн гарын улсын Засгийн эрхийг эргүүлэн авах ямар нэгэн үйл ажиллагаанд зориулан хүч хуримтлуулж байлаа.

* * *

Улс төрийн хүн хямралаас гарч, армия бэхжүүлэх, эдийн засгийн байдлаа батжуулахад Галдан бүхнийг хийсэн гэдэгт эргэлзэхгүй байж болно. Долнуурын их хурилдаанаас хойш Халх нь Цин улсын бүрэлдэхүүнд орж, ачиртаа бол тэрээр Цин улсын нутагт дэвсгэр дээр, тэгэхдээ Цин улсын цэрэг эс хүрэх нутаг дэвсгэр дээр түр хугацаагаар оршин сууж байлаа. 1692 оны 5

/V—15-наас VI—13/ сард Кан-Си Халхыг 3 замд хуваах тушаал өгчээ: Түшээт ханы эзэмшлийг хойд, Цэцэн ханыхныг Дорнод, Засагт ханыхныг баруун зам болгон хуваав.

9-р сард /X—10-наас XI—7/ Галдан Кан-Си-д захидал илгээж, халхчуудыг Халх руу “7 тугийг хуучин нутаг руу нь буцаахыг” хүсчээ. Галданд бичсэн урт захидалдаа Кан-Си өнгөрсөн үйл явдлын талаарх өөрийн дүгнэлтийг давтаад, Халхчуудыг өөрөө авчирснаа онцлон тэмдэглээд, Галдангаас ийн асуужээ: “Халхчууд хүнс ч үгүй байна. Хэрвээ тэд хуучин нутагтаа буцаад очвол, хэн тэднийг тэжээх юм бэ? Тэд өлбөрч үхэх нь тодорхой бус уу?”. Цааш нь Кан-Си Далай ламд халхчуудыг өлсгөлөнгөөс аврах тухай айлтгаснаа мэдэгдэж, түүний үйлдлүүдийг сайшаажээ. “Би одоо чамд энэ захидлыг илгээж байна. Үүнийг чи унш. Хэрэв Далай лам чамд захидал илгээж, өөр зүйл яривал надад тэр тухайгаа илтгэж болно. Цэвээн—Равдан чамтай таардаггүй гэж би эртнээс сонссон. Цуу яриаг магадлахад хэцүү, үнэн ч юмуу, худал ч юмуу, тэгээд би Даху-г асуулгахаар явууллаа. Цэвээн—Равдан намайг хишиг буянаа нэмэгдүүлэхийг гуйсан. Тэгээд ч би Мади-г бэлэг хүргүүлэхээр явуулсан. Хэдийгээр миний элч Мади танай хүмүүсийн дайралтанд өртсөн хэдий ч, чиний ажилд хошуу дүрэхийг хүссэнгүй”.

Галдан уншлагаа завсарлав. Тэгэхлээр Богдхаан Далай ламд итгэхгүй байна. Төвдөөс бичиж байгаа бүхнийг намайг мэдээлж байх дохио өгчээ. Тэрээр Цэвээн-Равдантай л хуйвалдахдаа л манай хэрэгт оролцохгүй царай гаргасан нь илт. Миний хүмүүс Мади-г Хами-д барьж авсан ч, түүнийг алаагүй л дээ. Хятадаас Цэвээн-Равдан руу байнга явдгийг нь зогсоох, нөгөө талаар Богд хааны уур унтууг бүү хүргээсэй л гэхдээ л айлган сүрдүүлэх нь зөв зүйтэй байлаа. Галдан захидлыг хүлээн аваад цааш нь уншлаа: “Жавзандамба, Түшээт хан хоёрыг өгөөч гэж чи мэдээлжээ. Тэд чинь өөдгүй хүмүүс, өөрөө өөрсдийнхөө арьсыг хуулахыг хүснэ. Энэ тухай ярих хэрэг байна уу? Чамд захирагддаг хүмүүсийг тэдний дайсанд нь барьж өгнө гэдэг ёс төртэй хэрэг үү? ... Надад захирагдсан хүмүүсийг шаардан, чи надад өгсөн тангаргаа одоо зөрчиж байна. Миний элчин руу дайрч довлон, надад захирагдсан хүмүүсийг шаардах чинь Далай ламын сургааль юмуу? Хэрэв чи цаашид тангаргаа няцах юм бол би таны элч нарыг хүлээж авахаа больж, буцааж явуулах болно”[85].

Галдан захидлыг хойш шидчихээд хараал тавив. Хүмүүсээ буцааж, тэднийг малаа адгуулах, армия сэлбэх, дайн тулалдаанд явуулахын тулд ямар нэгэн юм бодох шаардлага тулгарав. Хаашаа явах вэ? Цэвээнравдан руу юу? Түүний ойрадууд тийшээ явах болов уу? Халх руу юу? Халх хоосорсон. Цин улсын хил руу юу? Энэ бол ёстой үхэл. Яах вэ? Иймэрхүү бодолд Галдан бүхэл оройжингоо автагдсаар тав тух муутайхан хонов.

1692 оны намрын туршид Галдан Халхын захирагчдаас хэн нэгнийг өөрийнхөө талд татахыг оролдов. Тэрээр Түшээт хаанд болон Өвөр Монголын эрхтнүүдэд ч бичив. Бид эдгээр захидлыг мэдэхгүй. Магад ч үгүй эдгээр захидалдаа Галдан Чин улсын түрэмгий үйлдлийн эсрэг бүх Монгол хэлтэн ард түмнүүдийн нийтлэг үйл ажиллагаа шаардлагатай байгаа санаагаа илэрхийлсэн ч байж болно. Нэгэн зүйлийг баталж болно. Түүний энэ бүх оролдлогууд нь талаар өнгөрсөн юм. 1691-1692 онуудад ойрадын элчид Зоригт хишиг, Сунита болон бусад хүмүүс Эрхүү, Нэрчинск, Тоболск-т очжээ. Ач хишгийн тэргүүлсэн элч Москвад ч хүрсэн байна. Гэвч эдгээр элчүүд Галдангийн хувьд ямар ч үр дүнг олсонгүй.

Хөх хотод Монгол цэргүүдийг цэргийн эрдэмд сургахыг Кан-Си Фянгу-д тушаажээ.

Хэдийгээр Галдан баруун монголын хилээс гардаггүй Хөгөн хотод сууж байсан ч түүний харьяатууд нь Орхон гол хүртэл нүүдэллэж Халхчуудын хэсэг нь тус орны, төв дорнод муж руу буцжээ. Цэцэн хаан өөрийн хүрээгээ Буйр нуурын дэргэд байрлуулав.

1693 оны 5 сард /VI-4 - VII-2/ Кан –Си Галданд Цин улсад дагаар орох, Цин улсын хил орчмоор сууршихийг дахин санал болгон, хүнсний тусламж амлан, эргэлзэх эмээх явдалгүй” гэж уриалан түүнд 10 толгой торго илгээжээ. Галдангийн байдал хүнд хэвээрээ, цөөн тооны малтай үндсэндээ загас барьж өл залгадаг, нэн ядуу хүмүүс олонтой. Ховдод ч тэр, өөрт нь захирагдсан халхын нутагт ч тэр, газар тариалан, мал аж ахуй хөгжүүлэх арга хэмжээг Галдан авч байлаа.

Галдангийн хүнс хоолоо нөхөх гадаад эх үүсвэрээс салгах, түүний Төвдтэй болон Хөх нуурын тайжуудтай холбоо хэлхээг нь таслахаар Цин улсын цэргийн жанжин Лантань Эзнээ гол болон Хами руу хайгуулын цэргийн ангиуд илгээхийг санал болгосон аж. Энэ төлөвлөгөө батлагдаагүй ч 1693 оны эцсээр Цин Улсын хил орчмоор анхны босуулууд үзэгдэж, “Галдан Ховд голын эхэн дэхь Сагсай гэдэг газар байгаа. Бид хамт амьдарч байгаад, амь зуулгагүй болоод ирж захирагдлаа” [86] гэж мэдэгджээ.

1694 оны хавар Бавай тайж Галданг орхижээ. Түүний хэлснээр бол тэрээр хүмүүсийнхээ хамт нүүдэллэн явдаг байв. Улаан буданд болсон тулалдааны дараа Галданг орхих бодол төржээ. Тэгээд ч одоо бодлоо хэрэгжүүлсэн нь энэ ажээ. Бусад босуулууд өгүүлсэн нь : “Галдан хүнгүй, Завханд амьдарч байгаа, Улаан хун-д газар хагалж байгаа ч хураасан ургац нь хэрэгцээнийхээ дөнгөж хагаст нь л хүрэлцдэг. Тэрээр мянга гаруй цэрэг, цөөн морьт тэмээтэй, үхэр хонь бараг байхгүй. Газар ухаж олсноороо л өл залгадаг” [87].

Галдан урьдын адил ядуурч байсан нь эндээс илт байна. Хүнд хүчир нь өлсгөлөн, олон тооны бус хүмүүсээ алдсан явдал ч биш, монгол хэлтний ертөнцөөс бүрэн тусгаарлагдаж, өөрийн гэсэн төр улсгүй /1694 оны 4 сард Галдан, Цэвээн-Равдан хоёрын цэргийн мөргөлдөөний тухай мэдээ хамаарагддаг ч, түүний эсрэг дайлаар явж зүрхэлсэнгүй/, гаднаас нөлөөтэй тусламж авах боломжгүй болсон явдал байв. Төвд, Орос улсууд Галдангийн Цин улстай явуулсан зөрчилдөөнд зөвхөн санаа сэтгэлийн тусламж л үзүүлж чадах байв. Галданд Төвд рүү явах боломж байсангүй. Цин цэргүүд тэр даруйд нь барих байлаа. 1695 оны зун Галданг Цзяюйгуань-аас Хами-гийн Өмнөд муж, Хөндлөн гол, Эзнээ голын хөндийг дамжин Төвд рүү нэвтрэх гэж байна гэсэн мэдээ Хятадаар нэг түгэв. Цин улсын эрхтнүүд Ганьсу-гийн цэргийг яаралтай хөдөлгөсөн нь түүний арми болон хүмүүсийг устгах зорилготой байв.

1694-1696 онууд бол Галдангийн хувьд нэг талаас дотоодын хүчин чадлаа нэгтгэх, буй болсон байдлаас гарахад бүх нөөц бололцоогоо дайчлах явдал байлаа. Галдангийн энэ үйл ажиллагааны талаар харамсалтай нь бид юу ч мэдэхгүй байна. Нөгөө талаар эдгээр он жилүүд нь Галдан, Кан-Си нарын идэвхтэй дипломат захидал харилцаа явуулж, бие биенээ хуурах, шийдвэрлэх тулалдааны өмнө өөрөө таатай нөхцөл байдлыг бүрдүүлэх явдал байв.

1694 оны илүү 5-р сард /VI-22-VII-21/ Галдан Кан-Си-д “Жавзандамба, Түшээт хан хоёрыг өгч болгооно уу,...Халхын 7 тугийг хуучин нутаг руу нь буцаа. Далай лугаа хүнлэг сэтгэл гаргаж, надад 50-60 мянган лан мөнгө өгөхийг гуйж байна”[88].

Кан-Си Галданд “Галдан чи, Улаан-Буданд манай цэргүүдэд бут цохигдон зүгтсэн ...Будда бурханы өмнө өргөсөн тангаргаа бат сахихаа амлаж, гэмт хэрэг үйлдэхийг насан туршдаа эс зүрхэлнэ гэж ам өчиг өгсөн. Чиний тамгатай тангаргийн бичиг энэ байна. ...Одоо чи Жавзандамба,Түшээт хан хоёрыг эргүүлж өгөх, ...Халхын 7 тугийг хуучин газар руу нь буцаахыг хүсчээ. Чамд эзлэгдсэн хийгээд чиний хүлээж авсан хүмүүсийг дайсанд өгч болно гэж үү? Хоосорсон халхчууд ирж, дагаар орохоос аргагүйдсэн билээ. Би тэдэнд мөнгө, тариа, мал өгсөн... Энэ тухай Далай лам мэдээд ихэд баярласан билээ. Миний халхчуудад өгсөн хишиг нь Бурхан Буддагийн өгөөмөр сэтгэл шаналалтай адилхан гэж тэрээр надад мэдэгдэв. Галдангийн хувьд хамаатай нь гэвэл, чи бол эзэн хаан, түүнээс хариу шаардан, түүнийг цаазлахыг шаардах ёстой. Хэрэв чи халхчуудад бут цохигдон ирж захирагдсан бол би чамайг хүлээн авч хооллох байсан. Өөр ямар ч тохиолдолд халхчуудад өгөхгүй байсан... . Чи 50-60 мянган лан мөнгө гуйжээ. Чамайг миний өмнө өвдөг сөхрөн гуйваас би өөрийн хишиг, буян, шан харамжаа нэмэгдүүлж, хамтарсан худалдааг зөвшөөрнө гэж би эртний тушаалууддаа өгүүлж байсан. Чи миний зарлигийг хэзээ ч биелүүлэхгүй байж, надаас мөнгө гуйж байна гэнээ?... Өөр хүмүүс явуулаад нэмэргүй. Чи өөрийн биеэр ирж, надтай ажил төрлөө хэлэлцэх хэрэгтэй. Уулзах өдөр, газрыг аль болох түргэн ирж мэдэгд” [89].

1694 оны эцэс. Галдан Кан-Си-д

“Хязгааргүй хүнлэг эзэн хаан захидал илгээж, бэлэг ирүүлжээ. Энэ бүхнийг хүлээж авсан энэ үед би баяр хөөрөө нууж чадахгүй байна. Захидлын чинь үгс гүн утгатай, би бүрэн ойлгохгүй л байна... Элчин Мадиг руу довтолсон хэргийн талаар тодорхой зүйлийг би эс мэдэх тул хариу өгөхөд хүнд байна гэдгээ би эрт мэдээлсэн билээ... . Энх тайвны хэлэлцээр тогтоох цаг хугацааг товлох талаар бол тодорхойлоход хэцүү байна...Хоёрхон хүн Жавзандамба, Түшээт хан хоёр хэмжээлшгүй их эзэн хааны тушаал зарлигийг умартан Зонховын хаан ширээ, Далай ламын сургаалыг гутааж, бүх монголчуудыг ядуурал хоосролд хүргээ биз дээ? Урьдын адилаар би Халхын 7 тугийг хуучин нутагт нь буцааж, Жавзандамба, Түшээт хан хоёрын хэргийг шийдвэрлэхийг хүсч байна” [90].

1695 оны II сар /III-15 - IV-12/. Кан-Си Галданд

“Галдан, чи миний үгийг эс хүндэтгэн авч үзэж, өөрөө ч өөрийнхөө амьдралын буурь суурийг алдаж гүйцлээ. Монголчуудын 49 тугийг бүрмөсөн хоосролд хэн хэрхэн хүргэв?...Миний түрүүчийн захидлын талаар ойлгосонгүй хэмээн, чи хуурамчаар өгүүлж байна!...Би чиний элчүүдийг буцааж, тэднийг хил рүү хүргэхгүй” [91].

1695 оны эхний хагас. Галдан Кан –Си- д

“Уулзах, гэрээ байгуулахын тухайд бол энэ нь хүсэшгүй зүйл биш ээ. Эндээс ямар нэгэн шийд гаргах нь хэцүү гэж би үзэж байна. Жавзандамба хутагт, Түшээт хаан, Халхын 7 тугийн асуудлыг миний урьд тавьж байсан шаардлагатай нийцүүлэн шийдвэрлэж болно“ [92].

1695 оны VII сар /VIII-10 - IX-7/. Кан-Си Галданд

“Чи урьдын адил миний тушаалыг зөрчсөөр байна Чиний элчин Мэйсайхан чамайг Тамир руу нүүдэллэн, зүүн зүг хөдөлж байгаа гэж хэлсэн Нэгэнт чи зүүн тийш хөдөлж

байгаа бол одоо уулзалтын талаар тохиролцох нь зүйтэй. Данжила, Данчингомбо хоёрыг ирүүлж болох юм. Хэрвээ чи миний үгийг эс дагаваас, энэ үеэс эхлэн чи хэзээ ч над руу элчин илгээж, илтгэл өгөх эрхгүй болно” [93].

1695 оны VIII сар /IX-8 – X-7/. Кан – Си Галданд

“Чи цэрэгтэйгээ Шивгэй Хатанбаатар, Нами Засаг тойны хил рүү ойртон ирж эдгээр мужийг дээрэмдэн тонож ..., ингэснээрээ надад өгсөн тангаргаа зөрчлөө”[94].

Бяцхан тайлбар хэрэгтэй болов. Бүүр 1694 оны эцэст Цин улсын эрх баригчдад баривчлагдсан нэгэн ойрад хүний мэдэгдсэнээр Галдан Туул руу хөдөлж, тэндээс Хөх хот руу довтолгооноо эхлэх ажээ. Фянгу Туул руу довтолоход бэлэн байх тушаал авчээ. Манжууд Галдангийн эсрэг нэгэн зэрэг үзэл суртлын өргөн ажил эхлүүлж, Монголчуудын болон бусад буддын сүсэгтний дотор “Галдан Зонховын хуулийг зөрчиж, лалын шашинд орсон” гэж итгүүлж байлаа. 1695 оны эхээр Фянгу – гийн тагнуул Тамирын дэргэд Галдангийн хэсүүлтэй тулгаран буудалцсан байна. Цин улсын эрх баригчид өмнө зүг явах Галдангийн замыг таслах зорилгоор цэрэг илгээж, Хөндлөн гол, Эзнээ голын бэлчээрийг түймэрджээ. 1695 оны 10 сард Галдан Хэрлэнгийн эх хүрч, Туулд очоод, урсгал даган доош хөдөлжээ. Энд Галдантай Оросын хил орчимоос Туул руу хөөгдсөн адуу хайж явсан Оросын төлөөлөгч Сэлэнгийн хэлмэрч Гурий Уразов уулзсан байна. Оросын хил рүү давж орсон халхын тайжуудын хэсэг нь буцаж нутаг руугаа хөдөлсөн гэж Уразов Галданд мэдээлжээ. Уразов Галдантай уулзсан нь Оросууд Галданд 60 мянган буу зэвсэг өгч, цэргийн тусламж үзүүлэхээр амласан гэсэн цуу тарах шалтгаан болов. Олзлогдогсод, босуулуудын тараасан /энэ бол Галдангийн өөрийнх нь хатгалга болсон гэдэг нь үнэнтэй / цуу яриа Цин улсыг сандаргав. Галданг түргэхэн устгах зорилгоор 1695 оны 10 сард /XI-7 – XII-5/ Кан-си өөрийн цэргүүддээ Сиань болон Ниньс –ээс баруун чиглэлд, нийслэлээс төв чиглэл гэсэн хоёр чиглэлээр хөдлөх тушаал өгчээ.

Галдан Кан-Си – д элчээрээ захидал илгээв. Элчийг ч хүлээж авалгүй, захидлыг ч буцаажээ.

Галдан энэ үед Баян -Улаанд байсан ба Цин улсын тагнуулын мэдээгээр 5-6 мянгаас илүүгүй хүнтэй байв [95]. Ер бусын цас ихтэй өвөл байсан тул Цин улсын цэрэг хөдөлгөөнөө зогсоохоос аргагүйд хүрэв. Тэд Галданг бүслэх тушаал авчээ. 1695 оны XI сард /1695-XII-5 – 1696-I-5/ Баян улаанд байсан Галдангаас оргож, Цин улсад захирагдсан 4 ойрад Галданг 6 мянган цэрэгтэй гэж илтгэжээ. Эрээн хавирга гэгч газар хаан өргөөгөө барьсан Цэвээн-Равдан урьдын адил Галданг дайсагнасан хэвээр, түүний элчийг огт хүлээж авдаггүй байв. Галдангийн албатуудаас олонхи нь Цэвээн-Равдангийнх болжээ.

Кан-Си дайнд идэвхийлэн бэлтгэж, үзлэгийг биечлэн хийж, ирэх 1696 онд хийх Галдангийн эсрэг дайныг өөрөө удирдахаар шийджээ. Галдан руу явуулсан Аривгах далай түүнээс захидал авчирчээ.

Галдан-Кан-Си-д /1695 оны эцэс/

“Богдхаан Монголын хил рүү дөхөж ирэх бодолтой байна. Энэ бол алдаатай явдал болох байх гэж эмээж байна. Намайг хил дээр хүмүүсийг дээрэмдсэн гэж зэмлэж байна. Энэ тухай би

юу ч эс мэднэ ... Урьд тохиролцсон ёсоор өглөг хишгээ нэмэгдүүлэхийг хэмжээгүй энэрэнгүй эзэн хаан танаас гуйж байна. Хэрвээ надтай холбоотой элдэв асуудал байвал өгөөмөр сэтгэл гарган уучлахыг хүсье. Хэрвээ үүнд үндэслэл байвал захирагдах хүсэлтээ гаргах шаардлагыг надад эвтэйхэн хэлбрээр зааж өгөхийг гуйя”[96].

1696 оны II сар /III-1 – IV-1/. Кан-Си Цэвээн-Равданд

“Галдан одоо надад өгсөн тангаргаасаа няцаж, миний элч рүү дайрч, халхчуудыг дээрэмдэн, Панчин хутагтыг ирэхэд саад тотгор хийж байна. Одоо тэр Баян-Улаанд байгаа бөгөөд миний хүмүүсийг хилэгнүүлж байна. Би түүний эсрэг хүйс тэмтрэх аянд 3 чиглэлээр цэргээ явууллаа. Үүний бурууг зөвхөн Галдан л үүрэх болно. Гэхдээ 3 замаар илгээгдсэн их цэрэг маш олон тоотой, тэдний гаргасан дуу чимээ, сүр хүч, өнгө аймшигтай. Хилийн чанадад суугаа хүмүүс айн мэгдэх вий гэж эмээж байна. Чи өөрийн албатууддаа энэ захидлыг сонордуул, мөн Турфан руу энэ бүхний талаар мэдэгд. Бүгд амгалан тайван байцгааг”[97].

Кан-Си гурван чиглэлээр нэгэн цэгт цохилт өгөхөөр шийджээ. Фянгу-гийн удирдсан баруун замын цэрэг Нинь-Хөх хотоос хөдөлж, Төв замын цэргийг Кан-Си өөрөө удирдаж, Дашикоу - гаас гарч, зүүн замын цэрэг нь Субусын удирдлагаар Манжуураас хөдлөв. Гурван арми хангайгаас хойш уулзалдах ёстой байв.

3-р сарын эцсээр “Эзэн хааны удирдсан их цэрэг Галданг хүйс тэмтрэхээр нийслэлээс гарлаа”. Нэгэн зэрэг Кан - Си Харбин руу Түшээт ван Шаалууд нууц тушаал илгээв. “Чи Галдан руу хүн илгээж, түүнийг ойртуулахыг бод” [98]. Галдан ухаалгаар Хэрлэнгээс Туул руу нүүдэллэв. Энэ үеэр 4-р сард /V-20 – VI-18/ Галданг мэхлэх гэж ирсэн Очир гэгч Цин улсын цэргүүдэд Галданг 20 мянган хүнтэй армитай, галт зэвсэг бүхий 60 мянган орос цэрэг байна гэж мэдээлжээ. Түшмэлүүд нь Кан –Си-г буцахыг зөвлөжээ. Кан-Си цуу ярианд итгэсэнгүй, Орос улс Нерчинскийн хэлэлцээрийг баримталж байгааг ч мэдэж байлаа. Тэрээр хариулсан нь: “Надад зөвхөн урагш давшиж, Галданг устгах ганцхан санал байна” [99]. “60 мянган орос цэрэг байна гэдэг яриа бол худал!” [100] - гэж цэргүүддээ тушаажээ.

6-р сарын сүүлийн 10 хоногт Цин улсын цэрэг Галдангийн нутагт ойртож, олзны ойргдуудаар Кан- Си Галданд дахин зардал илгээв.

Кан – Си Галданд

“... Баруун замын цэрэг Туул гол хүрлээ. Зүүн замын цэрэг Хэрлэнг даган явж байна. Би өөрийн биеэр ирлээ... Би бүх чиглэлийн цэргийг удирдан чамайг устгаж чадахгүй гэж үү? ... Чамтай уулзаж ... тохиролцье. Чи бол юм мэддэг хүн, хэрэг явдал ийм болсныг чи ойлгохгүй байна уу? Тулалдаанд орохгүй байх тушаалыг би өгсөн. Энэ бол заль биш. Хэрэв чи итгэхгүй бол элчээ явуулан шалгуул. Хэрэв үүнд итгэхгүй бол миний элчийг хажуудаа үлдээ. Хэрэв хаа нэгтээ цэрэг хөдөлгөж, чамруу дайрвал өөрийнхөө дэргэд үлдсэн миний хүнийг явуул, Тэр тэднийг зогсоох болно” [101].

Галдан Кан-Си-д

/Кан-Си-гийн элч Авидийн дамжуулсан аман мэдээ/

“Чи намайг шахах гэж ирсэн болохоор би уулзахаас зайлсхийх болно. Хэрэв чи намайг мөрдөх аваас, би ч бас эсэргүүцэл үзүүлэх чадалтай шүү”[102].

Кан-Си Галданд

“Эсвэл эвсэх, эсвэл ямар нэгэн өөр шийдвэр гаргая. Элчийг яаралтай явуул. Хэрэв эс тэгвээс миний албатууд чам шиг саналтай биш байгаа гэдгийг бодолц. Чи тайван унтаж чадаж байна уу? Чи бүх юмыг сайтар тунгааж бодоод хариу бүхий элчийг мордуул”[103].

Нэгэн зэрэг Кан-Си “онцгой тушаал” өгч “Галдан зугтлаа. Энэ үнэн. Фянгу-гийн цэрэг урагшаа давшин, түүний замыг хаах ёстой, миний цэргүүд түүнийг ар талаас нь мөшгөх болно” [104].

Кан-Си Галданд

“Хэрэв чи бут цохигдож, амьд амьтан үхэж үрэгдэхийг хүсээгүй бол ирж захирагд. Данжила, Данчин Гомбо, Аравдан гурвын хэн нэгийг яаралтай явуулж болно” [105].

Цин улсын хоёр армитай халз тулгарахаас эмээсэн Галдан, тэдэнтэй тулгарахаас зайлсаар байлаа. Цин улсын хувилбраар үйл явдлыг тунгааж үзвэл түүний ухралт нь оргож босохтой төстэй байв. Тэрээр ядарсан хөгшид, эд хөрөнгө, дайны хогшил, тэр бүү хэл будда шашны эд агуурсаа ч орхин оджээ. Зүүн замын цэрэг Галдангийн хойш давах замыг таслахад бэлэн байлаа. Төв замын цэрэг нь Галданг Хэрлэнгийн эхээс Туул хүрэх чиглэлд шахаж байлаа. Туул хүрсэн баруун замын цэрэг түүнийг Ховд руу, баруун тийш явах замыг таслах зорилготой байв. 6-р сарын 2 нд Цин улсын энэ чиглэлийн 14000 хүнтэй тэргүүн ангиуд Туулыг гатлаж, Кан-Си-гийн өөрийнх нь дүгнэлтээр Галдангийн ухрах замыг хаав. Захидал харилцаа, дипломат арга нэгэнт дуусжээ. Шийдвэрлэх цаг нэгэнт ирэв!

Есдүгээр бүлэг

Навч цэцэг жам ёсоороо хагдарна.

Нартыг орхих хэн боловч

Надад авч явах юм юу ч алга хэмээн

Насан хутгийг олмуй.

Овсей Дриз

Кан-Си хааны өргөөг Дамба-Хашка алсаас харлаа. Уудам тэнүүн талын дунд дөрвөн зүгтээ хаалгатай, морьт дайчин ч харайж давамгүй өндөр шургааг модоор дугуй хэлбэрийн хашаа барьжээ. Хашааны гадна өөр хоорондоо 7-10 орчим алхам зайд Богд хааны бие хамгаалагч манж цэргүүд харуулд зогсоно. Хашааны урд хаалга нээлттэй харагдах бөгөөд хоёр эгнээ зоосон их бууны ам наранд гялалзаж, зүүн баруун талаар нь нум, сум, сэлэм агссан арван тав, арван таван цэргүүд эгнэн жагсчээ.

Дамба-Хашкаг дагалдан яваа манж хятадууд хаалгаар оронгуут богд хааны өргөөний үүдэнд очлоо. Дамба-Хашка эргэн тойрноо гайхан харав. Шар торгоор бүрсэн хааны том өргөөний хаалгыг наран ургах зүг харуулан төвд нь барьжээ. Өргөөний цаагуур тойруулан цэргийн майхан, монгол гэрүүд зай завсаргүй шавжээ. Хааны том өргөөний үүдэнд уужим талбай харагдана.

Дамба-Хашка биедээ зэвсэг агсаж яваагүй ч өргөөнд орохын өмнө түүнийг дагалдан ирсэн манж сүсэгтнүүдийн нэг нь сайтар шалгаж үзээд эзэн хаандаа айлтгахаар явлаа. Дамба-Хашка-г дагалдан ирсэн настайвтар сүсэгтэн монгол орчуулагчаар дамжуулан:

- Авралт мэргэн эзэн хаан чамаас Галдангийн тухай, түүний цэргийг бут цохисон цэргийнхээ талаар асууж лавлахыг хүсэж байна. Хаан эзэнд өвдөг сөгдөн, асуулт болгонд хариул, илэн далангүй тодорхой ярь. Сайн дураараа бидэнд хандсан чамайг эзэн хаан ивээн тэтгэнэ.

Цачираас дохио өгмөгц ахлагч нь Дамба-Хашка-г өмнөө түлхэн зэрэгцэн алхаад, хоёул нэгэн зэрэг өвдгөө сунган мөргөсөөр алтан саат торгоор чимсэн өргөөнд ороод явчихав. Манж зай тавин хойш болоход Дамба гурвантаа сөгдөн мөргөөд босож ирэв. Гадаа зуны халуун нар төөнөж, өргөөний дотор алтлаг шар өнгөөр гял цал болоод саруулхан уужим ажээ. Дамба-Хашка нүдээ нээн зориглон харвал Богд хаан сууж байв. Түшлэгтэй, тохойлууртай, хар чийгээр өнгөлсөн үнэт модон суудалдаа хаан тухлаад, цагаан эсгий ултай, хар даавуугаар өнгөлсөн гутлаа шүр сувд шигтгэн чимэглэсэн, матмал цоолбор хөлтэй сандал өшиглөжээ. Хааны хөх цэнхэр дээлийн хормойг алтан мөнгөн утсаар луу ороолгон хажиж, энгэрт нь урт савартай хүчирхэг араатны дүрс хатгажээ. Дамба-Хашка зориглон хааныг ширтэв. Цэцэг өвчний овон товон цоохордуу сорвитой, бага зэрэг монхордуу хамартай, эрүүний сахлаа мөлийтөл хуссан, буурь орж яваа гоёмсог сахлаа бавайлгасан, 40-45 орчим насны, гонзгой царайтай, дүглэгэр алаг нүдтэй, харвин суугаагүй манж эр суухыг хараад гайхав.

Кан–Си нум сумаар дасгал сургууль хийж ирээд сайхан зантай байв. Түүнийг манж сайд нарын хэн нь ч хатуу нумыг баруун солгойгүй тагдаггүй, хөдөлгөөнтэй хөдөлгөөнгүй, ямар ч байг босоо, суугаа морины давхиан дунд санаснаараа онодог өөрөөс нь өөр хүн байдаггүйг эзэн хаан сайн мэднэ. Галт сумыг нум сумаас дутуугүй эзэмшжээ. Эр чадал, эрхий мэргэнээ шалгаад мориор довтолгож ирсэн хаан бараалхах зочноо үл тоомсорлон, ихэрхэнгүй царайлна. Тэрбээр сайн дураар баригдаж ирсэн хүрэн ширэн гуталтай, хар дээлтэй, гэзгээ мөрөн дээрээ хаясан ойрад эрийг сонжин харж байснаа;

- Бусдын газар нутгийг түрэмгийлэн, дөрвөн ойрадыг залгиад, ах дүүсээ алан хядаж, дээрэм тонуул, хулгай худлыг эрхэмлэсэн догшин хэрцгий, уур омогтой хүн хэмээн Галданг ярилцах нь үнэн үү? - хэмээн асуув.

- Үгүй, яалаа гэж дээ, гэгээн эзэнтэн минь! Бошгот хаан хүний зүрх сэтгэлийг өөртөө татсан увдистай хүн шүү хэмээн зориг гарган хэлчихээд сандран:

- Улаан Будангийн дэргэд тулалдсандаа ихэд харамсаж байгааг би сонсож билээ, - гэв.

- Би ч үүнд харамсдаг. Галдан сүүлийн үед хаагуур нутаглаж байна?

- Хэрлэн Туулын хөндийгөөр, тэрээр өвөрлөгч нутгийн монголчууд, халхчуудыг өөрийн талд татахыг санаархаж байгаа юм.

- Юунд найдаж байгаа юм бол?

- Өөрийн нь бодож санасан их үйл хэргийг та нар мэдчихээд цэрэг дайчдаа илгээж таарна. Цөөн цэргээр довтолбол хариу байлдаж, олон цэргээр довтолбол газар нутгаа орхин зайлна. Манж цэргүүд мөрдөж хөөхөөр нь нуугдаж байгаад ардаас нь гэнэдүүлэн довтолно. Ийнхүү бүслэгдсэн цэргүүдийн хоол тэжээл дуусаж, өлсөж ядраад ирэхээрээ байлдах чадваргүй болно биз дээ.

- Ийм л төлөвлөөгөөтэй байхнээ. Гэхдээ бодит байдлыг ухаалгаар тооцоогүй шив дээ.

- Тийм ч байж болно. Гэгээн эзэн таныг цаг агаар тааламжгүй улирлаар туулах боломжгүй говийг их цэргийнхээ хүчээр гаталж ирнэ гэдгийг төсөөлсөнгүй. 6 сарын 6-нд танай цэргүүд гэнэт ойртон ирснийг мэдээд тэд хөрөнгө агуурсаа орхин, зугтан зайлахад Галдан хүчээр зогсоох гээд чадаагүй.

- Муур харсан хулгана шиг зугатсан уу? Яагаад хариу байлдсангүй вэ?

- Тооно уулын бэлд тосож байлдахыг санаархсан ч тогтоон барьж чадаагүй. Тэгээд ширэнгэ модтой Эхэн мухар хустайд отоож, тэмээгээр халхавч хийн тулалдахаар зэхэж байх үед Фянгугийн цэргийн талаар тагнуулийн мэдээ аваад Галдан бошгот хаан зарлигаа өөрчлөн: “Дайсны гол хүч нь бидний хувьд дийлдэшгүй учир одоогоор эсрэг тулалдаанд оролцолгүй Туул гол руу яаралтай хүрч, баруун жигүүррүү нь дайръя. Фянгу гэдэг нь манжаар отгон хүү гэсэн үг. Иймд отгон хүүг нь довтолж бут цохиод дээрэмдэе” хэмээсэн билээ.

- Ер нь надаас айж дээ! Биднээс сүүлээ хавчин зайлан оджээ!

- Тиймээ, их эзэнтэн минь. Танай дайчид мөрдөн хөөсөн ч Бошгот хаан танаас айгаагүй.

Хааны дэргэд зогсох амбан сайдууд сандран ширтэхэд, Кан-Си огт дуугарсангүй. Дамба-Хашка хэнэггүй царайлж:

- 6 сарын 12-нд бид Тэрэлжийн голд ортол гэнэт танай баруун жигүүрийн хүчтэй тулгарсан. Манайхан 5000 гаруй хүнтэй, 2000 орчим зэр зэвсэгтэй, морь мал турж эцээд яс арьс болсон байв.

- Яагаад?

- Хэрлэнгийн Баян Улаанд хазах ногоогүй, балгах усгүй, урьд өмнө нь үзэгдээгүй ган нэрвэж, манай цэргүүд таван өдөр, шөнө зогсолтгүй аялсаар туйлдаж ядраад, олонхи нь замд хоцорч, Туулд багахан хүч л очсон.

Харин Фянгу хичнээн дайчидтай байсныг мэдээгүй.

- 13000 илүүтэй.

- Фянгу-гийн цэргүүд өндөрлөг газар, ашигтай байрлалыг хэдийнээ эзэлчихээд, намхан гүвээ толгодоор халхавчлан, явган бид нар яах ч учраа ололгүй самгардсан.

- Тэгээд яав?

Дамба-Хашка Кан-Си хааны асуултыг сонсоогүй юм шиг царай нь хүрлийн цус асгаруулсан хядааныг эргэн санав. Намхан гүвээ толгодод нуугдсан ойрадын багахан хүчийг өндөрлөг газрыг эзэгнэсэн Фянгу-гийн дайчид их буугаар ээлжлэн галлахад, гал утаа манаран харанхуйлж, ойрадууд энд тэнд үхэтхийн унавч, улангасан дайрсаар байв. Галдан сандран тэвдэж, Данжила, Данзан-Гомбо нар тэсэлгүй зайлан зугтав. Ганцхан Равданы хэсэг цэргүүд тулалдсаар, манжийн морьт цэргүүдэд бүслэгдэн цохигдов. Ачаа хөсөг, хөглөрөн, эмс хүүхэд хашгиран, мал сүрэг хуйларна. Ийм л явдал болсныг санаад:

-Намайг харсаар байтал суманд Галдангийн хатан Ану, Дайбаатар-Байсан нарын дөрвөн хүн алагдсан. Фянгу-гийн цэргийг дайрсан ойрадууд буу ч үгүй, илд ч үгүй болж улаан гараараа үзэлцэж эхэлсэн. Үхсэн хүний тоог мэдэхгүй, – гэв.

- Намайг энд ирснийг Галдан мэдсэн үү?

- “Эзэн хаан цэргээ удирдаж яваа гэдэгт Галдан итгэхгүй юм”- хэмээн зарим хүмүүс ярилцаж байсан. Гэхдээ эзэн хаантай бичгээр харилцаж байсан болохоор мэдэж л таарна. Зарим хүмүүс Галдангийн нэр төрийг муутгах санаатай бүтэн өдөржин бурхандаа залбираагүй гэж худал хэлсэн. Галдан хаан дайтахад бэлтгэж байсан.

- Галдан хаашаа зугтав ?

- Миний бодоход Галдан хаашаа ч явахгүй, заавал Далай ламд бууж өгнө.

- Цэвээн-Равдан руу очихгүй юу ?

- Яалаа гэж дээ, тэр хоёр нэг эмэгтэйгээс болж муудалцсан улс. Очирт цэцэн ханы хүү Гартан-Гомбын охин Ахайд Цэвээн-Равдан сүй тавьсныг Галдан үл хэрэгсэн эхнэрээ болгоод, бас түүний ах Содном-Равданг алсан юм. Тэгээд Цэвээн-Равдан таван мянган дайчнаа дагуулан Галдангаас салж одоход тэрбээр хоёр мянган цэргээрээ мөрдөн хөөгөөд гүйцэн очоод яагаад зайлсан учрыг лавлахад: “Чи миний сүйт бүсгүйг дээрэмдээд, төрсөн ахыг минь алсан шүү. Одоо би алуулахаасаа айж байна” гэжээ. Галдан цааш Улаан-будан зүглэсний хойно Цэвээн- Равдан эхнэр, хүүхдийг нь булааж аваад зайлан оджээ. Ингээд л хоорондоо тэрсэлдэж эхэлсэн учир Цэвээн-Равданг зүглэсэнгүй.

- Тэгвэл Галдан одоо хаана байна?

- Дөч тавьхан хүн дагуулаад зугатсан.

- Аюух хааны зүг явах уу?

- Үгүй, нэгд тийш очих хол, хоёрт Аюухын охин Цэвээн-Равдангийн эхнэр шүү.

- Орос руу зугатах уу?

- Галдан Оростой зөвхөн худалдаа хийдэг. Тэгээд ч замд нь Галданг үзэн яддаг тэлэнгүүд саад хийх тул тийшээ зүглэхгүй.

- Тэгээд хаашаа явах билээ?

- Төвд рүү зүглэж магадгүй, замд нь Хами-д түүний дайснууд бий. Гэхдээ тэнд Галдангийн албат лалынхан ч бий. Хөх нуурын ойрад тайж нар түүнийг хоргодуулахгүй ч Төвд рүү зүглэхэд нь саад хийхгүй.. Төвдийн Санжаажамцтай нөхөрсөг харилцаатай.

- Данжила Данзангомбо хоёр яах бол?

- Тэд салахгүй. Гэгээн эзэн минь, Галдангаас салж, хэдэн зуун хүнээ дагуулан танд дагаар орохоор ирснийг та мэднэ. Намайг Фянгу-гийн хүмүүс угтан авч, энд ирсэн. Одоо тангэрийн дор манж та нарыг ялах дайсан үгүй, ойрадууд сөнөнө.

- Чи зөв шийджээ. Чамайг шагнана. Одоо яв.

Хашка бөхийн ухарсаар асраас гарав [1].

Урвагч Галдангийн талаар яг үнэнийг хэлсэн боловч зугтсан эсэхийг мэдээгүй явжээ. Зэр зэвсэггүй явган цэргүүдийг нь их буугаар хормын зуур сүйдлэх дөхөхөд Галдан хүмүүсийн амь насыг бодон нуугдах газар эрж ухрах тушаал өгсөн боловч амжсангүй. Тэрбээр сандарч тэвдсэн дайчдаа зогсоох хэмээн уурлан хашгирч ташуурдан давхисан ч цэргүүд нь мал сүрэг, эмс хүүхэд, өвгөд хөгшид, зэр зэвсгээ хөсөр хаян үймэлдсээр манж нарт олзлогджээ.

Өнчин дорой нялхсыг

Өрөвдөн хайрлахыг мэдэхгүй

Авгай хүүхэн сэвгэрийг

Адгуус луус шиг хурааж

Гинж тороор гавлан

Гай зовлонд унагаж

Ард олныг нь бузарлаж

Ариун ёсыг нь устгав.

Гадна харагдах ишиггүй

Ганхийх нохойн гөлөггүй

Хүний дуу,амьтны авиаггүй

Хүйтэн дүнсгэр газар болгов

Ийнхүү сүйрэлд орсон Галдан хүн болсоор анх удаа гашуудан гашуудан нулимс дуслуулжээ.

Кан-Си хэдийгээр дайснаа хялбархан дарсан ч амьдаар нь барих гэсэн Галдан дахиад л мултарсанд сэтгэл дундуур байв. Галдан ялагдсан хэдий ч бас л хүчтэй үлджээ. Ойрадын хоёр мянган цэрэг алагдаж, зуу илүүтэй хүн олзлогдсон гэж Фянгу мэдээлжээ. Гэвч Галдан хичнээн цэрэгтэйг тодорхой мэдсэнгүй. Дамба-Хашка таван мянга орчим, манж жанжнууд арван мянган цэрэгтэй гэж Галдангийн талаар мэдүүлжээ. Наад зах нь Галдан таван мянган цэрэгтэй байсан бол 2,5-3 мянган дайчин хоцорсон нь бас ч муугүй хүч байлаа. Кан-Си өөрөө Галданг бут цохиогүйдээ бухимдан суув. Галдан эзэн хааны асар, цэрэг дайчдыг хараад л зугтах замдаа Фянгу-гийн цэрэгтэй тулчихсан гэж манж жанжнууд түүнийг тайвшруулавч, Галданг алдчихсандаа харамсана.

Кан-Си ялалтаа тэмдэглэн, тэнгэр бурхан, элэнц хуланцдаа мөргөж суух хооронд Галдан баруун зүгт алслан оджээ.

Кан-Си хэдэн хоногийн хойно айлдсан зарлиг бичигтээ: “дээрэмчдийг бут цохиод хүн малыг булаан авч, олзлогдсон үрэгдсэний тоог алдав” хэмээжээ. Циний эзэнт гүрэн ялалтаа тэмдэглээд, албан ёсоор: “Далан хоногт хүчирхэг гүрнийг сөнөөж чадлаа” хэмээн зарлав.

Галдан дахин Зүүн гарын улсдаа буцаж ирэхгүй, Төвд рүү гарах аргагүй болсныг мэдсээр байвч, Кан-Си түүнээс сэрэмжлэн бүхий л арга хэмжээ авлаа. Галдан Хөх нуурыг л зүглэж магадгүй гэж Кан-Си бодож, Хөх нуурын тайж нарт элч илгээн зарлиг буулгахдаа Галданг харсан газраа баривчлан Цин гүрний засаг захиргаанд тушаахыг даалгаж Хөх нуурын

ойрадуудад хандан: ”Та бүхэн бусадтайгаа хамжин хамгаалалт хийж, чухал мэдээллийг олохоор тагнан турших хэрэгтэй. Ойрадын Галданг илэрсэн дор нь барьж бидэнд хүргүүл. Уулзаад бариагүй хэнийг ч тонуулчны хамсаатан хэмээн үзэж залхаана”[2]-гэж мэдэгджээ. 1693 оны 6-р сард манж цэргүүд буцах захирамж авчээ. Хятадын Цин гүрний харьяат ойрадуудаас захидал бичиг авбал заавал манж дээдэст дамжуулж байхыг монголын бүх эрхтэн дархганд даалгажээ. Тэрхүү бичиг захидал богино хугацаанд Эзэн хаанд хүрсэн байх ёстой ажээ. Хөх-нуурын нэгэн хошууны захирагчийн хатан Галдангийн охиныг болон түүний албат иргэдийг манж хаанд өгөхийг тулган шаарджээ. Дээрхи шаардлага бичигт Хятадын хаан ширээнд лал шашинтай хүнийг суулгахын тулд хятадын лалынхны дэмжлэгтэйгээр Хөх-нуурын ойрадууд болон Оростой хуйвалдан Галдан Хятадыг түрэмгийлэн эзлэх гэж санаархсан гэх иш үндэсгүй гүтгэлгийг шалтаг болгожээ [3].

Ойрадын урвагчдаас тавдугаар Далай лам аль эрт нас барсныг Кан-Си мэдсэн боловч Далай-ламыг алахаар Галдан санаархаж явна хэмээн Хөх нуурын ойрадуудад худал итгүүлжээ. Хятад цэргүүд Нань-Шан ордог Эфзин-голын хөндийд хуарагнан Галданг тандан хэрэв дайран ирвэл барьж аваад цаазлах тушаал авчээ. Цэвээн-Равдан энэ үед Хамийг эрхшээлдээ бүрэн оруулсан хэмээн тооцсон, Турфан захирагч Абдул-Рашид түүнтэй холбоо тогтоож Галдангийн эсрэг хандлаа. Хэрэв Галдан Төвд рүү зугтахыг оролдвол Ананд барьж авахаар тохиролцжээ. Ийнхүү Халхын нутаг бүрэн бүслэгдсэн боловч Цин гүрний засаг захиргаа Галдан чухам хаагуур явааг нь мэдээгүй байв.

1696 оны 6 сарын 29-нээс 7 сарын 28-ны үед Галданг мөрдөгчдийн нэг Абида эзэн хаандаа: “Галдан хаагуур явсныг би мэдэхгүй” [4] хэмээн мэдээлжээ. Гурван мянга орчим цэрэгтэй ул мөргүй алга болсон Галданг эрж олохыг Кан-Си Халхын ноёдод даалгав. Бууж өгсөн гурван ойрад, нэг манж түшмэл дөрвийг Галдангийн талд тагнуулаар шургуулж амжжээ.

Энэ оргодлууд Галдан, түүний талын Равдан, Данжила, Данзан-Гомбо, Сайсан-лам нар Халхын гүнд тус тусдаа яваа, Галдан Тамирын голын Тайхар чулуунд байрлаж бүх ойрадуудыг нэгэн газар цуглуулахыг санаа нэгтэндээ зарлаж байгааг манж нарт ховложээ. Орох оронгүй, идэх малгүй шахам Галдангийн таван мянга орчим цэрэг “амьдрахад хүнд” байгааг ч мэдээлжээ.

Их ялалтаа тэмдэглэж, баян тансаг найр хийсэн Кан-Си Галданг дахиад таван мянга орчим цэрэгтэй хань хамсаатантайгаа нэгдэж бараг л уугуул нутагтаа суугааг сонсоод бухимдаж, дахин шинэ довголгоон хийхээр төлөвлөжээ. Гэхдээ цөөхөн цэрэгтэй хүч илгээн Галданг бүслээд, баруун Халх дахь үйл явдлыг тандан, хүнд нөхцлийг нь ашиглан, өвөл болохыг хүлээх аймшигт хорон санаа өвөрлөжээ.

1696 оны зуны нэгэн халуун өдөр Тамирын голын хөвөөнд Галдангийн талынхан зөвлөлдөв. Ган гачигт нэрвэгдсэн уул хөндий цайвартан шаргалтаж, тарга хүчээ аваагүй цөөн мал бөөгнөрөн хургаж, унаа морьд ч сулджээ. Эхнэр хүүхэд ч харагдахгүй, өлсөж ядарсан хүмүүс холхилдоод хааны урьдын өргөө өнгө зүсээ алджээ.

Галдан цагаан эсгий суудалдаа заларч зүүн, баруун талд нь Данжила, Равдан хоёр суухад зарц нар тэдэнд арз, мах барихуйд хурал эхлэж Галдан:

- Хорин гурван оргилтой Хангай, цасан цагаан арван гурван оргилтой Алтай эх орон минь хаа байнам? Одоо хаашаа явж, юу хийх вэ? Онгийн гол орж, хил орчмыг тонон, манжийн агуулахыг дээрэмдэн, хоол хүнсээ базааж, Хами тийш зүглэе. Агт морь, эр цэргийнхээ хүч тамирыг сэлбээд төрөлх Алтайдаа бид хүрч чадна, Халхын урвагч хаадыг ч Халх руу оруулахгүй байж дөнгөнө гэв.

Ёс дэгийг баримтлан хамгийн ахмад, хамгийн үнэнч Данжила босож:

- Их хаан минь, бидэнд Онгийн гол хүрэх хүч алга, Алтай нутгаа зүглэн өмхий чавганц, үхэр Цэвээн-Равдантай хүчээ үзье гэв. Дараа нь Равдан:

- Алтай тийш зүглэвэл ард иргэд Цэвээн-Равдангийн зүг зугтаж арван гурван оргилт Алтай, буурь нутаг минь эзгүйрнэ. Энэ уулын бэлээс эх нутаг минь эхэлж байгаа шүү. Энд Богд хааны цэрэг хүрэлцэн ирж чадахгүй. Ирвэл бид сөнөөнө. Өлсөж ядарлаа гээд харсан зүгтээ явж болохгүй. Цэвээн-Равдан Хамийг эзэгнэсэн. Онгийн голд Цин гүрний цэргүүд ойрхон байгаа. Иймээс Оросын нутагт довтлон Буриадыг дээрэмдэн, хүнс хоолоо базаая хэмээн саналаа хэлэв.

Данзан-Гомбо босоод:

- Равдангийн хэлсэнтэй санаа нэг байна гэв.

Цугларагсад урьдын адил арз хорзоо ууж, аажуу уужуу зөвлөлдсөнгүй, эе эв, санаа нэгэнт үгүй болж, Галдан өөрийн дураар захирах цаг нэгэнт өнгөрчээ.

Хурал тарж, Галдангийн хамт Онгийн гол явах хүсэлтэй Равдан, Данзан-Гомбо хоёр салан нүүхдээ хоёр мянган цэргээ дагуулан одов. Данзан-Гомбо салж нүүгээд 8 сард Цэвээн-Равданд бууж өглөө. Хүлэг морьд нилээдтэй Равдан энд тэнд нүүдэллэн зусав. Данзан-Гомбо, Равдан хоёрын хойноос Галдан мөшгин мөрдсөн боловч удалгүй больжээ. Галдан Тамирын голын хөвөөнд Данжила, Цэрэн, Ялгуусан хутагт нартай хоцорчээ. Ядарч туйлдсан албатууд нь ан агнаж, загас барьж “орох оронгүй, оочих аягагүй, өмсөх хувцасгүй” болоод зарим нь төрөлх Алтай тийшээ, хэсэг нь манжийн талх горьдон Дамба-Хашкагийн зүг оргон зайлжээ.

Цин улсын цэргүүд буцаж, халхууд төрөлх нутагтаа ирэхээр хариугаа авна хэмээн Галдан горьдож суусан нь талаар өнгөрчээ.

Кан-Си 9-р сард Цэвээн-Равданд захидал игээж: “Хорон санаат, өшгөн Галдан хүн ардыг амар тайван суулгахгүй, алхам бүрдээ гай зовлон тарина. Ойрад, монголчуудыг амгалан жаргаахын тулд түүнийг даран сөнөөх хэрэгтэй. Чиний албат ойрадуудын газар нутагт хэсүүчлэн Хамид орж ирвэл амьдаар нь барих, аль эсвэл толгойг нь надад тушаа. Миний хүсэлтийг мөрдөн дагавал хязгааргүй энэрлээ танд хайрлана” [5] хэмээжээ.

Өвөл эхэлж Галдангийн байдал хүндэрчээ. Арай чуу мянга таван зуун цэрэг бүрдүүлэн Данжилагаар толгойлуулан Халхын өмнө зүгт илгээсэн боловч Цин гүрний хил хүртэлх газар нутаг эзгүйрч, хүн ард зайлан зугтаж, сайтар зэвсэглэсэн манж цэргүүд отож байгааг мэдээд буцжээ.

1696 оны 10-р сарын 4-нд Кан-Си дагаар орохыг сануулсан захидал бичгийг монгол манж хоёр хэл дээр бичиж Галданд хүргүүлжээ. “Миний хувьд гадаад, дотоод нутаг хэмээх ойлголт үгүй, би ертөнцийг эзэгнэж байна. Дуулгавартай дагалдагсадыг амьдрах боломжоор хангаж илбэн тохинуулна. Амьдрал ахуйд хандсан хар буруу санаатныг хүйс тэмтрэн цээрлүүнэ... би ахиад цэргээ захиран, аян дайнд мордоно. Дэг журам жигдэрч, зэр зэвсэг бэлэн. Чи эхнэр хүүхэд, морь мал, эд хөрөнгөө алдаад идэх хоолгүй, өмсөх хувцасгүй, хоргодох оромжгүй ядарч зүдэрч яваа шүү. Хүйт чангарахаараа үхэх өдөр чинь ойртоно. Албат иргэдийг чинь өрөвдөж... албан ёсоор надад дагаар орохыг зарлиг болгов. Үйлдсэн нүгэл хилэнцээ гэмшин ухаарвал, зарлигийг минь дага...Би чиний язгуур угсаа хөрөнгө мөнгөнд халдахгүй”[6].

Энэхүү захидлаа гурван зуу гаруй хувилаад Галданд төдийгүй, өлсөж ядарсан албат иргэдэд нь илгээжээ.

10-р сарын 1-нд Данжилагийн хэсэг хүмүүс Онгийн голд хүнс: хоол ачсан манжийн хөсгийг довглоод няцаагджээ. Кан–Си захидлынхаа зэрэгцээгээр Галдангийн гачигдлыг далимдуулан цэргийн жанжнууддаа: “Галдангийн албат иргэдийг дагаар орохыг ятгах хүмүүс явуул... Галдан өөрөө үл зөвшөөрөвч албат иргэд нь дагаар орохыг зөвшөөрч зугтан ирнэ”[7] - хэмээн даалгасан байжээ.

Галдан Данжила хоёр Кан–Си-гийн өөрийн нь хэлснээр “цэрэг дайчид хүрэх аргагүй” Засагт хааны хуучин өвөлжөө Бол-унаганд өвөлжжээ. Галдангийн албатын сэтгэлийг урвуулах, Цин гүрний засаг захиргааны бодлого тухай үедээ яг оножээ. Тэрэлжийн гол, Зуун мод орчмын тулалдаанд олзлогдоод дагаар орсон бүх ойрадуудын эздээс мөнгөн татвар авахаар Кан-Си 1696 оны 11-р сард зарлиг буулган Ойрад албат бүрд гучин лан мөнгө ноогдуулжээ [8].

Мөн сарын 13-нд Кан-Си дахин Галдан, Данжила хоёрт захидал илгээн олзны нэг ойрадаар хүргүүлжээ. Ойрад түмний амсаж буй түмэн зовлонг /дэлгэрэнгүй / тодорхой тайлбарлаад: “Та нарын дунд эцэг эх, эхнэр хүүхдээ олзлуулсан хүмүүс бий. Тэд салж хагацсан гэр орныхонтойгоо уулзахыг тэсэн ядан хүлээж суугаа. Хуучин газар нутгаа буцаж ирэхийг хүсвэл уналгын морь, унд хоол өгч, холдсоныг учруулж, хагацсаныг уулзуулаад буцахыг би зөвшөөрнө. Харин Цин гүрэнд дагаар орвол язгуур угсаа, хөрөнгө мөнгө хайрлаж, амьдрал ахуйд нь туслана. ... Галдан Бошгот хаан, Данжила та хоёр албат иргэдээ дагуулан яаралтай дагаар орцгоо! Гэр бүлийг чинь баян тансаг аз жаргалтай байлгана... Эргэлзэн тээнэгэлзэх, айх хэрэггүй!” [9] - хэмээжээ.

Цин гүрэнд дагаар орохыг шаардсан ийм захидлыг Галдангаас салан одсон Равдан, Данзан – Гомбо нарт бас илгээжээ. Кан-Си тэдэнд: “Равдан, Данзан –гомбо та хоёр урьд нь Галданд зүтгэж явсан ч тэрслэл биш. Одоо Галдангаас ангид яваад чинь талархая. Энэ захидал зарлигийг хүлээж аваад албатаа цуглуулан дагаар орцгоо. Та бүхэн Цэвээн Равдантай найрсаг харилцаж, Галданг устгаж, Равданг өршөөхийг Их эзнээс хүсэж суугааг бид сонслоо. Та нарыг сайшаан Цэвээн Равданд харьяалагдахыг хүсье” [10]-хэмээжээ.

1696 оны өвөл Галданг бүслэн барьж авахаар Цэвээн-Равдан Алтай руу мордсоныг манж дээдэс хэдийнээ сонсжээ.

Онгийн гол руу мордоод буцаж ирсэн Данжила зам гарц болгоныг Цин гүрний цэргүүд

бүслэн хаасныг илтгэхэд Галдан дүрэхийн уурлаж :

- Би чамд л найдаж байлаа. Одоо яаж амьдрах билээ. Энд бүслэгдээд сууж болохгүй, Хами руу мордож хүнс хоолоо бэлтгэе!-гэв.

- Яваад ашиг гарах болов уу?

- Энд суугаад ашиг олох уу? Явахыг чамд тушаая!- хэмээжээ.

11-р сарын 15нд Галдангийн ойрад цэргүүд Хамийг чиглэн мордсон боловч хүрч чадсангүй, зугтаж нүүсэн албат иргэд нь түүний санааг манж нарт хэдийнээ ховлож амжжээ.

Иймд 1696 оны 12-р сарын 18-нд Галдан хорин бараа бологчтой, хорин тэмээтэй, хорин морьтой элч Гэлэгүнийг найрамдал тогтоохоор илгээв. Энэ үед Ананд Галдангийн ач Түмэн доржийг баривчлаад байжээ. Тэрбээр Төвд рүү Галдангийн элчээр тохогдон Хүрэн бэлчирт байсан Галдангийн өргөөнөөс 10 сарын 30-нд Хөх нуурын ойрадын болон Төвдийн элчтэй хамт зорчиж яваад баригджээ. Тэд байцаалтанд Ойрадын хааны тарчиг хүнд амьдралыг нэг дуугаар батлан, Галдан Равдан хоёул мянга, мянга орчим цэргээ дагуулан тус тусдаа нүүдэллэж, өвлийн хувцас, үхэр хонио бараг дуусгаад, хахир хатуу цагийг давахад ер амаргүйд тулж, албат иргэд оргон зайлах нь олширсныг мэдээлжээ. Энэ бүхнээ үл тэвчин Гэлэгүнийг явуулсан. Тэр үеэр Бээжингээс мордож хил орчмоо эргэж явсан эзэн хаан Кан-Си түүнтэй биечлэн уулзжээ.

Кан-Си Гэлэгүнийг аяны өргөөндөө хүлээн аваад, Галдан Бошготын ойрадуудын талаар баримтлах бодлого, Цин гүрний харилцааг тодорхойлсон зарлиг бичгээ уншжээ. “Ойрадууд одоогоор бидэнд дайсагнаж байвч” дагаар орохыг хүссэн бүгдэд хишиг буянаа хайрлана. Нүглийн буруутан нь Галдан мөн, - хэмээжээ.

Ойрадууд одоогоор хэнд ч тэрслээгүй, халхчуудын хувьд саяхан Шагжул, Норов хоёр сайн дураар Галданд дагаар орж Бошгот хааны ивээлийг хүлээсэн, харин үл дагагсадыг халхчууд хэмээн бид үздэггүй гэж зарлигийг сонсоод Гэлэгүүн итгэлтэй өгүүлэв.

Кан-Си инээд алдан Гэлэгүүнд малгай бэлэглээд бараалхалт дуусжээ[11]. Эзэн хаан, Галдан, Данжила нарт захиа хүргэх хоёр элчийг Гэлэгүүнтэй

хамт явуулахаар шийдэв. “Галдан бошгот, хаан Данжила нараа! ...та нар үлдсэн ойрадуудыг дагуулан надад дагаар орвол, урьдын хийсэн нүглийг чинь наманчилья! Та нарт өгсөн зарлигийг мөрдөн дагаар ор гэж сануулахаас өөр үг хэлэх эрх надад алга” [12] хэмээн захидалдаа дурьджээ.

Гэлэгүүнийг мордохын өмнө Кан Си зөвхөн Галдантай биечлэн уулзаж ярилцахыг хүсэж байгаагаа мэдэгдээд, хэрэв Галдан биеэрээ ирж эс уулзваас цэргээ илгээнэ. Одоогоор Ордос руу анд явна. 70 хоногийн дотор хариу өг! -хэмээн мэдэгджээ. ”Галдан өөрөө ирж дагаар орохыг зөвшөөрч түүнд харъяалагдана” гэж Кан-Си найдаж байжээ.

?????

Кан-Си-д дагаар орсноос үхсэн нь дээр гэж Галдан хэдийнээ шийджээ. 1697 оны 3-р сард Гэлэгүүнтэй хамт ирсэн Кан-Си-гийн элчийг Галдан хүлээж аваад ярилцсан албан ёсны тайлан энэ байна.

Галдан: - Эзэн хаан хэдий тооны цэрэгтэй вэ?

Элч: - Тодорхой хэлж мэдэхгүй, тун олон цэрэгтэй.

Галдан: - Яагаад танай цэргүүд наашаа ирсэн юм бэ?

Элч: - Данжилагийн цэргүүд ойртож очсоноос болоод хамгаалах зорилгоор ирсэн.

Галдан: – Эзэн хааны алсын бодлого юу бол?

Элч: - Танайхыг харьяандаа авах. Гэхдээ таны хаан хэргэмийг хөндөхгүй.

Галдан: – Би түүнтэй биеэр уулзаж болох уу?

Элч: - Ордост уулзаж болно.

Галдан: - Танай хүнсний агуулахууд хаана байгаа вэ?

Элч: Хилийн дагууд байгаа. Хүнс арвин бий шүү.

Галдан: - Чи Дамба-Хашка, Цагаан-Шидор-Хашка нартай уулзсан уу?

Элч: - Тэд эзэн хааны ивээлээр нийслэлд суугаа.

Галдан: – Танайд дагаар орсон ойрадууд хэрхэн амьдарч байна?

Элч: - Эзэн хааны ивээлээр сайхан амьдарч байгаа. Салж хагацсан ах дүүстэйгээ уулзахад нь эзэн хаан өөрөө тусалж байна.

Галдан чимээгүй болов [13].

Кан-Си-гийн элч төлөөлөгч 1697 оны 4-р сард буцаж очоод Галдан дагаар орохыг яагаад ч зөвшөөрөхгүй, харин Данжила, Үржинжав Ноён Гэлэн нар магадгүй, албат иргэд нь ангаар амь зогоож, арга ядан хүлэг морьдоо ч алж идэж байгааг мэдээлжээ. Ийм хариу сонссон Кан-Си Галдангийн олзлогдсон хүү Сэвдэн-Балжиртай ярьснаа эргэн санах.

Кан-Си: - Гачаал зовлонд нэрвэгдсэн чиний эцэг дагаар орох уу, үгүй юу?

Сэвдэн-Балжир: – Эцэг минь юу бодож буйг би мэдэхгүй. Аугаа хүчирхэг эзэн

Хаан та хэзээ нэгэн цагт нэгтгэж л таарна.

Кан-Си: - Галдангийн д хүрэх зам хол уу?

Сэвдэн-Балжир: – Ган гачигт нэрвэгдсэн холын замыг туулан их цэрэг хүрэх аргагүй.

Галдан энэ үед өөрт нь үнэнч Ардар –Хашкатай ярилцсанаа бодож суулаа.

Тэрбээр: - Би ядарч туйлдаад, амьдрах аргагүй боллоо! –хэмээн шуудхан өгүүлжээ.

Галдан түүний ноорхой дээл, ядарсан царайг ширтэн юу хэмээн хариулахаа бодоод өөрт нь үнэнч хүмүүсээ тартагт нь тултал хүчээр албадан суугаадаа гэмшин:

- Чи миний гар хөл болж явааг би мэднэ. Одоо чамайг тэжээн тэтгэх тэнхэлгүй боллоо. Дуртай зүгтээ явж болно” [14] хэмээв.

Саяхан Галдан Ноён-Гэлэнгийн дүнд хүмүүстэй архи балган суухад Үржинжав: -Өнгөрөгч өвөл ан гөрөө элбэг байснаа ховорджээ. Хаврын дунд сард л ногоо цухуйдаг болжээ. Богд хаанд дагаар орвол хурдхан нүүцгээе. Хэрэв үгүй бол арга авралаа яаралтай олъё. Муу нүхэдсэн хулгана зурам шиг л амиа алдаж таарлаа. Чи өвөг дээдсийнхээ нэр төрийг хадгалахыг оролдовч Халхын долоон туг, дөрвөн ойрад аймаг мөхлийн ирмэгт тулан, төр улс чинь уналаа. Эцэг эх, үр хүүхэд, эхнэр нөхөр салан хагацаж, таран бутарч бид чиний хүсэл зоригийг чинь дагасаар яваад сүйрч гүйцлээ. Одоо тэсэхүйеэ бэрх болов. Энэ бүхний лайланчиг чамайг дайрч, чи тамд очоосой билээ. Бид чиний хойноос очно!-гэв.

Ноён-Гэлэн Үржинжавыг зэмлэж, Галдан дуугүй өнгөрлөө [15]. Ан ав хөөцөлдөн хоногийн хоолоо аргацааж яваа нүцгэн ноорхой, өлсөж ядарсан хүмүүст юу ч хэлэх билээ.

Гэрт гал дүрэлзэн давирхай (уулнаас мод татдаг), аргалын үнэр ханхлан Галдан баавгайн арьсан дээр хэвтээд багаас дадсан тохь тухаа үгүйлнэ. Анчид ан гөрөө хийн Галданг махаар тасалсангүй. Одоо ч тогоонд бор гөрөөсний гуя буцална. Харин архи нэрэх хэдийнээ больжээ. Ард иргэд өлсөж, даарч Галдан санаа сэтгэлээр унана. Өлсгөлөн зовлон өвөлжин салсангүй. Галдан занганд орсон амьтан шиг түгжигджээ. Дүн өвлийн ид хүйтнээр хөвүүн Сэвдэн-Балжир анд мордоход Галдан: “Алс гарч улайран хөөцөлдөж хэрэггүй” хэмээн захисан боловч залуу насны аагаар буурлын үгийг сонссонгүй. Хами овгийн үнэрч нохой Эбэйдүл Дархан-бэх Богд хаанд нэр нүүр олохыг бодож Сэвдэн-Балжир ан хийхээр Барс хүр рүү мордсоныг мэдээд хүү Хол-бэхээ цэрэгтэйгээ илгээн олзлон аваад шууд манж нарт хүргүүлжээ. Богд хаан туйлын их баярлаж : “Галдан баригдаагүй ч хүү нь олзлогдож дээрэмчний үндэс тасарна! Бурхан тэнгэр ивээсэнд залбиран мөргөө. Галдан одоо орох оронгүй, удирдан захирах улс гүрэнгүй боллоо”[16] – хэмээн дуу алджээ. Хятадын хаан ширээнд заларсан манж шулмасын хэлсэн үг үнэн байлаа. Галдангийн өвөг дээдэс манжийн ой тайгаар ан гөрөө хөөцөлдөж явсан цаг бий. Үл эвлэрэгч дайсан Кан-Си, Галдан хоёрын аль нэг нь заавал төрөл арилжих ёстой. “Галдан амьд яваа цагт өөр омгийнхон амар заяа үзэхгүй”[17] - хэмээн Кан-Си хаан хэлж байжээ. Манж нар Галданг “говийн шулмас “ хэмээн хочилжээ. “Би үхсэн ч өвдөг сөгдөхгүй. Кан-Си чи намайг барьж, устгаж чадахгүй. Би хүүгээ алдсандаа ихэд харамсана. Ард иргэд надаас зугтан Цэвээн-Равдантай нийлэн, төрөлх Зүүн гар гүрэндээ аж төрж явна. Зэр зэвсэггүй, хүч тамиргүй 600-700 дайчдын минь олонх ан гөрөө хийж, амиа борлуулж явна. Чи намайг дийлэхгүй. Хорон санаа, хорт бодлого намайг баллав. Богд хаан чиний хоолны шавхрууг сорох гэж хөлийн улыг чинь долоосон Халхын тэжээвэр хаан-ноход чамайг зулгуйдлаа. Ач хөвүүн Цэвээн-Равдан эх орноос минь салгав.

Чамтай хүчээ үзмээр байвч Зүүн гарын эх нутаг минь хөөрхий. Чамтай дайтал Богд хаан шулмас чи Зүүн гарын болон Халхын хэргийг баллана. Цагаан хаан захирагч нартайгаа гар нийлэн, богд хаантай эв зүйгээ олжээ. Надад зэвсэг, дарь, их буу өгөх л ёстой хүнсэн“ – хэмээн Галдан бодлогошрон хэвтжээ.

Галдангийн зарц эмгэн хайсны(тогооны) модон таглааг аваад шор модоор махаа хатган үзэв. Галдан эмгэнийг ширтэн :

- Түмэн-Солонго эгч ээ, хоол болтол үлгэр яриач!

- Юу ярих билээ! Цагаан хоншоорт бухандайн үлгэр ярих уу ?

- Тэгээч дээ.

Эмгэн Галдангийн дэргэд суугаад : “Эрт урьд цагт нэгэн голын хөндийд ядуу эр амьдарч байжээ. Мал хөрөнгөгүй, ганц үнээтэй юмсанж. Хээлтүүлгийн үе болоход бухаа эрээд олдсонгүйд ядуу эр гутран: “Үнээ минь тугаллахгүй бол би айраг, тосгүй өлсөж, цангаж үхнэ. Өөрөө хээлтүүлье“ гэж боджээ.

Гэтэл хойтон хавар нь хүн дүрстэй, бухан толгойтой урт сүүлтэй амьтан гарч гэнэ. Ядуу эр айн зэвүүцэж, алахаар завдтал ой руу зугтан оджээ. Ойд очсон хойноо Цагаан хоншоорт бухандай гэж нэрлэгдэж, ойн хүү Дэлгэр, өвсөн хүү Дэлгэр, модон хүү Дэлгэр хэмээх гурван найзтай болжээ. Дөрвөн найз тэнэж яваад мал тэжээсэн хашаатай, идэж уух хоол унд бялхсан эзэнгүй байшин олж амьдарчээ. Тэгээд өдөр бүр гурав нь анд явж, нэг нь гэрээ сахиж үлддэг болов.

Нэгэн удаа ойн хүү Дэлгэр гэрээ сахиж үлджээ. Гэтэл хумсан чинээ биетэй эмгэн ирээд “айраг мах амсуулаач” хэмээн гуйхад харамлалгүй өгөхөд гэрт байсан идэж уух бүхнийг ховх сорчихоод алга болов гэнэ. Айж сандарсан Дэлгэр хоёр хөгшин морио байшингаа тойруулан хөтөлж олон мөр гаргаад, хашаандаа сум /нумны/ дүүртэл шидээд найз нараа ирэхээр: “Өнөөдөр зуун морьтой дээрэмчид ирээд байшинг бүслээд тонож орхив” хэмээн худал хэлжээ.

Маргааш нөгөөдрийн өдөр өвсөн хүү Дэлгэр, модон хүү Дэлгэр хоёрт бас л дээрх явдал тохиолдов гэнэ.

Нөгөөдрийн маргааш нь цагаан хоншоорт бухандай гэрээ сахин, тос хольж /цохиж/ суутал хумсан чинээ эмгэн ирээд: “айраг мах амсуулаач “гэхэд “миний найз нарыг энэ л чаджээ” хэмээн бодоод юу ч амсуулалгүй, цоорхой хуйвин өгөөд “ус аваад ир“ гээд явуулжээ. Эмгэн байшингаас гармагцаа тэнгэрт тулам өндөр, зэс шүдтэй шулам болон хувирахыг бухандай ажаад, цоорхой хувингаар ус дүүргэх хооронд нь түүний уутнаас хүний шөрмөсөөр томсон цалам, төмөр чимхүүр, алхыг нь аваад оронд нь сарлагийн савгаар томсон цалам, модон алх чимхүүр хийчихжээ. Эмгэн шулмас ус авчраагүй учир хоол унд өгөөгүйд уурсаж: ”хоёулаа тоглоё” - гээд бухандайг сарлагийн савгаар томсон цалмаар хүлжээ. Бухандай хүлгээ тас татаад, эмгэнийг хүний шөрмөсөн цалмаар хүлэхэд хүчлэн зүтгээд ч таслаж чадсангүй гэнэ. “Чи намайг хожлоо. Одоо чимхэлцэж тоглоё” - гээд модон чимхүүрээр бухандайн цээжнээс

хавчихад огт тоосонгүй. Бухандайн ээлж ирж, төмөр чимхүүрээр эмгэн шулмын цээжнээс чимхэж, хэсэг мах тас татан хаяв. “Ёо ёо, чи хүчтэй байна. Одоо нэг нэгээ цохиж тоглоё”-гээд эмгэн шулам модон алхаар бухандайн толгой цээжийг цохиж гэнэ. Бухандай бас л тоосонгүй. Харин бухандайн ээлж ирэхэд: төмөр алхаар толгойруу нь цохимогц цус олгойдон эмгэн шулам сүүлээ хавчин зугтан оджээ.

Бухандай найз нараа орой буцаж ирэхэд: ”Та нар намайг юунд хуурав? Энэ байшингийн эзэн эмгэн шулмыг би алсан, явж үзэцгээе” -гэв. Гүн хавцлын ёроолд эмгэний хүүр, их хэмжээний алт, эд хөрөнгө байж гэнэ. “Чи шулам эмгэнээс айдаггүй зоригтой эр болохоор доош бууж, алт үнэт эдлэлийг бидэнд авч өг” - хэмээн найз нар нь гуйхад бухандай зөвшөөрчээ. Бүх эрдэнэсийг дээш гаргасны хойно гурван найз нь түүнтэй олзоо хуваахыг үл хүсэн татаж гаргалгүй хавцалд орхижээ.

Гарах аргагүй ганцаар хоцорсон Бухандай хавцлын ёроолоос гүйлсийн гурван яс олоод: “Би жинхэнэ цагаан хоншоорт бухандай мөн бол гурван мод урга” - гээд эмгэний хүүрийг дэрлэн унтаад өгчээ. Унтаж унтаж сэрээд хартал хавцлын оройтой зэрэгцсэн гурван мод ургасныг хараад авирч гараад баяжин хөрөнгөжсөн найз нараа эрж олоод алахаар завдсанаа бодож бодож амь өршөөжээ. Тэгээд эцгээ олохоор явах замдаа хар бух – шулмасуудтай байлдаж нэгийг нь цохонд харваж алахад бусад нь зугтан зайлав гэнэ. Хурмаст тэнгэрийн эзэн: “Чи ингэж явсаар шулмасын хотод орно. Өөрийгөө домч гэж хэлээрэй. Чиний харваж шархдуулсан нэг шулам үзүүлэх вий. Шуламны шархнаас сумыг нь сугалж авах дүр үзүүлээд тархийг нь цоортол хатгаарай” хэмээн захижээ.

Бухандай хурмастын эзний захиасыг даган шуламны тархийг цоортол хатгаад тэнгэрээс төмөр гинж унжиж ирэхэд амиа аврахыг бодон гинж даган өөд авиртал шуламсын хааны хатан төмөр саваагаар Бухандайг тас цохиход бут үсрэн долоон бурхан од болон тэнгэрт мөнхөрчээ”- хэмээн яриад тогоотой махаа хутгахаар босож: - Хаан чи яг л энэ цагаан хоншоорт Бухандай адил хүүтэй ч ухаалаг бус хандаж захирч тусалж явсан хүмүүс чинь чамаас урважээ! – гэв.

- Дуугаа тат! Чиний худал үгэнд итгэх аргагүй. Махаа гарга! - хэмээн Галдан уурлав. Эмгэн махаа тавганд гаргаж тавиад :

- Цагаан хоншоорт бухандай шиг чи ч урт наслахгүй! –гэв.

Галдан эмгэний хэлснийг ч сонссонгүй, дулаан хонин хөнжлөө нөмрөн, саяхан тохиолдсон золгүй явдлаа санан, эргэн хөрвөн хэвтэв. Далай лам бүр 12 жилийн өмнө жанч халж, шинэ тодорсон залгамжлагч нь нас бага, цус шингэнээс үйл хэрэгт оролцохгүй байгаа тухай анчид нь халхчуудаас дуулснаа түүнд хэлжээ. Ийнхүү ганц түшиг нь үгүй болж, одоо яах ч аргагүйгээ ойлгов. Хэдийн хавар болж, цас ханзарч, мөдхөн ногоо цухуйх ч, идэх мал сүрэг, эрчлэн довглох хүлэг морь байсангүйд харамсан гашуудна. Галдан шөнөжин дагжин чичирч, учир утгагүй хашгиран дэмийрч хонохыг эмгэн сонсжээ.

Өглөө нь Галдан өндийж чадахгүй болж, хоол унд идэхээс дургүйцэн, өдөрчийн газар албат иргэдтэйгээ суугаа Данжилад яаралтай элч илгээхийг даалгав. Домч ирээд судас шөрмөсийг нь барьж, шээсийг нь анхааралтай ажиглаад эм боохоор явлаа. Галдан туслагч нараараа

түшүүлж гэрээсээ гарлаа.

5-р сарын нарлаг сайхан өдөр цас цоохортон, анхны ногоо цухуйжээ. Үүлсийг сайтар ажвал том шар хэдгэнийн дүрсийг санагдуулна. Аянга гялсхийж хэдгэнийн хатгуур хэл шиг зурсхийхэд Галдан балмагдав. Хаврын анхны борооны эхний дуслууд бөмбөрдөн унаж эхэлмэгц, хонины нэхий дээл нөмөрсөн Галданг гэрт оруулав. Орой тийшээ Галдангийн бие улам муудаж, ухаан санаа нь орон гарахад өвдгийг нь түшээд урвагч Дамба- Хашка, Данзан – Гомбо, Равдан гурвыг суух шиг санан:

Баруун гарыг минь атгаж үзээгүй

Баатар байна уу, та нар дотор!

Хүлэг морийг минь унаж үзээгүй

Хүчтэн байна уу, та нар дотор !

хэмээн зэмлэн дуудав.

Тэднийг цаазал хэмээн дуу алдаад гараараа ийш тийш чичлэнэ. Бараантсан цасан дээр өлсөж цангаж, хөлдөж, хатаж, үхсэн ойрадууд нүдэнд нь үзэгдэхэд Галдан хашгирах гээд чадсангүй.

Данжила шөнө дөлөөр яаран ирэх үед Галдан хэдийнээ нас нөгчсөн байлаа. Манж нар Галдангийн цогцосийг ч болов булаан авч тоглоом тохуу хийнэ гэдгийг хэдийнээ ойлгосон Данжила яаралтай түүдэг асаахыг тушаав. Буян үйлдээч зурхайчийг дуудан ирүүлж, хойтохыг нь үйлдүүлэв. Буян үйлдээч түүдгийн гэрэлд талийгаачийн биеийг угааж очир хээ зурсан цаасаар амыг нь бүтээж, гөлийсөн нүдийг нь хар даавуугаар боолоо. Галдангийн шарилийг галд өргөхөөр шийдэв.

Дүрэлзэн асах түүдгийн дунд Галдангийн шарилийг тавьлаа. Таван сарын сэрүүвтэр шөнө хүйт даан, хааныг эцсийн замд үдэх цөөн хүмүүс дөлөнд ээгднэ. Дорно зүгээс үүр хаяаран, хар утаан хөшиг нүүгэлтэн уулын оройд замхрах үед шарил шатаж дуусав. Саяхан л нугаршгүй дайчин, хатуу эзэн явсан Галдан бошготийн түлэгдсэн ясыг цогон дундаас төмөр хавчуураар Данжила түүж эхлэв. Нар дээр хөөрөх үед түүсэн ясаа илгэн хүүдийд хийгээд, сураар амыг нь боож, аугаа их Зая Бандидын шарил дээр нэгэн цагт Тавдугаар Далай ламын айлдсан:

- Гал өөдөө! –хэмээх өрөөлийг Данжила өргөлөө.

Ийнхүү 1697 оны 5-р сарын 3-нд Галдан Бошгот хаан Баруун Монголын Ац амтай хэмээх газар жанч халжээ. Галдан нас нөхцсөн сургийг Цин гүрний хаан 5-р сарын 28-нд сонсжээ. Хятадын албан ёсны мэдээнд: “Галдан үүрээр муудаад, орой үхжээ. Ямар өвчин нь тодорхойгүй”[18] - хэмээжээ. Данжилагийн тушаалаар Галдангийн нас барсныг албан ёсоор хэл дуулгахаар Хятад явсан Цэцэр-зайсан: “5-р сарын 3-нд Галдан өвчнөөр нас барлаа. Шарилыг нь тэр шөнөдөө чандарлав”[19] - хэмээн мэдэгджээ.

Галданг гэнэт үхсэнээр шалтаглан “хор ууж, амиа хорлосон”[20] –гэх яриа ч гарчээ. Гэвч бүр 1708 онд Кан-си амьд байх үед хэвлэгдсэн ном зохиолуудад Галдан хор уусан ямар ч мэдээ гараагүй билээ. Эзэн хааныхаа эвлэршгүй нэр төрийг бузарлах санаа өвөрлөсөн Хятадын түүхчид түүнийг амиа хорлосон хэмээн зарлажээ.

Данжила хүргэн Ласылун болон Ноён гэлэн нарын хамтаар Галдангийн чандрыг аван охин Жунцихайг нь дагуулан Хятад руу явлаа.

Цэвээн-Равдан Галдангийн нас барсныг сонсоод өөрийгөө Зүүн гарын хаан хэмээн итгэлтэй бодон, ойрадын ёс заншлаар дайсныхаа чандрыг өс хонзонгийн бай болгохгүй гэдгээр шалтаглан хааны чандрыг, охинтой нь өгөхийг шаарджээ. Гэвч Цин гүрний эрхтэн дархтнууд шууд татгалзан: ”Аюултай тэрслэгч хэний ч бол удам угсааг устгаж, чандрыг нь хийсгэж, ул мөргүй устгах ёстой”-хэмээн хариулжээ. Кан-Си: - Манай ёсоор дайсныхаа хэнд ч хэрэггүй охин, шатаж өгөрсөн ясыг ч доромжлон гутаадаг” [21]-гэж мэдэгджээ. Галдангийн чандрыг бузарлах, хүүг нь цаазлах олон санал цухалзаж байсан боловч Кан-Си өөрийн нүдээр үзсэнийхээ эцэст дахин өс хонзон санахаасаа татгалзан, сэтгэлээ барьж, эрүүл ухаанаар ханджээ. Далд санаа нь ойрадын хэрэг явдал дуусаагүй байсантай холбоотой билээ. Цэвээн-Равдан гадна өнгөндөө Цин гүрэнтэй нөхөрсөг харилцаж байвч тусгаар тогтносон Зүүн гар улсыг бэхжүүлэх зорилго агуулжээ. “Галдангийн газар нутаг миний нүдэнд харагдаад байна. Хятадад дагаар орсон тэрслэгч бүх тайж, ноёдыг надад буцааж өгөх ёстой. Дагаар орсон ард иргэдийг ч буцаахыг шаардаж байна” [22]-гэж тэрбээр мэдэгдэв. Иймээс ч Галдангийн урьдын албат, дээдсийн итгэлийг хадгалахын тулд Кан-Си Галдангийн хөвүүнийг Цэвээн-Равдангийн эсрэг сөргөлдүүлэх зорилгоор түүнийг албанд томилж, Бошгот хааны охиныг эрд гарахыг зөвшөөрчээ.

Ийнхүү ойрадын ард түмний дайчин хүү, Төв Азийн түүхэн зүтгэлтний нэг Галдангийн төгсгөл болов. Цин гүрний харьяанд Халхын нутаг дэвсгэр орсон тэр үед дээрх үйл явдал болж өнгөрсөн юм. Цаг хугацааг эргүүлж болдоггүйн адил, түүхийн хүрдийг ч буцаах аргагүй.

Галдан Кан-Си хоёрын тэмцэл нь түүхийн нарийн учир шалтгаантай юм. XVI зууны үеэс эхлэн газар зүйн их нээлт хийж, капитализм хөгжин, колоничлон эзэгнэх бодлого газар авч, улс төр, эдийн засгийн тэнцвэргүй суурин дээр том гүрнүүд үүсэж эхлэв. Үүний зэрэгцээгээр колоничлох бодлого: барьсан Оттоманы эзэнт гүрэн, Ираны Шах-ин-шах, Хятадын Цин гүрэн бэхжлээ. Ийм нөхцөлд Халх, Зүүн гар, Төвдийн хувь заяа их гүрнүүдээс шалтгаалан шийдэгдэж байлаа.

Кан-Си манжийн хаадаас анх удаа Богд хаан хэргэм хүртсэн төдийгүй Хятадыг эрхшээлдээ бүрэн оруулан захирч байлаа. Энэ үед манжийн хаад Хятадын хаан ширээг эзлээд, хөрш орнуудад хандах Хятадын уламжлалт төрийн бодлого, үзэл суртлыг хэвээр нь баримтлан, манжийн дээдсийг нэгтгэн Хятадын ноёлох ангийн эрх ашгийг хамгаалсан булаан эзлэх их гүрний бодлогыг манж маягаар хөтлөн явуулжээ. Бусдын нутаг дэвсгэрт өнгөлзөх манжийн бодлого нь хятадынхаас шийдэмгий байснаар барахгүй “зарим үндэстний цөөнхийн амьдралын түвшин, үйлдвэрлэлийн өсөлтийг нэмэгдүүлэхэд”[23] биш харин Хятадын их гүрний сонирхолд нийцэж байв. ”Кан Си-гийн явуулсан нутаг орноо нэгтгэх бодлого нь бусад үндэстнийг эрхшээлдээ оруулж, газар нутагт нь өнгөлзөх ердийн явуулга байсан гэж үзэх нь нутгийн хөрөнгөтний үндсэрхэг үзэлтний үзэл бодлыг зөвшөөрсөнтэй адил юм”[24]-гэж

орчин үеийн хятадын түүхч Лю-Да-Нянь бичсэн нь Хятадын түүхэн дэх маогийн их гүрний дэрээнгүй бодлогыг илээр магтсан хэрэг юм. ”Хятад нь олон үндэстэн, ард түмний орон гэр бөгөөд ямар үндэстэн улс гүрний удирдлагад байх нь тэдний дотоодын хэрэг юм. Улс гүрний дотоодын үндэстэн ястны тэмцэлийг ”булаан эзлэх” гэсэн нэр томъёогоор нэрлэх нь буруу” [25]-гэдгийг хятадын ард түмэнд итгүүлэхийг оролдсоор байна. Үүндээ үндэслэн Галдан, Кан-Си хоёрын тэмцэл, Халхыг түрэмгийлсэн явдлаа дотоодын ердийн маргаан хэмээн итгүүлэхийг санархжээ.

Нөгөө талаас, сүүлийн үед өөрийнх нь түүх зүйн зөвлөлтийн эсрэг чиглэлийг баримтлан хятадын түүхчид Галданг оросын тагнуул, Оросын хятадын эсрэг бодлогын зэвсэг мэтээр дүрслэхийг оролдож байлаа[26]. Энэхүү санааны үндэсгүй болохыг Галдангийн намтрын үндсэн эх булаг болсон тэр үеийн хятадын баримт бичгүүд үгүйсгэдэг бөгөөд уншигч та бүхэнд толилуулж буй энэ ном ч мөн адил тэдгээр баимт бичгүүд дээр түшиглэсэн болой.

Халх монголын тогтворгүй байдал, Цин гүрний дэмжлэгээр Халхыг эзэгнэх гэсэн Түшээт ханы санаархлыг Цин гүрний дээдэс овжноор ашиглажээ. Зөвлөлтийн зарим түүхчид дээрх саналыг үгүйсгэдэг юм[27]. ”Монгол Ард Улсын Түүх” номонд халх, ойрадуудын хоорондын тэмцэл нь үнэн чанартаа Цин гүрний улс төрийн зүтгэлтнүүдийн хатгаасаар үүдэн гарчээ [28] - хэмээн үнэнээр нь бичжээ. Цин гүрний бодлогын уршгаар Халх “сайн дураар” Хятадад дагаар оржээ. Зүүнгарын хаад Хятадын энэхүү бодлогод бодитой саад болж, “тусгаар улсын бие даасан бодлого барьсан ойрадын феодалууд Цин гүрнийг эсэргүүцэх гадаад бодлого явуулсан” [29] хэмээн С.Л.Тихвинский зөв үнэлсэн байна. Далай ламын зарлиг, Төвдийн заалтаар Галдан тэмцэл хийгээгүй” [30] хэмээн И.Я.Златкин тодорхойлж, Галдан бол тийм ч булаан эзлэгч биш гэж А.М.Позднеев дүгнэжээ [31]. Галдан үйл ажиллагааныхаа эхний үед ойрадын нэгдсэн төр улс байгуулахыг санаархахдаа Зүүн гар гүрний ашиг сонирхлыг хамгаалж байв. Иймээс ч Цэвээн-Равдан, Галдан хоёр хоорондоо дайтаагүй байж болно. Тухайн үед хоорондоо дайтвал Зүүнгарын гүрэн сөнөнө гэдгийг тэд ойлгож байжээ.

Галдан Халхыг алдсаныхаа дараа байгаа бүх боломжоороо Зүүн гарын улсын хилийн дагуу салан одсон санаа нэгтнээ тогтоон барихыг оролдон өөрийгөө гаргуунд хаяжээ. Тухайн үед Халхыг Зүүн гарын гүрэнд нэгтгэхийг хүсэхийн адил бүх ойрад аймгийг нэгтгэх ямар ч боломж байгаагүй билээ. Цин гүрний булаан эзлэх бодлогын эсрэг бүх монгол хэлтэн аймгуудын тэмцлийг зориуд, тууштай зохион байгуулсан хүн ч Галдан биш. Гэхдээ л Цин улсын дарангуйллыг эсэргүүцэгчдийн туг сүлд нь байлаа. Иймээс ч Цин гүрний засаг захиргаа, эзэн хаан Кан-си түүнийг үзэн ядаж иржээ. Бидний үзэж байгаагаар Галдангийн үйл ажиллагаанд хамгийн оновчтой зөв дүгнэлтийг Монголын эрдэмтэн Д.Гонгор өгчээ. Тэрээр: “Галдан бошгот Монголын түүхэнд харийн булаан эзлэгчдийн эсрэг эвлэршгүй тэмцэгч болон тодорсон юм. Ойрадын хаан төрийн захирагч суугаад феодал ангийн эрх ашгийг хамгаалсан бодлого явуулжээ. Гэхдээ шунахай зорилгын үүднээс эх орныхоо ашиг сонирхолыг гаргуунд хаядаг адил зиндааны төлөөлөгчдөөс ялгагдах тал нь Монголын тусгаар тогтнол, эрх чөлөөний төлөө эцсээ хүртэл тэмцсэнд оршино” [32] хэмээн бичжээ.

Цэрэг зэвсэг давамгайлсан Цин гүрэнтэй тэмцэхээс хулчийсан олонхи ойрад, халхын ихэс дээдэс Кан-сид дагаар ороход Галдан л эцсээ хүртэл эрэлхэгээр тэмцсэн юм. Галдан харьж шантралгүй, туйлбартай тэмцсэн нь бодлогогүй хэрэг огт биш ээ. Монгол хэлтэн аймгуудын

түүхэн хувь заяанд Хятадын түрэмгий далд санаа байнга заналхийх аюулын эсрэг тэмцэх хэрэгтэйг зөн билгээр ойлгосон цөөн дээдсийн нэг нь Галдан байлаа. Иймээс ч нугаршгүй хатан зоригоороо домог болон мөнхөжсөн энэ хүн ойрадын ард түмний үндэсний баатар байсан, байх ч болно.

* * *

Уншигч танаа толилуулж буй энэ номонд Галдангийн намтрыг шинжлэх ухааны хялбаршуулсан хэлбрээр бичсэн юм. Уншигч та ойрадын ард түмний түүх, Галдангийн амьдрал, үйл ажиллагаатай холбоотой үйл явдлуудын тухай мэдээллийг шинжлэх ухааны тогтсон аргаар бичсэн бүтээлтэй танилцъя гэвэл И.Я.Златкины Москвад 1964 онд хэвлэгдсэн “История Джунгарского ханства” /”Зүүнгарын хаанчлалын түүх”/, Улаан Үдэд 1974 онд нийтлэгдсэн Ш.Б.Чимиддоржиевийн “Антиманьжурская освободительная борьба монгольского народа /XVII-XVIII вв/” /”Манжийн эсрэг монголын ард түмний чөлөөлөх тэмцэл / XVII-XVIII зуун/” зэрэг номуудыг уншвал зохино. Галдангийн үйл ажиллагааны тухай бидний үнэлэлт нь дээрхи эрдэмтдийн баримталдаг байр суурьтай тэр бүр тохирдоггүй. Энэ ялгаа ч миний номд тусгагдсан юм. XVII зууны үеийн Цин гүрний Хятад, Монголын ард түмнүүдийн харилцаатай танилцъя гэвэл И.С.Ермаченкогийн 1974 онд Москвад хэвлүүлсэн “Политика маньжурской династии Цин в южной и Северной Монголии в XVII веке” /”XVII зууны үеийн Өмнөд ба Ар Монголд явуулсан манжийн Цин эзэнт гүрний бодлого”/, Москвад 1977 онд нийтлэгдсэн хамтын бүтээл “Внешняя политика государства Цин в XVII веке” /”XVII зууны үеийн Цин улсын гадаад бодлого”/-тэй танилцах нь ашигтай.

Миний болон И.Я.Златкин, Ш.Б.Чимиддоржиев нарын бүтээлүүд дэх Галдангийн тухай бүхий л үндсэн мэдээллийг “Цинь чжэн пиндин Шамо фанлюе” – “Стратегия и тактика возглавленного лично императором похода для покорения Шамо” /”Говийг эрхшээлдээ оруулах гэсэн эзэн хааны өөрийнх нь тэргүүлсэн аян дайны стратеги, тактик”/ гэдэг нэг л эх сурвалжаас авсан юм. Шамо гэдэг нь хятадын Их цагаан хэрэм, Хятадын хилээс хойш орших Говь болон Төв Азийн хил залгаа бүхий л нутгийг хятадаар ийн нэрлэдэг. Дээрхи эх сурвалж бичгийг зохиогчдын олонх нь номд дурьдагдсан үйл явдалд оролцогчид байжээ. Энэхүү эх сурвалжийн 1708 онд хятад хэл дээр хэвлэгдсэн анхны эхээс нь миний бие ашигласан болой. Кан-Си, Галдан нарын дайн, Цин улс Халхыг эрхшээлдээ оруулсан тухай баримтаг тайлан нь манж хэл дээр нэгэн зэрэг бичигдсэн байдаг. Манж хэл дээрх эх нь СССР-ийн ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэнгийн Ленинград дахь салбарын /хуучин нэрээр/ манж гар бичмэлүүд ба хуучин хэвлэмэл номын тасагт буй. Энэ эх нь монгол хэл дээр орчуулагджээ. Улаанбаатарт хадгалагдаж байгаа тэрхүү монгол орчуулгыг Ш.Б.Чимиддоржиев өөрийн номоо туурвихад ашигласан ажээ.

Кан-Си-гийн Галдантай хийсэн аян дайны түүх нь Орос улсын хувьд ч ихээхэн сонирхол татаж байгаа нь эргэлзээгүй. “Говийг эрхшээлдээ оруулах гэсэн эзэн хааны өөрийнх нь тэргүүлсэн аян дайны стратеги, тактик” гарснаас 40 жилийн дараа энэхүү эх сурвалжийг Илларион Рассохин орос хэл дээр доорхи нэртэйгээр “Таван хэсгээс бүрдэх Их Татарын нутагт нүүдэллэн амьдардаг халх, өөлдийн ард түмнийг Хятадын хаан Кан-Си-гийн булаан эзэлсэн түүх. Манж хэлнээс орос буулгасан бага дарга Ларион Рассохин. 1750 он” /”История о завоевании китайским ханом Канхием калкаского и элетского народа, кочующего в

Великой Татарии, состоящая в пяти частях. Переведено с маньчжурского языка на российский прапорщиком Ларионом Рассохиным. 1750 год”/ хөрвүүлжээ. Энэхүү орчуулга / И.Я.Златкин номоо бичихэд ашигласан/ нь хэвлэгдээгүй ба СССР-ийн ШУА-ийн Ленинградын салбарын архивт гар бичмэлээр хадгалагдаж байна. Нилээд хожим нь энэхүү эх сурвалжийн материал дээр тулгуурлан хятад, манж судлаач Ал.Леонтьев “1677-1689 онуудад болсон зүүнгарчуудтай явуулсан хятадын дайны тухай мэдэгдэх бичиг” /Сибирь, 1777/ гэдэг ном хэвлүүлжээ.

Ийм маягаар бидний хөндсөн сэдэв нь шинэ биш ч гэсэн шинжлэх ухааны болон улс төрийн ач холбогдлоо алдаагүй юм. Бидний дээр өгүүлсэнчлэн орчин үеийн хятадын түүх зүй нь Галданг Хятадын эсрэг чиглэсэн Төв Ази дахь Оросын бодлогын гар хөл мэтээр үзүүлэхийг оролдож байгаа нь санамсаргүй хэрэг биш. Иймэрхүү баталгааны худал хуурмаг болох нь судлаачдад ч тов тодорхой билээ. Тиймэрхүү зохиолын зорилго нь орос-хятадын харилцааны өнгөрсөн үеийг муучлах, өөрсдөө асуудлын түүхийг тайлбарлаж чадахгүй хятадаар уншдаг хятадын уншигчдыг төөрөгдөлд оруулах явдал мөн. Уншигч та сонирхож байвал дээр дурьдсан эх бичиг, бүтээлүүдийг үзэж, сонирхож буй асуудлынхаа талаарх мэдлэгийг гүнзгийрүүлж чадна. Галдангийн намтарт эрээнтэй бараантай зүйл их байдаг хэдий ч Төв Азийн ард түмнүүдийн хувь заяанд энэ хүний үйл ажиллагаа чухал ач холбогдолтой учраас энэ талаар зөвлөлтийн төдийгүй, гадаадын зохиогчдын анхаарлыг татна гэдэгт бид итгэл төгс байна.

Table of Contents

[Ховд хот байгуулагдсаны 240 жилийн ойд](#)

[Оршил](#)

[Нэгдүгээр бүлэг](#)

[Хоёрдугаар бүлэг](#)

[Гуравдугаар бүлэг](#)

[Дөрөвдүгээр бүлэг](#)

[Тавдугаар бүлэг](#)

[Зургадугаар бүлэг](#)

[Долоодугаар бүлэг](#)

[Наймдугаар бүлэг](#)

[Есдүгээр бүлэг](#)